БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

ADB

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН НЭР ТОМЬЁОНЫ МОНГОЛ-АНГЛИ-ОРОС ТАЙЛБАР ТОЛЬ

## MONGOLIAN-ENGLISH-RUSSIAN GLOSSARY OF HIGHER EDUCATION TERMINOLOGY

Улаанбаатар хот
2019

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН

## НЭР ТОМЬЁОНЫ МОНГОЛ-АНГЛИ-ОРОС ТАЙЛБАР ТОЛЬ

---

## MONGOLIAN-ENGLISH-RUSSIAN GLOSSARY OF HIGHER EDUCATION TERMINOLOGY

Улаанбаатар хот
2019

ННА 413
ДАА 92
Д-966

Тус тайлбар толь нь боловсролын сургалт, судалгааны байгууллагын багш, мэргэжилтэн, суралцагч, судлаачдад зориулагдсан бөгөөд дээд боловсролын сургалтын хөтөлбөр, хөтөлбөр судлал, магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалт, багшлах болон суралцах үйл ажиллагаа, мэргэшлийн үндэсний хүрээнд холбогдох нэр томьёоны товч тайлбар, тодорхойлолтыг багтаасан болно.

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН НЭР ТОМЬЁОНЫ МОНГОЛ-АНГЛИ-ОРОС ТАЙЛБАР ТОЛЬ

# MONGOLIAN-ENGLISH-RUSSIAN GLOSSARY OF HIGHER EDUCATION TERMINOLOGY

Формат 175x250 мм
Хэвлэлийн хуудас: 11.1 х.х
Хэвлэсэн тоо: 1000Ш
"Содпресс" ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

© Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам

CC BY SA

ISBN: 978-99978-61-95-5

*Энэхүү тайлбар толийг Азийн хөгжлийн банкны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр хэвлэв.*

**“Дээд боловсролын нэр томьёоны монгол-англи-орос тайлбар толь”-ийг бэлтгэсэн:**

**Зөвлөх баг:**

Д. Бадарч, Монгол Улсын Их Хурлын даргын Нийгмийн бодлогын зөвлөх, профессор, (Ph.D)

Н. Бэгз, ШУА-ийн Нийгмийн ухааны салбарын бага чуулганы дарга, академич

Б. Жадамба, МУБИС-ийн Суурь судалгааны төвийн эрхлэгч, академич

Б. Туяа, МУИС-ийн Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн багш, проф., (Ph.D)

**Ажлын хэсгийн гишүүд:**

Т. Амаржаргалан, БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын дарга, профессор, (Ph.D)

П. Лхагвасүрэн, Боловсролын хүрээлэнгийн захирал, дэд профессор, (Ph.D)

С. Санжаабадам, Боловсролын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор, (Ph.D)

Ц. Батбаяр, СЭЗИС-ийн Хөгжил, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, (M.Ed)

С. Болормаа, Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын олон улсын зөвлөх (MBA), (Тажикстан)

О. Янжмаа, БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын мэргэжилтэн, (Sc.D)

Ж. Ариунболд, БМИҮЗ-ийн дэд дарга, ажлын албаны захирал, профессор, (Ph.D)

М. Дэлгэржав, МУИС-ийн Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн багш, дэд профессор, (Ph.D)

**Редакцын зөвлөл:**

Ш. Чоймаа, МУИС-ийн Монгол судлалын сургуулийн багш, профессор, (Sc.D.)

Ц. Батдорж, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, (Ph.D)

О. Шинэбаяр, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, дэд профессор, (Ph.D)

Ж. Тунгалаг, БМИҮЗ-ийн Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд профессор, (MA)

Н. Батчимэг, БСШУСЯ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн мэргэжилтэн, (MBA)

С. Нарантуяа, ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвийн Боловсролын бодлого, системийн динамикийн лабораторийн мэргэжилтэн (M.Ed)

Ж. Даваа, МУИС-ийн Боловсрол, сэтгэл судлалын тэнхимийн багш, профессор, (Ph.D)

**Эмхэтгэсэн:**

Б. Лхамцэрэн, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, (Ph.D)

**Consulting team:**

D. Badarch, Ph.D., professor, Social Policy Advisor to the Chairman of the Parliament of Mongolia

N. Begz, Academician, Head of the Sub-Assembly of Social sciences, Mongolian Academy of Sciences

B. Jadamba, Academician, Head of Basic Research Center, MNUE

B. Tuya, Ph.D., professor of Education and Psychology Department, NUM

**Working group members:**

T. Amarjargalan, Ph.D., professor, Head of Higher Education Policy Department, MECSS

P. Lkhagvasuren, Ph.D., professor, Director of Mongolian Institute for Educational Research

S. Sanjaabadam, Ph.D., ass.prof., Academic secretary of Mongolian Institute for Educational Research

Ts. Batbayar, M.Ed., Officer for Development and Partnership, UFE.

S. Bolormaa, MBA., Technical and Vocational and Training International Expert, (Tajikistan)

O. Yanjmaa, Sc.D., Specialist of Higher Education Policy Department, MECSS

J. Ariunbold, Ph.D., professor, Vice-Chairman, Director of Secretariat office, MNCEA

J. Tungalag, MA., ass.prof., Senior specialist for accreditation, MNCEA

M. Delgerjav, Ph.D., ass.prof., Teacher of Education and Psychology Department, NUM

**Editorial board:**

Sh. Choimaa, Sc.D., professor of School of Mongolian Studies, NUM

Ts. Batdorj, Ph.D., Academic secretary of Institute of Language and Literature, Academy of Science

O. Shinebayar, Ph.D., ass.prof., Head of Applied Linguistics Division, Institute of Language and Literature, Academy of Science

N. Batchimeg, MBA., Specialist of Higher Education Reform Project, MECSS

S. Narantuya, M.Ed., Specialist of the Education Policy and System dynamics lab, Open Education Center, MUST

J. Davaa, Ph.D., professor of Education and Psychology Department, NUM

**Compiled by:**

B. Lkhamtseren, Ph.D., Higher education researcher, MIER

# ӨМНӨХ ҮГ

*Хүрээгээ зах хязгааргүй тэлж байгаа глобалчлагдсан дээд боловсролын орон зай, нэр томьёо, ойлголт, ухагдахууныг олон улсын жишигт нийцүүлэн нэг мөр ойлгох, хэрэглэх хэрэгцээ манай улсын дээд боловсролын салбарын хөгжилд зүй ёсоор тулгарч байна.*

*Дээд боловсролын нэр томьёоны "Монгол-Англи-Орос" тайлбар толийг Азийн хөгжлийн банкны зээлээр Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн дэмжлэгтэйгээр боловсруулан бэлтгэж, хэвлэн гаргаж байна.*

*Тайлбар толийн нэр томьёоны агуулгын хүрээг тодорхойлохдоо дээд боловсролд түгээмэл хэрэглэдэг салбарын бодлого, хууль эрх зүй, сургалтын хөтөлбөр, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, багш, оюутан, суралцагч, төгсөгч, хөдөлмөрийн зах зээл, олон улсад түгээмэл хэрэглэдэг, ойрын ирээдүйд ойлгох хэрэгцээ, шаардлага гарч болзошгүй нэр томьёог түлхүү багтаахыг эрмэлзсэн бөгөөд дээд боловсролын сургалтын байгууллагуудаас авсан тайлбарлах шаардлагатай нэр томьёоны саналын судалгааг үндэслэл болгосныг дурдах нь зүйтэй.*

*Энэхүү бүтээлийг нэгтгэн гаргах үйлсэд хүч хөдөлмөрөө зориулан, идэвхтэй хамтран ажилласан Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны Дээд боловсролын бодлогын газар, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны харьяа Боловсролын хүрээлэн, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэмтэн, судлаач, багш нарын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийн гишүүд болон олон нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлэгт үнэтэй зөвлөмж өгч, санал бодлоо хуваалцсан нийт хүмүүст талархал илэрхийлье.*

*Уг тайлбар толинд оновчгүй илэрхийлэгдсэн, тодорхойгүй тайлбарлагдсан нэр томьёо байхыг үгүйсгэхгүй бөгөөд холбогдох үнэтэй санал, зөвлөмжөө Боловсролын хүрээлэнд ирүүлэх аваас бид талархан хүлээн авахын зэрэгцээ цаашид хөгжүүлэх, сайжруулах ажилдаа тусгахаа илэрхийлье.*

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА

Т. АМАРЖАРГАЛАН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ХАРЬЯА БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ

П. ЛХАГВАСҮРЭН

## FOREWORD

*In order to augment sustained development of the Mongolian education sector, there's a dire need to incorporate the definition and interpretation of meanings of terms and terminology emerged and used in the increasingly globalized world of higher education into vocabulary of Mongolian higher education sector to meet the internationally accepted requirements.*

*The "Mongolian-English-Russian glossary of Higher Education Terminology" being prepared and published with funding from the Higher Education Reform project implemented by the Ministry of Education, Culture, Science and Sports and funded by Asian Development Bank will undoubtedly serve as a vital tool in this pursuit.*

*Terminology encompassed within the glossary was compiled on the basis of consultations with higher education institutions in an attempt to provide a comprehensive glossary of education policies, legislation, terminology relating to curriculum, accreditation, quality assurance, instructors, students, graduates, and industry. Moreover, the dictionary builds on widely used terminology to extrapolate terms that may emerge within higher education in the immediate future.*

*Please allow me to take this opportunity to express my most sincere gratitude to representatives of the Higher Education Policy Department of the Ministry of Education, Culture, Science, and Sports, Mongolian Institute for Educational research, Institute of Language and Literature of Mongolian Academy of Sciences, Mongolian National Council for Education Accreditation as well as scientists, researchers, and instructors of higher education institutions that comprised the working group for the endeavor. It would also be wrong to not highlight the contributions of the invaluable advice and suggestions provided by participants of the public discussions throughout the project.*

*Given the possibility of inaccurate and unclear terms in the current iteration of the dictionary, the Institute for Mongolian Education Research shall continue work diligently to accept suggestions and advice in order to constantly develop and enhance the content of the glossary.*

HEAD OF HIGHER EDUCATION
POLICY DEPARTMENT, MECSS
T.AMARJARGALAN

DIRECTOR OF THE MONGOLIAN INSTITUTE
FOR EDUCATIONAL RESEARCH
P.LKHAGVASUREN

## ТОВЧИЛСОН ҮГ / ACRONYMS

| | | |
|---|---|---|
| AI | Artificial Intelligence | Хиймэл оюун ухаан |
| APQN | Asia Pacific Quality Network | Ази, Номхон Далайн Орнуудын Чанарын Сүлжээ (АНДОЧС) |
| ARWU | Academic Ranking of World Universities | Дэлхийн их сургуулийн эрэмбэ, чансаа тогтоох байгууллага |
| ASIIN e.V. | Accreditation Agency for Degree Programs in Engineering, Informatics, The Natural Sciences & Mathematics, Germany | Инженер, мэдээлэл зүй, байгалийн ухаан, математикийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх агентлаг, ХБНГУ |
| ABET | Accreditation Board for Engineering & Technology, USA | Инженер, технологийн магадлан итгэмжлэлийн зөвлөл, АНУ |
| ACBSP | Accreditation Council for Business Schools & Programs, USA | Бизнесийн сургууль, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөл, АНУ |
| ACQUIN | Accreditation, Certification & Quality Assurance Institute , Germany | Магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын байгууллага, ХБНГУ |
| APACC | Asia – Pacific Accreditation and Certification Commission | Ази, Номхон Далайн бүсийн Магадлан Итгэмжлэл, Батламжлалын Хороо |
| AACSB | Association to Advance Collegiate Schools of Business | Бизнесийн ахисан түвшний сургуулийн хөгжлийн байгууллага, АНУ |
| B.B.A. | Bachelor of Business Administration | Бизнесийн удирдлагын бакалавр |
| B.C.L. | Bachelor of Civil Law | Иргэний эрх зүйн бакалавр |
| BEd | Bachelor of Education | Боловсрол судлалын бакалавр |
| BE, BEng | Bachelor of Engineering | Инженерийн бакалавр |
| BMus | Bachelor of Music | Хөгжмийн урлагийн бакалавр |
| B.Phil. | Bachelor of Philosophy | Философийн бакалавр |
| B.Sc.IT | Bachelor of Science in Information Technology | Мэдээллийн технологийн магистр |

| | | |
|---|---|---|
| B.A. | Bachelor, Bachelor of Arts | Хүмүүнлэгийн бакалавр |
| CHEA | Council for Higher Education Accreditation, USA | Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн зөвлөл, АНУ |
| CLOs | Course Learning Outcomes | Хичээлийн хүрэх үр дүн |
| Ed.D, DrEdn | Doctor of Education | Боловсрол судлалын доктор |
| DLaw | Doctor of Law(s) | Хууль зүйн доктор |
| PhD, Ph.D., DPhil | Doctor of Philosophy | Философийн доктор |
| EFA | Education for All | Бүх Нийтийн Боловсрол (БНБ) |
| EMIS | Education management information system | Боловсролын удирдлагын мэдээллийн систем |
| ENQA | European Association for Quality Assurance in Higher Education | Дээд Боловсролын Чанарын Баталгаажуулалтын Европын Холбоо |
| ECTS | European Credit Transfer and Accumulation System | Европын кредит шилжүүлэх, тооцох систем |
| EQAR | European Register of Quality Assurance Agencies | Европын чанарын баталгаажуулалтын байгууллагуудын бүртгэл |
| Eurostat | European Statistics | Европын Холбооны Статистикийн алба |
| EU | European Union | Европын Холбоо |
| EUA | European University Association | Европын их сургуулиудын холбоо |
| EQA | External Quality Assurance | Чанарын хөндлөнгийн баталгаажуулалт |
| HOT | High-Order Thinking | Дээд эрэмбийн сэтгэлгээ |
| DAAD | German Academic Exchange Service | Германы эрдмийн солилцооны алба |
| GCED | Global Citizenship Education | Дэлхий Иргэний Боловсрол |
| GEM Report | Global Education Monitoring Report | Дэлхийн боловсролын хяналт, шинжилгээний тайлан |
| GPE | Global Partnership for Education | Боловсролын төлөөх дэлхийн түншлэл |

| | | |
|---|---|---|
| GPA | Grade Point Average | Голч дүн |
| GDP | Gross Domestic Product | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| HE | Higher education | Дээд боловсрол (ДБ) |
| HRD | Human Resource Development | Хүний нөөцийн хөгжил (ХНХ) |
| HRM | Human Resource Management | Хүний нөөцийн менежмент (ХНМ) |
| ICT | Information and communications technology | Мэдээлэл, харилцаа, холбооны технологи (МХХТ) |
| ID | Instructional Design | Суралцахуйн загвар |
| ILO | Intended Learning Outcome | Суралцахуйн хүрэх үр дүн |
| IQA | Internal Quality Assurance | Чанарын дотоод баталгаажуулалт (ЧДБ) |
| IB | The International Baccalaureate | Олон улсын боловсролын сан (Швейцар) |
| IBE | International Bureau of Education (UNESCO) | ЮНЕСКО-гийн Олон улсын боловсролын товчоо |
| UNEVOC | International Centre for Technical and Vocational Education and Training | ЮНЕСКО-гийн Техник, Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Олон Улсын Төв (ЮНЕВОК) |
| IELTS | International English Language Testing System | Олон улсын англи хэлний түвшин тогтоох шалгалт |
| IIEP | International Institute for Educational Planning (UNESCO) | Боловсролын Төлөвлөлтийн Олон Улсын Хүрээлэн |
| ILO | International Labour Office / Organization | Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага |
| INQAAHE | International Network for Quality Assurance Agencies in Higher Education | Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллагуудын олон улсын сүлжээ |
| ISO | International Organization for Standardization | Олон Улсын Стандартчиллын Байгууллага |
| ISCED | International Standard Classification of Education | Боловсролын олон улсын стандарт ангилал |
| ISCO | International Standards Classification of Occupations | Ажил мэргэжлийн олон улсын стандарт ангилал |
| JUAA | Japan University Accreditation Association | Япон улсын их сургуулийн магадлан итгэмжлэлийн холбоо |
| MIS | Management Information System | Удирдлагын мэдээллийн систем |

| | | |
|---|---|---|
| MOOC | Massive open online course | Нийтийг хамарсан нээлттэй цахим хичээл |
| MAT | Master of Arts in Teaching | Заах арга зүйн магистр |
| MBA | Master of Business Administration | Бизнесийн удирдлагын магистр |
| M.A.Ed., M.Ed., M.Ed.L., M.S.E., M.S.Ed., MEd | Master of Education | Боловсрол судлалын магистр |
| M.Phil | Master of Philosophy | Философийн магистр |
| M.Sc.IT | Master of Science in Information Technology | Мэдээллийн технологийн магистр |
| MA | Master's degree | Магистрын зэрэг |
| MoU | Memorandum of Understanding | Харилцан ойлголцлын санамж бичиг |
| MECSS | Ministry of Education, Culture, Science and Sports | Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам (БСШУСЯ) |
| MNCEA | Mongolian National Council for education accreditation | Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИҮЗ) |
| MCAT | The Medical College Admission Test | Анагаахын сургуулийн элсэлтийн шалгалт (АНУ) |
| NQF | National Qualification Framework | Мэргэшлийн үндэсний хүрээ (МҮХ) (шаталсан бүтэц) |
| NAS | Natural Sciences | Байгалийн шинжлэх ухаан |
| OE | Open Education | Нээлттэй боловсрол |
| OERs | Open Educational Resources | Боловсролын нээлттэй эх материал |
| OBE | Outcome-based education | Үр дүнд суурилсан боловсрол |
| PISA | Program for International Student Assessment | Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр (ОУСҮХ) |
| PLOs | Program Learning Outcomes | Хөтөлбөрийн хүрэх үр дүн |
| PPPs | Public-Private Partnerships | Төр, хувийн хэвшлийн түншлэл |
| QS | Quacquarelli Symonds | Боловсролын зөвлөх байгууллага (их сургуулийн эрэмбэ, чансаа тогтоох байгууллага) |
| QUO | Quality Assurance Office | Чанарын баталгаажуулалтын алба |
| QAU | Quality Assurance Unit | Чанарын баталгаажуулалтын нэгж |
| R&D | Research and Development | Судалгаа ба хөгжүүлэлт (СХ) |

| | | |
|---|---|---|
| ESG | Standards & Guidelines for Quality Assurance in the European Higher Education Area | Европын дээд боловсролын орон зайн чанарын баталгаажуулалтын стандарт ба зөвлөмж |
| SD | Sustainable Development | Тогтвортой хөгжил (ТХ) |
| SDE | Sustainable Development education | Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) |
| SDG | Sustainable Development Goals | Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ) |
| TOEFL | Test of English as a Foreign language | Англи хэлний олон улсын сорил |
| TQM | Total Quality Management | Чанарын ерөнхий удирдлага |
| OECD | The Organization for Economic Co-operation and Development | Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ) |
| EHEA | The European Higher Education Area | Европын дээд боловсролын орон зай |
| THE | Times Higher Education | Дэлхийн их сургуулийн эрэмбэ, чансаа тогтоох байгууллага |
| TVET | Technical and Vocational Education and Training | Техник, Мэргэжлийн боловсрол, сургалт (ТМБС) |
| UIS | UNESCO Institute for Statistics | ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэн |
| UN | United Nations | Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) |
| UNDP | United Nations Development Programme | НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр |
| UNESCO | United Nations Educational, Scientific and Cultural Organization | Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) |
| UNO | United Nations Organization | Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) |
| VET | Vocational Education and Training | Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС) |
| WEF | World Economic Forum | Дэлхийн эдийн засгийн чуулган |

## ДЭЭД БОЛОВСРОЛЫН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

## HIGHER EDUCATION TERMS

| A | | | |
|---|---|---|---|
| *Авьяас*<br>*Ability*<br>*Способность* | febiye_ | Шинэ мэдлэг, ур чадвар эзэмших болон ашиглах хувь хүний нөөц боломж. | Individual's potential for acquiring and applying new knowledge or skills. (UNESCO, 2013) |
| *Авьяастай суралцагч*<br>*Gifted learners*<br>*Одаренный студент* | febiyesdel Sorolceecl | Оюуны, бүтээлч, нийгмийн болон бие бялдрын гэсэн дөрвөн үзүүлэлтээс нэг эсвэл хэд хэдэд нь дунджаас дээш түвшний чадвартай суралцагч. Тэдний авьяасыг бүрэн хөгжүүлэхэд сургуулийн хэвийн үйл ажиллагааны зэрэгцээ нэмэлт үйлчилгээ, нөөц, шаардлагатай. | Gifted learners are those whose potential is distinctly above average in one or more of the following domains: intellectual, creative, social and physical. They need services and activities not ordinarily provided by the school in order to fully develop their potential. (UNESCO, 2013) |
| *Агуулгын стандарт*<br>*Content standard*<br>*Стандарт содержания* | fegol) T iia SDenderDA | Тодорхой хичээл, сургалт, мэргэжлийн хүрээнд суралцагчийн эзэмшсэн байх мэдлэг, чадварыг тодорхойлсон хэм хэмжээ. Стандарт нь тодорхой, нарийвчилсан, цогц, хэм хэмжээндээ тохирсон, үнэн бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй байна. | Specifications of what all learners are expected to know and be able to do within a particular field of study, discipline or subject at different grade levels, ages, or other criteria. These standards should be clear, detailed, and complete; reasonable in scope; rigorous and scientifically correct. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Ажил хайгч*<br><br>*Job seeker*<br><br>*Ищущий работу* | feji& Heiiecl | Ажилгүй, ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн болон хандсан иргэн. | A job seeker is a citizen who has been employed or employed but has been looking for a job to improve work condition or to earn additional income who has been registered in and approached to employment organizations and labour offices. (The Law of Mongolia on Maintaining Employment, 2011) |
| *Ажил, мэргэжлийн дэмжлэг*<br><br>*Career support*<br><br>*Карьерная поддержка* | feji&, Merkjii& oa Demjilkt | Суралцагч ур чадвар, зан чанар, хүсэл сонирхолдоо нийцүүлэн ирээдүйн ажил, мэргэжлээ сонгох, мөн нийгмийн болон мэргэжлийн хувьд бие даасан хувь хүн болон төлөвшихөд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх зорилгоор сургалтын байгууллагаас үзүүлж буй дэмжин туслах үйлчилгээ. | Support services offered by an institution to help students choose their future career/ employment according to their abilities, qualities, and wishes, and to cultivate the abilities necessary for being socially and professionally independent. (NIAD-QE, 2016) |
| *Ажил, мэргэжлийн чадвар*<br><br>*Hard skills*<br><br>*Твердые навыки / Профессиональные навыки* | feji&, Merkjii& oa CideBrl | Тодорхой ажил, мэргэжилд хамаарах мэдлэг, дэг журам, мэргэжлийн болон техникийн ур чадвар. | Skills typically related to the professional or job-related knowledge, procedures, or technical abilities necessary for an occupation. (UNESCO, 2013) |

*Ажил, мэргэжлийн чиг баримжаа ба зөвлөгөө өгөх үйлчилгээ*

*Career guidance and counseling*

*Профессиональная ориентация и консультирование*

fejil, Merkjil oa Ciit birimjiIT bit Joib,ekit foihK foiilecilekit

Хувь хүн боловсрол, сургалт, мэргэжлээ сонгох, ажил, мэргэжилдээ амжилт гаргахад туслах зорилго бүхий үйл ажиллагаа, үйлчилгээ. Энэ үйлчилгээг бүх шатны боловсролын байгууллага, олон нийтийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний алба, ажлын байр, сайн дурын, хувийн хэвшлийн байгууллагууд үзүүлэх боломжтой бөгөөд энд мэргэжлийн талаар мэдээлэл өгөх (хэвлэмэл, МХХТ-д суурилсан болон бусад хэлбэрээр), өөрийн үнэлгээ хийх, ганцаарчилсан ба бүлгийн зөвлөгөө өгөх ярилцлага хийх, ажил, мэргэжилтэй холбоотой боловсрол, сургалтын хөтөлбөр (мэдлэгээ хөгжүүлэх, түвшнээ тогтоох, мэргэжлийн ур чадварт суралцахад туслах), турших хөтөлбөр (ажил, мэргэжил сонгохоос өмнө туршиж үзэх), ажил хайх хөтөлбөр болон шилжилт хөдөлгөөн хийх зэрэг багтана. Ганцаарчилсан эсвэл бүлгийн хэлбэрээр, нүүр тулж эсвэл зайнаас (утсаар, вебэд суурилан) зохион байгуулах боломжтой.

Services and activities intended to assist individuals of any age and at any point throughout their lives, to make educational, training and occupational choices and to manage their careers. Such services may be found in schools, universities and colleges, in training institutions, in public employment services, in the workplace, in the voluntary or community sector and in the private sector. The activities may take place on an individual or group basis, and may be face-to-face or at a distance (including help lines and web-based services). They include career information provision (in print, ICT-based and other forms), assessment and self-assessment tools, counselling interviews, career education programmes (to help individuals develop their self-awareness, opportunity awareness, and career management skills), taster programmes (to sample options before choosing them), work search programmes, and transition services. (VETP, 2018)

| | | | |
|---|---|---|---|
| *Ажилгүй иргэн*<br><br>*Unemployed Citizen*<br><br>*Безработный гражданин* | fej1& foik:l firk:a | Ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн. | A person without a paid job but available to work. (The Law of Mongolia on Maintaining Employment – 2011) |
| *Ажилгүйдлийн ангилал*<br><br>*Unemployment classification*<br><br>*Классификация занятости* | fejilKiide& oa feehkulle& | Нас, хүйс, ажилгүй болохын өмнөх ажил эрхлэлтийн байдал мэргэжил, иргэншил, оршин суугаа улс орон, бүс нутгийн ялгаа зэргийг үндэслэн гаргасан ажилгүйдлийн ангилал. | Classification of unemployment based on age, sex. Pre-unemployment condition, profession, citizenship ad permanent settlement in a region or country. (VETP-1, 2018) |
| *Академик эрх чөлөө*<br><br>*Academic freedom*<br><br>*Академическая свобода* | fe\:dwmi! frk:t Cilok:t | Хөндлөнгийн оролцоо, шахалт дарамтаас ангид суралцах, багшлах, судлах, хэвлэн нийтлүүлэх судлаачийн эрх. | Academic freedom is the rights for individual scholars to learn, teach, research and publish without interference or fear of reprisal. (INQAAHE, 2017) |
| *Албан боловсрол*<br><br>*Formal education*<br><br>*Формальное образование* | felb:a Blb:sore& | Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангахуйцаар зохион байгуулагдсан сургалтын үйл ажиллагаа. | Educational structured activities aimed to provide the needs of learners to obtain general and basic vocational education through official educational institutions. (The Law of Mongolia on Education, 2002) |
| *Албан бус боловсрол*<br><br>*Non-formal education*<br><br>*Неформальное образование* | felb:a Bs0 Blb:sore& | Албан ёсны боловсролын тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа. | Structured activities aimed to provide education services to citizens beyond the official education system. (The Law of Mongolia on Education, 2002) |

| | | | |
|---|---|---|---|
| *Албан сургалтын хөтөлбөр*<br><br>*Formal curriculum*<br><br>*Формальная образовательная программа* | KidolBrl felbia Sorgelda iia | Албан боловсролын гэрчилгээ олгох үндэс суурь болдог албан ёсоор баталгаажсан боловсролын үйл ажиллагаанд суралцагчийг хөтлөх боломж хийгээд суралцахуйн туршлага. | The learning experiences and opportunities that are provided to learners in the context of formal education and serve as a basis for certification processes. (UNESCO, 2013) |
| *Амжилтгүй төгсөлт*<br><br>*Unsuccessful graduation*<br><br>*Неудачный выпуск* | femjilda foikil DeKsolda | Боловсролын хөтөлбөрийн бүх бүрэлдэхүүн хэсэгт (шаардлагатай бол төгсөлтийн шалгалт) хамрагдаж оролцсоны үл харгалзан боловсролын хөтөлбөрийн сургалтын зорилгыг биелүүлээгүй байдал. Өөрөөр хэлбэл, сургалтын зорилгын биелэлтийн зарим үнэлгээ хийгдсэн боловч эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжийг хангалтгүй гэж дүгнэхийг хэлнэ. | Despite involvement in all education program components (if required graduation exam), learning goals of the education program have not been met. Unsuccessful graduation means that however, training goal fulfillment has been assessed, acquired knowledge, skills and competencies have been concluded as unsatisfactory. (UNESCO, ISCED, 2011) |
| *Амьдрах орчин, туршлагаас суралцахуй /Албан бус боловсрол*<br><br>*Informal learning*<br><br>*Неформальное обучение / Информальное обучение* | Sorolceeol < felbia BsO Blbisore& femidoreeeO forcia, Dorsil)T fca | Гэр бүл, ажлын байр, нийгмийн орчин, өдөр тутмын амьдралаас хувь хүний суралцах үйл ажиллагаа. Албан ба албан бус боловсролтой харьцуулахад сул бүтэц, зохион байгуулалттай бөгөөд суралцагчийн хувьд төлөвлөгдөөгүй байдаг. | Learning activities that occur in the family, workplace, local community and daily life, on a self-directed, family-directed or socially-directed basis. It is consequently less organized and structured than either formal or nonformal education. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Үүнийг ихэнх тохиолдолд туршлагаас суралцах гэж үздэг ба ном зохиол унших, нийгмийн харилцаанд орох болон бусад амьдралын туршлагаас олж авсан мэдлэг, ойлголт, ур чадварыг хэлнэ. Зарим утгаар нь санамсаргүйгээр суралцах гэж ойлгож болно. Ямар нэгэн гэрчилгээ олгогддоггүй. | It is often referred to as, experiential learning i.e., learning in the form of awareness, knowledge or skills derived from experience, reading, social contact, etc., and can, to a certain degree, be understood as accidental learning. Typically, it does not lead to certification. (UNESCO, 2013) |
| *Амьдрах чадвар, ухаан*<br><br>*Life skills*<br><br>*Жизненно необходимые навыки* | femidoreeO CideBrl , foeeegea | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас амьдрах чадварыг анх тодорхойлохдоо хүмүүсийн шийдвэр гаргах, асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх, үр дүнтэй харилцах, эрүүл харилцааг бий болгох, бусдыг ойлгон энэрэх, бүтээлч байдлаар амьдралаа удирдан зохицуулахад нь ач тустай нийгмийн хүчин зүйл болоод хувь хүн хоорондын харилцааны цогц ур чадвар гэжээ. Амьдрах чадварыг хувь хүний хөгжил болон насан туршийн боловсролын үйл явцад чухал ач холбогдолтой мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагын өргөн | Originally defined by the World Health Organization as a group of psychosocial competencies and interpersonal skills that help people make informed decisions, solve problems, think critically and creatively, communicate effectively, build healthy relationships, empathize with others, and cope with and manage their lives in a healthy and productive manner. Life skills are not normally seen as a domain, or a subject, but as cross-cutting applications of knowledge, skills, values and attitudes which are important in the process of individual development and lifelong learning. In some cases the term is used as an equivalent of |

| | | | |
|---|---|---|---|
| | | хүрээн дэх хэрэглээ гэж үздэг. Зарим тохиолдолд энэ нэр томьёог үндсэн (түлхүүр) чадамжтай дүйцүүлэн авч үздэг. Хүүхэд бүр хүссэнээрээ амьдарч, нийгмээ өөрчлөх чанартай боловсрол эзэмших эрхтэй. | key competencies/skills, and in certain contexts it is used to indicate a subject area. Children are fundamentally entitled to quality education to live a life they value and to transform the societies in which they live. (UNESCO, 2013) |
| *Анги танхимд хийгдэх үнэлгээ*<br><br>*Classroom-based assessment (CBA)*<br><br>*Оценка в классе* | feehk/A, Deehk/^ dO k/kdeK foineIekit | Бусад хичээлийн үнэлгээнээс хамааралгүйгээр тухайн хичээлийн агуулгын хүрээнд багшийн хийх үнэлгээ. Энэ нь багш болон суралцагчид сургалтын чанарын талаарх үнэлгээ болж сурлагын дүнг ахиулахад дэмжлэг болдог. Мөн “Нэгж хичээлийн үнэлгээ” ба “багшийн үнэлгээ” гэж нэрлэгддэг. | Assessment carried out by teachers based on the learning that has taken place within the context of a classroom, without reference to assessment being conducted in other classes or groups. It offers feedback to teachers and students on the quality of the learning performance supporting its ongoing improvement. Also referred to as ‘classroom assessment’ and ‘teacher-based assessment’. (UNESCO, 2013) |
| *Ангийн багшийн тогтолцоо*<br><br>*Room teacher system*<br><br>*Система классных руководителей* | feehk/A iia bieesI iia DoedeIce)T | Оюутны сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор салбар сургууль эсвэл тэнхимийн хүрээнд суралцагчдыг мэргэжлийн чиглэлээр нь жижиг бүлэг болгон хуваарилж тэдгээрийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий багшийг томилох тогтолцоо. | A system that appoints a supervisory teacher to a small group of students drawn from beyond or under faculties or departments, which enables students to receive finely-tuned support for their educational and student lives. (NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Ангилал*<br><br>*Classification*<br><br>*Классификация* | feehkulle& | 1. Үндсэн үйл ажиллагаа эсвэл эдийн засгийн статусыг нь харгалзан сургалтын байгууллагын төрлийг тодорхойлох үйл явц. 2. Суралцагчдад олгох боловсролын зэргийг бүлэглэн тодорхойлох үйл явц. | Classification is (1) the process of identifying types of institution based on their core functions or economic status; (2) the process of delineating the class of award gained by a student. (INQAAHE, 2017) |
| *АНУ-ын анагаахын сургуулийн элсэлтийн шалгалт*<br><br>*Medical college admission test (MCAT)*<br><br>*Вступительный экзамен в медицинский колледж в США* | Sorgegoll iia flselda Jia Silgelda fe, Ni, fo - oa fenegeeO Jia | Америкийн анагаахын сургуульд элсэгчдээс авдаг элсэлтийн шалгалт. | Medical college admission test, required when applying to american medical schools. (Glossary of terms in HE) |
| *Асуудал шийдвэрлэх үйл явц*<br><br>*Problem solving*<br><br>*Решение проблемы* | fesegode& SiioeBrilek foiila YeBca | Асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн сэтгэхүйн цогц үйл явц. Асуудал нь байнга давтагддаг эсвэл шинэлэг байж болох бөгөөд байнга давтагддаг асуудлыг шийдвэрлэх нь урьд өмнө эзэмшсэн ижил төстэй туршлагадаа суурилан тухайн нөхцөл байдлаас зорилтот түвшинд шилждэг. Шинээр бий болсон асуудлыг шийдвэрлэх гэдэг нь тухайн нөхцөл байдлаас зорилтот түвшинд хүрэхийн тулд шинэ шийдлийг олж нээхийг хэлнэ. | Within the cognitive tradition, the set of thinking processes or actions involved in the solving of a problem. Problems may be routine or novel. Routine problem solving involves moving from a given state to a goal state based on a solution plan primed from similar past experiences. In contrast, novel problem solving entails the problem solver moving from a given state to a goal state by inventing the solution procedure. (UNESCO, 2013) |

*Асуудалд суурилсан сургалт*

*Problem-based learning*

*Проблемное обучение*

fesegode& dO Segorileeesea Sorgelda

Суралцагчдын амьдрах, суралцах үйл ажиллагаанд чухал, ач холбогдолтой цогц асуудлаар хэлэлцэж, ярилцах үйл явц. Энэ нь суралцагч асуултынхаа хариултыг олох гайхширал, эргэлзээгээ, арилгах замаар мэдлэг, ойлголтоо дээшлүүлэх, баяжуулах боломжийг олгодог. Хэлэлцэх асуудал нь олон талын санаа бодлыг тусгах, хамтарсан яриа өрнүүлэх, олон шийдлийг гаргаж болохуйц өргөн хүрээтэй, суралцагчдад утга учиртай, амьдралд чухал ач холбогдолтой мэдээ, мэдлэгийг олж авахуйц бодитой байх бөгөөд асуух, бодох, тунгаах зэргээр суралцах идэвх, санаачлалыг нь дэмжих ёстой байдаг.

A process designed to experientially engage learners in processes of inquiry into complex problems of significance and relevance to their lives and learning. It is intended to challenge learners to pursue authentic questions, wonders, and uncertainties in a focused way, which enables them to construct, deepen, and extend their knowledge and understanding. Problems must be complex enough that there is a need to seek many perspectives on the issues, to engage in collaborative inquiry, and to generate multiple possible solutions. The problems have an authenticity that holds meaning for the learners, enables them to assume ownership of the problems, and results in findings of significance in the broader context of their lives. Problems must invite a deep approach to learning – to inquiry, thinking, and reflection – which leads to shifts or changes in learners' knowledge. (UNESCO, 2013)

| | | | |
|---|---|---|---|
| *Аудит*<br><br>*Audit*<br><br>*Аудит* | feoidiDA | Байгууллага эсвэл хөтөлбөрийг эрхэлсэн нэгж нь хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлж буй эсэх, тодорхойлсон зорилго, зорилтууд (сургалтын төлөвлөгөө, дэд бүтэц, багшлах бүрэлдэхүүн зэргийн хувьд)-аа ханган ажиллаж буйг хянан шалгах үйл явц. | The process of reviewing an institution or a program that is primarily focused on its accountability, and determining if the stated aims and objectives (in terms of curriculum, staff, infrastructure, etc.) are met. (UNESCO-CEPES, 2007) |
| *Ахисан түвшний сургууль*<br><br>*Graduate school*<br><br>*Структурное подразделение для магистратуры и аспирантуры* | feKleesea Doibsia O SorgegolI | Ихэвчлэн их сургуульд харьяалагдаж, магистр, докторын болон мэргэжлийн зэрэг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бүтцийн нэгж. Бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байж болно. | A graduate school is an organizational unit, often located in a university, which offers masters, doctoral and/or professional degree programs. It may be established without undergraduate programs. (NIAD-QE, 2016) |
| *Ахисан түвшний хөтөлбөр*<br><br>*Graduate program*<br><br>*Программа для магистратуры и аспирантуры* | feKleesea Doibsia O KidolBrI | Ахисан түвшний сургуульд тавигдах стандарт шаардлагын дагуу хэрэгжих магистр, доктор болон мэргэжлийн зэрэг олгох хөтөлбөр. | The term refers to master's, doctoral, and professional degree programs, according to the standards for the establishment of the graduate schools. (NIAD-QE, 2016) |
| *Ачаалал*<br><br>*Workload*<br><br>*Нагрузка / трудозатраты* | feciyele& | Лекц, семинар, дадлага ажил, бие даан суралцах цаг, мэдээлэл боловсруулалт, судалгаа, шалгалт гэх мэт суралцахуйн үр дүнд | A quantitative measure of the learning activities that may be required for the achievement of learning outcomes (e.g. lectures, seminars, practical work, |

| | | | |
|---|---|---|---|
| | | хүрэхэд шаардлагатай сургалтын үйл ажиллагааны тоон хэмжүүр. | private study, information retrieval, research, examinations). Related terms: Credit. (UNESCO-CEPES, 2007) |
| *Ашигтай загвар*<br><br>*Utility model*<br><br>*Полезная модель* | fesieedel JeeeB* | Үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдэл. | Utility model is a new technical solution that can be applied in production which is related to production tools, utilities and methods. (The Law of Mongolia on Patent, 2006) |
| *Ашигтай загварын гэрчилгээ*<br><br>*Utility model certificate*<br><br>*Свидетельство на полезную модель* | fesieedel JeeeB* oa kireciIlekit | Ашигтай загварыг эрх бүхий этгээд өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичиг. | Utility model certificate is a document issued by the state competent authority recognizing that the body has a right of ownership of the utility model. (The Law of Mongolia on Patent, 2006) |

| Б | | | |
|---|---|---|---|
| *Багаар ажиллах*<br><br>*Team work*<br><br>*Командная работа* | bE( iie* fejlleeO | Тодорхой зорилгод хүрэхийн тулд бүлэг хүмүүстэй хамтран ажиллах үйл явц. Хувь хүн хоорондын аливаа зөрчлөөс үл хамааран, хүн бүр ур чадвараа ашиглан бүтээлч санал, санаачилга гарган ажиллах хүмүүсийн хамтын ажиллагаа. | The process of working collaboratively with a group of people in order to achieve a goal. Teamwork means that people will try to cooperate, using their individual skills and providing constructive feedback, despite any personal conflict between individuals. (VETP-1, 2018) |
| *Багаар багшлах үйл ажиллагаа*<br><br>*Team teaching*<br><br>*Групповое обучение* | bE( iie* bEesIleeO foiila fejIle)T | Хоёр ба түүнээс олон багш нэг бүлгийн суралцагчдад хамтран удирдах сургалтын үйл ажиллагаа. Багаар багшлах үйл ажиллагаа нь олон хэлбэртэй байж болно. Тэд хичээлийн жилийн хугацаанд нэг хичээлийг хамтран заах, хичээлийг хослуулах, сургалтын нэг нэгжийг төлөвлөн заах, нэг эсвэл өөр өөр хичээлийн агуулгыг заах болно. Ингэхдээ суралцагчдыг нэг том бүлэг болгох эсвэл хэд хэдэн бүлэгт хуваах болно. | An arrangement by which two or more teachers teach the same group of learners. Teachers may teach together in many different ways. They may teach a course, or a combination of courses, for an entire school year, or they may plan and teach a particular unit of study. They may present content from the same, or different, subject areas. And they may keep the students in a single large group or divide them up for some purposes. (UNESCO, 2013) |
| *Багц цаг*<br><br>*Credits*<br><br>*Кредит / зачетная единица* | bEeca Ce( | Хүрэх үр дүнгийн биелэлт, түүнд хамаарах ачаалал дээр үндэслэн суралцахуйн агуулгын багтаамжийг илэрхийлэх тоон утга. | A credit is an agreed upon quantified means of expressing the level of learning based on the achievement of learning outcomes and their associated workloads. (UNESCO-CEPES, 2007) |

| | | | |
|---|---|---|---|
| *Багш бэлтгэх тогтолцоо*<br><br>*Tenure track system*<br><br>*Система тенюра* | b:eesI b:leokiK Doeedel ce)T | Залуу судлаачдыг тодорхой хугацаанд сургалтын болон судалгааны үйл ажиллагаанд оролцуулах замаар ажил олгох тогтолцоо юм. Тухайн хүсэлт гаргагчдыг өндөр түвшний боловсролын мэдлэг, ур чадвартай гэж үзэж, хүлээн зөвшөөрвөл дээр боломжийг олгодог. Багшлах боловсон хүчний дунд өндөр чанартай сургалтын үйл ажиллагааг явуулахад түлхэц үзүүлэх зорилгоор хэрэгжүүлдэг. | A system under which young researchers can apply for tenure after engaging in academic research and educational activities for a certain period. Candidates will be granted tenure if it is accepted that they have demonstrated a high level of skills and academic abilities. Its purpose is to provide a stimulus for high-quality educational activity among the academic staff body. (Tayyeb Ali Khan, Nasira Jabeen, 2011) |
| *Багш нарын зөвлөл*<br><br>*Faculty council*<br><br>*Совет профессорско-преподавательского состава* | b:eesI Ne* oa Joib;e& | Сургалт болон судалгаатай холбоотой гол асуудлыг авч хэлэлцдэг, их сургууль болон коллеж бүрд заавал байдаг хамтын байгууллага. Энэ зөвлөл нь профессор, дэд профессор, бусад ажилтнуудаас бүрдэнэ. Үндэсний их сургуульд сургалт болон судалгааны зөвлөлийг байгуулсны дараа салбар сургууль бүрд багш нарын зөвлөлийг байгуулдаг. Сургуулийн захирал элсэлт, төгсөлт, хөтөлбөр дүүргэх, зэрэг олгох болон сургалт, | A collegial body mandatory in every university and junior college to discuss key issues in education and research. It can consist of associate professors and other staff, in addition to professors. Following the establishment of education and research councils in national universities, faculty councils now exist in each faculty. A president can invite a faculty council to state its opinions on specific matters which he or she has to decide. These matters may include |

| | | | |
|---|---|---|---|
| | | судалгааны үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлууд зэрэг нэн чухал асуудлаар шийдвэр гаргахдаа багш нарын зөвлөлийг урьж санал бодлыг сонсдог. | student admission, graduation, and program completion, awarding of degrees, and other matters important for education and research. (NIAD-QE, 2016) |
| *Багшийг үнэлэх оюутны үнэлгээ*<br><br>*Student evaluation of teachers*<br><br>*Оценка преподавателей студентами* | bÉesI iI foinelK foyodea O foinelkit | Багшийн үйл ажиллагаа, хандлагыг оюутны зүгээс үнэлэх үйл явц. Энэ нь шинжээчдэд оюутны хүлээлт болон багшийн сургах үйл ажиллагаа хоорондын нийцлийг тодорхойлоход тустай. Оюутны үнэлгээгээр дамжуулан багшийн оюутнуудтай ойр ажилладаг байдал, нээлттэй, нөхөрсөг, бүтээлч, тэвчээртэй байдал, оюутныг сэдэлжүүлэх, идэвхжүүлэх, мэдээллийг хүргэх чадварыг үнэлэх боломжтой. | The process of using student inputs concerning the general activity and attitude of teachers. These observations allow the overall assessors to determine the degree of conformability between student expectations and the actual teaching approaches of teachers. Student evaluations are expected to offer insights regarding the attitude in class of a teacher (approachable, open-minded, entertaining, creative, patient, etc.), and the abilities of a teacher (to explain things, to motivate students, to help students think, to correct mistakes in a friendly manner, to offer information efficiently, etc.). Related terms: Quality, Assessment, Evaluation, Student survey. (UNESCO-CEPES, 2007) |

| | | | |
|---|---|---|---|
| *Багшийн ажлын гүйцэтгэл*<br><br>*Teacher performance*<br><br>*Показатели труда преподавателя* | bieesI iia fejil& oa Kiiceoekil& | Суралцагчдын хөгжил, хүмүүжил, төлөвшил, хандлага, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан бусад чиг үүргийн хүрээнд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр илэрхийлэгдэх үр дүн. | The results from own and external evaluations within the scope of other functions reflected in the definition of a student's development, discipline, maturity, attitude, and job description. (The Law on Teacher's Development, 2018) |
| *Багшийн ёс зүйн зөрчил*<br><br>*Teacher ethic's violations*<br><br>*Нарушение педагогической этики* | bieesI iia YosO<br>Joil iia Joirice& | Багшийн ёс зүйн зөрчил гэж тухайн дүрмээр тогтоосон багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ. | Teacher Ethics violation means an intentional or unintentional act or omission that violates ethical standards of a teaching profession set forth in the given Code. (MECSS, 2006) |
| *Багшийн мэргэжлийн ёс зүй*<br><br>*Teacher's professional ethics*<br><br>*Профессиональная этика преподавателя* | bieesI iia Merkijil& oa<br>YosO Joil | Багшийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой нийтээр хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшил, хэвшсэн соёл болон харилцааны үйлдэл, эс үйлдэл. | Teacher's professional ethics is a commonly accepted belief, culture, and communications acts or omissions related to the professional practices. (MECSS, 2006) |
| *Багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ*<br><br>*Standards of teacher's professional ethics*<br><br>*Стандарт профессиональной этики преподавателя* | bieesI iia Merkijil& oa YosO<br>Joil iia kei kemjiiT | Багшийн мэргэжилдээ үнэнч байж, багш мэргэжлийн нэр хүндийг хамгаалж, хүлээсэн үүргээ чанд биелүүлэх талаар тогтоосон шаардлагын цогц. | The professional ethics standards of a teacher are a set of requirements to be faithful to the teacher's profession, protect reputation of the profession and fulfill obligations and responsibilities strictly. (MECSS, 2006) |

| | | | |
|---|---|---|---|
| *Багшийн хөгжил*<br><br>*Faculty development*<br><br>*Профессиональное развитие преподавателя* | bfeesI iia Kihji& | Багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явц. (Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, 2018).<br>Их сургуулийн сургалтын үйл ажиллагаар сайжруулах, хөгжүүлэх зорилгоор багш нарт чиглэсэн системтэй арга барилыг илэрхийлэх нэршил. Энэ нь харилцан туршлага солилцох, багшлахуйн арга зүйг сайжруулах, шинэ багш нарыг хөгжүүлэх сургалт семинар зэрэг олон арга хэлбэрээр хэрэгждэг. | An ongoing process for developing teachers' knowledge, methodology, skills and education. (The Law on Teacher's Development, 2018).<br>The term is used for the systematic approach by academic staff to improve and develop the university's educational functions. It includes various approaches such as mutual class observations between academic staff, holding workshops on teaching methods, and giving training opportunities for newly employed staff. (NIAD-QE, 2016) |
| *Багшийн хөгжлийн төв*<br><br>*Teacher development center*<br><br>*Центр профессионального развития преподавателя* | bfeesI iia Kihji& oa Doi$ | Багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчин. | An environment, equipped with tools and facilities that are essential for continuous on the job development of the teachers. (The Law on Teacher's Development, 2018) |
| *Багшлах бүрэлдэхүүн*<br><br>*Academic staff*<br><br>*Профессорско-преподавательский состав* | bfeesilleeeO BirildoKa | Профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлд дээд боловсролын сургалт, судалгааны ажил гүйцэтгэж буй бүрэлдэхүүн. | Staff who conduct education and research in subject institutions such as professors, associate professors, lecturers, and assistant professors. NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Багшлахуй*<br><br>*Teaching*<br><br>*Преподавание* | bɨeesilaeeol | Суралцах үйл ажиллагааг дэмжихэд, багшлахуйн олон янзын арга хэлбэр байдаг. Үүнд, багш төвтэй, агуулгад чиглэсэн лекцийн арга голлох бөгөөд суралцагчид багшийн дамжуулсан мэдээллийг идэвхгүй хүлээн авагч болдог. Нөгөө талаас суралцагчдын өмнөх мэдлэгт тулгуурлан, суралцагч төвтэй хандлагыг ашиглан суралцах үйл явцад нь дэмжлэг үзүүлдэг. Түүнчлэн суралцагчдын танин мэдэхүйн болон суралцах үйл явцад хяналт тавьж оролцдог. | There are diverse approaches to teaching which also implicitly reflect the approach to learning. The didactic approach mainly entails lecturing and is typically teacher-centred and content-oriented, i.e. teaching as transmission where the learners are considered to be the passive recipients of information transmitted. Teaching can also be seen as supporting the process of learners' knowledge construction and understanding, building on what is already known by the learner and involving a learner- centred approach (i.e. teaching as facilitation). Another approach emphasizes the development of learners' cognitive processes and awareness and control of thinking and learning. (UNESCO, 2013) |
| *Байгууллага хоорондын жишиг үнэлгээ*<br><br>*Trans-institutional benchmarking*<br><br>*Транс-институциональный бенчмаркинг* | Jiziit foinelekit<br>bɨiigolol) T Hogoroed0 iia | Шинэ, бүтээлч үйл ажиллагааг эрэлхийлэн олон байгууллагуудыг харьцуулан жиших үйл явц. | Benchmarking that looks across multiple institutions in search of new and innovative practices. (UNESCO-CEPES, 2007) |

| | | | |
|---|---|---|---|
| *Байгууллагын аудит, хяналт*<br><br>*Institutional audit / institutional review*<br><br>*Аудит / Инспекция образовательного учреждения / организации* | kimelda biiigolol)T iia feoidiDA , | Чанарыг хангах, дээшлүүлэх, баталгаажуулах талаарх дүрэм, журам, стандартыг тухайн сургалтын байгууллага хэрхэн хангаж буйг мэргэжлийн шинжээч баримт нотолгоонд суурилан хянах үйл явц. | An evidence-based process carried out through peer review that investigates the procedures and the mechanisms by which an institution ensures its quality assurance and quality enhancement. (UNESCO-CEPES, 2007) |
| *Байгууллагын магадлан итгэмжлэл*<br><br>*Institutional accreditation*<br><br>*Аккредитация образовательного заведения / организации* | fidekimjiile& biiigolol)T iia Megeoelea | Аль нэг сургалтын хөтөлбөрийн чанарыг бус бүх хөтөлбөр, орчин нөхцөл, хэрэгжүүлж буй арга зүй зэргийг хамруулан байгууллагыг бүхэлд нь магадлан итгэмжлэх үйл ажиллагаа. | The terms refer to the accreditation of an entire institution, including all its programs, sites, and methods of delivery, without any implication to the quality of the study programs of the institution. (UNESCO-CEPES, 2007) |
| *Байгууллагын судалгаа*<br><br>*IR (institutional research)*<br><br>*Исследования организационного уровня* | biiigolol)T iia Sodol)T | Байгууллагын хаа талаарх мэдээллийг дүгнэн шинжлэх судалгаа, судлалын ажлыг хариуцсан дээд боловсролын байгууллагын дотоод үйл ажиллагаа эсвэл хэлтэс. Энэ үйл ажиллагаа буюу хэлтэс нь тухайн байгууллагын талаарх бүх мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийж, сайн төлөвлөгөө боловсруулах, бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад туслах үүрэгтэй. | (IR) is a function or department within a higher education institution responsible for the implementation of study and research analysis of information about the institution itself. This function/department gathers and analyzes all the institutional information and is available to assist with the effective design of plans, formulation of policy, and decision-making. The function/ department also |

| | | | |
|---|---|---|---|
| | | Дотоод болон гадаад оролцогч талуудыг тухайн байгууллагын талаарх шаардлагатай мэдээллээр хангах үүргийг мөн хүлээнэ. | takes responsibility for providing any necessary information about the institution, either internally or externally. (NIAD-QE, 2016) |
| *Байгууллагын үнэлгээ*<br><br>*Institutional evaluation*<br><br>*Оценка образовательного заведения / организации* | b:iigolol)T iia foinelek:t | Байгууллагын үр өгөөжийг шинжилж, байгууллагыг бүхэлд нь дүгнэх үнэлгээ. | Evaluation of an institution as a whole, analyzing the effectiveness of the institution. (NIAD-QE, 2016) |
| *Бакалаврын зэрэг*<br><br>*Bachelor degree*<br><br>*Степень бакалавра* | b:\:lew* oa Jerk:t | Дээд боловсролын анхан шатны боловсролын зэрэг (мэргэшил). Энэхүү зэргийг эзэмшихийн тулд гурваас дөрвөн жил (анагаах ухаан зэрэг зарим салбарт илүү олон жил) суралцах шаардлагатай. | A bachelor degree is the first-level higher education award, usually requiring three or four years' study but more in some medical subjects. (INQAAHE, 2017) |
| *Бакалаврын хөтөлбөр*<br><br>*Undergraduate program*<br><br>*Образовательная программа бакалавриата* | b:\:lew* oa KidolBrl | Бакалаврын зэрэг олгохоод чиглэсэн, ихэнхдээ дөрвөн жилийн (анагаах ухаан, мал эмнэлгийн чиглэлийн хөтөлбөрүүд 6 жил гэх мэт) хугацаанд хэрэгжих сургалтын хөтөлбөр. | A four-year curriculum (six years for medicine, veterinary medicine, dentistry and certain parts in pharmacy) in a faculty. Graduates are awarded a Bachelor's Degree. (NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Баримт бичгийн шинжилгээ*<br><br>*Document analysis*<br><br>*Анализ документов* | bi:rimda bicit oa Siejilekit | Магадлан итгэмжлэх байгууллагаас томилогдсон шинжээчийн ажлын хэсэг тухайн сургуулийн өөрийн үнэлгээний тайлан болон дагалдах мэдээллийг хянан үзэж, шинжилгээ хийх үйл явц. | A process in certified evaluation and accreditation and in national university corporation evaluation. Evaluation units established by the evaluation and accreditation organization examine and analyze the condition of the institution being evaluated based on self-assessment reports and the data on which they are based. (NIAD-QE, 2016) |
| *Баримт нотолгоо хэрэглэх соёл*<br><br>*Culture of evidence*<br><br>*Культура доказывания* | bi:rimda Nodele) T kirek;eK Soyo& | Байгууллагын чанарын соёлын соёлын хувьд баримт нотолгоо хэрэглэх соёл нь дээд боловсролын сургалтын байгууллагад төлөвшсөн сэтгэлгээ бөгөөд ёс зүйн үнэт зүйл, зарчим, холбогдох дүрэмд үндэслэнэ. Ингэхдээ байгууллагын төлөвлөлт шийдвэр гаргалт, сургалтын чанарыг тодорхойлох гэх мэт чиглэлд ахиц дэвшил гарч буй эсэхийг баталгаажуулах, улмаар суралцахуйн болоод багшлахуйн үр дүнг сайжруулах зорилгоор өөрийн үнэлгээ хийнэ. Ингэснээр багшлах бүрэлдэхүүн, сургалтын ажилтнуудыг | As it relates to institutional quality culture, the culture of evidence is a mindset acquired in a higher education institution and based on clear ethical values, principles, and rules, which consists of the self- evaluation of its learning outcomes, engaging the teaching staff and the academic administration in a thoughtful, regular collection, selection, and use of relevant institutional performance indicators, in order to inform and prove, whenever (and to whomever) necessary, that it is doing well |

| | | | |
|---|---|---|---|
| | | оролцуулан мэдээллийг тогтмол, цуглуулж, сургалтын байгууллагын гүйцэтгэлтэй холбоотой үзүүлэлтийг сонгон шинжилж, холбогдох хүмүүст мэдээлдэг юм. | in specific areas (e.g. institutional planning, decision-making, quality, etc.) and for the purpose of improving its learning and teaching outcomes. (UNESCO-CEPES, 2007) |
| *Баталгаажилт*<br><br>*Verification*<br><br>*Верификация* | b;dolegej ilda | Чанарын баталгаажуулалтын байгууллагын хийсэн хөндлөнгийн үнэлгээний дараа тухайн үнэлгээний үр өгөөж, нийцтэй байдалд дүгнэлт хийх үйл явц. | The process to judge the effectiveness and appropriateness of a QA agency's evaluation activities after their implementation. (NIAD-QE, 2016) |
| *Баталгаажуулалт*<br><br>*Assurance*<br><br>*Обеспечение* | b;dolegej igololda | Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь сургалт, судалгааны үйл ажиллагаа (орц – явц - гарц) наад захын шалгуурыг хангаж байгааг эрх бүхий байгууллага баталгаажуулах үйл явц. | Assurance of quality in higher education is a process of establishing stakeholder confidence that provision (input, process and outcomes) fulfills expectations or measures up to threshold minimum requirements. (INQAAHE, 2017) |
| *Блумын таксономи*<br><br>*Bloom's taxonomy*<br><br>*Таксономия Блума* | b;oi^ oa De\sonoml | Блумын таксономиор сургалтын үндсэн гурван тулгуур нь танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, мэдрэх хөдөлгөөн юм. Сэтгэл хөдлөл нь баярлах, хамгаалах, хүндэтгэх, дэмжих зэрэг сэтгэл хөдлөл, хандлага, хүндэтгэл, үнэ цэнэтэй хамааралтай. Мэдрэх хөдөлгөөнд сургалтын | The taxonomy comprises three learning domains — cognitive, affective and psychomotor. The affective domain relates to emotions, attitudes, appreciations, and values, such as enjoying, conserving, respecting, and supporting. The psychomotor domain refers to the motor-skills |

танин мэдэхүйн үйл явц болон мэдрэх хөдөлгөөн, зан төлөвийн хоорондын ур чадвар хамаарна. Танин мэдэхүйд мэдлэгийг сэргээх, хүлээн зөвшөөрөх, оюуны чадварыг хөгжүүлэх зэрэг багтана. Блумын шинэчилсэн таксономи 6 ангилалтай байх ба танин мэдэхүйн үйлүүд нь: санах (сэргээх, таних, холбогдох мэдээллийг эргэн санах), ойлгох (утгыг буулган ойлгох, жишээ татах, ангилах, дүгнэх, бодож тунгаах, харьцуулах, тайлбарлах), ашиглах (дүрэм журмыг хэрэглэх эсвэл хэрэгжүүлэх), дүн шинжилгээ хийх (ялгах, зохион байгуулах, ойлгох эсвэл хамаарлыг олж тогтоох зорилгоор мэдээллийг хэсэг болгон хуваах), үнэлэх (шалгах, нарийвчлах замаар шалгуур, стандартын дагуу үнэлэлт, дүгнэлт өгөх), бүтээх (жижиг хэсгүүдийг бүхэл болгон нэгтгэх, шинэ санаа, бүтээгдэхүүн эсвэл аливаа зүйлийг таньж мэдэх арга замыг олох) зэрэг болно. Дүн шинжилгээ хийх,

or behavioural skills that constitute the relationship between the cognitive process and physical movement in education. The cognitive domain is described as the recall or recognition of knowledge and the development of intellectual abilities and skills. In the revised Bloom's taxonomy the six categories and cognitive processes are: remembering (retrieving, recognizing, and recalling relevant knowledge); understanding (constructing meaning through interpreting, exemplifying, classifying, summarizing, inferring, comparing, and explaining); applying (carrying out or using a procedure through executing, or implementing); analysing (breaking information into parts to explore understanding and relationships through differentiating, organizing, and attributing) evaluating (making judgements based on criteria and standards through checking and critiquing); and creating (putting

| | | | |
|---|---|---|---|
| | | үнэлэх, бүтээх гэсэн танин мэдэхүйн үйлүүд нь сэтгэхүйн дээд түвшинд хамааралтай. Блумын таксономийн шинэчилсэн өөр хувилбарууд ч байдаг. | elements; together to form a coherent or functional whole; generating new ideas, products or ways of viewing things). Higher-order thinking refers to the cognitive processes of analysing, evaluating and creating. There are also other revised versions of the Bloom’s taxonomy. (UNESCO, 2013) |
| *Бодит суралцахуй*<br><br>*Authentic learning*<br><br>*Аутентичное обучение* | BdedO SorolCeeol | Бодит ахуй, амьдралд хэрэгцээтэй мэдлэг, ур чадвар олгох сургалт. Бодит сургалтаар багаар ажиллах, асуудал шийдвэрлэх, төсөлт ажил гүйцэтгэх, зохион байгуулах, ач холбогдлоор нь эрэмбэлэх зэрэг чадваруудыг эзэмшүүлдэг. Ажилд орохоосоо өмнө тухайн ажлын байранд юу хийх ёстойгоо мэддэг, чаддаг байх шаардлагатай. | Learning related to real-life or “authentic” situations – the kinds of problems faced by citizens, consumers, or professionals. Authentic learning situations require teamwork, problem-solving skills, and the ability to organize and prioritize the tasks needed to complete the project. Learners should know what is expected before beginning their work. (UNESCO, 2013) |
| *Бодит үнэлгээ (дүгнэлт)*<br><br>*Authentic assessment*<br><br>*Аутентичное оценивание* | BdedO foinelekit :doiekneIda" | Суралцагчийн гүйцэтгэлийг амьдралд ойр, бодит нөхцөл байдалтай холбон үнэлэх үйл ажиллагаа. Үнэлгээг бодитой болгох нэг арга бол суралцагчид сурсан зүйлээ үнэлүүлэхдээ даалгавраа өөрсдөө сонгох явдал юм. | Assessment of learner performance that is as closely related to a real life situation as possible and is not artificial or contrived. One way to make an assessment more authentic is to have learners choose the particular task they will use to demonstrate |

| | | | |
|---|---|---|---|
| | | Олон талын эх сурвалжаас, ялангуяа шалгуулагчаас мэдээлэл цуглуулах нь бодит үнэлгээ болдог. Портфель, хянах хуудас, ажлын даалгавар, журнал, бүтээгдэхүүн, сорил, ажиглалт зэрэг үнэлгээний аргаар суралцагч сургалтын хөтөлбөрт заасан чадамжуудыг эзэмшсэн эсэхийг үнэлэх боломжтой. “Гүйцэтгэлийн үнэлгээ”-г харна уу. | what they have learned. Authentic assessment involves the collection of information from a rich range of sources, including, importantly, the individual. Portfolios, checklists, work samples, diaries, permanent products, pencil-and-paper tests, observations and other forms of assessment may shed light on what the learner knows or is able to demonstrate, and the direction(s) required in one’s learning programme. Related terms: “Performance assessment”. (UNESCO, 2013) |
| *Бодлогын шинжилгээ*<br><br>*Policy analysis*<br><br>*Анализ политики* | Bdol)T iia Siejjilekt | Нийгмийн шинжлэх ухааны холбогдох салбарын онол, арга зүйг ашиглан одоогийн эсвэл хувилбарт бодлогын мөн чанар, үндэслэл, өртөг, үр нөлөө, үр өгөөж, ач холбогдлын талаарх системтэй судалгаа. | Systematic study of the nature, rationale, cost, impact, effectiveness, implications, etc., of existing or alternative policies, using the theories and methodologies of relevant social science disciplines. (Noori, 2018) |
| *Боловсрол*<br><br>*Education*<br><br>*Образование* | Blbsore& | Хүн төрөлхтний хөгжлийн талаар хуримтлагдсан мэдлэг, чадвар, хандлага, үнэт зүйл, чадамжийг дараагийн үедээ дамжуулах үйл явц, түүний үр дүн. Энэ нь суралцахуйд чиглэсэн харилцаанд хамаарна. | A process of transferring intentionally socially accumulated information, knowledge, perceptions, attitudes, values, skills, competencies and behaviors to generations. This includes learning focused communication. (UNESCO, ISCED, 2011) |

| | | | |
|---|---|---|---|
| *Боловсролын үр ашиг*<br><br>*Educational efficiency*<br><br>*Продуктивность образования* | Blbisore& oa foi*T fesi( | Нөөц, хүчин чармайлт, цаг хугацаа, хөрөнгийг хамгийн бага хэмжээгээр ашиглан амжилттай ажиллах, үр дүнд хүрэх чадвар. (ЮНЕСКО, 2007). Үр ашиг нь гадаад, дотоод үр ашиг хэлбэртэй. Гадаад үр ашиг: хөрөнгө оруулалт (цалин хөлс, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, ашиглалтын зардал г.м.) болон суралцагч, нийгэмд үзүүлж буй үр өгөөж (хөдөлмөр эрхлэлт, орлого, эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмэр, бүтээмж г.м.) хоорондын харилцан хамаарал. Дотоод үр ашиг: Боловсролын нөөцийн ашиглалт болон үр дүн хоорондын харилцан хамаарал. Үүнийг боломжит нөөцөө хамгийн үр дүнтэйгээр ашиглаж байгаагаар тайлбарлана. | An ability to perform well or to achieve a result without waste of resources, effort, time, or funds (using the smallest quantity of resources possible). (UNESCO-CEPES, 2007). Efficiency can be two typer: External efficiency and internal efficiency. External efficiency: The relationship between the resources invested (e.g., personnel salary, equipment, maintenance and other operating expenses) and the resulting benefits accruing later to the learners and the society (e.g. employment, earnings, productivity and contribution to economic growth). Internal efficiency: The relationship between utilization of educational resources and results. This is explained as optimal (best) use of the available resources for maximum results. , (VETP-1, 2018) |
| *Боловсролын агуулга*<br><br>*Educational content*<br><br>*Содержание образования / Образовательный контент* | Blbisore& oa fegol)T | Боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, чадамж, төлөвшлийн цогц. | A set of knowledge, skills, competence and formation necessary to be obtained at specific level of education. (The Law of Mongolia on Education, 2002) |

| | | | |
|---|---|---|---|
| *Боловсролын зэрэг*<br><br>*Academic degree*<br><br>*Академическая степень / учёная степень* | Blbisore& oa Jerkit | Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн суралцагчдад олгох зэрэг (мэргэшил). Бакалавр, магистр, доктор г. м. | A qualification conferred upon students who successfully complete academic programs of universities, graduate schools and junior colleges. Bachelor's, Master's, Doctoral Degrees etc., (ANQA, 2016) |
| *Боловсролын зэрэг, агуулгыг хүлээн зөвшөөрөх*<br><br>*Academic recognition*<br><br>*Академическое признание* | il Kiliyea JoibsiyereK Blbisore& oa Jerkit , fegol)T | Суралцагч, төгсөгчийн судалсан хичээл, эзэмшсэн мэргэшил, диплом, гэрчилгээг бусад дээд боловсролын сургалтын байгууллага хүлээн зөвшөөрөх. | Approval of courses, qualifications, or diplomas from one higher education institution by another for the purpose of student admission to further studies. (UNESCO-CEPES, 2007) |
| *Боловсролын нээлттэй эх материал*<br><br>*Open Educational Resources (OERs)*<br><br>*Открытые образовательные ресурсы* | Blbisore& oa NekiKilda Del fkit MeDwriye& | Боловсролын нээлттэй эх нөөц гэдэгт ерөнхийдөө онлайн сургалтын материалууд ордог ба эдгээр материалуудыг үнэ төлбөргүйгээр авч хэрэглэх, дахин ашиглах, сайжруулах, өөрчлөлт хийх, бусдад түгээх боломжтой байдаг. 2012 оны Парисын Боловсролын Нээлттэй Эх Нөөцийн Тунхаглалд: боловсролын нээлттэй эх нөөц гэдэг нь олон нийтийн домэйнд байршуулсан үнэ төлбөргүйгээр хандаж болох, нээлттэй эсхүл | Open educational resources (OER) are generally described as online learning materials that can be Retained, Reused, Revised, Remixed and Redistributed for free (5Rs). One of the most internationally recognised definitions is contained in the 2012 Paris OER Declaration: OER are teaching, learning and research materials in any medium, digital or otherwise, that reside in the public domain or have been released under an open license |

| | | | |
|---|---|---|---|
| | | зарим хязгаартайгаар хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан ашиглах, бусдад түгээх зөвшөөрөлтэй цахим эсхүл бусад хэлбэрийн багшлахуйн, суралцахуйн болон судалгааны материалууд юм гэж тодорхойлсон нь дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгджээ. Нээлттэй эх нөөцийн зөвшөөрөл нь олон улсын холбогдох конвенц, зохиогчийн эрхийн дагуух одоо мөрдөгдөж буй оюуны өмчийн эрхийн хүрээнд зохицуулагдана. | that permits no-cost access, use, adaptation and redistribution by others with no or limited restrictions. Open licensing is built within the existing framework of intellectual property rights as defined by relevant international conventions and respects the authorship of the work. (ЮНЕСКО, 2012) |
| *Боловсролын олон улсын стандарт ангилал (БОУСА)*<br><br>*International Standard Classification of Education (ISCED)*<br><br>*Международная стандартная классификация образования (МСКО)* | BIbsore& oa folea folo_ oa SDenderDA fehkuIe&<br>:B, fo, fo, S, fe" | Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ангиллын дагуу боловсролын үйл ажиллагаар эрэмбэлэх, багцлах үйл явц. Боловсролын түвшин, боловсролын чиглэл гэсэн гол хоёр үзүүлэлтийг ашиглан хөтөлбөрийг агуулгаар нь ангилдаг. БОУСА-ийн үндсэн үзэл баримтлал болон тодорхойлолтууд нь олон төрлийн боловсролын тогтолцоог олон улсад хүчин төгөлдөр, цогц байлгахыг зорьдог. | ISCED is a framework to classify educational activities as defined in programmes and the resulting qualifications into internationally agreed categories. It classifies education programmes by their content using two main variables: levels of education and fields of education. The basic concepts and definitions of ISCED are intended to be internationally valid and comprehensive of the full range of education systems. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Боловсролын салбарын мэдээллийн систем*<br><br>*Education information system*<br><br>*Информационная система в образовании* | BIbisorel& oa SelBrI iia Medekilel& oa SisDw^ | Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, сургалтын орчин, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн мэдээллийг бүртгэх, тайлан, мэдээ боловсруулах, хяналт тавих зориулалт бүхий программ хангамж, сүлжээний дэд бүтэц болон техник хангамжийн нэгдэл. | Software, network infrastructure and hardware for registration, reporting, data processing and controlling institutions of all levels, learning environment, training processes, human resources and learners' information. (The Law on Teacher's Development, 2018) |
| *Боловсролын стандарт*<br><br>*Educational standards*<br><br>*Образовательный стандарт* | BIbisorel& oa SDenderDA | Орц, үйл явц, гарц зэрэг үе шатуудын харилцан хамаарал болон сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлага болон нөхцөлийг заасан түвшин. Боловсролын стандарт нь сургалтын нөөц материал, хөтөлбөр, үр дүн, суралцагчийн сурлагын амжилт зэргийг хамарсан (агуулгын стандарт, гүйцэтгэлийн стандарт, чадварын стандарт, суралцахуйн боломжийн стандарт) хэд хэдэн төрөлтэй. | Level of requirements and conditions regarding different stages of the educational process and the relationship between those stages, such as inputs, processes, and outputs. Various types of educational standards exist with regard to learning resources, programs, and results, in general, and student performance (content standards, performance standards, proficiency standards, and opportunity-to-learn standards). (UNESCO-CEPES, 2007) |

*Боловсролын түвшин*

*Levels of education*

*Уровень образования*

Blbisore& oa Doibsia

Боловсролын олон улсын стандарт ангилал (БОУСА)-ын хүрээнд боловсролын түвшин болон хөтөлбөрийн хүрээнд олгох мэдлэг, ур чадвар, чадамжаас хамаарч хөтөлбөрүүдийг бүлэглэх замаар боловсролыг хэд хэд түвшинд ангилдаг. Энэхүү ангилал нь боловсролын хөтөлбөрийг дэс дараалалтай ангиллаар бүлэглэх боломжтой гэсэн байр сууринд үндэслэн бий болсон. БОУСА 2011 ангилал нь боловсролын есөн түвшинг агуулдаг. Үүнд: сургуулийн өмнөх боловсрол (0 түвшин); бага боловсрол (түвшин 1); суурь боловсролын доод (түвшин 2); суурь боловсролын дээд (3-р түвшний); суурь боловсролын дараах дээд (4-р түвшин); богино хугацааны дээд боловсрол (5-р түвшин); бакалавр, түүнтэй адилтгах түвшин (6 дугаар түвшин); мастер, түүнтэй адилтгах түвшин (түвшин 7); доктор, түүнтэй адилтгах түвшин (түвшин 8).

Within the framework of the International Standard Classification of Education (ISCED), levels of education are an ordered set of categories, intended to group educational programmes in relation to gradations of learning experiences and the knowledge, skills and competencies which each programme is designed to impart. Levels of education are therefore a construct based on the assumption that education programmes can be grouped into an ordered series of categories. The ISCED 2011 classification consists of nine levels of education, namely: early childhood education (level 0); primary education (level 1); lower secondary education (level 2); upper secondary education (level 3); postsecondary non-tertiary education (level 4); short-cycle tertiary education (level 5); bachelor’s or equivalent level (level 6); master’s or equivalent level (level 7); doctor or equivalent level (level 8). (UNESCO, 2013)

| | | | |
|---|---|---|---|
| *Боловсролын үр өгөөж*<br><br>*Educational effectiveness*<br><br>*Эффективность образования* | Blbisorel oa foi*T foihKkij l | Сургалтын байгууллага дэвшүүлсэн зорилго, зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг шинжлэн дүгнэсэн чанарын үзүүлэлт. | An output of specific analyses that measure (the quality of) the achievement of a specific educational goal or the degree to which a higher education institution can be expected to achieve specific requirements. (UNESCO-CEPES, 2007) |
| *Болоны тунхаглал*<br><br>*Bologna declaration*<br><br>*Болонская декларация* | Bloa O DoeKieeele | 1999 онд Европын 29 улс орнуудын Боловсролын сайд нар олон улсын хамтран ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Болоны тунхаглалд гарын үсэг зурсан. Энэ нь Болоны үйл явцын үндсийг тавьж Европын дээд боловсролын орон зайг хөгжүүлэхийн тулд ойрын ирээдүйн дараах үндсэн зорилгыг тунхагласан. Үүнд: 2 шатлалтай бүтэц болон тодорхой харьцуулж болохуйц зэргийн хөтөлбөрийг нэвтрүүлэх; БОУСА-тай адил багц цаг шилжүүлэн, тооцох нэгдмэл тогтолцоог хүлээн зөвшөөрөх; шилжилт хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжих; Европын дээд боловсролыг өргөжүүлэн тэлэх, чанарын баталгаажуулалтын салбарт европын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг юм. | It is the Declaration on the international cooperation in the higher education signed by Ministers of Education of 29 European countries in 1999 in Bologna which laid the foundation for Bologna Process and proclaimed on the near-term outlook the following main objectives for the European space of the higher education: introduction of precisely certain and comparable degrees and also two-stage structure; acceptance of a system of the credits, similar ECTS system; stimulation of mobility; development of the European cooperation in quality control and expansion of the European aspects of the higher education. (Bologna Process, 2009) |

| | | | |
|---|---|---|---|
| *Болоны үйл явц*<br><br>*Bologna process*<br><br>*Болонский процесс* | Bloa 0 foiila YeBca | Европын улс орнуудын хооронд дээд боловсролын боловсролын стандарт, чанарыг харьцуулах боломжийг хангах зорилготой сайд нарын уулзалт, зөвшилцлийн үйл явц. Энэ үйл явц нь Лисбоны гэрээний дагуу Европын дээд боловсролын орон зайг бий болгосон бөгөөд Европын зөвлөлийн соёлын конвенцын орнуудад нээлттэй болгож Засгийн газар хоорондын хурал 2001 (Прага), 2003 (Берлин), 2005 (Берген), 2007 (Лондон), 2009 онуудад (Левен) тус тус зохион байгуулагдсан. | The Bologna Process is a series of ministerial meetings and agreements between European countries to ensure comparability in the standards and quality of higher-education qualifications. The process has created the European Higher Education Area under the Lisbon Recognition Convention. The process was opened to other countries in the European Cultural Convention of the Council of Europe, and governmental meetings have been held in Prague (2001), Berlin (2003), Bergen (2005), London (2007) and Leuven (2009). (Wiki, 2019) |
| *Босго*<br><br>*Threshold*<br><br>*Порог* | Bzo)T | Оюутны эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хөтөлбөрийн агуулга эсвэл мэргэшил, зэрэгт тавигдах хамгийн доод түвшний шалгуур. | The minimum expectations of student performance for the achievement of, or of program content for, a particular qualification or award. (INQAAHE, 2017) |
| *Брейнсторминг*<br><br>*Brainstorming*<br><br>*Брейнсторминг, мозговой штурм* | brwiinsDormieit | Тодорхой асуудлыг бүтээлчээр хэлэлцэх, шийдвэрлэх зорилго бүхий бүлгийн бүтээлч байдлыг нэмэгдүүлэх арга. | Brainstorming is a group creativity technique by which efforts are made to find a conclusion for a specific problem by gathering a list |

| | | | |
|---|---|---|---|
| | | Өөрөөр хэлбэл, тодорхой үйл ажиллагаа, сонирхлын хүрээний шинэ санаа, шийдлийг бий болгохын тулд хэсэг бүлэг хүмүүс санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг орчин гэж хэлж болно. Энд хүмүүс чөлөөтэй сэтгэн бодож, тухайн асуудлын талаарх боломжит шинэ санаанууд бий болгох бөгөөд эцэст нь тэдгээрт үнэлгээ хийж, шийдлийн хувилбарыг боловсруулдаг. | of ideas spontaneously contributed by its members. In other words, brainstorming is a situation where a group of people meet to generate new ideas and solutions around a specific domain of interest by removing inhibitions. People are able to think more freely and they suggest many spontaneous new ideas as possible. All the ideas are noted down and those ideas are not criticized and after brainstorming session the ideas are evaluated. Source: https://en.wikipedia.org/ |
| *Буцалтгүй тусламж*<br><br>*Grant*<br><br>*Грант* | Bcelda foikil Doselemj l | Иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгө. | A sum of money given by a government or other organization for a particular purpose. (The Law of Mongolia on Science and Technology, 2006) |
| *Бүрэлдэхүүн сургуулийн захирал*<br><br>*Dean*<br><br>*Декан / директор* | iia Jekuro&<br>BirildoKa Sorgegoll | Их сургуулийн бүрэлдэхүүн эсвэл салбар сургуулийг ерөнхийлөн удирдах эрх бүхий албан тушаалтан. | Director or highest authority within a certain professional school or college of a university. (NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Бүрэлдэхүүн сургууль*<br><br>*Faculty*<br><br>*Факультет* | BirildoKa Sorgegoll | Их сургуулийн сургалт, судалгааны чиг үүрэг бүхий бүтцийн үндсэн нэгж. Тэнхимүүдтэй байж болно. Түүнчлэн их сургуулийн хүрээнд бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг сургалт, судалгааны багш, ажилтантай байна. | A basic organizational unit of a university, for conducting education and research, to which students and academic staff belong. It is composed of departments. It may also indicate a basic unit that offers undergraduate programs in a university, or a group of staff for education and research. (NIAD-QE, 2016) |
| *Бүс нутгийн магадлан итгэмжлэл*<br><br>*Regional Accreditation*<br><br>*Региональная аккредитация* | Bisa Nodo( oa Megeoelea fidekEmjile& | Дээд боловсролын сургалтын байгууллагыг тодорхой газар зүйн бүс нутгаар (ихэвчлэн гурван ба түүнээс дээш улс, муж) бүсчлэн магадлан итгэмжлэх үйл ажиллагаа. Тухайлбал, АНУ нь бүс нутгийн зургаан магадлан итгэмжлэх комисстой. | Accreditation granted to a higher education institution by a recognized accrediting association or commission that conducts accreditation procedures in a particular geographic area (usually that of three or more states). The United States has six regional accrediting commissions. (UNESCO-CEPES, 2007) |
| *Бүтцийн сургууль*<br><br>*Structural school/ branch school*<br><br>*Структурное подразделение/ Филиал* | Bidoca iia Sorgegoll | Их, дээд сургуулийн байнгын үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн дагнасан үйл ажиллагаа явуулдаг сургууль юм. | A school which carries out specialized activities within permanent activities of universities and institutes. Source: (MECSS, 2007) |

| | | | |
|---|---|---|---|
| *Бүтээгдэхүүний загвар*<br><br>*Product design*<br><br>*Продуктовый дизайн* | BidokikdeKa 0 JeeeB* | Бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдэл. | Product design is an innovative and unique solution that incorporates a decoration, color and color combination to the product outline and design. (The Law of Mongolia on Patent, 2006) |
| *Бүтээлийн сангийн үнэлгээ*<br><br>*Portfolio assessment*<br><br>*Оценивание на основе предоставленного портфолио* | Bidok& oa Seeit oa foinelekit | Системтэйгээр гүйцэтгэсэн ажил, бүтээлийн санг (бичгээр гүйцэтгэсэн даалгавар, баримт бичгийн төсөл, бүтээл, илтгэл гэх зэрэг) үндэслэн суралцагчийн чадамж, сургалтын ахицыг үнэлэх хэлбэр. Гаргасан загвар, бүтээл, гүйцэтгэсэн ажлаас гадна бүтээлийн санд суралцагчдын бэлтгэсэн тайлан, мэдээ багтсан байдаг. Сургалтын үр дүнг стандарттай харьцуулах зорилгоор суралцагчдын амжилтын нотолгоо болгож бүтээлийн санд үнэлгээ хийдэг. | Assessment based on the systematic collection of learner work (such as written assignments, drafts, artwork, and presentations) that represents competencies, exemplary work, or the learner's developmental progress. In addition to examples of their work, most portfolios include reflective statements prepared by learners. Portfolios are assessed for evidence of learner achievement with respect to established learning outcomes and standards. (UNESCO, 2013) |
| *Бүтээлийн хуулбарлалт*<br><br>*Plagiarism*<br><br>*Плагиат* | Bidok& oa HegolBrilelda | Хэн нэгний бүтээл, бүтээлийн хэсэг, зохиогчийн эрхэд хамаарах зүйлийг нэг буюу түүнээс дээш тоогоор шууд буюу шууд бусаар, ямар нэг арга, хэлбэрээр хуулбарласан хууль бус үйлдэл. | Plagiarism is an act of to reproduce copyrighted objects one or more copies, directly or indirectly, by any methods or forms which are related to someone else's work, part of the work or copyright. (The Law of Mongolia on Copyright and related rights, 2006) |

| | | | |
|---|---|---|---|
| *Бүтээлийн чөлөө*<br><br>*Sabbatical*<br><br>*Творческий отпуск* | Bidokᡥ oa Cilokit | Мэргэшлийн ур чадварыг нь дээшлүүлэх үүднээс тодорхой хугацаанд өөр сургалтын байгууллагад сургалт, судалгааны ажилд төвлөрөн ажиллах боломж олгох зорилгоор багшлах бүрэлдэхүүний гишүүнийг үүрэгт ажлаас нь түр чөлөөлөх тогтолцоо. | A system that allows academic staff to be exempted from their management duties and to focus entirely on education and research at a different institution for a certain period, in order to improve their abilities in their field of specialization. (NIAD-QE, 2016) |
| *Бүтээлч байдал, бүтээлч сэтгэлгээ*<br><br>*Creativity, creative thinking*<br><br>*Креативность, креативное мышление* | Bidokicl biidᡥ, Bidokicl Seoekᡥkit | Тодорхой зорилготойгоор шинэлэг бүтээл, бүтээгдэхүүн, үйл ажиллагааг санаачлах, бий болгох, хэрэгжүүлэхтэй холбоотой бие хүний төрөлхийн өгөгдөл болон олдмол авьяас, чадвартай байх харьцангуй тогтвортой шинж. Уламжлалт хандлагаар бүтээлч байдлыг шинэ чиг хандлага, бүтээгдэхүүн гаргах хэрэгцээнд нийцүүлэн хариу үйлдэл үзүүлэх чадвар гэж үзсээр ирсэн. Сүүлийн жилүүдэд бүтээлч байдлын талаарх үзэл санаа өөрчлөгдсөөр байна. Өдөр тутам болон нийгмийн бүтээлч байдлын талаар зарим салбарт (дүрслэх урлаг дэвшилтэт шинжлэх ухаан гэх зэрэг), хувь хүний гоц авьяасаас өдөр тутмын амьдрал дахь | Traditionally creativity has been seen as an ability to respond adaptively to the needs for new approaches and new products. It is often defined as the ability to bring something new into existence purposefully. The concept of creativity has expanded and changed in recent years. A new emphasis on 'everyday' and 'social' creativity is shifting the focus from individual genius in some fields (e.g. fine arts, advanced science) to collaborative creativity in everyday life, with new implications for learning and education. In order to produce a stable aptitude in learners to think and behave creatively, it is generally recommended to: |

хамтын бүтээлч байдалд шилжиж байгааг онцолж байна. Суралцагчийн бүтээлч сэтгэлгээ хандлагыг тогтвортой хөгжүүлэхэд дараах зүйлийг санал болгодог. Үүнд: А. Тодорхой нөхцөл байдалд эсвэл бүтээлч үйл ажиллагааны тодорхой үе шатанд үүрэг гүйцэтгэх оюун ухааны янз бүрийн үйлдлээс бүрдсэн нэгдмэл бүтцийг бий болгох; Б. Сургалтын үйл ажиллагаагаар шийдвэрлэх асуудал болон бодит нөхцөл байдлын хоорондын хамаарлыг ойлгоход суралцагчдад туслах; В. Бүтээлч сэтгэхүйн талаарх хувь хүний өөрийн итгэл үнэмшил, хандлагыг харгалзан үзэж сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх, улмаар хувь хүний итгэл үнэмшил, хандлага, стратегийг зөв чиглүүлэн хөгжүүлэх; Г. Суралцагчийг зөвхөн бүтээлч хандлагад сургах биш, мөн гүйцэтгэлдээ хяналт тавих ухамсрыг хөгжүүлэх; Д. Хуучин арга барилаар хандахаас зайлсхийж,

(a) develop an integrated structure of various mental mechanisms, each playing a role in a particular kind of situation or in a particular phase of the creative process; (b) use materials that mimic real-life situations or, at least, help trainees to recognize the relationship between the training tasks and such situations; (c) consider individuals' spontaneous beliefs and tendencies toward creative thinking and start the teaching and learning process from their naïve creative competencies, with the hope of changing spontaneous beliefs, tendencies, and strategies by means of an internal restructuring process; (d) show a metacognitive sensibility, that is, train learners not only to execute creative strategies, but also to control their execution; and (e) encourage learners to accept the risks and discomforts that creativity involves, to avoid the tendency to stick to familiar responses and

| | | | |
|---|---|---|---|
| | | шинийг санаачлах хандлагыг хөгжүүлэхэд суралцагч эрсдэл болон бэрхшээлтэй тулгардаг явдлыг хүлээн зөвшөөрч, дэмжих зэрэг юм. | to induce learners to look for novelty. (UNESCO, 2013) |
| *Бүх нийтийн боловсрол (БНБ)*<br><br>*Education for All (EFA)*<br><br>*Образование для всех (ОДВ)* | BiK Neiida iia Blbisore& :Bi, Ne, B" | Олон улсын байгууллагууд 2015 он гэхэд бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн сургалтын хэрэгцээг хангах зорилгоор боловсролын 6 зорилтыг дэвшүүлсэн. Үүнд: (a) Бага насны, ялангуяа эмзэг, тусгай хэрэгцээт бүлгийн хүүхдийн цогц асаргаа, боловсролын үйлчилгээг өргөжүүлэх, сайжруулах; (b) хүүхэд бүрд, ялангуяа охид, хүнд нөхцөлд байгаа болон үндэстний цөөнхийн бүлгүүдэд чанартай, үнэ төлбөргүй бага боловсрол эзэмшүүлэн төгсгөх; (в) Залуучууд болон насанд хүрэгчдийг тохирсон сургалт болон амьдрах ухааны хөтөлбөрт тэгш хүртээмжтэй хамруулах; (г) насанд хүрэгчдийн, ялангуяа эмэгтэйчүүдийн суурь боловсролд хамруулан, бичиг үсгийн боловсролыг 50%-иар дээшлүүлэх, | International organizations identified six key education goals which aim to meet the learning needs of all children, youth and adults by 2015 (a) expand and improve comprehensive early childhood care and education, especially for the most vulnerable and disadvantaged children; (b) ensure that all children, particularly girls, those in difficult circumstances, and those belonging to ethnic minorities, have access to and complete, free and compulsory primary education of good quality; (c) ensure that the learning needs of all young people and adults are met through equitable access to appropriate learning and life-skills programmes; (d) achieve a 50% improvement in adult literacy, especially for women, and equitable access to basic |

B

| | | | |
|---|---|---|---|
| | | насан туршийн боловсролын үйл ажиллагаанд тэгш хамрагдах боломжоор хангах; (д) суурь болон дунд боловсролд охидыг чанартай, суурь боловсролд бүрэн, тэгш хамруулах замаар боловсрол дахь жендерийн тэгш байдлыг хангах; (е) боловсролын чанарыг бүхий л талаар сайжруулах, хүлээн зөвшөөрөгдсөн, хэмжигдэхүйц сургалтын үр дүнг, ялангуяа бичиг үсэг, тооны ухаанд суралцах болон амьдрах ухааны зайлшгүй чадваруудыг хүн бүрд эзэмшүүлэх зэрэг орно. | and continuing education for all adults; (e) eliminate gender disparities in primary and secondary education, and achieve gender equality in education, with a focus on ensuring girls' full and equal access to and achievement in basic education of good quality; and (f) improve all aspects of the quality of education and ensure the excellence of all so that recognized and measurable learning outcomes are achieved by all, especially in literacy, numeracy and essential life skills. (UNESCO, 2013) |
| **B** | | | |
| *Виртуал их сургууль*<br><br>*Virtual university*<br><br>*Виртуальный университет* | WirDoiw& Yekit Sorgegol l | Мэдээлэл, холбоо, харилцааны технологийг ашиглан онлайн сургалтын хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль. | The virtual university provides online learning courses featuring streaming audio and video, computer animations, email, newsgroups, chat rooms, bulletin boards, digital portfolios, and more. (Budikina, 2017) |

| Г | | | |
|---|---|---|---|
| *Гарааны бизнес*<br><br>*Start up Business*<br><br>*Стартап бизнес* | Gerogea 0 bu[inw_ | Тогтвортой байдлаар зарлагаасаа давсан орлого олох хараахан болоогүй, эсвэл хязгаарлагдмал хугацаанд үйл ажиллагаа эрхэлж байгаа шинэ бизнес гэж тодорхойлно. | A Start Up is defined as a new business that has yet to achieve a sustainable positive cash flow or has been in operation for a limited period of time. (VETP-1, 2018) |
| *Гарааны компани*<br><br>*Start up company*<br><br>*Стартап компания* | Gerogea 0 \|mpinl | Үйл ажиллагааныхаа эхний шатанд явж буй компани. Эдгээр нь бизнесийн үүсгэн байгуулагчдын санхүүгийн дэмжлэгтэйгээр эрэлт хэрэгцээтэй гэж үзсэн бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээг бий болгох зорилгоор хөрөнгө оруулалт хийгдэж үүсгэн байгуулагдсан компани. | A startup is a company that is in the first stage of its operations. These companies are often initially bankrolled by their entrepreneurial founders as they attempt to capitalize on developing a product or service for which they believe there is a demand. (The Law of Mongolia on Innovation, 2012) |
| *Гарц / үр дүн*<br><br>*Outputs*<br>*Промежуточный результат* | Gerca < foi*T doieit | Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтээгдэхүүн. Үүнд: Төгсөгч, судалгааны үр дүн, нийгмийн болон бизнесийн үйл ажиллагаа, дээд боловсролын сургалтын байгууллагын нийгмийн хариуцлага зэргийг хамааруулж үзнэ. | Outputs refers to the products of higher education institutions: including, graduates, research outcomes, community/business activities and the social critical function of academia. (INQAAHE, 2017) |

*Голч дүн*

*Grade point average (GPA)*

*Средний академический балл*

Goolcl doieit

Оюутны судалсан хичээл бүрээр дүгнэгдсэн нийт тоон үнэлгээг багц цагийн тоогоор нь үржүүлэн тооцож, дундаж оноонд суурилсан сурлагын амжилтыг бүртгэх тогтолцоо. Сургалтын байгууллагаас хөтөлбөр эхлэхээс өмнө суралцагчдад үнэлгээний шалгуурыг ойлгомжтойгоор танилцуулж, үнэлгээнд энэхүү шалгуурыг дагаж мөрдөнө. Голч дүнгийн тогтолцоо нь их сургуулиудын хувьд суралцагчийн үнэлгээг ил тод, бодитой үнэлэхэд ашиглагддаг академик үнэлгээний арга хэрэгсэл юм. Ихэнх голч дүнгийн механизмд багц цаг тус бүрээр оюутны амжилтыг А-ээс D эсвэл F хүртэлх 5 түвшинд, хамаарах оноог 4-ээс 0–ийн хооронд авч үзнэ. Нийт онооны дундаж нь оюутны голч дүн байх ба энэ нь сургууль төгсөх эсвэл тухайн хичээл, хөтөлбөрийг дүүргэхэд тавигдах шалгууруудын нэг болдог.

A system of recording academic achievement based on an average, calculated by multiplying the numerical grade received in each course by the number of credit hours studied. Institutions should present clear assessment criteria to students prior to the start of a program, and should follow the criteria throughout the assessment process to ensure its objectivity and accuracy. The Grade Point Average (GPA) system is one of the academic grading methods used in universities for objective and transparent student assessment. In the most common GPA mechanism, student achievement for each credit is ranked in five levels from: A to D and F (Failure), each given corresponding points from 4 to 0. The average of the total scores will be the student's GPA, and may be used as an element of graduation/completion requirements. (NIAD-QE, 2016)

| | | | |
|---|---|---|---|
| *Гуравдагч талын үнэлгээ*<br><br>*Third-party evaluation*<br><br>*Оценка третьей стороной* | foinelekit Gorbideecl De&T iia | Бие даасан, хараат бус байгууллагаар хийгдэх үнэлгээ. Ингэхдээ тухайн байгууллага нь шинжээч болон үнэлгээний шалгуурыг санал болгоно. Энэ нь хөндлөнгийн үнэлгээнээс ялгаатай. | Evaluation conducted entirely by independent bodies. They nominate the evaluators and the evaluation items. It is different from external evaluation. (NIAD-QE, 2016) |
| *Гүйцэтгэлийн стандарт*<br><br>*Performance standards*<br><br>*Стандарты выполнения* | Kiiceoek& oa SDenderDA | Гүйцэтгэлийн зохист, жишин үзэх түвшин. Агуулгын стандартыг ханган биелүүлэхэд оюутны ажлын чанарт тавигдах шаардлагын түвшнийг заасан тодорхойлолт. Гүйцэтгэлийн стандарт нь сургалтын хүрэх үр дүнг тодорхойлдог. | Levels of achievement that are deemed exemplary or appropriate, i.e. specifications of the required level of quality of a student's work to meet the content standards. Performance standards shape expectations for educational outcomes. Related terms: Criteria, Culture of Evidence, Indicators, Outcomes, Quality assurance. (UNESCO-CEPES, 2007) |
| *Гүйцэтгэлийн үзүүлэлт*<br><br>*Performance indicators*<br><br>*Индикаторы выполнения* | Kiiceoek& oa foijeKlolda | Дээд боловсролын сургалтын байгууллага эсвэл хэрэгжүүлж буй хөтөлбөр нь чанарын хэмжүүрт хэрхэн нийцэж байгааг илтгэх статистик хэмжигдэхүүн. Энэ нь системийн болон хөтөлбөрийн бүтээмж юм. Энэ нь үр дүнгийн богино хугацааны, үр өгөөжийн урт хугацааны хэмжүүрүүдийн тоон, чанарын үзүүлэлт болдог. | A range of statistical parameters representing a measure of the extent to which a higher education institution or a program is performing in a certain quality dimension. They are short term or long-term qualitative and quantitative measures of the output of a system or program. They allow institutions to benchmark their own performances |

Г

| | | | |
|---|---|---|---|
| | | Эдгээр үзүүлэлт нь тухайн байгууллагад өөрийн зорилтын биелэлтийг жишин үзэх буюу бусад дээд боловсролын сургалтын байгууллагатай харьцуулан харах боломжийг олгодог. | or allow comparison among higher education institutions. (UNESCO-CEPES, 2007) |
| *Гүйцэтгэлийн үнэлгээ*<br><br>*Performance assessment*<br><br>*Оценка выполнения* | Kiiceokiß oa foinelekit | Тодорхой үүрэг, даалгаврын гүйцэтгэлээр суралцагчид юу мэдэж байгаа, юу хийж чадаж байгааг хэмжих, үнэлэхэд чиглэгдсэн үнэлгээ. | Assessment that is designed to measure and judge what learners know and are able to do based on how they perform certain tasks. (UNESCO, 2013) |
| *Гүйцэтгэлийн шалгуур*<br><br>*Performance criteria*<br><br>*Критерии выполнения* | Kiiceokiß oa Silgegorl | Стандартын биелэлтийг үнэлэхэд хэрэглэх босго түвшин эсвэл жишиг. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь оноо (рубрик) эсвэл дүнгээр амжилтын шатлалыг илэрхийлэн, суралцагч юу мэдэх, ямар ур чадвар эзэмших ёстой тухайд хүлээсэн үр дүндээ хэрхэн хүрч байгааг харуулна. | Checkpoints or benchmarks that are used to judge the attainment of performance standards. For example, they indicate how well students meet expectations of what they should know and be able to do, as expressed by varying gradients of success by (scoring) rubrics or by grades. (UNESCO-CEPES, 2007) |
| *Гэрчилгээжүүлэлт*<br><br>*Certification*<br><br>*Сертификация/ Свидетельство* | kreciIekjiKlolda | Эрх бүхий байгууллага, мэргэжлийн холбооноос тухайн иргэнийг (суралцагч эсвэл багш) тогтоосон чанарын стандартыг хангасан болохыг нь хүлээн зөвшөөрч, албан ёсоор баримтжуулах, баталгаажуулах үйл явц. | The process by which an agency or an association acknowledges the achievement of established quality standards and usually grants certain privileges to the target individual (student or teacher). (UNESCO-CEPES, 2007) |

| Д | | | |
|---|---|---|---|
| *Давтан суралцагч*<br><br>*Repeater*<br><br>*Повторитель / Студент повторного обучения* | Debdea Sorolceecl | Боловсролын нэг түвшинд дахин суралцаж буй суралцагч. Эхний хөтөлбөрийг амжилттай дүүргэж, нэг түвшний боловсролын хоёрдох эсвэл дараа шатны хөтөлбөрт суралцаж буй оюутныг давтан суралцагч гэж үзэхгүй. Өмнөх хичээлийн жилийн хичээлийг давтан судлах явдал юм. | A repeater is a student who is enrolled in the same grade for a second or further time. Students who participate in a second or further education programme at the same level of education having successfully completed a first programme are not regarded as repeaters. A repeater is one who repeats predominantly the same subject matter as in a previous year. (UNESCO-UIS, OECD, EUROSTAT, 2018) |
| *Дагалдан сургалт*<br><br>*Apprenticeship*<br><br>*Ученичество* | Degeldoa Sorgelda | Албан ба албан бус боловсролын хүрээнд хууль журмын дагуу хэрэгжүүлж, ажлын байран дээр сургах, дадлагажуулах тогтолцоо. Дагалдан суралцагч нь ажил олгогчтой гэрээ байгуулж, урамшуулал (цалин, хөлс) авч болно. Түүнчлэн ажил олгогч нь суралцагчийг сургалтын дараа тодорхой ажлын байраар хангах үүрэг хүлээж болно. Дагалдан сургалт нь бүтэн цагийн, хагас цагийн эсвэл сургууль дээр суурилсан хэлбэртэй байж болно. | A system of training in both formal and non-formal education regulated by law or custom which combines on-the-job training and work experience while in paid employment with formal off-the-job training. The apprentice may enter into a contract of training or training agreement with an employer who imposes mutual obligations on both parties. The employer may have obligations to provide the workplace the after training. (UNESCO, 2013) |

Д

| | | | |
|---|---|---|---|
| *Дадлагажих сургалт*<br>*Field study / Internship program*<br>*Практический опыт* | Dedolgejiee0 Sorgelda | Сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд танхимын болон лабораторийн хичээлээс гадуур зохион байгуулж буй дадлагажуулах сургалтын үйл ажиллагаа. | Practical classes conducted out of classrooms or laboratories for increasing the effectiveness of education, such as field research. (NIAD-QE, 2016) |
| *Даяаршил*<br>*Globalization*<br>*Глобализация* | Deyegersi& | Хүмүүс, байгууллагын харилцан ажиллагаа, нэгдэл, харилцан хамаарал үндэсний хил хязгаараас хальж буй хөдөлгөөн буюу улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа, хөрөнгө, хүн ам, технологийн болон мэдээллийн өсөн нэмэгдэж байгаа урсгал. | Globalization – the movement toward greater interaction, integration, and interdependence among people and organizations across national borders – is increasing transactions among countries in trade and investment and in the international flows of capital, people, technology, and information. (Davaadulam, 2010) |
| *Дидактик*<br>*Didactics*<br>*Дидактика* | dide\Di! | Багшлахуйн болон суралцахуйн онол, практик хэрэглээг судалдаг салбар шинжлэх ухаан. Багшийн мэдлэг, боловсрол, сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад өргөн хэрэглэгддэг. Герман хэлтэй болон Скандинавын орнууд, ОХУ-ын хувьд сургалтын үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэдэг онол юм. | Didactics is a theory of teaching, and in a wider sense, a theory and practical application of teaching and learning. Didactics serves as a major theory in teacher education and curriculum development, especially in the German-speaking and Scandinavian countries, as well as in the Russian Federation. In French, German, and Scandinavian educational contexts |

| | | | |
|---|---|---|---|
| | | Франц, Герман, Скандинавын орнуудын боловсролын тогтолцоонд уг нэр томьёог суралцахуй болон багшлахуйн онол, үйл ажиллагаа гэж үзэх хандлагатай байдаг. Заах арга зүйн тухай ойлголтыг энгийнээр дараах байдлаар тодорхойлж болно: юунд суралцах ёстой вэ? (агуулга тал); бид хэрхэн сургах болон суралцах вэ? (дамжуулах ба суралцах талаас); мөн ямар зорилго, зорилттойгоор сургах болон сурах ёстой вэ? (зорилго/ зорилтын хүрээнд). | there is a marked tendency to didactics where the term is viewed as the theory and practice of teaching and learning. In a simplified way, the concern of didactics can be described as follows: what should be taught and learned (the content aspect); how do we teach and learn (the aspects of transmitting and learning); and to what purpose or intention should something be taught and learned (the goal/aims aspect). (UNESCO, 2013) |
| *Диплом*<br>*Diploma*<br>*Диплом* | dip.o'v | 1. Тухайн хувь хүн дээд боловсрол эзэмшсэнийг нотлох албан ёсны баримт бичгийн ерөнхий нэршил.<br>2. Зарим улс орнуудад бакалавр болон магистрын түвшний хооронд олгодог боловсролын зэрэг (мэргэшил) | Diploma is:<br>1. A generic term for a formal document (certificate) that acknowledges that a named individual has achieved a stated higher education award.<br>2. An award for a specific level of qualification (diploma level) which in some countries is between a bachelor and a masters-level award. (NIAD-QE, 2016) |

Д

| | | | |
|---|---|---|---|
| *Дипломын хавсралт*<br><br>*Diploma supplement*<br><br>*Приложение к диплому* | dip;o^ oa Hebsorolda | Мэргэшил эзэмшсэнийг нотлох баримт бичиг (диплом)-г дагалдаж буй суралцагчийн судалсан хичээлийн дүнгийн дэлгэрэнгүй жагсаалт. | A diploma supplement is a detailed transcript of student attainment that is appended to the certificate of attainment of the qualification. (INQAAHE, 2017) |
| *Диссертац*<br><br>*Dissertation*<br><br>*Диссертация* | disswrDe] I | Докторын сургалтыг бүрэн дүүргэж, төгсөлтийн шалгуурыг хангаж, тодорхой сэдвээр судлан бичиж, хамгаалсан судалгааны бүтээл. | Thesis written on an original topic of research, usually presented as one of the final requirements for the doctorate. (Glossary of terms in HE, 2016) |
| *Докторант*<br><br>*Doctoral student*<br><br>*Докторант* | do\DorenDA | Докторын шатлалд суралцагч | Learner in Ph.D cource. (The Law of Mongolia on Higher Education, 2002) |
| *Докторын дараах судлаач*<br><br>*Postdoctoral researcher*<br><br>*Постдокторант / Постдокторский научный сотрудник* | Sodologec I do\Do* oa DeregekUA | Судалгааны ажлын чанар чансааг дээшлүүлэх, үргэлжлүүлэх зорилгоор докторын дараах түвшний судалгааны үйл ажиллагаанд хамрагдаж буй судлаач. | A researcher who engages in research activity after finishing a doctoral program for enhancing his/her research capacity. (NIAD-QE, 2016) |
| *Докторын сургалтын хөтөлбөр*<br><br>*Doctoral program*<br><br>*Программа аспирантуры \ Докторская программа* | KidolBr I do\Do* oa Sorgelda iia | Докторын зэрэг олгох ахисан түвшний сургалтын хөтөлбөр. | Graduate program that leads to a doctoral degree. (NIAD-QE, 2016) |

Д

| | | | |
|---|---|---|---|
| *Дүгнэх үнэлгээ*<br><br>*External evaluation*<br><br>*Внешнее оценивание* | doieknek foinelekit | Мэргэшсэн байгууллагаас дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлж, дүгнэх зорилгоор тухайн байгууллагын тодорхой нэгж болон үндсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, нотолгоог цуглуулах үйл явц. | The process whereby a specialized agency collects data, information, and evidence about an institution, a particular unit of a given institution, or a core activity of an institution, in order to make a statement about its quality. (UNESCO-CEPES, 2007) |
| *Дүнгийн тодорхойлолт*<br><br>*Transcript*<br><br>*1. Зачетная книжка*<br>*2. Справка об успеваемости студента* | doieit oa Dodoeeiilelda | Суралцагчийн судалсан хичээлийн нэр, цуглуулсан багц цаг, хичээл бүрийн үнэлгээ зэргийг агуулсан сурлагын амжилтын талаарх мэдээллийн баталгаажсан хуулбар. | A certified copy of a student's educational record containing titles of courses, the number of credits, and the final grades in each course. (Glossary of terms in HE, 2016) |
| *Дэлхийн иргэний боловсрол*<br><br>*Global citizenship education (GCED*<br><br>*Образование в духе глобальной гражданственности* | Delekil iia firkia O Blbisore& | Дэлхий нийтэд тулгарсан бэрхшээлийг даван туулах, тэдгээрийг шийдвэрлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх, илүү тайван, тэсвэр тэвчээртэй, оролцоотой, аюулгүй ертөнцийг бүрдүүлэхэд идэвх санаачилгатай оролцогч байх суралцагч бэлтгэхэд чиглэсэн боловсролын нэг төрөл. | A type of education that aims to empower learners to assume active roles to face and resolve global challenges and to become proactive contributors to a more peaceful, tolerant, inclusive and secure world. (UNESCO G. E., 2019) |

Д

| | | | |
|---|---|---|---|
| *Дэлхийн ур чадварын тэмцээн*<br><br>*World Skills Competition*<br><br>*Ворлдскиллс* | DeleKI iia fo*T CideBrI iia Demecekia | Дэлхийн ур чадварын тэмцээн 2 жил тутамд зохион байгуулагддаг, дэлхийн түвшний аж үйлдвэрийн хөгжлийн тусгал болсон мэргэжлийн боловсролын ур чадварын хамгийн том хэмжээний уралдаан юм. Тэмцээнд оролцогчид нь гишүүн орон, эсвэл бүс нутгийн тэмцээнээс шалгарсан шилдэг өрсөлдөгчид байдаг. Тэд ганцаарчлан болон багийн бүрэлдэхүүнээр өөрийн сурч байгаа, эсвэл ажиллаж байгаа мэргэжлийн хүрээнд даалгавруудыг гүйцэтгэж, техник ур чадвараа танилцуулдаг. | The Worlskills Competition occurs every two years and is the biggest vocational education and skills excellence event in the world that truly reflects global industry. The competitors represent the best of their peers and are selected from skills competitions in Worldskills Member countries and regions. The demonstrate technical abilities both individually and collectively to execute specific tasks for which the study and/or perform in their workplace. (VETP-1, 2018) |
| *Дээд боловсрол*<br><br>*Tertiary education*<br><br>*Высшее образование* | DekidO BlbisoreA | Дунд боловсрол дээр суурилан тодорхой мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа. Энэ нь мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх зорилготой. (ЮНЕСКО, 2013) Гуравдагч шатны боловсрол (БОУСА түвшин 5–8). Ерөнхий боловсролд тулгуурлан мэргэжлийн | Tertiary education builds on secondary education, providing learning activities in specialized fields of education. It aims at learning at a high level of complexity and specialization. Tertiary education includes what is commonly understood as academic education but also includes advanced vocational or professional education. (UNESCO, 2013) Tertiary education (ISCED |

боловсролын салбарт суралцах үйл ажиллагааг дэмжсэн боловсролын төрөл. Энэ нь нарийн төвөгтэй, мэргэшлийн өндөр түвшинд суралцахыг хэлэх бөгөөд дараах түвшнийг хамарна. Үүнд: Түвшин 5: суралцагчдад мэргэжлийн мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн гуравдагч шатны богино хугацааны үе шат. Энэ нь практикт суурилсан, мэргэжлийн онцлогт тулгуурласан байх бөгөөд суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэнэ. Түвшин 6: Бакалаврын зэрэг. Суралцагчдад дунд түвшний академик эсвэл мэргэжлийн мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшүүлэх зорилготой бөгөөд 1 дүгээр зэрэг буюу түүнтэй адилтгах зэрэг олгоно. Түвшин 7: Магистр, эсвэл түүнтэй дүйцэх түвшин. Суралцагчдад дээд түвшний академик эсвэл мэргэжлийн мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшүүлэх зорилготой бөгөөд 2 дугаар зэрэг буюу түүнтэй

levels 5–8). It builds on secondary education, providing learning activities in specialized fields of education. It aims at learning at a high level of complexity and specialization. It comprises: Level 5: Short-cycle tertiary education, often designed to provide participants with professional knowledge, skills and competences. It is practically based, occupationally specific and prepares students to enter the labour market. Level 6: Bachelor's, often designed to provide participants with intermediate academic and/or professional knowledge, skills and competences, leading to a first degree or equivalent qualification. Level 7: Master's or equivalent level, often designed to provide participants with advanced academic and/or professional knowledge, skills and competences, leading to a second degree or equivalent qualification. Level 8: Doctoral or equivalent level, designed primarily to lead to

Д

| | | | |
|---|---|---|---|
| | | адилтгах зэрэг олгоно. Түвшин 8: Докторын эсвэл түүнтэй дүйцэх түвшин. Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр гүнзгийрүүлсэн судалгаа хийж гүйцэтгэнэ. | an advanced research qualification. (UNESCO G. E., 2019) |
| *Дээд боловсролын интернациональчлал*<br><br>*Internationalisation of higher education*<br><br>*Интернационализация высшего образования* | Dekɨd0 BlIbɨsore& oa finDwrne]iyonelicile& | Дээд боловсролын сургалт, судалгааны үйл ажиллагаанд гадаадын улс орны багш, ажилтан, оюутан, суралцагчдыг татан оролцуулах, олон талт, олон соёлт сургалт, судалгааны орчныг бүрдүүлэх үйл явц юм. Дээд боловсролын интернациональчлал нь олон арга замаар дээд боловсролыг олон улсын шинж чанартай болгож болдгийг дэлхий дахинд харуулан нотолсон. Орон нутгийн, үндэсний болон бүс нутгийн нөхцөл байдал нь өөрийн гэсэн онцлогтой ч дэлхийн түвшинд өргөн хүрээний хэд хэдэн чиг хандлага байж болно. Эдгээрт хүмүүс, хөтөлбөр болон байгууллагуудын хөдөлгөөнт байдал; хамтарсан судалгааны өсөн нэмэгдэж буй ач холбогдол; багшлах, суралцах арга болон сургалтын хөтөлбөрийн | Internationalisation in higher education is the process of developing a multilateral and multicultural learning and research environment through, for example, redesigning curricula, engaging non-local staff, encouraging students to study abroad and aatracting overseas students. (INQAAHE, 2017). The internationalization of higher education is notable for the multiple ways in which it has manifested itself around the world. Although each local, national, and regional context presents unique characteristics, several broad trends can be identified globally. These developments include mobility of people, programs, and institutions; the rising prominence of collaborative research; evolving curricula as |

| | | | |
|---|---|---|---|
| | | боловсруулалт; дэлхий даяар дээд боловсролын байгууллагын харилцан хамаарлын талаарх ойлголт нэмэгдэж буй байдал; дээд боловсролын байгууллагуудын болон системийн өргөн хүрээнд олон улсжих үзэгдэл улам бүр өргөжин тэлж буй байдал орно. | well as approaches to teaching and learning; an increasingly heightened sense of the interconnectedness of the higher education enterprise across the globe; and the growing pervasiveness of the phenomenon of internationalization across institutions and broader systems of higher education. (UNESCO, 2009a) |
| *Дээд боловсролын салбар*<br><br>*Higher education sector*<br><br>*Сектор высшего образования* | DekidO BIb:sore& oa SeIBrI | Энэ салбар нь дараах байгууллагуудаас бүрдэнэ: -Санхүүжилтийн эх сурвалж болон эрх зүйн статусаас үл хамааран бүх их сургууль, технологийн коллеж, бүрэн дунд боловсролын зэрэг олгож буй байгууллагууд. - Дээд боловсролын байгууллагын шууд удирдлагад, дэргэд харьяа болон хувь нийлүүлсэн бүх судалгааны хүрээлэн, туршилтын станц, клиник эмнэлэг. | This sector is composed of: - all universities, colleges of technology and other institutions providing formal tertiary education programmes, whatever their source of finance or legal status- all research institutes, centres, experimental stations and clinics that have their R&D activities under the direct control of, or administered by, tertiary education institutions. (OECD, Frascati Manual: Guidelines for Collecting and Reporting Data on Research and Experimental Development, 2015) |

| | | | |
|---|---|---|---|
| *Дээд боловсролын стратеги*<br>*Strategy of higher education*<br>*Стратегия высшего образования* | SDreDWkIA Dekid0 BIbisore& oa | Дээд боловсролын салбарын хөгжлийн урт хугацааны зорилгыг тодорхойлсон хэтийн бодлого, төлөвлөлт. | Definition of the long-term purposes of development of the higher education. (Bologna Process, 2009) |
| *Дээд боловсролын сургалтын байгууллага*<br>*Higher education institution*<br>*Высшее учебное заведение* | Dekid0 BIbisore& oa Sorgelda iia biiigolol)T | Албан ёсны сургалтын хөтөлбөрт үндэслэн дээд боловсрол олгох үйл ажиллагаа эрхлэн явуулж буй сургалтын байгууллага. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үйл ажиллагааны чанараа үнэлүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх зөвшөөрөл авахын тулд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, цаашлаад байгууллага болон сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэх шаардлагатай. Хэрхэн үнэлэгдэх, магадлан итгэмжлэгдэхээс хамаарч "их сургууль" юм уу эсхүл ижил төстэй албан ёсны нэрээр нэрлэгдэнэ. Түүнчлэн, дээд боловсролын байгууллагууд нь өөрсдийн хэрэгжүүлж буй сургалт болон бусад үйл ажиллагааны чанар, баталгааг хариуцна. Дээд боловсролын | An educational body which carries out higher education activities based on legally approved study programs. Any higher education organization must follow an external evaluation procedure in order to assess its quality and to acquire the provisional functioning authorization, followed by its official accreditation, as well as the accreditation of its study programs. Generally, this requirement is compulsory for all higher education institutions (HEI) or organizations providing higher education programs and activities and entitles HEIs, upon successful completion, to use the name 'university' or other similar legally recognized names. Also HEIs have the primary responsibility for the quality of their provision, |

| | | | |
|---|---|---|---|
| | | байгууллагууд нь хамрах хүрээ, чанар, материаллаг болон хүний нөөц, оюутны тоо гэх мэт үзүүлэлтээр ялгаатай байж болох авч амжилттай байгууллага нь ихэнхдээ оролцогч талуудын эрэлт хэрэгцээ болон байгууллагынхаа үнэт зүйлсийн хоорондох тэнцвэртэй байдлыг бий болгохыг эрмэлздэг. Тэдгээр нь дотоодын болон олон улсын, цөөнхөд эсхүл олон нийтэд чиглэсэн, мэргэшсэн эсхүл олон салбарыг хамарсан, академик (мэдлэг бүтээдэг, шинжлэх ухаанч, академик эрх чөлөөтэй, үр дүнг чөлөөтэй хуваалцдаг соёл төлөвшсөн) ба бизнесийн (ашиг олох, нийгмийн баялгаас хувь хүмүүс ашиг хүртэх) гэх мэт олон янз байдаг. | and its assurance. Higher education institutions may differ in size, quality, resources, number of teaching staff and students, etc., as successful HEIs generally have to find a balance between often conflicting stakeholder demands and institutional values. HEIs can therefore be either local or global; elite or mass-oriented; specialized or trans-disciplinary, and may foster either an academic culture (characterized by knowledge creation, scientific excellence, academic freedom and freely shareable results) or a business culture (characterized by profit creation and individual appropriation of social wealth). (UNESCO-CEPES, 2007) |
| *Дээд боловсролын сургалтын байгууллагын засаглал*<br><br>*Governance (of a higher education institution)* | DekidO BIbisoreæ oa Sorgelda | Дээд боловсролын сургалтын байгууллагын бүтэц, удирдлага, зохион байгуулалттай холбоотой ерөнхий нэршил. Үүнд сургалт, судалгааны зорилтын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор сургалтын болон | A general term relating to the organizational and governing structure in a higher education institution. It includes the setting of policy on the roles and allocation of responsibility of members and internal organizations |

Д

| | | | |
|---|---|---|---|
| *Управление высшим учебным заведением* | iia biiigolol)T iia Jeseeelee | удирдлагын үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс, дотоод нэгжийн үүрэг, хариуцлагын талаар бодлого боловсруулах, батлах үйл явц багтана. | involved in teaching/ learning and management, as well as the establishment of a decision-making process in order to maximize objectives related to education and research in higher education institutions. (NIAD-QE, 2016) |
| *Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансаа*<br><br>*Ranking of higher education institutions*<br><br>*Рейтинг высших учебных заведений* | DekidO BIbisoree oa Sorgelda iia biiigolol)T iia frembit Ciese)T | Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эсхүл хэрэгжүүлдэг хөтөлбөрийн чанарын үзүүлэлтийг харьцуулан судлах механизм. Харьцуулалтын үзүүлэлт нь тухайн сургалтын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны чанартай холбоотой үзүүлэлтийг хэмжиж, илэрхийлдэг. Эрэмбэлэх нь сонирхогч талууд, хэрэглэгч болон бодлого боловсруулагчдыг ижил төстэй байгууллагуудын үйлчилгээний чанар хоорондын хэмжигдэхүйц ялгаатай байдлын талаарх мэдээллээр хангахад чиглэгдэнэ. Энэ ойлголт нь арга зүйн хувьд маргаантай байдаг хэдий ч энэхүү арга нь олон нийтийг мэдээллээр | The quantitative mechanism of comparison of quality of higher education institutions (and/or the educational programs implemented by them) which indicators reflect or measure qualitative characteristics (the academic quality) of institution of higher education. (Bologna Process, 2009). They are meant to supply information to interested stakeholders, consumers, and policy-makers, alike on measurable differences in service quality of several similar providers. Even if somewhat controversial, especially concerning the methodological aspects, they are quite popular and seen as a useful instrument for public information, while also providing an additional |

хангахад нэлээд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд чанарыг дээшлүүлэх нэмэлт түлхэц хэрэгсэл болдог. Эрэмбэлсэн жагсаалтыг олон нийтэд танигдсан хэвлэл, тусгай мэргэшсэн сэтгүүлд хэвлэхээс гадна цахим талбарт байршуулдаг. Эрэмбэлэх үйл явц нь байгууллагын сургалт, судалгааны ажил болон бусад холбогдох мэдээлэл цуглуулснаар эхлэх ба дараа нь цуглуулсан өгөгдлөөс хувьсагчийн хэлбэр, тоог сонгодог. Үүний дараа сонгосон хувьсагчаас үзүүлэлтүүдээ стандартчилж, хэмжинэ. Эцэст нь тооцоолол гаргаж, харьцуулалт хийснээр байгууллагуудыг эрэмбэлсэн дараалалд жагсаана. Байгууллага, хөтөлбөрийг үнэлэхдээ төрөл бүрийн, ялгаатай шалгуур үзүүлэлтийг ашиглан эрэмбэлнэ. Эрэмбийн үр дүн, жагсаалт нь үзүүлэлтийн тооноос хамааран өөр өөр байж болох бөгөөд эрэмбэлэх үзүүлэлт, шалгуур нь шинжлэх ухааны сурган заах арга зүйн, удирдлагын болон нийгэм эдийн засгийн,

incentive to quality improvement. Ranking/ league tables are generally published in the popular press and magazines, specialized journals and on the Internet. The ranking process starts with the collection of data from existing data sources, site visits, studies, and institutional research. Following collection, the type and quantity of variables are selected from the information gathered. Then, the indicators are standardized and weighted from the selected variables. Finally, calculations are conducted and comparisons are made so that institutions are sorted into “ranking order”. Ranking/league tables make use, in the process of evaluation of institutions or programs, of a range of different indicators. The results of ranking/league tables (the “scores” of each assessed institution) may thus vary from one case to another depending on the number of indicators used or on the indicators themselves. Ranking indicators or criteria, usually take into consideration scientific,

хүрээг харгалзан үздэг. Үүнд: нэгж оюутанд ноогдох багшийн тоо, А дүнтэй оюутны тоо, сургалт, судалгааны ажил, номын сан, компьютерын болон бусад лабораторид зарцуулж буй зардал, сургуулиас гарсан оюутны тоо, сэтгэл ханамж, сурах нөхцөл, ажилтан ажиллуулах бодлого зэрэг орно.
Сүүлийн үеийн олон улсын эрэмбийн конвенцуудад дурдсанаар, эрэмбийг харьцуулсан мэдээлэл болон дээд боловсролын талаар илүү тодорхой ойлголт өгөхөд ашиглах нь зүйтэй, харин академик чанарыг үнэлэх гол арга хэрэгсэл болгон авч үзэж, ашиглах нь зүйд нийцэхгүй гэсэн байна. Түүнчлэн хэрэглэгчдэд аливаа дээд боловсролын байгууллага, хөтөлбөрийг эрэмбэлэхдээ авч үзсэн бүхий л үзүүлэлт, хүчин зүйлсийнх нь талаар мэдээлэл өгч олон нийтэд сургалтын байгууллага, хөтөлбөрийг сонгох суралцах тал дээр бусдаас хамаарахгүйгээр шийдвэр гаргах боломжийг олгох хэрэгтэй.

pedagogic, administrative, and socio-economic aspects: student/staff ratio, A-level points (held by first-year students), teaching and research (as marks received in teaching and research assessments by individual departments), library and computer spending, dropout rates, satisfaction, study conditions, employment perspectives, etc. In accordance with the latest international conventions on ranking (i.e. 'Berlin Principles'), rankings should offer comparative information and a better understanding of higher education, but should not be considered and used as a primary method for the assessment of academic quality. They should also clearly inform consumers with regard to all the indicators and factors used to rank higher education institutions or programs, allowing the public to independently decide upon their respective weight. Related terms: Assessment, Criteria, Evaluation, Performance Standards. (UNESCO-CEPES, 2007)

*Дээд эрэмбийн сэтгэлгээ*

*Higher-order thinking (HOT)*

*Мышление высшего порядка*

DekidO frembit iia SeoekulIkit

Дээд эрэмбийн сэтгэлгээ нь Блумын таксономийн танин мэдэхүйн айн дээд гурван түвшинд хамаарна. "Блумын таксономи"-ийг үзнэ үү.

HOT as referring to the top end of Bloom's taxonomy, which are the analysis, synthesis and evaluation domains. (Nitko and Brookhart, 2007) See 'Bloom's taxonomy'.

## E

*Европын дээд боловсролын чанарын баталгаажуу-лалтын байгууллагуудын бүртгэл*

*Register of European Higher Education Quality Assurance Agencies (REHEQA)*

*Европейский реестр агенств по обеспечению качества высшего образования*

Nogooa oa Birioeki& fwoiropit iia DekidO Blbisore& oa Cine* oa bidolegejigololda iia biigolol)T

Европын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын агентлагийн бүртгэл нь Европын орнуудын хамтын ажиллагаар дэмжих зорилготой Болоны үйл явцтай шууд холбоотой. 2005 оны 5-р сард Берген хотод болсон дээд боловсролын талаарх Европын сайд нарын хурлаас гарсан шийдвэрийн дагуу BFUG (Болоны үйл явцаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хянан зохицуулах ажлын хэсэг)-ийн зөвлөлдөх гишүүд болох Е үсгээр эхэлсэн 4 байгууллага (ENQA, EUA, EURASHE, ESIB) энэхүү бүртгэлийн үйл ажиллагаар эхлүүлэх төсөл боловсруулсан. Энэхүү төслийн ажлын үр дүнд тус бүртгэлийн

The idea and implementation of the Register of European Higher Education Quality Assurance Agencies (REHEQA) is directly related to the Bologna Process and its objective of promotion of the European cooperation in quality assurance. In line with the decision of the Conference of the European Ministers Responsible for Higher Education in Bergen (May, 2005), the following four organizations and Consultative Members of the BFUG – ENQA, EUA, EURASHE and ESIB (the E4 Group) have developed a project which should lead to the operationalization of the Register. This work has been finalized and the

байгууллагын хуулийн статус, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт зэрэг холбогдох баримт бичгүүдийг боловсруулан 2017 оны 5-р сард Лондонд болсон сайд нарын хурлаар батлуулахаар өргөн барьсан. Энэхүү бүртгэлийн гол зорилго нь нээлттэй веб сайтаар дамжуулан Европт үйл ажиллагаагаа явуулж буй найдвартай чанарын баталгаажуулалтын агентлагуудын талаарх мэдээллийг нэг дор цуглуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах явдал юм. Эл бүртгэлд орохын тулд холбогдох байгууллага нь өөрийн улсын хууль тогтоомжийг мөрдөн Европын дээд боловсролын салбарын чанарын баталгаажуулалтын стандарт, зөвлөмжийн дагуу тавигдсан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

relevant document presenting the structure, legal status, organization and financing of the Register will be submitted at the ministerial conference in London in May 2007. The purpose of the Register is to collect in a transparent way and provide generally accessible relevant information (through access to open website) about reliable and trustworthy quality assurance agencies operating in Europe. In order to be part of the Register, respective agencies and bodies need to comply with their national legislation as well as meet criteria set by the Standards and Guidelines for Quality Assurance in the European Higher Education Area. Related terms: Criteria, Culture of Evidence, Indicators, Outcomes, Quality Assessment. (UNESCO-CEPES, 2007)

| | | | |
|---|---|---|---|
| *Европын мэргэшлийн хүрээ (шаталсан бүтэц)*<br><br>*European qualifications framework*<br><br>*Европейская квалификационная рамка* | fwoiropit iia Merkisi& oa KiriIT :ZedoIeeesea Bidoca" | Дээд боловсролын салбарт шинэ хөгжил болох насан туршийн боловсролын Европын мэргэшлийн хүрээ Европын комиссын санаачилгын зорилтот үр дүн бөгөөд европын парламент ба зөвлөл 2007 онд баталсан юм. Энэ нь 8 ерөнхий түвшний суралцахуйн хүрэх үр дүнгийн багц дээр үндэслэдэг бөгөөд боловсролын бүхий л түвшинд хамаарна. Европын мэргэшлийн хүрээ нь оролцогч талууд болон ажил олгогчдод нийтлэг ойлголт, тайлбараар хангаж, улмаар боловсролын тогтолцоо, мэргэшлийн түвшнийг харьцуулан боломжийг олгохыг зорьдог. | A new development in higher education, the european qualifications framework for lifelong learning (EQF) is the targeted result of a european commission initiative to be enacted by the european parliament and council in 2007. It focuses on a set of eight general reference levels or learning outcomes that cover the whole range of qualifications and are valid on a trans-systemic basis. The EQF should provide stakeholders and employers with a global reference tool (or 'translation device') allowing them to clearly compare and relate qualifications and education and training systems. (UNESCO-CEPES, 2007) |
| *Европын холбооны кредит шилжүүлэх, тооцох тогтолцоо*<br><br>*ECTS (European Credit Transfer and Accumulation System)*<br><br>*Европейская система переноса и накопления кредитов* | SiljikIK , DogeceeO DoeedeIce) T<br>fwoiropit iia HoIBgea O \rwdiDA | Суралцагчийн суралцах ачааллалд тулгуурлан эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг тодорхойлсон, сургалтын хөтөлбөрийн зорилтыг хангаж биелүүлэхэд тавигдах оюутан төвтэй тогтолцоо буюу суралцсан хугацааг хүлээн зөвшөөрөх ил тод, үндсэн арга хэрэгсэл. | The main transparency tool for the recognition of study periods, ECTS is a student-centered system based on the student workload required to achieve the objectives of a program of study specified in terms of learning and competencies to be acquired. (UNESCO-CEPES, 2007) |

E

*Ерөнхий боловсрол*

*General education*

*Общее образование*

Yeroehk:I Blbisore&

Суралцагчдын ерөнхий мэдлэг, ур чадвар, хандлага, ялангуяа бичиг үсэг, тооны ухааны чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн боловсролын хөтөлбөр. Энэ нь суралцагчдыг ахисан түвшний боловсролын хөтөлбөрт бэлтгэдэг ба насан туршийн боловсролын үндэс суурь болдог. Ерөнхий боловсрол нь суралцагчдыг м э р г э ж л и й н боловсролын сургуульд элсэхэд бэлтгэх хичээлийн хөтөлбөрийг агуулдаг хэдий ч хөдөлмөрийн зах зээл дээр тодорхой нэг мэргэжлээр ажиллахад бэлтгэхгүй.

Education programmes that are designed to develop learners' general knowledge, skills and attitudes, as well as literacy and numeracy skills, often to prepare students for more advanced education programmes and to lay the foundation for lifelong learning. General education includes education programmes that are designed to prepare students for entry into vocational education but do not prepare for employment in a particular occupation, trade, or class of occupations or trades, nor lead directly to a labour market-relevant qualification. (UNESCO, 2013)

*Ерөнхий санааны зураглал*

*Concept map*

*Концептуальная карта*

Yeroehk:I Senegea O Jiroeele&

Мэдлэгийг дүрсээр илэрхийлэх үйл явц бөгөөд үзэл санаа, хандлагын харилцан хамаарлыг харуулдаг. Түлхүүр үгсийг дөрвөлжин, дугуй, гурвалжин зэрэг дүрсэнд бичиж хоорондоо уялдаа бүхий санаануудыг сумаар холбож ерөнхий санааны зураглалыг гаргадаг. Мөн түлхүүр ойлголт, санаанууд

A concept map is a visual organization and representation of knowledge. It shows concepts and ideas and the relationships among them. You create a concept map by writing key words (sometimes enclosed in shapes such as circles, boxes, triangles, etc.) and then drawing arrows between the ideas that are related. Then you add

| | | | |
|---|---|---|---|
| | | хоорондоо хэрхэн уялдаж байгааг сумны хажууд товч тайлбар зүүн илэрхийлж болно. | a short explanation by the arrow to explain how the concepts are related. https://ctl.byu.edu/tip/concept-mapping |
| | | **Ж** | |
| *Жендерийн тэгш байдал*<br><br>*Gender equality*<br><br>*Равноправие мужчин и женщин /Гендерное равноправие* | Jwndw* oa Deksl biirde& | Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд амьдралынхаа туршид тэгш эрх эдэлж, тэгш боломжоор хангагдаж, үйлчилгээг тэгш хүртэх явдал. Хүмүүсийн эрх үүрэг, хариуцлага, нийгмийн байр суурь, нөөц бололцоог хүртэх боломж нь эрэгтэй, эмэгтэй гэдгээс үл хамаарч тэгш байх ёстой. | According to the International Labour Office, gender equality refers to the enjoyment of equal rights, opportunities and treatment by men and women and by boys and girls in all spheres of life. It asserts that people's rights, responsibilities, social status and access to resources do not depend on whether they are born male or female. (UNESCO, 2013) |
| *Жишиг өгөгдөл*<br><br>*Viewpoints*<br><br>*Ориентиры* | Jiziit foinKkde& | Сургалтын байгууллага өөрийн үнэлгээг хэрэгжүүлэхдээ үнэлгээний шалгуур, стандарт тус бүрд хавсаргасан лавлах оноо, жишиг өгөгдөл. Чанарын баталгаажуулалтын байгууллагаас сургалтын байгууллагын гүйцэтгэл, стандартыг хангаж буй эсэхийг үнэлэхдээ дээрх лавлах оноог ашиглана. Сургалтын байгууллага өөрийн тодорхой онцлогийг тусгах үүднээс өөрийн лавлах жишгийг бий болгож болно. | Reference points and example data listed under each evaluation standard for subject institutions to refer to when implementing self-assessment. A QA agency refers to these viewpoints when judging whether an institution's performance meets the Standards or not. Institutions may also create their own viewpoints to reflect their particular characteristics. (NIAD-QE, 2016) |

Ж

| | | | |
|---|---|---|---|
| *Жишиг үзүүлэлт (магадлан итгэмжлэл)*<br><br>*Benchmark (in accreditation)*<br><br>*Бенчмарк* | Jiziit foijeKlolda :Megeoelea fidekimjile&" | Үйл ажиллагааны үр дүнг хэмжих, чанарыг үнэлэхэд харьцуулан ашигладаг шалгуур үзүүлэлт, стандарт, жишиг түвшин. | A standard, a reference point, or a criterion against which the quality of something can be measured, judged, and evaluated, and against which outcomes of a specified activity can be measured. (UNESCO-CEPES, 2007) |
| *Жишиг харьцуулалт*<br><br>*Benchmarking*<br><br>*Бенчмаркинг* | Jiziit Hericegolola | Сайн туршлагыг тодруулах, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг оношлох, давуу талыг тодорхойлох зорилгоор байгууллагын үйл ажиллагаа эсвэл сургалтын хөтөлбөрүүд-ийн хэрэгжилтийг харьцуулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, тайлагнахад зориулагдсан стандарт аргачлал. | A standardized method for collecting and reporting critical operational data in a way that enables relevant comparisons among the performances of different organizations or programs, usually with a view to establishing good practice, diagnosing problems in performance, and identifying areas of strength. (UNESCO-CEPES, 2007) |

Ж

| З | | | |
|---|---|---|---|
| *Зайны сургалт*<br><br>*Distance learning*<br><br>*Дистанционное обучение* | Jel iia Sorgelda | МХХТ-ын хэрэгсэл (цахим хэрэглэгдэхүүн, радио, телевиз, утас, захидал, компьютер, видео бичлэг) ашиглан зайнаас (нүүр тулан уулзахгүйгээр) олгох сургалтын хэлбэр. | A method of study where teachers and students do not meet in a classroom but use the Internet, e-mail, mail, etc., to have classes. (VETP, 2018) |
| *Зайны сургалтын хөтөлбөр*<br><br>*Distance learning program*<br><br>*Программа дистанционного обучения* | Jel iia Sorgelda iia KidolBrl | Зайн сургалтын хөтөлбөрийг их сургууль, ахисан түвшний сургууль, мөн коллежууд хэрэгжүүлдэг. Сургалтын хэлбэр нь уламжлалт сургалтаас ялгаатай бөгөөд төгсөгчдөд боловсролын зэрэг олгоно. | Correspondence learning programs offered by a university, graduate school, or a junior college. Their modes of teaching vary from material-based lessons to the use of broadcasts and face-to-face teaching. Graduates are awarded an academic degree. (NIAD-QE, 2016) |
| *Залгамж хичээл*<br><br>*Pre-requisite*<br><br>*Предварительные необходимые предметы* | Jelgemjl kuciye& | Илүү ахисан түвшний хөтөлбөр эсхүл мэргэшлийн хичээлийг сонгон судлахад суралцагч өмнө нь заавал судалсан байх шаардлагатай хөтөлбөр эсхүл хичээл. | Program or course that a student is required to complete before being permitted to enroll in a more advanced program or course. (Glossary of terms in HE, 2016) |
| *Засан сайжруулах үйл ажиллагаа*<br><br>*Corrective action*<br><br>*Корректирующее действие* | JeSea Seiijiregolee0<br>foiila fejille) T | Алдаа, дутагдлыг засан сайжруулах үйл ажиллагаа. | Corrective action is process of rectifying problems. (INQAAHE, 2017) |

| | | | |
|---|---|---|---|
| *Захиргааны зөвлөл*<br><br>*Administrative council*<br><br>*Административный совет* | Jekirgea O Joib;e& | Сургалтын байгууллагын менежментийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэг бүхий нэгж. | A mandatory body set up in every national university corporation to discuss key issues of management. (NIAD-QE, 2016) |
| *Зорилго*<br><br>*Aim*<br><br>*Цель* | Joril)T | Дээд боловсролын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилт, бодлого, төлөвлөлтийн ерөнхий тодорхойлолт. | An aim is an overall specification of the intention or purpose of a program of study or institutional mission or policy. (INQAAHE, 2017) |
| *Зохиогч*<br><br>*Author*<br><br>*Автор* | Jokiyeec l | Оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинэ бүтээл, бүтээгдэхүүний ашигтай загвар зохиосон хувь хүн. | An author is an individual who created a work with his or her own mental creativity. (The Law of Mongolia on Copyright and related rights, 2006) |
| *Зочин профессор*<br><br>*Visiting professor*<br><br>*Профессор, приглашенный для чтения лекций в учебное заведение* | Jocia proqisso* | Нэг сараас эхлэн нэг улирал, жилийн хугацаатайгаар дотоодын болон гадаадын улс орны их сургууль, коллежид хичээл заахаар уригдсан багш. | A visiting professor is a professor at a college or university who is invited to teach at another college or university for a short period such as one term or one year. Source: https://www.collinsdictionary.com |
| *Зөвлөгөө (хөтөлбөрт)*<br><br>*Consultation (in curriculum)*<br><br>*Консультация (в образовательной программе)* | Joib;ekt :KidolBr l dO" | Хөтөлбөр боловсруулах, хянах, хөгжүүлэхэд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч, мэргэжилтнүүд болон бусад оролцогч талуудын үзэл санаа, туршлагыг ашиглах, үнэлэх үйл явц. | The process of seeking and valuing opinions and experience of experts and various, legitimate stakeholders that is an integral part of the broader curriculum development/ review process. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Зөвлөх багш*<br><br>*Academic advisor / Thesis advisor*<br><br>*Консультант по учебным вопросам* | Joib;eK b[eesl | Сургалт, судалгаатай холбоотой асуудлаар суралцагчдад туслах, зөвлөх үүрэгтэй багш. | A member of faculty who helps and advises students purely on academic matters. (Glossary of terms in HE, 2016) |
| *Зөөлөн чадвар*<br><br>*Soft skills*<br><br>*Мягкие навыки* | JoikIlea CideBrl | Хувь хүний дэвшилтэт зан чанар, шинж төлөв, хийж гүйцэтгэсэн туршлагын үр дүнд тогтсон дадал зуршил. Жишээ нь: өрөвдөж, энэрэх, манлайлах, хариуцлагаа ухамсарлах, шударга байх, өөрийгөө үнэлэх, удирдах, идэвх санаачилгатай байх, уян хатан, нийтэч байх, цаг барих, шийдвэр гаргах гэх мэт. Өргөн хүрээнд хэрэглэгдэх боломжтой тул хөрвөх ур чадвар гэж бас хэлдэг. Энэ нь “хатуу ур чадвар” буюу тодорхой ажил, мэргэжилд хамаарах мэргэжлийн буюу техникийн ур чадвараас онцлог бөгөөд хатуу ур чадвар эзэмшүүлэх нь зөөлөн ур чадвар эзэмшүүлэхээс хялбар байдаг. Зөөлөн чадвар нь хувь хүний төрөлхийн өгөгдөл, хөгжил, төлөвшил, ухамсрын түвшинтэй нягт холбоотой. | A set of intangible personal qualities, traits, attributes, habits and attitudes that can be used in many different types of jobs. As they are broadly applicable they are also seen as transferable skills. Examples of soft skills include: empathy, leadership, sense of responsibility, integrity, self-esteem, self-management, motivation, flexibility, sociability, time management and making decisions. The term is also used in contrast to ‘hard’ skills that are considered as more technical, highly specific in nature and particular to an occupation, and that can be (generally) taught more easily than soft skills. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Зэрэг олгох журам*<br><br>*Rules for degrees*<br><br>*Правила присуждения учёных степеней* | Jerkit folgoeO Jiro^ | Дээд боловсролын сургалтын байгууллага, чанарын баталгаажуулалтын байгууллагаас боловсролын зэрэг олгох үйл ажиллагааг журамласан эрх зүйн баримт бичиг. | The law set out for the award of degrees by universities, junior colleges and QA agency. (NIAD-QE, 2016) |

И

## И

| | | | |
|---|---|---|---|
| *Идэвхтэй суралцахуй*<br><br>*Active learning*<br><br>*Активное обучение* | fidebkidel Soro\|Ceeo\| | Багшаас суралцагчид мэдлэгийг дамжуулах нэг чиглэлт сургалтын арга барилаас татгалзан, суралцагчийн идэвхтэй суралцах үйл явцыг дэмжих арга зүй. Идэвхтэй суралцахуй нь асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах сэтгэлгээ, харилцааны зэрэг олон талт ур чадварыг хөгжүүлдэг. Идэвхтэй суралцахуйн нь хичээл, бүлгийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн, багийн ажил, хичээлээс гадуур, хамтран суралцах, кейс судалгааг ашиглах мөн танин мэдэх, нээн илрүүлэх, эрэн сурвалжлах, турших зэрэг суралцахуйн бусад хэлбэрүүдтэй. | The method and process of learners' learning actively, as opposed to the approach to learning based on one-way transmission of knowledge. Active learning is expected to develop versatile abilities such as problem solving skills, critical thinking, and communication skills. Generally, examples of active learning include, in the classroom, group discussion, debate, and group work and, outside the classroom, collaborative learning, and the use of case studies and other approaches found in discovery learning, investigative learning, and experiential learning. Reading and writing as well as analyzing and summarizing the contents of a class are also learning that is conducted actively. (NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Импакт фактор*<br><br>*Impact Factor*<br><br>*Импакт-фактор* | fimpE\DA qE\Do* | Эрдэм шинжилгээний сэтгүүлийн түвшнийг тодорхойлогч заалтуур (Нөлөөт үр дүнг илтгэгч). | The impact factor (IF)) of an academic journal is a scientometric index which reflects the yearly average number of citations to recent articles published in that journal. https://en.wikipedia.org/wiki/Impact_factor |
| *Инновац*<br><br>*Innovation*<br><br>*Инновация* | fin-nowe] I | Шинэ нээлт болон санааг бүтээгдэхүүн эсхүл үйлчилгээ болгон хувиргах үйл явц. Үүний үр дүнд баялаг, үнэ цэнэ бүтээгдэж, түүний төлөө хэрэглэгчид төлбөр төлдөг. Технологийн бүтээгдэхүүний инновац нь хэрэглэгчдэд шинэ, сайжруулсан үйлчилгээ хүргэх зорилгоор бүтээгдэхүүний үр дүн, үзүүлэлтийг сайжруулан хэрэгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхийг хэлнэ. Технологийн үйл явцын инновац нь бүтээмж эсхүл хүргэх арга замыг ихээр нэмэгдүүлэн хэрэгжүүлэх, өөрчлөлт хийхийг хэлнэ. Үүнд: тоног төхөөрөмж, хүний нөөц, ажлын арга барил эсхүл эдгээрийг хослуулсан байдал хамаарч болно. | The process of translating an idea or invention into a good or service that creates value or for which customers will pay. A technological product innovation is the implementation/commercialization of a product with improved performance characteristics such as to deliver objectively new or improved services to the consumer. A technological process innovation is the implementation/adoption of new or significantly improved production or delivery methods. It may involve changes in equipment, human resources, working methods or a combination of these. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |

И

И

| | | | |
|---|---|---|---|
| *Инновацын тогтолцоо*<br><br>*Innovation system*<br><br>*Инновационная система* | fin-nowe] I iia Doeedel ce) T | Инновацыг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлогын хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, үйлдвэрлэх, зах зээлд нэвтрүүлэх зэрэг инновацын үйл ажиллагаанд харилцан шүтэлцээтэй хамтран оролцогч байгууллагууд болон тэдгээрийн үйл ажиллагааны цогц. | A set of comprehensive activities that engage interrelated partner organizations and actors in the innovation process through invention, production and introduction of new products or services on the market within the government policy regarding innovation development. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |
| *Их сургууль*<br><br>*University*<br><br>*Университет* | Yekit Sorgegol I | Бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага. Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, технологийн коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, гарааны компани, ахлах сургуультай байж болно. Хэд хэдэн чиглэлээр өргөн хүрээний хөтөлбөрийг хамран бакалавр, магистр, докторын зэрэг, мэргэшил олгох | A higher education training institution with research-training-industry integrated components and research focused laboratories besides offering bachelor, master and doctor level degree programs. A universite may have an institute, a college, a technology college, a research institution8 a start-up company and a high school as its affiliations. (The Law of Mongolia on Higher Education, 2002). A type of the higher educational institution having the academic freedom, the right for self-government and autonomy which |

| | | | |
|---|---|---|---|
| | | зорилгоор сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг, шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулдаг академик эрх чөлөө бүхий өөрийн удирдлагатай, бие даасан дээд боловсролын сургалтын байгууллага. | provides a wide range of programs of preparation in various directions for the purpose of granting the academic degrees and qualifications including at the postdegree level; carries out basic and applied scientific research. (Bologna Process, 2009) |
| **К** | | | |
| *Компьютерын загварчлалын программ*<br><br>*Computer-simulation*<br><br>*Компьютерное моделирование / симулирование* | I mpyoiDw* oa JeeeBrcIl& oa proeere^ | Төлөвлөлтийн тооцоолол хийдэг компьютерын программ. | Computer program to make planning estimation. Source: Mongolia's Master plan to develop Education in 2006-2015 |

К

| Л | | | |
|---|---|---|---|
| *Лаборатори*<br><br>*Laboratory / Lab*<br><br>*Лаборатория* | LeBreDorI | Эрдэм шинжилгээ болон технологийн судалгаа, туршилт, хэмжилтийн ажил гүйцэтгэх зориулалт бүхий тусгайлан тоноглосон байр. | A laboratory is a facility that provides controlled conditions in which scientific or technological research, experiments, and measurement may be performed. (Budikina, 2017) |
| *Лабораторийн ажил*<br><br>*Laboratory work*<br><br>*Лабораторная работа* | LeBreDorI iia feji& | Тусгайлан тоноглосон байр, лабораторид урьдаас бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу, багш, зөвлөхийн удирдлагын дагуу хийгдэх тодорхой туршилт, судалгааны ажил. | The aim of laboratory work is to deepen and fix theoretical knowledge and to develop the skills of independent experimentation. (Budikina, 2017) |
| *Лайкертын шкал*<br><br>*Likert scale*<br><br>*Шкала Лайкерта* | Leii\wrDA oa Z\E& | Судалгаанд оролцогчид асуумжид өгөгдсөн нөхцөл байдалтай ямар түвшинд санал нийлж, эсвэл нийлэхгүй байгаа илэрхийлэх хандлагыг хэмжихэд ашигладаг хэмжүүр. | A method used to measure attitudes, which involves respondents indicating their degree of agreement or disagreement with a series of statements. (Noori, 2018). |
| *Лекц*<br><br>*Lecture*<br><br>*Лекция* | Lw\]A | Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын нийтлэг арга хэлбэр. | Common method of instruction in college and university courses. (Glossary of terms in HE, 2016) |

Л

| | | | |
|---|---|---|---|
| *Либерал арт боловсрол*<br><br>*Liberal arts education*<br><br>*Либеральное образование* | Libwre& ferDA Blbisore& | Хүмүүнлэг, энэрэнгүй төлөвшилтэй, хүн төрөлхтний талаар өргөн хүрээний ойлголттой, өөрийгөө бодитоор үнэлэх чадвартай, өөрийн мэдлэг хийгээд нийгмийн амьдралд оролцох хэв маягаа харж, төсөөлж чаддаг суралцагчийг бий болгох зорилго бүхий боловсролын нэг төрөл. Либерал арт хичээлүүд нь сэдвийн хязгаарт баригдалгүй мэдлэг, чадвар олгодгоороо мэргэжлийн салбараар ангилан мэдлэг олгохыг зорьдог явцуу хүрээний боловсролоос ялгаатай. | Education designed to nurture students' appreciation of the richness of humanity, giving them broader perspectives, abilities to judge appropriately and self-actively and to consider their own knowledge and lifestyles in society. Unlike more narrowly focused education that offers knowledge in vertically divided fields, the knowledge and skills acquired through liberal arts subjects transcend subject boundaries. (NIAD-QE, 2016) |
| | | **M** | |
| *Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр*<br><br>*Accredited / validated program*<br><br>*Аккредитованная/ утвержденная программа* | KidolBrl Megeoelea fidekim jilekdeksea | Гэрчилгээжүүлэлтийн стандарт, шалгуурыг хангасны үндсэн дээр магадлан итгэмжлэх байгууллагаас баталгаажуулагдсан, эсвэл магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр (мэргэшил). | Qualifications which have been granted approval by an accrediting agency or organization as having met specific requirements or certification standards. (VETP-1, 2018) |
| *Магадлан итгэмжлэл*<br><br>*Accreditation*<br><br>*Аккредитация* | Megeoelea fidekim jile& | Дээд боловсролын сургалтын байгууллагын эсвэл хөтөлбөрийн чанар нь урьдчилан тогтоосон шалгуур, стандартад нийцэж буй эсэхийг | The process by which a (non-) governmental or private body evaluates the quality of a higher education institution as a whole or of a specific |

M

төрийн эсвэл хувийн хэвшлийн байгууллагаас албан ёсоор үнэлэх үйл явц. Энэхүү үйл явцын эцэст магадлан итгэмжлэх эсэхийг шийдвэрлэж, магадлан итгэмжилсэн тохиолдолд тодорхой хугацаанд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгодог. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь дараах үе шатаас бүрдэнэ. Үүнд: (I) магадлан итгэмжлэх байгууллагаас тогтоосон шалгуур, стандартад тухайн байгууллага эсвэл хөтөлбөр нийцэж буй эсэх талаар багш, ажилтан, удирдах албаны хүмүүс өөрийн үнэлгээ хийж, тайлан бэлтгэх; (II) магадлан итгэмжлэх байгууллагын томилсон хөндлөнгийн шинжээчийн баг нотлох баримтад тулгуурлан сургуульд ажиллаж, хөндлөнгийн үнэлгээ хийн, үр дүнг тайлагнах ба тайланд сайжруулах зөвлөмжийг тусгах; (III) шинжээчийн багийн дүгнэлт, холбогдох нотолгоо, зөвлөмжийг тогтоосон шалгуурын дагуу шүүн хэлэлцэж, албан ёсны шийдвэрийг

educational program in order to formally recognize it as having met certain predetermined minimal criteria or standards. The result of this process is usually the awarding of a status (a yes/no decision), of recognition, and sometimes of a license to operate within a time-limited validity. The process can imply initial and periodic self-study and evaluation by external peers. The accreditation process generally involves three specific steps: (I) a self-evaluation process conducted by the faculty, the administrators, and the staff of the institution or academic program, resulting in a report that takes as its reference the set of standards and criteria of the accrediting body; (II) a study visit, conducted by a team of peers, selected by the accrediting organization, which reviews the evidence, visits the premises, and interviews the academic and administrative staff, resulting in an assessment report, including a recommendation to the

| | | | |
|---|---|---|---|
| | | сургууль болон холбогдох талуудад мэдээлэх; | commission of the accrediting body; (III) an examination by the commission of the evidence and recommendation on the basis of the given set of criteria concerning quality and resulting in a final judgment and the communication of the formal decision to the institution and other constituencies, if appropriate. (UNESCO-CEPES, 2007) |
| *Магадлан итгэмжлэлийн мэдээллийн сан*<br><br>*Portfolio for Accreditation*<br><br>*Портфолио для аккредитации* | Megeoelea fidekimjile& oa Medekile& oa Seit | Сургалтын байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ, баталгаажуулалтын явцад цуглуулсан мэдээллийн сан. Энэхүү үйл ажиллагааг тухайн байгууллага өөрөө эсвэл хөндлөнгийн шинжээч-ажиглагч хэрэгжүүлнэ. | An accumulation of evidence (record of achievement) about specific proficiencies and the characteristics of an institution in relation to a specific type of activity, especially to learning standards. This operation can be performed either by the concerned institution or by an external assessor. (UNESCO-CEPES, 2007) |
| *Магадлан итгэмжлэлийн статус*<br><br>*Accreditation status*<br><br>*Статус аккредитации* | Megeoelea fidekimjile& oa SDeDoi | Үндэсний, бүс нутгийн, мэргэшлийн түвшинд магадлан итгэмжлэх байгууллагаас тогтоосон боловсролын зохих чанарын шалгуур, стандартыг тухайн сургууль эсвэл хөтөлбөр | The formal recognition benefiting an institution or specialized program for meeting the appropriate standards of educational quality established by the accrediting body at a regional, national, |

M

| | | | |
|---|---|---|---|
| | | хангасан болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдал. | or specialized level. (UNESCO-CEPES, 2007) |
| *Магадлан итгэмжлэлийн судалгаа*<br><br>*Accreditation survey*<br><br>*Обзор/Отчет/ Обследование аккредитации* | Megeoelea fidekımjile& oa Sodol)T | Магадлан итгэмжлэх байгууллагаас тогтоосон шалгуур, стандартыг ямар түвшинд хангаж буйг тодорхойлох, магадлан итгэмжлэлийн статусыг тогтоох зорилго бүхий үнэлгээ. Томилогдсон шинжээчдийн баг дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж, тухайн байгууллагаас ирүүлсэн баримт бичиг, холбогдох мэдээлэл (нотлох баримт)–д хийсэн үнэлгээ нь магадлан итгэмжлэлийн судалгаанд хамаарна. | The evaluation of an institution to identify its level of compliance with the applicable standards of the accreditation body and to make determinations concerning its accreditation status. The survey includes an evaluation of documents and information (evidence) provided by the personnel of the higher education institution, following on-site observations by mandated visitors. (UNESCO-CEPES, 2007) |
| *Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа*<br><br>*Duration of accreditation / validity of accreditation*<br><br>*Срок действия аккредитации* | Megeoelea fidekımjile& oa Kicoedel Hogoce)T | Магадлан итгэмжилсэн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал нь тодорхой хугацаагаар хязгаарлагдана. Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ хүчинтэй байх хугацааг магадлан итгэмжлэх байгууллагаас тогтоох ба ямар нэгэн алдаа, дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох шийдвэрийг үндэслэн магадлан итгэмжлэлийг цуцлах эрхтэй. | Accreditation decisions are limited in time. The duration of validity of the accreditation license is established by the accrediting body, which generally holds the right to suspend or to renew the license, upon the satisfactory resolution of any identified issues. (UNESCO-CEPES, 2007) |

*Магадлан итгэмжлэх байгууллага*

*Accreditation body*

*Аккредитационный орган*

Megeoelea fidekimjilek bijigolol)T

Магадлан итгэмжлэх шалгуур, стандартыг боловсруулж, шинжээчийн баг томилон, уг шалгуур стандартыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийх үндэсний эсвэл бүс нутгийн төрийн (бус), хувийн хэвшлийн боловсролын холбоо (нийгэмлэг). Энэ байгууллага нь магадлан итгэмжлэх эсэх талаар шийдвэр гаргах, магадлан итгэмжилсэн тохиолдолд тодорхой хугацаанд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрхтэй. Магадлан итгэмжлэх байгууллага нь олон хэлбэр (агентлаг, зөвлөл, комисс г.м.)-тэй. Магадлан итгэмжлэх байгууллагыг бүс нутгийн болон олон улсын сүлжээнд дэмжлэг үзүүлж, бэхжүүлэхийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) болон НҮБ-ийн Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас (UNESCO) уриалдаг.

A (non-) governmental or private educational association of national or regional scope that develops evaluation standards and criteria and conducts peer evaluations and expert visits to assess whether or not those criteria are met. It is entitled to accord formal status and sometimes a license to operate to individual higher education institutions or programs, following the successful examination of the application and evaluation of the respective educational unit. There are different types of accreditation bodies (e.g. agencies, councils, commissions, etc.). Also, one of the OECD-UNESCO recommendations requests agencies to sustain and strengthen the existing regional and international networks. Related terms: Assessment, Criteria, Evalution, Quality, Quality Assurance, Recogniton, Standards. (UNESCO-CEPES, 2007)

M

M

| | | | |
|---|---|---|---|
| *Магистрант*<br><br>*Graduate student*<br><br>*Магистрант* | MekisDrenDA | Магистрын шатлалд суралцагч. Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр ахисан түвшний судалгаа гүйцэтгэж буй суралцагч. | A learner enrolled in master degree course. Graduate student who has earned a bachelor's degree and is pursuing additional education in specific field. (The Law of Mongolia on Higher Education, 2002). |
| *Магистрын сургалтын хөтөлбөр*<br><br>*Master's program / Graduate program*<br><br>*Программа для магистратуры* | MekisD* oa SorgelDa iia KidolBrl | Бакалаврын түвшний сургалтын дараах 2 жилийн ахисан түвшний хөтөлбөр. 5 жилийн докторын хөтөлбөрийн хувьд сургалтын эхний 2 жил нь магистрын зэргийн сургалт байдаг бөгөөд энэ тохиолдолд "докторын хөтөлбөрийн эхний шат" гэж үздэг. | A two-year graduate program at a higher level than the bachelor's. Students who complete a master's program are awarded a master's degree. In the context of a five-year doctoral program, it means the first two years of the curriculum leading to a master's degree. In this case, it is also called a "first stage doctoral program". (NIAD-QE, 2016) |
| *Ментор*<br><br>*Mentor*<br><br>*Ментор* | MmnDo* | Залуучууд, суралцагчдад янз бүрийн хэлбэрээр зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг туршлагатай хүн. Ментор нь гол төлөв үлгэр дуурайл болж, чиглүүлэгч, зааварлагч, дадлагажуулагч, халамжлан зөвлөгчийн үүрэг гүйцэтгэдэг. | An experienced person who provides guidance and support in a variety of ways to a young person or novice (i.e., someone joining a new learning community or organization). The "Mentor" often acts as a role model, guide, tutor, coach or confidante. (VETP-1, 2018) |

| | | | |
|---|---|---|---|
| *Мета - үнэлгээ*<br><br>*Meta-evalution*<br><br>*Мета-оценка* | MwDa - foinelekit | Үнэлгээний чанарт хийх үнэлгээ. Хийж буй үнэлгээний үр өгөөж болон шинжээчийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашигладаг. | The assessment of the quality of evaluation itself. It is used to assess the effectiveness of the evaluation being carried out and the evaluators' performance. (ANQA, 2016) |
| *Модулийн тодорхойлолт*<br><br>*Module specification*<br><br>*Спецификация модуля* | ModoilI iia Dodoreeeiilelda | Модулийн тодорхойлолт нь нэгж судлагдахуунд хамааралтай зорилго, зорилт буюу суралцахуйн үр дүн, агуулга, суралцахуйн болон багшлахуйн үйл явц, оюутны үнэлгээний хэлбэр, сургалтын нөөц материалын талаарх тайлбар юм. | Module specification is statement of the aims, objectives/learning outcomes, content, learning and teaching processes, mode of assessment of students and learning resources applicable to a unit of study. (INQAAHE, 2017) |
| *Модуль*<br><br>*Module*<br><br>*Модуль* | ModoilI | Сургалтыг нэгж болгон задалж буй албан сургалтын хэлбэр. Сургалтын хөтөлбөр нь өөр хоорондоо холбоотой модулиудаас бүрдэнэ. | A module is a formal learning experience encapsulated into a unit of study, usually linked to other modules to create a program of study. (INQAAHE, 2017) |
| *Мэдлэг*<br><br>*Knowledge*<br><br>*Знание* | MedelKit | Боловсролын үйлчилгээ болон амьдралын туршлагаасаа олж авдаг дэлхий ертөнц, хүн, нийгмийн талаарх харилцан уялдаатай ойлголт, бодит мэдээлэл. Нэршлийн мэдлэг (Declarative knowledge) нь "юуг мэдэх" (жишээ нь: юмс, үзэгдлийн | The body of concepts and factual information (data), including their interrelated structures and patterns, concerning the natural and social environment as well as our understanding of the world, people and society, gained through learning and/or experience. |

M

| | | | |
|---|---|---|---|
| | | талаарх нэршил, бодит мэдээлэл), харин үйлийн мэдлэг (procedural knowledge) “яаж мэдэх” (жишээ нь: ажил, даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай үйлийн талаарх мэдлэг)-ийг тодорхойлдог. | Declarative knowledge points to ‘knowing what’ (e.g. factual knowledge), while procedural knowledge to ‘knowing how’, e.g. knowledge of specific functions and procedures to perform a complex process, task or activity. (UNESCO, 2013) |
| *Мэдлэгт суурилсан нийгэм*<br><br>*Knowledge society*<br><br>*Общество знания* | Medelkit dO Segorileesea Neiik | Хүний хөгжлийн төлөө мэдлэг бүтээх, хэрэглэх зорилгоор мэдээлэл олж авах, өгөх, боловсруулах, дамжуулах, түгээх, ашиглах орчин. Мэдлэгт суурилсан нийгэм нь олон ургалч байдал, тэгш хамрагдалт, нэгдмэл байдал болон оролцоог чухалчилсан шинж чанартай байдаг. | Knowledge societies are about capabilities to identify, produce, process, transform, disseminate and use information to build and apply knowledge for human development. They require an empowering social vision that encompasses plurality, inclusion, solidarity and participation. (UNESCO, 2013) |
| *Мэдлэгт суурилсан эдийн засаг*<br><br>*Knowledge-based economy*<br><br>*Экономика, основанная на знаниях* | Medelkit dO Segorileesea fdA oa Jese( | Мэдлэг, мэдээлэл, өндөр түвшний ур чадварт түлхүү анхаарч бизнесийн болон нийгмийн салбарт тэдгээр ур чадварын хэрэгцээг улам бүр нэмэгдүүлэх чиг хандлага бүхий эдийн засгийн салбар. | An expression coined to describe trends in advanced economies towards greater dependence on knowledge, information and high skill levels, and the increasing need for ready access to all of these by the business and public sectors. (UNESCO, 2013) |

M

| | | | |
|---|---|---|---|
| *Мэдээллийн сан*<br><br>*Portfolio*<br><br>*Портфолио* | MedekEle& oa Seit | Үнэлгээний үйл ажиллагаа, түүнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар цуглуулсан мэдээллийн сан. Мэдээллийн сан нь ололт амжилтыг дэмжих, сайжруулан шат ахиулах, мэдээлэл хуваалцах зорилгоор ашиглагдана.<br>Дээд боловсролын салбарт: оюутны суралцах үйл явц, суралцахуйн хүрэх үр дүн зэргийг агуулсан суралцахуйн мэдээллийн сан; багш нарын удирдсан, зөвлөн тусалсан ажил болон идэвх санаачилгыг агуулсан сургахуйн мэдээллийн сан, багшийн хувийн санаачилгаар гүйцэтгэсэн судалгаа, үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан академик мэдээллийн сангууд ашиглагддаг. | Generally, a record, gathered and accumulated over a certain period, describing evaluated activities, and self-reflections on those activities and related achievements. A portfolio of records and evaluations can be used to back up claims of achievements, as well as to make improvements at the next stage and for sharing information. Specific examples of use in higher education include: learning portfolios that gather and record students' learning processes and various learning outcomes; teaching portfolios that record faculties' achievements and efforts in teaching, including the classes they taught and the supervision they provided; and academic portfolios that record a faculty's individual achievements such as research and service activities in addition to teaching, filtered through self-reflection. (NIAD-QE, 2016) |

M

M

| | | | |
|---|---|---|---|
| *Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)*<br><br>*Information and Communication Technology (ICT)*<br><br>*Информационно-коммуникационная технология* | Medekilel, HerilCe)T HolBgea O DwknolokiA<br>:Me, He, Ho, Dw" | Мэдээлэл дамжуулах, хадгалах, бүтээх, солилцоход ашигладаг олон төрлийн технологийн хэрэгсэл, нөөц. Үүнд: компьютер, интернэт (вэбсайт, блог, мэйл), радио, телевиз, зэрэг өргөн нэвтрүүлгийн технологи (аудио, видео тоглуулагч, хадгалах төхөөрөмж) болон суурин болон хөдөлгөөнт телефон утас, хиймэл дагуул, видео, онлайн хурлын төхөөрөмж зэрэг багтана. | A diverse set of technological tools and resources used to transmit, store, create, share or exchange information. These include computers, the Internet (websites, blogs and emails), live broadcasting technologies (radio, television and webcasting), recorded broadcasting technologies (podcasting, audio and video players, and storage devices) and telephony (fixed or mobile, satellite, visio/video-conferencing, etc.). (UNESCO, 2013) |
| *Мэдээлэл, харилцаа, холбооны технологийн чадвар*<br><br>*Information and communications technology (ICT) skills*<br><br>*Умения /Навыки в области информационно-коммуникационных технологий (ИКТ)* | Medekilel, HerilCe)T, HolBgea O DwknolokiA iia CideBrI | Сүүлийн 3 сарын хугацаанд компьютертой холбоотой дараах жагсаалтад хамаарах тодорхой үйлдлүүдийг хийсэн бол ийм чадвартай гэж тооцно. Үүнд: файл эсвэл хавтсыг хуулах эсвэл зөөх; баримт бичиг дэх мэдээллийг хувилах эсвэл зөөх зэргээр хуулах; файл хавсарган цахим шуудан илгээх (жишээ нь, баримт бичиг, зураг, дүрст бичлэг); хүснэгтэд арифметикийн үндсэн томьёог ашиглах; шинэ техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг холбох, суулгах (жишээ нь, модем, | Individuals are considered to have such skills if they have undertaken certain computer-related activities in the last three months: copying or moving a file or folder; using copy and paste tools to duplicate or move information within a document; sending emails with attached files (e.g. document, picture, video); using basic arithmetic formulas in a spreadsheet; connecting and installing new devices (e.g. a modem, camera, printer); finding, downloading installing and configuring, |

| | | | |
|---|---|---|---|
| | | камер, хувилагч); программ хангамж хайх, татах, суулгах, тохируулах; программ хангамжийг ашиглан цахим илтгэл бэлтгэх (эх бичвэр, зураг, дуу, дүрст бичлэг, график); компьютер болон бусад хэрэгслийн хооронд файл шилжүүлэх; тусгай программын хэл ашиглан компьютерын программ бичих зэрэг орно. | software; creating electronic presentations with presentation software (including text, images, sound, video or charts); transferring files between a computer and other devices; and writing a computer program using a specialized programming language. (UNESCO G. E., 2019) |
| *Мэргэшсэн багшлах бүрэлдэхүүн*<br><br>*Professional faculty*<br><br>*Профессиональный преподавательский состав* | Merkisiksea bieesileeO BirildoKa | Тухайн салбартаа таван жил ба түүнээс дээш хугацаанд ажилласан, мэргэжлийн болоод багшлах өндөр дадлага, ур чадвартай мэргэжлийн ахисан түвшний сургуулийн багшлах бүрэлдэхүүн. | Academic staff of a professional graduate school, who have advanced practical skills with five or more years of career in the field they teach. (NIAD-QE, 2016) |
| *Мэргэжлийн боловсрол*<br><br>*Vocational education*<br><br>*Профессиональное образование* | Merkiji& oa BIbisore& | Суралцагчдад тодорхой ажил мэргэжил, бүлэг мэргэжилд хамааралтай мэдлэг, ур чадвар, чадамжийг эзэмшүүлэхэд чиглэсэн боловсролын нэг төрөл. Энэ нь ажлын байранд суурилсан бүрэлдэхүүн хэсэгтэй байж болно. (Жишээ нь: дагалдан сургалт, хосмог боловсролын хөтөлбөр). Энэ хөтөлбөрийг амжилттай дүүргэснээр үндэсний хэмжээний | Education programmes that are designed for learners to acquire the knowledge, skills and competencies specific to a particular occupation, trade, or class of occupations or trades. Vocational education may have work-based components (e.g. apprenticeships, dualsystem education programmes). Successful completion of such |

| | | | |
|---|---|---|---|
| | | эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжлийг эзэмшдэг. | programmes leads to labour market-relevant vocational qualifications acknowledged as occupationally-oriented by the relevant national authorities and/or the labour market. (UNESCO, 2013) |
| *Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)*<br><br>*Vocational education and training (VET)*<br><br>*Профессиональное образование и обучение* | Merkijil oa Blbisoreg, Sorgelda | Тодорхой мэргэжилд шаардлагатай эсвэл хөдөлмөрийн зах зээл дээр илүү эрэлттэй мэдлэг, ноу-хау, мэргэжил, ур чадвар, чадамж эзэмшүүлэх боловсрол, сургалт. | Education and training which aim to equip people with knowledge, know-how, skills and/or competences required in particular occupations or more broadly on the labour market. (UNESCO, 2013) |
| *Мэргэжлийн ёс зүйн код (магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтад)*<br><br>*Code of professional ethics (in quality assurance and accreditation)*<br><br>*Моральный кодекс (в аккредитации и обеспечении качества)* | Merkijil oa YosO Joil iia \| dA :Cine* oa bidolegejigololda Megeoelea fidekimjilea" | Дээд боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шийдвэр гаргах болон ёс зүй, зан төлөвийн хэм хэмжээг тодорхойлсон олон нийтэд нээлттэй баримт бичиг. | A public document establishing a framework for ethical behaviour and decision making in the conduct of quality assurance and accreditation activities in higher education. (UNESCO-CEPES, 2007) |

M

| | | | |
|---|---|---|---|
| *Мэргэжлийн зэрэг олгох хөтөлбөр*<br><br>*Professional degree program*<br><br>*Программа для профессиональной подготовки* | Merkijil& oa Jerkit folgoeO KidolBrl | Мэргэжлийн ахисан түвшний сургуулиас хэрэгжүүлж буй хөтөлбөр. | A program offered by professional graduate schools. (NIAD-QE, 2016) |
| *Мэргэжлийн сургалтын коллеж*<br><br>*Professional training college*<br><br>*Колледж профессиональной подготовки* | Merkijil& oa Sorgelda iia J llwjl | Дунд сургууль төгссөн суралцагчдыг элсүүлж мэргэжлийн суурьтай дээд боловсрол, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага. | A specialized training college offering practical/ vocational higher education, which requires graduation from upper secondary schools for admission. (NIAD-QE, 2016) |
| *Мэргэжлийн суурь чадвар*<br><br>*Vocational basic skills*<br><br>*Профессиональные навыки* | Merkijil& oa Segorl CideBrl | Нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшил. | Professional basics is knowledge, skills and behaviour required to engage in social relations. (The Law of Mongolia on Vocational Education and Training, 2009) |
| *Мэргэжлийн түвшнийг хүлээн зөвшөөрөх*<br><br>*Professional recognition*<br><br>*Профессиональное признание* | Merkijil& oa Doibsia l Kiliyea JoibsiyereK | Тухайн мэргэшлийг эзэмшигч хувь хүний мэргэжлийн түвшин, түүгээрээ ажиллах эрх. Зэрэг, цолыг хүлээн зөвшөөрөх тогтолцоо янз бүр байдаг. Үүнээс хоёр төрлийг авч үзвэл: 'de Jure Professional Recognition' нь тодорхой хуулиар зохицуулагддаг аливаа мэргэжлээр | Refers to the right to practice and the professional status accorded to a holder of a qualification. Owing to different regulations for the recognition of degrees or titles, a differentiation of two groups should be made: 'de Jure Professional Recognition' applies to the right to |

| | | | |
|---|---|---|---|
| | | (тухайлбал, эмчээр) гадаадын улс оронд ажиллах эрх. De Facto Professional Recognition' нь үндэсний ямар нэг хууль тогтоомж байдаггүй эсвэл хуулийн зохицуулалт шаардлагагүй нөхцөлд мэргэжлийг хүлээн зөвшөөрөх, мэргэжлээр ажиллах эрхэд хамаарна. | work in a specific country in a legally regulated profession (e.g. as a medical doctor). 'De Facto Professional Recognition' refers to situations of unregulated professional recognition, such as situations in which no national legal exists or is required. (UNESCO-CEPES, 2007) |
| *Мэргэжлийн үндсэн ур чадвар*<br><br>*Vocational key skills*<br><br>*Профессиональные основные навыки* | fo*T CideBrl Merkɛji& oa foiedosoa | Аливаа ажил үүрэг бие даан гүйцэтгэх, ажиллах, өөрчлөлтөд зохицон өсөж хөгжих чадвар. | Abilities to perform tasks and assignments independently, to work and develop yourself adapting to changes. (The Law of Mongolia on Vocational Education and Training, 2009) |
| *Мэргэжлийн хандлага*<br><br>*Professionalism*<br><br>*Профессионализм* | Merkɛji& oa Heedol)T | Нийгэм 'мэргэжилтэн' хэмээн хүлээн зөвшөөрсөн аливаа этгээд ажил үүргээ гүйцэтгэхдээ баримтлах хандлага, ур чадвар, зан суртахуун, шинж чанар, эрхэмлэх зүйлсийн нэгдлийг илэрхийлсэн нэр. | The term professionalism embraces a set of attitudes, skills and behaviours, attributes and values which are expected from those to whom society has extended the privilege of being considered a professional. (Davaadulam, 2010) |
| *Мэргэжлийн хөтөлбөр*<br><br>*Study program*<br><br>*Программа* | Merkɛji& oa KidolBrl | Боловсролын зэрэг авахад заавал судлах тодорхой мэргэжлийн салбарын үндсэн модуль бүрэлдэхүүн хэсэг. Үүнд: суралцахуйн дизайны төлөвлөлт, зохион байгуулалт, удирдлага | A core, modular component of higher education including all the activities (design, organization, management, as well as the process of teaching, learning and research) carried out in a |

M

болон сургалт, судалгааны үйл ажиллагаа хамаарна. Сургалтын байгууллагын боловсруулсан хөтөлбөр нь боловсролын зэрэг (бакалавр, магистр, доктор)-ээр, сургалтын хэлбэр (үндсэн, эчнээ анги, зайн болон холимог сургалт)-ээр болон мэргэшиж буй салбараар ялгаатай байдаг. Мэргэжлийн хөтөлбөр нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: 1. Сургалтын төлөвлөгөө (жил, улирлаар төлөвлөсөн хичээлүүдийн жагсаалт); 2. Суралцахуй болон үнэлгээтэй холбоотой хичээлийн сэдэв, практик үйл ажиллагааны мэдээлэл, тодорхойлолтыг агуулсан хичээлийн хөтөлбөр; 3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин, нөөц (оюутан болон багшлах бүрэлдэхүүний талаарх мэдээлэл); 4. Сургалтын хөтөлбөрийг дүүргэхэд шаардлагатай бүхий л үйл ажиллагааны академик чанарын баталгаажуулалтын тогтолцоо зэрэг юм.

certain field and leading to an academic qualification. Study programs are established by higher education institutions or organizations and may differ by level of academic qualification (Bachelor, Master, Doctorate); study mode (full-time, part-time, distance learning, etc.); and field of knowledge specialization. A study program is accomplished through: (I) a curriculum, including all disciplines leading to an academic qualification, distributed by year of study; (II) syllabuses or course programs, containing a description of the teaching and learning themes and practices associated with teaching, learning and evaluation; (III) the organizational chart of students and teaching staff covering the period of implementation of the study program; (IV) the system of academic quality assurance for all activities necessary for the completion of the study program. Related terms: Accreditation, Benchmark, Credits, Evaluation, Higher Education Institution/ Organization, Quality. (UNESCO-CEPES, 2007)

| | | | |
|---|---|---|---|
| *Мэргэжлийн чадамж*<br><br>*Professional competencies*<br><br>*Профессиональная компетенция* | Merk:ji& oa Cidemjl | Мэдээллийн эх сурвалж, хэрэглээ, технологи, үйлчилгээ, удирдлагын чиглэлээр хувь хүний эзэмшсэн мэдлэг хийгээд тэрхүү мэдлэгээ тодорхой зорилтыг амжилттай хэрэгжүүлэх, үр дүнд хүрэхийн тулд ашиглах ур чадвар. | An individual’s specialized knowledge of information sources, access, technology, services, and management, and the ability to critically and effectively evaluate, filter and use this knowledge in order to successfully accomplish specific assignments and obtain results. (UNESCO-CEPES, 2007) |
| *Мэргэшил*<br><br>*Qualification*<br><br>*Квалификация* | Merk:si& | Тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшин. (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009). Эрх бүхий, хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролын сургалтын байгууллагын хэрэгжүүлж буй хөтөлбөрийг дүүргэснийг гэрчлэн олгосон баримт бичиг (зэрэг, диплом эсвэл бусад албан ёсны гэрчилгээ). Үүнд дээд боловсролын сургалтын байгууллагаас олгож буй бүхий л зэрэг (бакалавр, магистр, доктор г.м.)-ийг хамааруулж ойлгоно. Зарим тохиолдолд мэргэжлийн ажил үүрэг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг ч хамруулдаг. | Any higher education award (degree, diploma, or other type of formal certification) issued by a competent, registered authority attesting to the successful completion of a course program. (The law of Mongolia on vocational education and training, 2009). It covers a wide variety of higher education awards at different levels and across different countries (e.g. the Bachelor’s and Master’s Degree, the Doctorate, etc.). Sometimes it is equivalent to a license to practice. Related terms: Assessment, Learning Outcome, Recognition, Validation. (UNESCO-CEPES, 2007) |

M

| | | | |
|---|---|---|---|
| *Мэргэшил олгох байгууллага*<br><br>*Awarding body*<br><br>*Орган по присуждению квалификации* | Merkisi& folgoeO bɨigolol)T | Эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшил, диплом олгох үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага эсвэл консорциум. | An organization or consortium, recognized by the regulatory authorities, whose purpose is to award accredited qualifications. (UNESCO, 2013) |
| *Мэргэшлийн түвшний тодорхойлогч*<br><br>*Qualification descriptors*<br><br>*Дескрипторы уровней квалификаций* | Merkisi& oa Doibsia O Dodoreeeiileeecl | Мэргэшлийн тодорхойлолт гэдэг нь тухайн түвшин (ихэвчлэн зэрэг олгох)-д дээд боловсролын суурь мэргэшлийн хүрэх үр дүнг тодорхойлж, боловсролын түвшин хоорондын өөрчлөлтийн онцлогийг заасан тодорхойлолт. Зарим түвшинд нэг ба түүнээс олон мэргэшлийн төрлүүд байж болно. Мэргэшлийн тодорхойлолтын эхний хэсэг нь тухайн мэргэшлийг эзэмшихийн тулд оюутны эзэмшсэн байвал зохих суралцахуйн хүрэх үр дүнг заасан байна. Хоёрдох хэсэг нь оюутны цаашид хөгжүүлбэл зохих өргөн хүрээтэй ур чадварыг заасан байна. Одоо байгаа мэргэшлийн тодорхойлогчийг тодорхой хугацаанд үнэлэн мөн бусад | Qualification descriptors are statements that set out the outcomes of principal higher education qualifications at given levels (usually of an awarded degree) and demonstrate the nature of change between levels. At some levels, there may be more than one type of qualification. The first part of a qualification descriptor is a statement regarding outcomes, i.e. the achievement of a student that he or she should be able to demonstrate for the award of the qualification. The second part is a statement of the wider abilities that the typical student could be expected to have developed. Upon periodical review of the existing qualification descriptors and in light of the development of other points of reference, such |

бенчмарк тодорхойлолтуудын хөгжил дэвшилтэй нийцүүлэн түвшин тус бүрд нэмэлт мэргэшлийн тодорхойлогчийг боловсруулна. Европын дээд боловсролын талбарыг үүсгэхдээ “Дублины тодорхойлогч” гэх багц тодорхойлогчийг дээд боловсролын салбарын олон улсын шинжээчийн баг (Joint Qulaity Inititative) боловсруулж, Европ даяар олон чанарын баталгаажуулалтын байгууллагууд, бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд жишиг болгон ашиглаж байна. “Дублины тодорхойлогч” тодорхой нэг хязгаарт баригдалгүйгээр мэргэшлийн мөн чанарыг бүхэлд нь тодорхойлохыг зорьсон.

as benchmark statements, additional qualification descriptors at each level are elaborated. In view of the creation of the European Higher Education Area, a set of descriptors known as the ‘Dublin Descriptors’ was developed by an international group of higher education experts (Joint Quality Initiative) and serves as reference for a number of national quality assurance agencies, policy makers and specialists throughout Europe. The Dublin Descriptors seek to identify the nature of a qualification as a whole, without imposing a specific threshold. Related terms: Qualifications, Outcomes, Assessment, Benchmark, Credit. (UNESCO-CEPES, 2007)

M

*Мэргэшлийн үндэсний хүрээ (шаталсан бүтэц)*

*National qualifications framework*

*Национальная рамка квалификаций*

:Zedoleeesea Bidoca"
Merkisi& oa foiedosoa O KiriIT

Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн нийтлэг стандарт, мэргэшлийг тогтоох, эзэмшсэн мэдлэг болон чадамжийг хүлээн зөвшөөрөх, одоо байгаа болон цаашид гарч ирэх мэргэшлийг тодорхойлох, хөгжүүлэх,

Generally, a national qualifications framework (NQF) is designed to provide nationally recognized and homogeneous standards and qualifications, as well as recognition for all learning of knowledge and competencies and a

| | | | |
|---|---|---|---|
| | | үнэлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг. Энэхүү баримт бичиг нь сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийг зохицуулж, хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хэрэгцээ шаардлага, хөгжлийг дэмжих зорилготой. Дунд хугацааны бодлого боловсруулалтын түвшинд олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд үндэсний мэргэшлийн хүрээ (шаталсан бүтэц)-г боловсруулдаг. Европын дээд боловсролын талбар дах улс орнууд мэргэшлийн үндэсний хүрээгээ боловсруулахдаа Европын мэргэшлийн хүрээг жишиг болгон авч, бодлогодоо нийцүүлэн ашиглаж байна. Түүнчлэн Азийн мэргэшлийн хүрээ, Австралийн мэргэшлийн хүрээ гэх зэргээр бүс нутгийн шинжтэй байдаг. | basis for further review, articulation and development of existing and impending qualifications. Also, among other purposes, it should facilitate curricular change and allow for the improvement of access and social inclusion, as well as the integration of changing societal needs. A national qualifications framework is primarily developed through a medium-term process of policy development and public consultation. The NQFs in the European Higher Education Area are expected to be convergent by taking as reference the European Qualifications Framework. (UNESCO-CEPES, 2007) |
| *Мэргэжлийн багш*<br>*Qualified teacher*<br>*Квалифицированный преподаватель* | MerkEjil& oa bEEesI | Тухайн улс орны боловсролын тодорхой түвшинд багшлах хамгийн наад захын шаардлагыг хангасан боловсролын зэрэгтэй, мэргэшил бүхий багш. | Teacher who has the minimum academic qualification necessary to teach at a specific level of education in a given country. (UNESCO G. E., 2019). |

M

| | | | |
|---|---|---|---|
| | | Н | |
| *Насан туршийн боловсрол*<br><br>*Lifelong learning*<br><br>*Образование в течение всей жизни* | Nesoa Dorsl iia Blbisore& | Бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагаа. (Боловсролын тухай хууль, 2002) Хувийн, нийгмийн, мэргэжлийн шалтгаанаар мэдлэг, ноу-хау, ур чадвар, чадамж, мэргэшлээ дээшлүүлэхэд чиглэсэн амьдралын бүхий л хугацааны суралцах үйл ажиллагаа. | The provision or use of both formal and informal learning opportunities throughout people's lives in order to foster the continuous development and improvement of the knowledge and skills needed for employment and personal fulfilment. (The Law of Mongolia on Education, 2002). All learning activity undertaken throughout life, which results in improving knowledge, know-how, skills, competences and/or qualifications for personal, social and/or professional reasons. (UNESCO, 2013) |
| *Насанд хүрэгчдийн боловсрол*<br><br>*Adult education*<br><br>*Обучение взрослых* | Nesoa dO Kirokcioa oa Blbisore& | Насанд хүрэгчдийн техникийн болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, албан боловсрол эзэмшүүлэх, эсхүл тодорхой чиглэлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, сэргээх, сайжруулах зорилго бүхий боловсролын нэг төрөл. Өнөөдөр насанд хүрэгчдийн боловсрол нь албан бус сургалтаас, эсвэл амьдралын туршлагаас | Education specifically targeted at individuals who are regarded as adults by their society to improve their technical or professional qualifications, further develop their abilities, enrich their knowledge with the purpose to complete a level of formal education, or to acquire, refresh or update their knowledge, skills and competencies in a particular field. In, |

Н

| | | | |
|---|---|---|---|
| | | олж авах чадвар гэх мэт олон хэлбэрээр хөгжиж буй бөгөөд насан туршийн боловсролын бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. | many contexts today competencies acquired in non-formal or informal education – including different forms of adult education – are increasingly recognized as part of lifelong learning. (UNESCO, 2013) |
| *Нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуй*<br><br>*Social and emotional learning (SEL)*<br><br>*Социально-эмоциональная учебная деятельность* | Neiik^ - Seoeku& Kidelo& oa Sorolceeol | Өөрийгөө илэрхийлэх, нийгэм хамт олон, бусдын санаа бодлыг хүлээж авах, зүй зохистой харьцах харилцаа, сэтгэл хөдлөл, мэдрэмж, үзэл бодлоо харилцан солилцоход суралцах үйл ажиллагаа. Энэ нь хүмүүсийн сэтгэл хөдлөлийг таньж мэдэх, өрөвдөх, энэрэх сэтгэл, мэдрэмжийг хөгжүүлэх эерэг харилцааг бий болгоход чиглэгддэг. Мөн эерэг харилцаа үүсгэх, уян хатан байх, бэрхшээлтэй нөхцөл байдлыг шийдвэрлэх, зөв шийдвэр гаргах, бусдад санаа тавих мэдлэг, чадвар, хандлагыг суралцагчдад эзэмшүүлэхэд оршино. Ихэнхдээ өөрийгөө таньж мэдэх, удирдах, нийгмээ таних, хариуцлагатай шийдвэр гаргах, эерэг харилцааг бий болгох зэрэг ур чадварт түлхүү анхаардаг. | Learning how to manage feelings and relationships with others. This includes ways to also recognize emotions and to maintain positive relationships in developing sympathy and empathy. It involves the acquisition of knowledge, skills and attitudes that learners need to create positive relationships, build resilience, handle challenging situations, make appropriate decisions and care for others. Commonly it focuses on skills such as self-awareness, selfmanagement, social awareness, relationship skills and responsible decision-making. (UNESCO, 2013) |

Н

| | | | |
|---|---|---|---|
| *Нийтийг хамарсан нээлттэй цахим хичээл*<br><br>*MOOC (Massive Open Online Course)*<br><br>*Массовый открытый онлайн-курс* | Neiida il Hemoroeesea Nekikilda Del Cekil^ kiciyel | Веб технологийг ашиглан олон тооны суралцагчдад бакалаврын болон ахисан түвшний хичээлийг чөлөөтэй ашиглах боломжийг олгодог бөгөөд суралцагчийн суралцсан түүхийг хадгалж байдаг платформ. Энэхүү хичээлийн хамгийн том жишээ бол АНУ–д төвтэй, бизнесийн компаниудаас санхүүждэг Coursera, edX, Их Британид байршилтай, их сургуулиудаас голчлон санхүүждэг FutureLearn зэрэг юм. Сургалтын агуулгаа нийтэд хүргэхийн тулд их сургуулиуд мэдээллийн дээрх талбаруудтай хамтран ажилладаг. | Platforms that provide free online courses at the undergraduate and graduate levels to large numbers of learners simultaneously using web technology and that can record their learning histories. At present, the leading examples are the us-based coursera, which has been funded with venture capital, and the us-based edx and uk-based futurelearn, which rely mainly on funding from universities. Universities cooperate with these platforms to provide courses. (NIAD-QE, 2016) |
| *Нийцэл*<br><br>*Consistency*<br><br>*Согласованность/ Связность* | Neiicel | Алдаа дутагдлыг арилгах хэрэгцээг чухалчилсан чанарыг эрхэмлэсэн хандлага. | Consistency is an approach to quality that emphasizes the need to eliminate errors. (INQAAHE, 2017) |
| *Ногоон ур чадвар*<br><br>*Green skills*<br><br>*Зеленые навыки* | Nogogea fo*T CideBrl | Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааны хүрээнд нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг дэмжих, түүнийг хөгжүүлэхийн тулд хүний нөөцөд шаардлагатай техникийн мэдлэг, чадвар, үнэт зүйл, хандлагын цогц. | Technical skills, knowledge, values and attitudes needed on the workforce to develop and support sustainable social, economic and environmental outcomes in business, industry and the community. (TESDA, 2017) |

Н

| | | | |
|---|---|---|---|
| *Ном зүй*<br><br>*Bibliography*<br><br>*Библиография* | No^ Joil | Судалгааны ажилд ашигласан эх сурвалжийн жагсаалт. Гол төлөв судалгааны материалын төгсгөлд эсвэл хавсралтад ордог. | A list of the books referred to in a research project. It usually appears at the end, or as a separate section, known as an appendix. (Noori, 2018) |
| *Нормд харьцуулсан үнэлгээ*<br><br>*Norm-referenced assessment*<br><br>*Нормативно-ориентированная оценка* | Nor^ dO Hericegoloeesea foinelekit | Суралцагчийн амжилт, ахицыг үе тэнгийнхэн, нэг ангийнхны амжилтын түвшин эсвэл түүврийн ижил төстэй хүн амын дунджийг ашиглан хийдэг үнэлгээ. | Assessment of learner's progress and achievement with reference to the levels of achievement of his/her peer group and/or by reference to norms derived from a sample of a similar population. (UNESCO, 2013) |
| *Ноу-хау*<br><br>*Know-how*<br><br>*Ноу-хау* | NoO - HeO | Ноу-хау гэдэг нь үйлдвэрлэл, удирдлага, худалдаа, санхүүгийн үнэ цэнэ бүхий мэдлэг, туршлагыг хэлэх бөгөөд хуулиар эрхийн хамгаалалт хийгдээгүй, нууцлагдсан, эзэмшиж ашиглахад тодорхой мэргэшил шаардагддаг. | Know-how refers to any knowledge or experience of production, management, trade or financial values as well as concealed which is not protected by law rights and requires certain qualification to possess or use it. (The Law of Mongolia on Technology Transfer, 1998) |
| *Нэг сэдэвт бүтээл*<br><br>*Monograph*<br><br>*Монография* | Nikit Sedobd0 Bidokü | Шинжлэх ухааны тодорхой сэдвээр эсвэл сэдвийн нэг хүрээг хамран судлан туурвисан судалгааны мэргэжлийн түвшний бүтээл. Ихэвчлэн нэг зохиогчтой байдаг. | A monograph is a specialist work of writing on a single subject or an aspect of a subject, often by a single author, and usually on a scholarly subject. https://en.wikipedia.org/wiki/Monograph |

Н

*Нээлттэй боловсрол*

*Open education*

*Открытое образование*

Nekikilda DeI BIbisore&

1. Нээлттэй боловсрол гэдэг нь дэлхий дахинд боловсролын хүртээмж болон үр өгөөжийг сайжруулахын тулд нээлттэй хуваалцах гэсэн зарчмын хүрээнд хэрэглэгдэж байгаа сургалтын эх нөөц, арга хэрэгсэл, практикийг багтаасан ойлголт юм.
2. Нээлттэй боловсрол нь хүмүүсийн мэдлэг бүтээн хуваалцах үйл явц, үүн дээр тулгуурлан шинэ мэдлэг бий болгодог арга замын талаарх философи юм. Энэ ертөнц дээрх хүн бүр сайн чанартай боловсролын эх нөөцөд хандаж, суралцах боломжоор хангагдах хэрэгтэй бөгөөд үүний тулд саад бэрхшээлүүдийг нь арилгах шаардлагатай. Эдгээр саад бэрхшээлд санхүүгийн зардал, хэрэгцээнээс гарсан сургалтын материал, эсхүл эрдэмтэд болон сурган хүмүүжүүлэгчдийн хамтын ажиллагааг хязгаарласан хууль эрх зүйн механизм зэрэг багтана

1. Open education encompasses resources, tools and practices that employ a framework of open sharing to improve educational access and effectiveness worldwide. (www.oeconsortium.org/about-oec/)
2. Open education is a philosophy about the way people should produce, share, and build on knowledge. Proponents of open education believe everyone in the world should have access to high-quality educational experiences and resources, and they work to eliminate barriers to this goal. Such barriers might include high monetary costs, outdated or obsolete materials, and legal mechanisms that prevent collaboration among scholars and educators. (www.opensource.com)

Н

| | | | |
|---|---|---|---|
| *Нээлттэй их сургууль*<br><br>*Open university*<br><br>*Открытый университет* | Sorgegol I Nekikilda Del Yekit | Мэдээлэл, холбоо, харилцааны технологийг ашиглан зайнаас суралцаж, боловсрол, мэргэжил эзэмших боломжийг олгож буй их сургууль. | A university that provides opportunities to access to education and a profession from a distance using ICT. (Mongolia's Master Plan to develop Education in 2006-2015, 2006) |
| *Нээлттэй хичээл*<br><br>*Open class*<br><br>*Открытый урок* | Nekikilda Del kicIye& | Багц цаг тооцдоггүй, хичээлээс гадуур зохион байгуулж буй лекц, семинар. Дээд боловсролын сургалтын байгууллагууд нийгмийн болон үйлдвэрлэлийн салбарын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын үндсэн хөтөлбөрийг тасалдуулахгүйгээр тодорхой түвшинд нийцүүлэн нээлттэй хичээлийг зохион байгуулдаг. | Lectures and seminars without the awarding of credits held by academic institutions outside regular courses. These are held at an appropriate level in response to the specific needs of the community and industry, without interrupting the conduct of full-time study programs. (NIAD-QE, 2016) |

Н

*Олон улсын жишиг үнэлгээ*

*International benchmarking*

*Международный бенчмаркинг*

folea folo_ oa Jiziit foinelekt

Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор цуглуулсан янз бүрийн үнэлгээний хэмжигдэхүүн, технологийг илэрхийлэх үйл явц. Кейс судалгааны арга, гүйцэтгэлийн үзүүлэлт ашиглан бенчмаркинг хийж болно. Нэг улсын үзүүлэлтийг бусад улсынхтай харьцуулж, улс орнуудын дээд боловсролын тогтолцооны ижил төстэй болон ялгаатай байдлуудыг тодорхойлох, улмаар дэлхийн түвшний боловсрол эзэмшүүлэх сорилтыг даван туулах шинэ арга барилыг дэвшүүлдэг. Олон улсын жишиг үнэлгээ нь дэлхийн түвшний чанартай боловсролын тогтолцоог бий болгох, үр дүн, үр өгөөж, хариуцлагыг бэхжүүлэх хэрэгсэл болох олон улсын стандартын түвшинд хүргэдэг. Олон улсын харьцуулалтын нотолгоонд суурилсан үр дүн нь үндэсний бодлого боловсруулахад ач холбогдолтой хэдий ч судлаачид бусдын амжилтыг хэрсөнд буулгахдаа болгоомжтой хандахыг зөвлөдөг.

The term benchmarking is used to describe a large variety of different measurement and evaluation technologies which have been collected to improve organizational performance. Benchmarking can be conducted using a case study approach or through performance indicators. International indicators provide an opportunity to compare a country performance with that of other countries, to identify similarities and differences between one system and others, and to suggest new approaches to the challenge of providing a world-class education. International benchmarks lead to international standards as a tool to ensure high quality, effectiveness and accountability and achieve a worldclass education system. While evidence from international comparisons is certainly useful to inform national policies, most researchers and analysts recommend being cautious in interpreting the success of others. (UNESCO, 2013)

*Олон улсын их сургууль*

*International university*

*Международный университет*

folea folo_ oa Yekit Sorgegoll

Олон улсын их сургууль нь олон орны засгийн газрын санхүүжилт, хяналт дор үйл ажиллагаа явуулдаг бөгөөд бүс нутгийн болон олон улсын байгууллагууд ихэвчлэн үүсгэн байгуулдаг. Их сургуулийн хувьд олон улсын, 2 улсын, улс хоорондын, үндэстэн дамнасан, дэлхийн түвшний хэмээн нэрлэгдэх ойлголт нь маргаан дагуулдаг. Олон улсын их сургууль гурван хэлбэртэй. (I) Олон улсын түнш байгууллагуудтай, гадаад оюутан болон албан хаагчидтай, олон талт хамтын ажиллагаа бүхий их сургууль. Энэ нь хамгийн нийтлэг хэлбэр бөгөөд дэлхийн улс орнуудад их сургуулиудыг олон улсжуулах (internationalize) зорилгыг тусгасан байдаг. (II) Салбар сургууль, кампус, судалгааны төв, менежментийн төслийн алба зэрэг хэлбэрээр төлөөллөө дэлхийн бусад улс орнуудад байгуулсан их сургуулиуд юм.

An international university is funded by the governments of many countries and thereby is controlled by the officials from the government of different countries. These universities are often formed by the regional and international organizations. There is much confusion as to what it actually means for a university to be international, bi-national, transnational, multinational or global. Here are three “generations” of international universities. There are variations within each group. The 1st generation is an internationalised university with a diversity of international partnerships, international students and staff, and multiple collaborative activities. This is the most common type and reflects the internationalisation mandate of universities in countries around the world. The 2nd generation includes universities that have established satellite offices in different

О

| | | | |
|---|---|---|---|
| | | (III)Хоёр ба түүнээс дээш улс орны түнш байгууллагууд хамтран байгуулсан эсхүл хөгжүүлсэн шинэ хэлбэрийн бие даасан их сургууль юм. | countries of the world in the form of branch campuses, research centres and management/project offices. The 3rd and most recent generation of international universities are new, standalone institutions co-founded or co-developed by two or more partner institutions from different countries. (OECD, 2014) |
| *Олон хэлний боловсрол*<br><br>*Multilingual education*<br><br>*Мультилингвальное образование* | folea kilea O Blbisore& | Эх хэлийг оролцуулаад дор хаяж хоёр өөр хэлийг эзэмшихэд чиглэсэн боловсролын нэг төрөл. | The use of at least three languages in education including mother language. (UNESCO, 2013) |
| *Оношлох үнэлгээ*<br><br>*Diagnostic assessment*<br><br>*Диагностическая оценка* | fonosileeO foineIekit | Суралцагчийн суралцах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тэдний давуу болон сул талыг тодорхойлох үнэлгээ. Сургалтын өмнө суралцагчийн бэлэн байдал болон чадварын түвшнийг үнэлэхэд ашигладаг. | Assessment aimed at identifying a learner's strengths and weaknesses with a view to taking necessary action to enhance learning. Also used prior to the teaching and learning process to appraise the learner's readiness or level of achievement. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Оролцогч тал*<br><br>*Stakeholders*<br><br>*Заинтересованные стороны / Стейкхолдер* | forolceecl De&T | Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд шууд болон дан байдлаар оролцдог хүмүүс (оюутан, эцэг эх, ажилд орохоор хүсэлт гаргагч, ажил олгогч). | In the higher education sector, the term is generally used to describe people with an interest in, or a connection with, higher education institutions such as students, parents, applicants, and employers. (NIAD-QE, 2016) |
| *ОУСҮХ (Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр)*<br><br>*PISA (Programme for International Student Assessment)*<br><br>*Международная программа по оценке образовательных достижений учащихся* | fo , fo , So , foi , Ki :folea folo_ oa Soroeecioa oa foimelekia O KidolBrl" | Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас (ЭЗХАХБ) 1997 онд эхлүүлсэн ОУСҮХ нь олон улсын түвшинд зөвшилцсөн нийтлэг шалгуураар 15 настнуудын сурлагын амжилтыг тогтмол хэмжиж боловсролын тогтолцооны үр дүнд хяналт тавьдаг. Энэ нь насанд хүрэгчдийн ахуй амьдралд хэрэгцээтэй ур чадварыг тогтоох шинэлэг арга хэлбэрээр боловсролын чиг хандлагыг тодорхойлж, хэрэгжүүлэх зорилготой хамтын ажиллагаа, бодлогын хэлэлцүүлгийн суурь юм. ОУСҮХ нь амьдралын өдөр тутмын үйл ажиллагаа, асуудлыг шийдвэрлэхэд сургалтын хөтөлбөрийг чиглүүлэх зорилгоор шаардлагатай мэдлэг, | Launched by the Organization for Economic Cooperation and Development (OECD) in 1997, PISA represents a commitment by governments to monitor the outcomes of education systems through measuring 15-year-old student achievement on a regular basis and within an internationally agreed common framework. It aims to provide a new basis for policy dialogue and for collaboration in defining and implementing educational goals, in innovative ways that reflect judgements about the skills that are relevant to adult life. The PISA assessment takes a broad approach to measuring knowledge, skills and attitudes that reflect current changes in |

| | | | |
|---|---|---|---|
| | | ур чадвар, хандлагыг тогтоож, хэмжих өргөн цар хүрээтэй арга мөн. Сурагчдад хэл бичиг, математик, шинжлэх ухаан зэрэг голлох хичээлээр мэдлэг эзэмшихээс гадна сурч мэдсэн зүйлээ янз бүрийн шинэ нөхцөл байдалд ашиглах чадварыг нь үнэлэхэд анхаардаг. | curricula, moving beyond the school-based approach towards the use of knowledge in everyday tasks and challenges. PISA covers the domains of reading, mathematics and science not merely in terms of whether students can reproduce specific subject matter knowledge, but also whether they can extrapolate from what they have learned and apply their knowledge in novel situations. (UNESCO, 2013) |
| *Оюуны шилжих хөдөлгөөн*<br><br>*Brain drain*<br><br>*Утечка мозгов* | KidelKkia foyoa 0 SiljiK | Өндөр боловсрол, ур чадвартай хувь хүмүүс эх нутгаасаа гадаад оронд суурьшихаар шилжин нүүх, цагаачлах хөдөлгөөн. | Emigration of (highly) skilled individuals from the country of origin. (UNESCO G. E., 2019) |
| *Оюутан*<br><br>*Student*<br><br>*Студент* | foyodea | Их сургууль, дээд сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд суралцагч. | A student at a university, a college, or a college diploma and a bachelor's degree. (The Law of Mongolia on Higher Education, 2002) |
| *Оюутан солилцооны хөтөлбөр*<br><br>*Student exchange program*<br><br>*Программа студенческого обмена* | KidolBrl foyodea SolilCegea 0 | Дунд сургууль эсвэл их, дээд сургуулийн оюутнууд суралцаж буй сургуулийнхаа гадаадын аль нэг хамтын ажиллагаатай сургалтын байгууллагад суралцах | A student exchange program is a program in which students from a secondary school or university study abroad at one of their institution's partner institutions. |

O

| | | | |
|---|---|---|---|
| | | хөтөлбөр. Оюутан солилцооны хөтөлбөр нь хувь хүний хөгжлийг дэмжих үүднээс оюутанд гадаад оронд суралцан өөр улс орны түүх, соёлын талаар мэдлэг, туршлагатай болох, шинэ найз нөхөдтэй болох боломжийг бүрдүүлдэг. | Foreign exchange programs provide students with an opportunity to study in a different country and environment experiencing the history and culture of another country, as well as meeting new friends to enrich their personal development. (https://en.wikipedia.org) |
| *Оюутанд чиглэсэн дэмжлэг*<br><br>*Student support*<br><br>*Поддержка студенческой жизни* | foyodea dO Cik,eksea Demjilkit | Оюутныг суралцах хугацаандаа бүрэн төвлөрөх, үр бүтээлтэй ажиллахад чиглэсэн дэмжлэгийн тогтолцоо. Хөдөлмөр эрхлэлт, амьдралын талаар зөвлөгөө өгөх, осол гэмтэл тохиолдсон үед нөхөн олговор олгох тогтолцоо зэрэг хамаарна. | Various supporting systems that enable students to fully concentrate on their studies and have a meaningful campus life. They include career/ employment advice, life guidance and accident compensation systems. (NIAD-QE, 2016) |
| *Оюутны судалгаа*<br><br>*Student survey*<br><br>*Опрос студентов* | foyodea O SodolJT | Асуулга болон ярилцлагын аргыг ашигласан үнэлгээний арга. Оюутны сургалтын хөтөлбөр, сургалт, судалгааны үйл ажиллагаа болон бусад үйлчилгээ талаарх талуудын сэтгэл ханамжийг тодорхойлох зорилготой. Асуулга судалгааг ангид, цахим шуудангийн хаягаар, утсаар, ярилцлагаар | An assessment method that uses surveys and interviews to ascertain the satisfaction of enrolled students with programs, services, and different other aspects of their academic experience. The survey may include in-class questionnaires, mail questionnaires, telephone questionnaires, and interviews (standard, in-person, or focus group). |

О

| | | | |
|---|---|---|---|
| | | (фокус бүлэг, ганцаарчилсан) авах боломжтой бөгөөд харьцангуй өртөг багатай, удирдахад хялбар, өргөн хүрээнд оролцогчдыг хамруулах боломжтой байдаг. Мөн тухайн өгөгдсөн цаг хугацаанд тодорхой сэдвийн хүрээнд холбогдох сургалтын байгууллагын талаарх ойлголтыг оюутны үзэл бодлоор дамжуулан авахад тохиромжтой. | Student surveys are relatively inexpensive, easy to administer, and can reach participants over a wide area. They are best suited for concise and non-sensitive topics, being able to give a sense, from the student perspective, of what is happening at, a given moment in time in the respective higher education institutions. Related terms: Assessment, Evaluation, Culture of Evidence. (UNESCO-CEPES, 2007) |
| *Оюутны суралцахуйн үр дүнгийн үнэлгээ*<br><br>*Student outcome assessment*<br><br>*Оценка результатов учебной деятельности студентов* | foinelekit foyodea 0 Sorolceeol iia foi*T doieit oa | Сургалтын зорилго, зорилтын биелэлтийг нягтлах, цаашид сайжруулан хөгжүүлэх зорилгоор суралцахуйн хүрэх үр дүнгийн талаар тоон болон чанарын мэдээлэл, баримтыг цуглуулан, дүн шинжилгээ хийх үйл явц. | The act of assembling, analyzing, and using both quantitative and qualitative evidence of teaching and learning outcomes, in order to examine their congruence with stated purposes and educational objectives and to provide meaningful feedback that will stimulate improvement. (UNESCO-CEPES, 2007) |
| *Оюутны үнэлгээ*<br><br>*Course evaluation (by students)*<br><br>*Оценка в курсе* | foyodea 0 foinelekit | Хичээлийн агуулга болон багшлах арга зүйн чанарт оюутнаас өгч буй үнэлгээ (оюутнаас асуулгаар авах судалгаа г.м.). Энэ төрлийн үнэлгээг | An evaluation (e.g. a student survey) undertaken by students to review the quality of lesson contents and teaching methods. |

| | | | |
|---|---|---|---|
| | | сургалтын байгууллагад түгээмэл ашигладаг бөгөөд багшлах бүрэлдэхүүний өөрийн үнэлгээ болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой. | It is in widespread use in many universities and colleges as an effective way to encourage self-assessment by academic staff and faculty development activities. (NIAD-QE, 2016) |

## Ө

| | | | |
|---|---|---|---|
| *Өгөгдлийн шинжилгээ*<br><br>*Data analysis*<br><br>*Анализ данных* | foihKkde& oa Siejilekit | 1. Зорилтот хүн амын зан үйлийн хэв маягийг сайтар ойлгох зорилгоор өгөгдлийг зохион байгуулах үйл явц. Энэ нь агуулгын шинжилгээ, зардал-үр ашгийн шинжилгээ, сүлжээний шинжилгээ, хувьсагч хоорондын хамаарлын шинжилгээ, регрессийн шинжилгээ гэх мэт шинжилгээний олон хэлбэрүүдийг багтаасан чухал үйл ажиллагаа юм.<br>2. Ойлгомжтой болгох зорилгоор өгөгдлийг хялбаршуулах үйл явц. | 1. The process by which data are organized to better understand patterns of behavior within the target population. Data analysis is an umbrella term that refers to many particular forms of analysis such as content analysis, cost-benefit analysis, network analysis, path analysis, regression analysis, etc.<br>2. The process of simplifying data in order to make it comprehensible. (Noori, 2018) |
| *Өгөгдөл*<br><br>*Data*<br><br>*Данные* | foihKkde& | 1. Үндэслэл, хэлэлцүүлэг эсвэл тооцооллын суурь болгон ашигладаг бодит мэдээлэл (хэмжүүр эсвэл статистик).<br>2. Түүвэр эсвэл хүн амын талаар цуглуулсан мэдээлэл. | 1. Factual information [as measurements or statistics] used as a basis for reasoning, discussion, or calculation.<br>2. Any information obtained about a sample or a population. (Noori, 2018) |

Ө

Ө

| | | | |
|---|---|---|---|
| *Өгөгдөл цуглуулга*<br><br>*Data collection*<br><br>*Сбор данных* | foinKkdeǿ Coeelegol)T | Судалгааны ажлын хүрээнд мэдээллийг цуглуулах, ажиглах, хэмжих үйл явц. | The observation, measurement, and recording of information in a research study. (Noori, 2018) |
| *Өмнөх мэдлэгийг хүлээн зөвшөөрөх*<br><br>*Recognition of prior learning*<br><br>*Признание предварительного обучения* | Kiliyea JoibsiyerK fmoneKdA Medelkit ii | Албан болон албан бус сургалтын үр дүнг албан боловсрол, сургалтын стандартад нийцүүлэн тодорхойлох, баримтжуулах, үнэлэх, баталгаажуулах үйл явц. | Identifying, documenting, assessing and certifying (mainly) non-formal and informal learning outcomes according to standards used in formal education and training. (UNESCO G. E., 2019). |
| *Өөрийн үнэлгээ*<br><br>*Self-assessment*<br><br>*Самооценка* | foib:* oa foinelek:t | Бодит нөхцөл байдлаа үнэлэх, тавьсан зорилго, зорилтдоо хүрэхийн тулд сайжруулах шаардлагатай эсвэл жишиг болохуйц сайн зүйлсээ тодруулах зорилгоор хэрэгжүүлж буй цогц үнэлгээ. | A systematic assessment to check current conditions and discover areas of excellence or in need of improvement in achieving objectives and goals. (ANQA, 2016) |
| *Өөрийн үнэлгээний баг*<br><br>*Self-assessment personnel*<br><br>*Персонал по самооценке* | foib:* oa foinelek:a O bi:( | Сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний үйл ажиллагаанд удирдан чиглүүлэх, тайлан бичиж боловсруулах үүрэгтэйгээр оролцож буй багшлах бүрэлдэхүүн болон захиргааны ажилтнуудын төлөөлөл. | Academic/administrative staff that head self-assessment work in institutions undergoing assessment and who write the actual self-assessment report. (NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Өөрийн үнэлгээний тайлан*<br><br>*Self-assessment report*<br><br>*Отчет самооценки* | foibj:* oa foinelakia O Deiiloa | Сургалтын байгууллагын зүгээс өөрийн үнэлгээний үр дүнд үндэслэн тайлагнан боловсруулж, чанарын баталгаажуулалтын байгууллагад хүргүүлж буй баримт бичиг. | A document subject institutions submit to a QA agency as the result of their self-assessment. (ANQA, 2016) |
| *Өөрийн үнэлгээний удирдамж*<br><br>*Guidelines for self-assessment*<br><br>*Руководство для самооценки* | foibj:* oa foinelakia O fodoridomj I | Дээд боловсролын сургалтын байгууллага өөрийгөө үнэлэхэд зориулан чанарын баталгаажуулалтын байгууллагаас гаргасан баримт бичиг. | A document prepared by a QA agency for subject institutions which contains instructions for carrying out self-assessment. (NIAD-QE, 2016) |
| *Өргөжин тэлэх сургалтын хөтөлбөр*<br><br>*Spiral curriculum*<br>*Спиральная*<br><br>*образовательная программа* | foirkjia DeleK Sorgelda iia KidolBrI | Сургалтын агуулга нарийсан гүнзгийрч, өргөжин тэлэх хэдийч хөтөлбөрийн гол үзэл санаа байнга давтагдаж байдгаар боловсруулагдсан хөтөлбөр. Энэ нь өмнөх мэдлэг, чадвартаа уялдуулан суралцах болон өөр сургалтын агуулгыг гүнзгийрүүлэн судлах боломжийг олгодог. | Curriculum design in which key concepts and topics are repeatedly presented over time in the context of new, broader and more complex learning experiences. It serves for consolidating preexistent learning as well as broadening and exploring more in-depth the different learning content. (UNESCO, 2013) |

Ө

| П | | | |
|---|---|---|---|
| *Парадигм*<br><br>*Paradigm*<br><br>*Парадигма* | pi:redie^ | Шинжлэх ухааны аливаа салбар, эсвэл төрлийн дотор хийгдэх онол, хууль, дүгнэлт, туршилтуудыг заан чиглүүлж байдаг философи, онолын хүрээ. Парадигмын шилжилт нь үзэл баримтлалын хүрээг өөрчилснөөрөө асуудлыг урьд өмнөхөөс тэс өөрөөр ойлгох, тэдгээрийг шинэ нөхцөл байдалд тохируулан оновчтой шийдвэрлэх, нөөц боломжийг дайчлан ашиглах боломжийг олгодог. | Paradigm is a philosophical and theoretical framework of a scientific school or discipline within which theories, laws, and generalizations and the experiments performed in support of them are formulated. A paradigm shift changes the conceptual framework that allows large numbers of people to perceive problems and opportunities in very different ways than in the past, or to conceive of responses to problems and opportunities in a new context. (Davaadulam, 2010) |
| *Патент*<br><br>*Patent*<br><br>*Патент* | pE:DwnDA | Патент гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, үйлдвэрлэлийн загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичиг. | Patent refers to a document issued by the state competent authority acknowledging that the solution is a new invention or industrial design, and accepting that the author holds a right of ownership for a limited period of time. (The Law of Mongolia on Patent, 2006) |

П

| | | | |
|---|---|---|---|
| *Патент, гэрчилгээ эзэмшигч*<br><br>*Patent and certificate holder*<br><br>*Патентообладатель* | pEDwnDA, kErecilekEt fjemsikcI | Шинэ бүтээл, үйлдвэрлэлийн загварын патент болон оюуны өмчийн эрхийн гэрчилгээг эзэмшигч, түүнтэй холбоотой онцгой эрхийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан этгээд. | The holder of a patent or certificate refers to an inventor who has been granted an invention or industrial design patent or utility model certificate and related exclusive rights based on legal justifications or regulations or the person authorised to acquire the right. (The Law of Mongolia on Patent, 2006). |
| **С** | | | |
| *Сайжруулалт*<br><br>*Improvement*<br><br>*Улучшение* | Seiijiregololda | Үйлчилгээний чанар эсвэл үр дүнгийн стандартыг дээшлүүлэх, шинэчлэх, баяжуулах үйл явц. | Improvement is the process of enhancing, upgrading or enriching the quality of provision or standard of outcomes. (INQAAHE, 2017) |
| *Сайн засаглал*<br><br>*Good governance*<br><br>*Благое / хорошее управление* | Seiia Jeseeele& | НҮБХХ-өөс сайн засаглалын шинж байдлыг иргэдийн өргөн оролцоог хангах, эрх зүйт ёсонд үндэслэн шийдвэр гаргах, засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах, иргэдийн хэрэгцээ, сонирхолд соргог мэдрэмжтэй байх, бүх иргэдэд тэгш шударгаар хандах төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах, улс төрийн хариуцлагатай, байх, хөгжлийн | UNDP has defined characteristics of good governance as widespread participation by all citizens, decision making by rule of law, transparency in the actions of governance institutions, responsiveness to the needs and desires of citizens, equity in the treatment of citizens, effectiveness and efficiency in the use of public resources, public accountability, and the |

С

| | | | |
|---|---|---|---|
| | | төлөвлөлтөд алсын хараатай хандах явдал хэмээн тодорхойлсон байна. | exercise of strategic vision in planning for development. (Davaadulam, 2010) |
| *Сайн сайхан байдал (сургалтын байгууллагын)*<br><br>*Wellbeing (in institution)*<br><br>*Благополучие (в учебном заведении)* | Seiia Seiieea bïiide& :Sorgelda iia bïiigolol)T iia" | Сургалтын байгууллагын ээлтэй, таатай байдал нь суралцагчдын бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэнд болон хөгжилд чухал нөлөө үзүүлдэг бөгөөд сургуулийн талаарх эерэг хандлага ба сэтгэл хөдлөл; сургуульдаа дуртай байх; суралцах эерэг хандлага; сургуультай холбоотой санаа зовоох асуудал, санал гомдолгүй байх; нийгэм сэтгэл зүйн ямар нэгэн асуудалгүй байх нөхцөлийг хэлнэ. Нөгөөтэээгүүр, амжилттай суралцах нь сургуульдаа дуртай байхаас ихээхэн хамаардаг учраас сургалтын байгууллагын ээлтэй байдал нь маш чухал хүчин зүйл бөгөөд суралцах үйл ажиллагаанд харилцан нөлөөлж, хамааралтай байдаг. | Wellbeing in school contributes to learners' physical and psychological health and development. As such it is strongly connected to learning. It consists of cognitive, emotional, and physical components, i.e. a learner's thoughts, feelings, and bodily sensations. Wellbeing in school generally involves: positive attitudes and emotions toward school in general; enjoyment in school; positive academic self-concept; absence of worries about school; absence of physical complaints in school; and absence of social problems in school. Wellbeing contributes to the maintenance of a positive basis for learning at school. On the other hand, learning is crucial for the occurrence of wellbeing because successful learning is an important source of enjoyment in school. Thus, wellbeing and learning in school are interdependent concepts which influence each other. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Салбар нэгж*<br><br>*Branch unit*<br><br>*Отделение университета* | SelBrI NikCa | Хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд төв сургуулийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу заримыг нь гүйцэтгэдэг нэгж. Салбар нэгжийн эрх зүйн байдал нь бүтцийн нэгжтэй адил байна. | A unit which doesn't have the right of a legal entity and, however the location is different, it executes functions of the central school wholly or partly. The legal status of a branch unit is the same as the structural unit. |
| *Салбар хоорондын хамтын ажиллагаа*<br><br>*Interdisciplinary activity*<br><br>*Междисциплинарная деятельность* | SelBrI HogoroedO iia HemdO Jia fejille)T | Өөр өөр салбарын үзэл санааг нэгтгэн, нийцүүлэн хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа. | Interdisciplinary refers to research or study that integrates concepts from different disciplines resulting in a synthesised or co-ordinated coherent whole. (INQAAHE, 2017) |
| *Салбар хоорондын арга, хандлага*<br><br>*Interdisciplinary approach*<br><br>*Междисциплинарный подход* | SelBrI HogoroedO iia fer)T HeedolI)T | Хичээл хоорондын сэдэв, агуулгын уялдаа болон бодит ертөнц дэх харилцан хамаарлыг ойлгож танин мэдэх боломжийг бүрдүүлдэг сургалтын нэгдмэл хандлага. Энэ нь хоёр буюу түүнээс дээш шинжлэх ухааны салбарын онол, агуулга, арга зүй, чиг хандлагыг нэгтгэсэн агуулга, бүтээгдэхүүнийг тодорхойлоход бус, харин цогц байдлаар хандах гэсэн утгыг илэрхийлнэ. | An approach to curriculum integration that generates an understanding of themes and ideas that cut across disciplines and of the connections between different disciplines and their relationship to the real world. It normally emphasizes process and meaning rather than product and content by combining contents, theories, methodologies and perspectives from two or more disciplines. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Санал, зөвлөмж*<br><br>*Feedback*<br><br>*Информация / отзыв/Обратная связь* | Senel& , Joib;em;j l | Аливаа бүтээгдэхүүн, хувь хүний ажлын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор өгч буй санал, зөвлөмжийг агуулсан мэдээлэл. | Information about reactions to a product, a person's performance of a task, etc. which is used as a basis for improvement. (Budikina, 2017) |
| *Санхүүгийн дэмжлэг*<br><br>*Financial support*<br><br>*Финансовая поддержка* | SeehKO iia Dem;jilkit | Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид буцалтгүй мөнгөн тусламж болон хөнгөлөлттэй эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгө. | Students in tertiary education institutions receive money from grant aid and concessional repayment. (The Law on Higher Education Financing and Social Security, 2011) |
| *Сахилгын журам*<br><br>*Code of practice*<br><br>*Кодекс практики* | Sekil)T iia Jiro^ | Сахилгын журам нь аудитын анхан шатны босго шаардлагыг тодорхойлох онцлог бүхий заавал дагаж мөрдөх шаардлагагүй баримт бичиг. Хяналт үнэлгээний практик ач холбогдлыг тодотгоход үүнийг хэрэглэдэг. Энэхүү дүрэм нь дээд боловсролын академик/сургалтын чанар, стандартын удирдлагатай холбоотой асуудлуудыг хамарсан системийн төвшний тогтоосон хандлага/үйл ажиллагааны дэлгэрэнгүй багцыг тодорхойлно. | A code of practice is a non-binding document that describes the minimum audit requirements and those that are considered to reveal a practice worthy of consideration. A code identifies a comprehensive series of system-wide expected conduct covering matters relating to the management of academic quality and standards in higher education. It provides an authoritative reference point for institutions as they consciously, actively, and systematically assure |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | Мөн дээд боловсролын байгууллагууд өөрийн хөтөлбөр, олгож буй боловсролын зэрэг, боловсролын академик чанарыг ухамсартайгаар, идэвхтэй, системтэйгээр баталгаажуулахад энэхүү дүрэм ач холбогдолтой / чухал шаардлагатай мэдээллээр / зүйлсээр хангаж өгдөг. Энэхүү дүрмээр дээд боловсролын байгууллага бүр чанарын баталгаажуулалтын системийн үр өгөөжийн мөн сургалтын чанар, стандартын бие даасан систем, баталгаажуулалтыг бий болгосон байх шаардлагатай гэж үздэг. Энэхүү дүрмийг боловсруулахдаа туршлагатай, мэдлэгтэй мэргэжилтнүүдээс зөвлөгөө туслалцаа авах шаардлагатай. | the academic quality and standards of their programs, awards, and qualifications. A code assumes that, taking into account nationally agreed upon principles and practices, each institution has its own systems for independent verification both of its quality and standards and of the effectiveness of its quality assurance systems. (UNESCO-CEPES, 2007) |
| *СВОТ шинжилгээ*<br><br>*SWOT analysis*<br><br>*СВОТ анализ* | SwoDA Siejilekt | Байгууллага өөрийнхөө дотоод давуу болон сул тал мөн гадаад орчны боломж, аюул эрсдэлийг тодорхойлох, илрүүлэхэд чиглэсэн стратеги, төлөвлөлтийн техник. | A study undertaken by an organization to identify its internal strengths and weaknesses, as well as its external opportunities and threats. (Budikina, 2017) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Семестр*<br><br>*Semester*<br><br>*Семестр* | SwmwsD* | Хичээлийн жилийн хагастай тэнцэх буюу 15–16 долоо хоног үргэлжлэх сургалтын хугацаа. | Period of study of approximately 15 to 16 weeks' duration, usually half of an academic year. (Glossary of terms in HE, 2016) |
| *Семинар*<br><br>*Seminar*<br><br>*Семинар* | Swmine* | Багшийн удирдлага, арга зүйн дагуу бие даасан судалгаа болон ангийн хэлэлцүүлгийг хослуулан бүлэг, хэсгээр зохион байгуулах сургалтын хэлбэр. | A form of small group instruction, combining independent research and class discussions under the guidance of a professor. (Glossary of terms in HE, 2016) |
| *Силлабус*<br><br>*Syllabus*<br><br>*Силлабус /Учебно-методическая программа* | SilleBi_ | Сургалтын зорилго, зорилт, агуулгын сонголт ба дараалал, заах арга зүй, ашиглах материал, сургалтын даалгавар, үйл ажиллагаа, хүлээгдэж буй үр дүн, үнэлгээний төлөвлөгөө, нэгж хичээл зэргийг багтаасан баримт бичиг. Энэ нь хичээл тус бүрийг хэн, хэзээ, хаана, хэрхэн зохион байгуулах талаарх мэдээлэл, хичээлийн зорилт, сэдэв, үнэлгээний бодлого, шалгалтад бэлтгэх заавар зэрэг мэдээллийг агуулсан байдаг. Мөн багшийн зүгээс хичээлийн агуулгад өөрчлөлт хийх, сургах үйл явц, үр дүнг үнэлэхэд ашиглаж болно. | A document which outlines the aims, selection and sequence of contents to be covered, mode of delivery, materials to be used, learning tasks and activities, expected learning objectives or outcomes, and assessment/evaluation schemes of a specific course, unit of study or teaching subject. (UNESCO, 2013). It contains specifics on how, where, when and by whom each class will be held, objectives, topics that will be covered, grading policies, instructions for preparation, etc. It may also be used for adjustment of subject contents by academic staff or evaluation of teaching. (NIAD-QE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Соёл хоорондын харилцан ойлголцол*<br><br>*Intercultural understanding*<br><br>*Межкультурное взаимопонимание* | Herilcea foiilegelce& Soyo& Hogoroed0 iia | Өөрийн болон бусдын соёл, зан заншлыг ойлгох, таньж мэдэх, хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх хандлага. | Awareness, understanding and appreciation of one's own and other cultures. It implies openness towards and respect for other cultures. (UNESCO, 2013) |
| *Соёлын мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр*<br><br>*Culturally responsive curriculum*<br><br>*Культурно-адаптивная образовательная программа* | Soyo& oa Mederemjidel Sorgelda iia KidolBrl | Суралцагчийн үндэсний соёлын онцлог, өмнөх дадлага туршлагыг хүндэтгэж боловсруулагдсан, суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичиг. Нийгэмд ноёрхож буй соёлыг дангаар нь биш, харин соёлын олон төрлийг хүндэтгэн таниулж, соёл хоорондын ойлголцлыг дэмжсэн сургалтын хөтөлбөр. Соёлын талаарх агуулгыг нэмэлт модуль юм уу хичээл болгохгүйгээр сургалтын хөтөлбөрт шигтгэж оруулдаг. | A curriculum that respects learners' cultures and prior experiences. It acknowledges and values the legitimacy of different cultures, not just the dominant culture of a society, and encourages intercultural understanding. It incorporates cultural aspects into the curriculum, rather than adding them on as an extra or separate module or course. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Соёлын мэдрэмжтэй сурган хүмүүжүүлэх зүй*<br><br>*Culturally responsive pedagogy*<br><br>*Педагогика, учитывающая особенности культуры* | KimojiKlK Joil Soyo& oa Mederemjidel Sorgea | Анги танхим дахь суралцагчдын соёлын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, мэдрэмжтэй байх хэрэгцээнд тулгуурлан явагдах сурган хүмүүжүүлэх арга хэлбэр. | Teaching methodologies which address the need to be sensitive and responsive to cultural differences within the classroom. (UNESCO, 2013) |
| *Соёлын хэм хэмжээ*<br><br>*Cultural norms*<br><br>*Культурная норма* | Soyo& oa kEʌ kEmjiIT | Ёс зүйн стандарт, эсвэл аливаа соёлд хүлээн зөвшөөрөгдсөн зан үйл юм. Хүмүүсийн харилцааны хэв загвар, хооллох хэв маяг, жендерийн асуудал, мэргэжлийн ёс зүй, бусад олон нөхцөл байдал соёлын хэм хэмжээнээс хамааралтай байдаг. | Cultural norms are standards of conduct or acceptable behaviour in any given culture. The way people communicate, the way they eat, gender issues, the work ethic and many other situations are influenced by cultural norms. (Davaadulam, 2010) |
| *Сонгон судлах сургалтын хөтөлбөр*<br><br>*Elective curriculum*<br><br>*Факультативная программа* | Soekgoa SodoleeO Sorgelda iia KidolBrl | Суралцагч сонирхол, хэрэгцээндээ нийцүүлэн сонгон судлах боломжтой хөтөлбөр. Ерөнхий болон дээд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаанд хичээл сонгон судлах боломжтой бөгөөд бүх суралцагчийн заавал судлах үндсэн сургалтын хөтөлбөрт нэмэлтээр ордог. “Сонгон судлах хичээл” гэдэг нь сонгох боломжтой олон хувилбараас нэг юм уу хэд хэдэн хичээлийг сонгон судлах шаардлагатайг илэрхийлнэ. | Courses or subjects from which learners can choose according to their interests and needs. Typically offered in secondary and tertiary education and complementing the core curriculum that all learners must follow. ‘Electives’ usually refer to subjects to be chosen within a range of options where opting for one or more subjects is compulsory. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сонгон судлах хичээл*<br><br>*Elective course*<br><br>*Факультативные курсы \ Курсы по выбору* | Soekgoa SodoleO kiciye& | Боловсролын зэрэг авахад шаардагдах багц цагийг цуглуулах зорилгоор сонгон судлах хичээл. Энэ нь заавал судлах хичээлээс ялгаатай. | Courses that students may choose to take for credit toward their intended degree, as distinguished from courses that they are required to take. (Glossary of terms in HE, 2016) |
| *Сорил*<br><br>*Test*<br><br>*Тест* | Sori& | Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх зорилгоор боловсруулсан шалгалтын материал, үнэлгээний дасгал ажлын нэг хэлбэр. Сорилыг багш эсвэл хөндлөнгийн байгууллага бэлтгэж, хэрэглэж болдог. | An examination or assessment exercise designed to measure the learner's acquired knowledge and skills. Tests may be set and marked by the teacher or by an external agency. (UNESCO, 2013) |
| *Сорилын даалгаврын сан*<br><br>*Test item bank*<br><br>*Фонд тестовых заданий* | Sori& oa DegegelgeBrl iia Seit | Тестийн сангийн даалгавар эсвэл асуултын сан гэдэг нь даалгаврууд болон асуултуудын хадгалах хэрэгсэл юм. Энэ нь тест боловсруулах зорилгын хүрээнд тэдгээрийг хадгалах, удирдах, засварлах болон ашиглах боломжийг олгодог. | The test item or question bank is a storage facility for items or questions that allows them to be stored, managed, maintained and used for test generation purposes. (VETP-1, 2018) |
| *Стандарт*<br><br>*Standards*<br><br>*Стандарты* | SDenderDA | Аливаа үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зорилгодоо нийцэж буй эсэхийг баталгаажуулах баримт бичиг бөгөөд үүнд тавигдах шаардлага, тодорхойлолт, заавар | A standard is a document that provides requirements, specifications, guidelines or characteristics that can be used consistently to ensure that materials, products, processes |

С

шинж чанар зэргийг зааж өгдөг. Дээд боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны хувьд дээд боловсролын сургалтын байгууллага болон сургалтын хөтөлбөрийн хүрэх ёстой чанарын үнэлгээний шаардлага, нөхцөлийн түвшнийг илэрхийлсэн шалгуур үзүүлэлт. Стандарт гэсэн нэр томьёо нь нэг талаас үр дүнг хэмжих тогтсон шалгуур үзүүлэлт, нөгөө талаас хүрсэн түвшин гэсэн утгатай. Стандарт нь жишиг харьцуулалт хийсэн тоон эсвэл боловсролын үр өгөөж, тогтвортой байдал, үндсэн үүрэг хариуцлага гэх мэт зөвхөн тодорхой зорилтот асуудлыг харуулсан чанарын хэлбэртэй байж болно. Тоон хэлбэртэй гэдэг нь ДБСБ эсвэл хөтөлбөрийн хүрэх ёстой босго түвшнийг багтаасан стандартыг хэлнэ. Ихэвчлэн босго буюу суурь стандарт нь чанарын хувьд зөвшөөрөгдөхүйц хамгийн бага түвшин байдаг. Бусад тохиолдолд, стандарт нь чанарын хамгийн өндөр

and services are fit for their purpose. (UNESCO, 2013). Statements regarding an expected level of requirements and conditions against which quality are assessed or that must be attained by higher education institutions and their programs in order for them to be accredited or certified. The term standard means both fixed-criteria (against which an outcome can be matched) and a level of attainment. Standards may take a quantitative form, being mostly the results of benchmarking, or they may be qualitative, indicating only specific targets (e.g. educational effectiveness, sustainability, core commitments, etc.). When quantitative, the standards include threshold levels that have to be met in order for higher education institutions or programs to be accredited. More often than not, the thresholds or the “basic standards” are defined at the level of minimally acceptable quality.

C

түвшнийг зааж болох ба үүнийг чанарын дээд стандарт гэдэг. Стандарт нь өөр өөр үнэлгээний үзүүлэлттэй. 1. Орц (агуулгын стандарт); 2. Гарц (гүйцэтгэлийн стандарт); 3. Үйл явц. Стандартыг бакалавр, магистрын гэх зэрэг боловсролын түвшний ерөнхий стандарт, эсвэл тодорхой мэргэжлийн хичээлийн стандарт (Их Британид хичээл, мэргэжлийн чиглэлээр жишиг харьцуулалт хийдэг) гэж ангилж болно. АНУ, Канад зэрэг улс орнуудад стандарт нь шалгуур үзүүлэлттэй ихэвчлэн ижил утгаар ойлгогдож хэрэглэгддэг бол Европын орнуудад шалгуур үзүүлэлтээс ялгаатайгаар ойлгогддог. Түүнчлэн, чанар болон стандартын хооронд ялгаа хэдий ч "чанарын стандарт" хэмээх ойлголт нь зарим тохиолдолд стандартыг шалгуур гэсэн ойлголттой ижил байдлаар хэрэглэхэд хүргэж байна. Дээд боловсролд үндсэн дөрвөн чиглэлээр стандартын үнэлгээ

On other occasions, the standards refer to the highest level of quality, thus being considered as "standards of excellence". Standards may have different reference points: (I) inputs (e.g. content standards); (II) outputs (e.g. performance standards), (III) processes. Standards can be general (for a degree level, e.g. a Bachelor's or a Master's Degree) or subject-specific (e.g. discipline benchmarking statements in the United Kingdom). Standards are often used synonymously with criteria, as in the United States, while in Europe, standards are becoming increasingly distinct from criteria. A distinction between quality and standards (similar to the difference between process and outcomes) is also made, the term "quality standards" that is sometimes used being equivalent to the notion of standards as criterion. In higher education standards are frequently set and assessed in four main areas: academic standards (related to

| | | | |
|---|---|---|---|
| | | хийдэг. Үүнд: академик стандарт (оюутны оюуны чадвар); чадамжийн стандарт (оюутны мэргэжлийн чадвар); үйлчилгээний стандарт (оюутанд үзүүлж буй байгууллагын үйлчилгээний чанар); байгууллагын стандарт (байгууллагын зүгээс сургалт, судалгааны зохист орчныг бүрдүүлснийг баталгаажуулах зарчим, зохион байгуулалт) зэрэг юм. | the intellectual abilities of students); standards of competence (related to the technical abilities of students); service standards (refer to the standards of service provided by the organization to the student); organizational standards (principles and procedures by which the institution assures that it provides an appropriate learning and research environment). (UNESCO-CEPES, 2007) |
| *Судалгаа шинжилгээний ажлын үр дүн*<br><br>*Research outcome*<br><br>*Результат исследования* | Sodol)T Siejilekia 0 fejik oa foi*T doieit | Шинжлэх ухааны хүрээнд бий болсон шинэ болон нэмэлт мэдлэг, техник технологийн шийдлийг илэрхийлсэн мэдээлэл. | Information on new and additional knowledge and technical solutions created within the scope of science. (The Law of Mongolia on Science and Technology, 2006) |
| *Судалгаа, хөгжүүлэлт*<br><br>*Research and Development (R&D)*<br><br>*Исследование и Разработка* | Sodol)T , KikjiKlolda | Хүн, соёл, нийгмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хийгдэж байгаа системтэй, бүтээлч үйл ажиллагаа, түүний үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг хэрэглээнд нэвтрүүлж ашиглахад чиглэсэн үйл ажиллагааны цогц. | Research and experimental development (R&D) comprise creative work undertaken on a systematic basis in order to increase the stock of knowledge, including knowledge of man, culture and society, and the use of this stock of knowledge to devise new applications. The term R&D covers three activities: basic |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | Суурь судалгаа, хэрэглээний судалгаа, туршилт, хөгжүүлэлт гэсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. | research, applied research and experimental development. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |
| *Судалгаанд суурилсан сургалт*<br><br>*Inquiry-based learning*<br><br>*Обучение, основанное на исследованиях* | Sodolgea dO Segorileeesea Sorgelda | Суралцагчдад эргэн тойрныхоо байгаль, нийгмийн нарийн төвөгтэй юмс, үзэгдлийн талаар ойлгож, мэдэх боломжийг олгодог сургалт. Асуумжид суурилсан сургалтын олон загвар нь асуудал, бэрхшээл, үзэл баримтлалыг судалж шинжлэх; суралцагч төвтэй байх, ойлгоход төвөгтэй асуудлуудыг илрүүлэх, шалгах, бодож тунгаах, сургалтад шингээх зэрэг нийтлэг шинж чанаруудыг агуулдаг. Сургалтын хөтөлбөрт энэхүү аргыг нэвтрүүлснээр суралцагчид шинээр гарж буй, тулгамдсан асуудал, үзэл баримтлалтай танилцах, шинэ мэдлэгээ хуучин мэдлэгтэйгээ холбох, тунгаан бодох болон суралцах стратегиа сонгох, төлөвлөх, хянах болон өөрийн сэтгэх үйл явцдаа үнэлэлт дүгнэлт өгөх боломжуудыг бүрдүүлнэ. | A process that provides opportunities for learners to construct their own understanding of the complexity of the natural and human world around them. Many models of inquiry-based learning share some common features such as: investigation into a relevant issue, problem or concept; a learner-centred approach; the discovery and examination of the complexity of understanding and the involvement of thinking and reflection in the learning process. A curriculum adopting this approach implies that learners work with new and challenging content and concepts, connect new information to former knowledge, select thinking and learning strategies deliberately and plan, monitor, and evaluate their own thinking processes. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Судалгааны ажил*<br><br>*Research*<br><br>*Исследование* | Sodolgea O fejil& | Дээд боловсролын хүрээнд судалгаа, шинжилгээний ажил гэдэг нь шинжлэх ухаан, технологи, инженерийн, анагаах ухааны, соёлын, нийгмийн, хүмүүнлэгийн ухааны болон боловсролын салбар дахь эх судалгаа, шинжилгээ бөгөөд шийдвэрлэх тодорхой асуудлуудын мөн чанар, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр арга барилыг хэрэглэж, нарийвчлан авч үзсэн, аль болох бодитой дүгнэлт гаргахуйц ач холбогдол бүхий албан ёсны судалгаа шинжилгээг хэлнэ. Эдгээр нь аливаа байгууллагын хүрээнд зохих дэд бүтцэд түшиглэн асуудлыг тодорхойлох, тэдгээрийн шийдлийг олоход чиглэгдэнэ. | 'Research', within the context of higher education, means original scientific, technological and engineering, medical, cultural, social and human science or educational research which implies careful, critical, disciplined inquiry, varying in technique and method according to the nature and conditions of the problems identified, directed towards the clarification and/or resolution of the problems, and when within an institutional framework, supported by an appropriate infrastructure. (UNESCO, ILO, 2016) |
| *Судалгааны ажлын зөвлөх*<br><br>*Thesis advisor*<br><br>*Научный руководитель* | Joib;eK Sodolgea O fejil& oa | Бакалавр, магистр, докторын судалгааны ажлын удирдагч, чиглүүлэгч. | The student should find a faculty thesis advisor who shares her\his interest in exploring the topic. (Budikina, 2017) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Судалгааны ажлын удирдагч*<br><br>*Research supervisor*<br><br>*Научный руководитель* | Sodolgea O fejik oa fodoridoecl | Суралцагчийн судалгааны ажлыг удирдан чиглүүлж зөвлөгөө өгдөг ахисан түвшний сургуулийн судалгааны арвин туршлага, өргөн мэдлэгтэй үндсэн ажилтан багш. | Appointed full-time staff in graduate schools with excellent research careers, wide knowledge and experience, who supervise and advise on students' research. (NIAD-QE, 2016) |
| *Судалгааны их сургууль*<br><br>*Graduate university*<br><br>*Исследовательский университет* | Sodolgea O Yekit Sorgegoli | Ихэнх тохиолдолд ахисан түвшний сургалтыг явуулахад чиглэсэн их сургууль байна. Мөн бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлж болно. Тодорхой сургалтын эсвэл судалгааны хэрэгцээ, шаардлага үүссэн үед энэ төрлийн сургуулийг байгуулдаг. | Graduate university is a university dedicated to graduate-level education, without undergraduate programs. It is established when there is a particular education or research need. (NIAD-QE, 2016) |
| *Судалгааны тайлан*<br><br>*Research report*<br><br>*Научный отчет* | Sodolgea O Deiiloa | Судалгааны ажлын зорилго, гүйцэтгэл, үр дүн, дүгнэлтийг агуулсан мэдээлэл. | A description of how a study was conducted, including results and conclusions. (Noori, 2018) |
| *Судалгааны төсөл*<br><br>*Research proposal*<br><br>*Научный проект* | Sodolgea O Doisok | Тодорхой асуудлыг судлахаар төлөвлөсөн судалгааны төслийн талаарх дэлгэрэнгүй тайлбар, тодорхойлолт. | A detailed description of a proposed study designed to investigate a given problem. (Noori, 2018) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Судалгааны туслах ажилтан ажиллуулах тогтолцоо*<br><br>*Research assistant system*<br><br>*Система научных сотрудников* | Sodolgea O DoseleeeO fejildea fejillegoleeO DoeedeIce)T | Судалгааны ажилд туслуулах зорилгоор ахисан түвшний шилдэг оюутныг авч ажиллуулах тогтолцоо. Энэхүү тогтолцооны зорилго нь залуу судлаачдыг бэлтгэх, судалгааны үйл ажиллагаар жигд хэрэгжүүлэх, санхүүгийн дэмжлэг олгоход оршино. | A system to employ excellent graduate students to assist with research. Its purpose is to provide financial support, facilitate the smooth conduct of research activities and recruit young researchers. (NIAD-QE, 2016) |
| *Судалгааны тэтгэлэг*<br><br>*Fellowship /research grant*<br><br>*Стипендия / научный грант* | Sodolgea O DeoeKIkt | Ихэвчлэн ахисан түвшний суралцагч, судлаачдын судалгаанд зориулан санхүүгийн дэмжлэг болгон олгодог сургалтын тэтгэлэг. | A study grant of financial assistance, usually awarded to a graduate student. (Glossary of terms in HE, 2016) |
| *Судлаач*<br><br>*Researcher*<br><br>*Исследователь* | SodologecI | Шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаач. | A qualified worker who carries out academic or scientific research. (The Law of Mongolia on Science and Technology, 2006) |
| *Суралцагчийн тэтгэлэг*<br><br>*Student scholarship*<br><br>*Студенческая стипендия* | SorolCeeeoI iia Demjigololda | Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцах болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламж. | A grant or payment made to support a student's education, awarded on the basis of academic or other achievement. (The Law on Higher Education Financing and Social Security, 2011) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Суралцагчийн ялгаатай байдалд тулгуурласан заах аргазүй*<br><br>*Differentiated instruction*<br><br>*Дифференцированная инструкция* | Dolgegorileeesea JigeeeO fer)T Joil Sorolceeecl iia filgedel biidel& dO | Суралцагч бүрийн сурах боломжийг нэмэгдүүлэхийн тулд төрөл бүрийн сургалтын үйл ажиллагааг санал болгож, тэдний ялгаатай хэрэгцээнд нийцүүлсэн заах арга зүй. Багш хичээлээ уян хатан зохион байгуулж, суралцагчдын ялгаатай түвшинд тохируулан мэдлэгийг олгох боломжтой. | An approach to teaching that involves offering several different learning experiences and proactively addressing students' varied needs to maximize learning opportunities for each student in the classroom. It requires teachers to be flexible in their approach and adjust the curriculum and presentation of information to learners of different abilities. (UNESCO, 2013) |
| *Суралцах боломж*<br><br>*Opportunity to learn*<br><br>*Возможность в обучении* | SorolceeeO Blomj l | Сургалтын зорилтот үр дүнд хүрэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын орчин, нөхцөлийг суралцагчдад нийцүүлэн тохируулах нөхцөл. | The provision of learning conditions, including suitable adjustments, to maximize a student's chances of attaining the desired learning outcomes. (UNESCO, 2013) |
| *Суралцахуй*<br><br>*Learning*<br><br>*Учение / Учебная деятельность* | Sorolceeol | Сургалтын үйл ажиллагаа, дадлага туршлага, чиглэл зааварчилгааны үр дүнд хувь хүний мэдлэг, ойлголт, үнэт зүйл, ур чадвар, чадамж, хандлага бүрэлдэн тогтох урт хугацааны цогц үйл явц. Суралцахуйг тодорхойлох үндсэн 3 загвар бий. Үүнд: зан үйлийн онол (бихевиоризм) нь суралцахуйг хүрээлэн буй | The complex and long-term psychosocial process consisting of the individual acquisition or modification of information, knowledge, understanding, attitudes, values, skills, competencies or behaviours through experience, practice, study or instruction. There are at least three different models in defining the learning process. |

| | | | |
|---|---|---|---|
| | | орчны хэд хэдэн хүчин зүйлийг хамарсан үйлийн үр дүнд зан төлөвт гарах хэмжигдэхүйц өөрчлөлт гэж үздэг. Танин мэдэхүйн онолын (когнитивизм) үүднээс суралцахуй нь мэдлэг олж авах, мэдээлэл боловсруулахад чиглэсэн оюун ухаан, танин мэдэхүйн үйл явцын зохион байгуулалт юм. Конструктив онолын үүднээс суралцахуйг суралцагч өмнөх мэдлэг, туршлага дээрээ үндэслэсэн идэвхтэйгээр шинэ санаа, ойлголтыг бүтээх үйл явц гэж үздэг. | Behaviourism views learning as a measurable change of behavior as a result of the joint action of a number of environmental factors. Cognitive theories emphasize internal mental organization of knowledge, stressing the acquisition of knowledge, mental structures, and the processing of information. Constructivism views learning as a process in which the learner actively constructs new ideas or concepts based on prior knowledge and/or experience. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйг удирдан чиглүүлэх загвар*<br><br>*Instructional design (ID)*<br><br>*Педагогический дизайн/ Педагогическое проектирование* | SorolCeeeol Jl fodoridoa Cik,eKIK JeeeB* | Сурах, сургах үйл ажиллагааны загвар гэдэг нь мэдлэгийг үр ашигтай, үр өгөөжтэй, сонирхолтой, оролцоонд тулгуурласан, сэтгэл татахуйц хэлбэрээр олгоход чиглэсэн сургалтын материал болон сургалтын үйл ажиллагаар тэнхимийн болон цахим орчинд системтэйгээр тогтмол бөгөөд найдвартай төлөвлөх, боловсруулах, хүргэх үйл явц юм. Энэ нь өргөн утгаараа суралцагчийн хэрэгцээ ба түвшин, мөн сургалтын | Instructional design (ID), also known as instructional systems design (ISD), is the practice of systematically designing, developing and delivering instructional products and experiences, both digital and physical, in a consistent and reliable fashion towards an efficient, effective, appealing, engaging and inspiring acquisition of knowledge. The process consists broadly of determining the state and needs of the learner, defining the end goal |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | эцсийн зорилгыг тодорхойлон түүнд хүрэхэд дэмжлэг болохуйц үйл ажиллагаар бий болгон хэрэгжүүлэх үйл явц. Сурах, сургах үйл ажиллагааны олон янзын загварууд байдаг ба ихэнх нь ADDIE гэсэн загварт суурилдаг. Энэхүү загвар нь дүн шинжилгээ хийх, төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх гэсэн 5 үе шатаас бүрддэг. | of instruction, and creating some “intervention” to assist in the transition. There are many instructional design models but many are based on the ADDIE model with the five phases: analysis, design, development, implementation, and evaluation. (https://en.wikipedia.org/wiki/Instructional_design) |
| *Суралцахуйд зарцуулах хугацаа*<br><br>*Learning time*<br><br>*Срок обучения* | SorolCeeeol dO JerocegoleeO Hogoce)T | Суралцагчид сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, мэдлэг, чадвар, дадал олох, даалгавар гүйцэтгэх цаг хугацаа. Боловсролын тогтолцоонд цаг хугацааг төлөвлөх янз бүрийн арга байдаг. Тухайлбал: (а) албан ёсоор тогтоосон хугацаа (хичээлийн хөтөлбөрийн хүрээнд суралцахуйд зориулагдсан анги танхимд үргэлжлэх хичээлийн цаг); (б) суралцагчид даалгавар гүйцэтгэх буюу суралцахад зарцуулах цаг хугацаа; (с) зохих түвшний хүндрэлтэй | The amount of time during which learners are actively working on tasks and are effectively engaged in learning. There are different approaches to time in education. For example: (a) officially allocated time, which includes school time (i.e. the total amount of time spent in school), classroom time (i.e. the amount of time spent in the classroom), and instructional time; (b) engaged time or time-on-task, which refers to the portion of time during which students are paying attention to a learning task and attempting to learn; |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | даалгаврыг гүйцэтгэж, амжилтад хүрэхэд зарцуулах хугацаа. | and (c) academic learning time, which indicates that portion of engaged time that students spend working on tasks at an appropriate level of difficulty for them and experiencing high levels of success. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн арга туршлага*<br><br>*Learning experiences*<br><br>*Опыт учебной деятельности* | Sorolceeol iia fer)T Dorsil)T | Суралцагчийн үзэл, ойлголтыг хөгжүүлэх, зөв хандлага, үзэл баримтлалыг төлөвшүүлэх, сэтгэл хөдлөлөө удирдах мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд чиглэсэн янз бүрийн орчин, нөхцөл дэх арга туршлагууд. Боловсролын орчинд суралцахуйн арга, туршлага нь сонирхолтой, утга учиртай, суралцагчдын хэрэгцээнд тохирсон байна. Суралцахуйн өмнөх туршлагууд нь цаашдын суралцахуйг төлөвлөх гол хүчин зүйл болдог. | A wide variety of experiences across different contexts and settings which transform the perceptions of the learner, facilitate conceptual understanding, yield emotional qualities, and nurture the acquisition of knowledge, skills and attitudes. In educational settings learning experiences are ideally challenging, interesting, rich, engaging, meaningful, and appropriate to learner needs. Previous learning experiences are considered to be key factors predicting further learning. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн ахиц*<br><br>*Learning progression*<br><br>*Прогресс в учебной деятельности* | Sorolceeol iia fekIca | Хичээл, мэргэжлийн сургалтын үйл ажиллагааны хүрээнд мэдлэг, ур чадвар, дадал эзэмших мэдлэгийн агуулга гүнзгийрэх, | A description of increasing levels of difficulty and complexity in acquiring knowledge, skills and attitudes within a domain. It implies that |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | нэмэгдэх, тэлэх тухай ойлголт. Энэ нь тодорхой анги, түвшинд олгох сургалтын агуулгын хүрээ биш, харин сургалтыг улам нарийн, төвөгтэй болгох үйл явц юм. Багш тодорхой мэдлэгийн хүрээнд суралцагчдын одоогийн түвшин ямар байгааг тодорхойлох замаар сургалтыг цаашид хэрхэн үргэлжлүүлэх, хөгжүүлэх, сургалтын ямар арга зүй, технологи ашиглах талаар төлөвлөдөг. Сургалтын ахицыг тодорхойлох нь ямар мэдлэг, чадвар эзэмших талаар цогц ойлголт өгөхийн зэрэгцээ сургалтыг төлөвлөх, явцын үнэлгээний шалгуурыг тогтооход чухал. | learning is a process of increasing difficulty and complexity, rather than a body of content to be covered within specific grade levels. Teachers need to have in mind a continuum of how learning develops in any particular knowledge domain so that they are able to locate students' current learning status and decide on pedagogical action to move students' learning forward. Learning progressions that clearly articulate a progression of learning in a domain can provide a comprehensive view of what is to be learned, support instructional planning, and act as a touchstone for formative assessment. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн дамжуулалт*<br><br>*Transfer of learning*<br><br>*Перенос учебной деятельности* | SorolCeeol iia Demjigolda | Нэг нөхцөл байдалд суралцах нь өөр нөхцөл байдалд суралцахад нөлөөлдөг гэсэн утгыг илэрхийлнэ. Тодорхой хичээлийг судлах нь тухайн хичээлийн дараагийн шат эсвэл өөр хичээлд төдийгүй сургуулиас гадуурх суралцах үйл ажиллагаанд нөлөөлж | Generally, refers to the influence of learning in one situation on learning in another situation. It is concerned with how learning in a certain school subject affects subsequent learning in the same or another subject or how school learning influences achievements outside of school. |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | байдагтай холбоотой. Гурван үндсэн хэлбэрээр суралцахуйг дамжуулах боломжтой. Хэвтээ дамжуулалт гэдэг нь суралцагч аль нэг асуудлыг шийдэж сурсныхаа дараа түүнтэй ойролцоо ижил түвшний өөр асуудлуудыг шийдвэрлэх чадварыг хэлнэ. Дараалсан дамжуулалт гэдэг нь сургуульд заадаг ихэнх агуулгыг олон хичээлээр, дэс дараалалтайгаар заах утгыг илэрхийлнэ. Босоо дамжуулалт нь доод түвшинд сурсан зүйл нь танин мэдэхүйн чадварын дээд түвшинд дамжуулагдах ёстой гэдгийг илэрхийлдэг. Тиймээс босоо дамжуулалт нь урьд өмнө олж авсан мэдлэгийн тусламжтайгаар ижил төстэй төдийгүй илүү нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэх чадвар юм. | There are at least three basic forms of transfer. Lateral transfer occurs when learners are able to solve different but similar problems of equal complexity as soon as they have learned to solve one of them. The concept of sequential transfer corresponds with the observation that most content learned in school is organized into broad disciplines and is taught sequentially. Vertical transfer requires that learning at a lower level must be transferred to a higher level of cognitive skills. Thus, vertical transfer is the ability to solve similar and at the same time more complex or elaborated problems with the help of previously acquired knowledge. Source: UNESCO, IBE. Glossary of curriculum terminology, 2013 |
| *Суралцахуйн дөрвөн тулгуурт суурилсан сургалтын хөтөлбөр*<br><br>*Four pillars-oriented curriculum* | Dolgegorl dO Segorileeesea Sorolceeol iia Doirbia | Боловсролын үндэс болох дөрвөн тулгуурт суурилсан сургалтын хөтөлбөр. Дөрвөн тулгуурт зарчим нь: мэдэхийн тулд суралцах, хийхийн тулд суралцах, | Curriculum that takes into account the four pillars defined as the foundations of education, namely: learning to know, learning to do, learning to live |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Образовательная программа, основанная на четырёх столпах образования* | KidolBrl Sorgelda iia | хамтдаа амьдрахын тулд суралцах, оршихуйн тулд суралцах зэрэг болно. | together, and learning to be. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн дэмжлэг*<br><br>*Learning support*<br><br>*Учебная поддержка* | Sorolceeol iia Demjilkt | Дээд боловсролын сургалтын байгууллагаас оюутны амжилттай суралцах, хичээл сонгох, заавар, зөвлөгөө авахад нь туслах зорилгоор бүрдүүлсэн дэмжлэгийн цогц тогтолцоо. | A comprehensive support system in higher education institutions which enables students to concentrate in studying effectively, such as guidance for taking courses, student counseling and advice. (NIAD-QE, 2016) |
| *Суралцахуйн интерактив арга*<br><br>*Interactive teaching and learning*<br><br>*Интерактивное обучение* | fe\DiWA fer)T Sorolceeol iia finDw* | Суралцагчийг мэдлэг, туршлагаа хуваалцах замаар сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулах арга, технологи. Энэ нь суралцах үйл ажиллагаар тодорхойлж, зохион байгуулахад хувь нэмэр оруулдаг. | The practice of involving learners in the educational process by encouraging them to bring their own experience and knowledge into the process, while also contributing to defining or organizing their learning. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн орчин*<br><br>*Learning environment*<br><br>*Условия, в которых протекает учебная деятельность* | Sorolceeol iia forcia | Суралцагчийн хүрээлэн буй бодит орчин (анги танхим, сургууль), сурах үйл ажиллагаар дэмжих нөөц бололцоо, сургалтад хамааралтай эсвэл нөлөө үзүүлэх нийгмийн харилцан үйлчлэл, харилцааны хэлбэрүүд. | It indicates the learner's immediate physical surroundings (classroom, school), the resources made available to support the learning process, and the social interaction or types of social relationship functioning within this context and having an influence on learning. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Суралцахуйн удирдлага*<br><br>*Management of teaching and learning*<br><br>*Управление преподавания и обучения* | Sorolceeol iia fodoridol)T | Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох, дотоод зохион байгуулалтыг хөгжүүлэх, түүнчлэн нэгдсэн үнэлгээ хийх, сайжруулах замаар боловсролын чанарыг сайжруулах дээд боловсролын сургалтын байгууллага дахь системтэй хандлага. Боловсролын зорилгыг системтэй хэрэгжүүлэхийн тулд багшлахуй ба суралцахуйн үүрэг, хариуцлагыг тодорхой заасан засаглалын бүтцийн хүрээнд удирдана. | A systematic approach within a higher education institution to establish a policy for the achievement of educational objectives, develop internal organizations as well as attempts to enhance the quality of education while conducting evaluations and making improvements. Education and learning must be managed under a governance structure with clearly defined roles and responsibilities, in order to provide education systematically. (NIAD-QE, 2016) |
| *Суралцахуйн үндсэн хэрэгцээ*<br><br>*Basic learning needs*<br><br>*Основные потребности в обучении* | Sorolceeol iia foiedosoa kirekcekit | Хүн төрөлхтний амьдрах арга ухаанд суралцах, бүх боломжоо бүрэн хөгжүүлэх, нэр төртэй амьдарч ажиллах, хөгжил дэвшилд гар бие оролцох, амьдралын чанараа дээшлүүлэх, оновчтой шийдвэр гаргах, тасралтгүй суралцахад зайлшгүй шаардлагатай хэрэгцээ. Үүнд: суралцах арга, хэрэгсэл (бичиг үсэг болон тооны ухаанд суралцах, хэл ярианы хөгжил, асуудал шийдвэрлэх | Needs which comprise both essential learning tools (such as literacy, oral expression, numeracy, and problem solving) and the basic learning content (such as knowledge, skills, values, and attitudes) required by human beings to be able to survive, to develop their full capacities, to live and work in dignity, to participate fully in development, to improve the quality of their lives, to make informed decisions, and to continue learning. |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | чадвар) болон сургалтын үндсэн агуулга (мэдлэг, ур чадвар, үнэт зүйл, хандлага) хамаарна. Суралцахуйн үндсэн хэрэгцээ, түүний цар хүрээ нь улс орны онцлог, соёл, цаг хугацаанаас хамаарч янз бүр байна. | The scope of basic learning needs and how they should be met varies with individual countries and cultures, and inevitably, changes with the passage of time. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн үнэлгээ*<br><br>*Evaluation (in teaching and learning)*<br><br>*Оценивание (в учебной деятельности)* | Sorolceeol iia foinelekit | Сургалтын (багшлахуйн болон суралцахуйн) үйл ажиллагааны ур өгөөжийг үнэлэх системтэй үйл явц. | A systematic process aimed at judging the effectiveness of any teaching and learning programme. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн үр дүн*<br><br>*Learning outcomes*<br><br>*Результаты учебной деятельности* | Sorolceeol iia foi*T doieit | Боловсролын хөтөлбөрийг амжилттай дүүргэснээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц. Өөрөөр хэлбэл, суралцагчийн мэдэх, ойлгох, хэрэглэх шаардлагатай хүрэх үр дүнгийн илэрхийлэл. Суралцахуйн хүрэх үр дүн нь үнэлгээний шалгуурын хамт багц цаг олгох босго шалгуурыг тодорхойлдог бол сурлагын дүн нь энэхүү шалгуураас дээгүүр эсхүл доогуур байгааг харуулдаг. Суралцахуйн хүрэх үр дүн нь сургалтын зорилгоос | The totality of information, knowledge, understanding, attitudes, values, skills, competencies or behaviours a learner has mastered upon the successful completion of an education programme. (UNESCO, 2013) Statements of what a learner is expected to know, understand, and be able to demonstrate after completion of a process of learning as well as the specific intellectual and practical skills gained and demonstrated by the successful completion of a unit, course, or program. |

| | | | |
|---|---|---|---|
| | | ялгаатай ба багшийн тавьсан зорилтоос илүүтэй суралцагчийн сурлагын амжилтыг илүү чухалчилж үздэг. | Learning outcomes, together with assessment criteria, specify the minimum requirements for the award of credit, while grading is based on attainment above or below the minimum requirements for the award of credit. Learning outcomes are distinct from the aims of learning in that they are concerned with the achievements of the learner rather than with the overall intentions of the teacher. (UNESCO-CEPES, 2007) |
| *Суралцахуйн хэв маяг*<br><br>*Learning styles*<br><br>*Стиль учебной деятельности учащегося* | SorolCeeeol iia ki$ Meyi( | Суралцагч хэрхэн суралцах, багш болон бусад суралцагчидтай харилцахад нөлөөлдөг зан төлөв, хандлагын цогц. Энэ нь суралцагч суралцах орчноо хэрхэн хүлээн авах, ямар байдлаар харилцах, хариу үйлдэл үзүүлэхийг тодорхойлдог танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, физиологийн зан үйл. Д.Колб (1984)-ын тодорхойлсноор суралцахуй бол туршлага солилцох замаар мэдлэг бүтээх үйл явц юм. Д. Колбын загварт (a) туршилтаар танин мэдэх, (туршилт, ажиглалт хийх), (b) хийсвэр сэтгэхүйгээр | A set of behaviours and attitudes that influence how students learn and interact with teachers and peers. Learning styles are cognitive, affective, and physiological behaviours that serve as indicators of how learners perceive, interact with, and respond to the learning environment. For example, for David Kolb (1984) learning is the process whereby knowledge is created through the transformation of experience. In Kolb's model, learning is based on two continuums, namely: (a) processing continuum, |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | танин мэдэх (төсөөлөн бодох, мэдрэх) гэсэн суралцахуйн хоёр хэлбэрт суурилдаг гэжээ. Суралцах зорилгоос хамаарч хувь хүн хэд хэдэн сурах арга барилтай байж болох ба энэ нь цаг хугацааны эрхээр өөрчлөгдөж болдог. | e.g. approach to a task, such as preferring to learn by doing (active experimentation) or watching (reflective observation); (b) perception continuum, e.g. emotional response, such as preferring to learn by thinking (abstract conceptualisation) or feeling (concrete experience). An individual may have several learning styles which can change over time and according to the learning task. (UNESCO, 2013) |
| *Сурах бичиг*<br><br>*Textbook*<br><br>*Учебник* | SoreeO biciit | Сургалтыг чанарын шаардлагад нийцүүлэх үүднээс хичээлийн хөтөлбөр, сэдвийн агуулгын хүрээнд суралцагчдад зориулж боловсруулсан мэдээллийн бичгэн (хэвлэмэл, цахим) эх сурвалж. Сурах бичигт сургалтын хөтөлбөрийн агуулгын дараалллыг баримталдаг. | A written source of information, designed specifically for the use of students, on a particular subject or field of study that is usually developed based on a syllabus and geared towards meeting specific quality and learning requirements. School textbooks pertain to an instructional sequence based on an organized curriculum. (UNESCO, 2013) |

C

*Сурахын тулд суралцах*

*Learning to learn*

*Научиться учиться*

SoreeO iia Doleda SorolCeeO

Суралцагч нь тодорхой зорилготойгоор эсвэл зөнгөөрөө сурах үйл ажиллагаагаа төлөвлөх, хянах, өөрт нийцсэн насан туршийн суралцах үйл явц. Хувь хүн сурахын тулд суралцаж байгаа тохиолдолд үйл ажиллагаа нь асууж лавлах, ойлгож мэдрэх, дүн шинжилгээ хийх олон шинжийг агуулдаг. Европын Холбооны бүс нутагт цаг хугацаа, мэдээллийг үр дүнтэй зохицуулах замаар суралцах ба суралцах үйл ажиллагаагаа бие даан, бүлгээр зохион байгуулах чадвар гэж үздэг. Энэ нь суралцах бүх боломж, үйл явц, хэрэгцээгээ ойлгож мэддэг, амжилттай суралцахын тулд бэрхшээлийг даван туулах чадварыг агуулдаг шинэ мэдлэг, ур чадвар эзэмших, бэхжүүлэх, удирдах, ашиглах гэсэн утгатай. Сурахын тулд суралцах нь суралцагчид янз бүрийн нөхцөл байдалд мэдлэг, ур чадвараа өмнөх сургалтын болон амьдралын туршлагадаа суурилан ашиглахыг дэмждэг.

A lifelong process in which individuals deliberately or intuitively plan, monitor, and adapt their learning. When individuals learn to learn, they treat learning activities as objects of inquiry, personal reflection and self-analysis. Within the European Union area learning to learn is seen as the ability to pursue and persist in learning, to organize one's own learning, including through effective management of time and information, both individually and in groups. This key competence includes awareness of one's learning process and needs, identifying available opportunities, and the ability to overcome obstacles in order to learn successfully. Learning to learn engages learners to build on prior learning and life experiences in order to use and apply knowledge and skills in a variety of contexts. (UNESCO, 2013)

С

| | | | |
|---|---|---|---|
| *Сургагч*<br><br>*Tutoring*<br><br>*Репетиторство* | Sorgeeci | Суралцагчдад удирдамж, зөвлөгөө, чиглэл өгдөг туршлагатай, чадварлаг мэргэжилтэн. Сургагч нь суралцагчийн суралцах үйл явцад (сургууль, сургалтын төв, ажлын байранд) дараах байдлаар дэмжлэг үзүүлдэг. Үүнд: сургалтын амжилтыг сайжруулах зорилгоор тодорхой чиглэл, хичээлийн хүрээнд дэмжлэг үзүүлэх; сургуулиа төгсөөд хөдөлмөрийн зах зээлд хөл тавих шилжилтийн үед туслах, ажил мэргэжлийн зөвлөгөө өгч чиглүүлэх; суралцагчид амьдралдаа ухаалаг сонголт хийх хувь хүний хөгжилд дэмжлэг үзүүлэх зэрэг юм. | Any activity offering a learner guidance, counselling or supervision by an experienced and competent professional. The tutor supports the learner throughout the learning process (at school, in training centres or on the job). Tutoring can cover: academic subjects to improve educational achievement; careers to ease transition from school to work; and personal development to encourage learners to make wise choices. (UNESCO, 2013) |
| *Сургалтын агуулга*<br><br>*Learning content*<br><br>*Содержание обучения* | Sorgelda iia fegol)T | Багшлахуйн болон суралцахуйн үндэс болсон эзэмших ёстой мэдлэг, ур чадвар, үнэт зүйл болон хандлагын хүрээнд суралцах чиглэл, судлах агуулгаар бүлэглэсэн сэдэв, үзэл баримтлал, баримт мэдээ. | The topics, themes, beliefs, behaviours, concepts and facts, often grouped within each subject or learning area under knowledge, skills, values and attitudes, that are expected to be learned and form the basis of teaching and learning. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын багц цагийн бүрдэл*<br><br>*Accumulation of study credits*<br><br>*Накопление зачетных единиц* | Ce( oa Birido& Sorgelda iia bieca | Сургалтын түвшин, агуулгын нийтлэг байдлаас хамааран өөр сургалтын байгууллага хүлээн зөвшөөрөх, харилцан дүйцүүлэх боломжтой суралцагчийн цуглуулсан багц цагийн бүрдэл. | Set credits gained by a student in a given higher education institution may be recognized in another institution, depending upon the commonality in terms of level and context, considered as transferable. (UNESCO-CEPES, 2007) |
| *Сургалтын далд хөтөлбөр*<br><br>*Hidden curriculum*<br><br>*Образовательная скрытая программа* | Sorgelda iia Delda KidolBrl | Сургуулийн соёл, зан үйл, уламжлалаар шууд ба шууд бусаар суралцагчдад дамждаг албан бус хэм хэмжээ, ёс суртахуун, үнэт зүйл бөгөөд энэ нь заавал зорилготой байх албагүй. Сургуулийн үйл ажиллагаа нь нийгэм, соёлоос ихээхэн хамааралтай болохыг далд хөтөлбөр мэдрүүлдэг. | This term has various interpretations and in general it refers to unofficial norms, behaviours and values that teachers teach and students learn at school, or that are directly / indirectly transferred by the school culture or ethos, and which are not necessarily a product of conscious intention. The hidden curriculum acknowledges that schooling takes place in a broad social and cultural environment that has an influence on learning. Increasingly referred to as 'school-related factors'. (UNESCO, 2013) |
| *Сургалтын зээл*<br><br>*Student loan*<br><br>*Кредит на образование* | Sorgelda iia Jikla | Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу элсэн суралцаж байгаа иргэний сургалтын төлбөр болон | A type of loan designed to help students pay for tertiary education and the associated fees, such as tuition, books and supplies, and living |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох зээл. | expenses. (The Law on Higher Education Financing and Social Security, 2011) |
| *Сургалтын нөөц*<br><br>*Learning resources*<br><br>*Учебные ресурсы/ учебные материалы* | Sorgeldа iia Noikica | Сургалтын үйл ажиллагааг шууд ба шууд бус хэлбэрээр дэмжин сайжруулдаг аливаа биет болон биет бус нөөц. Үүнд: хэвлэмэл, хэвлэмэл бус материалууд (цахим, нээлттэй эх материал) хамаарна. Хичээлд хэрэглэгдэх сургалтын нөөцийг сургууль, орон нутгийн болон үндэсний түвшинд үнэлгээ хийж, баталгаажуулдаг. Үнэлгээний шалгуур нь сургалтын хөтөлбөр болон суралцах хүлээлтэд нийцсэн эсэх, нийгмийн асуудлыг тусгасан, суралцагчийн нас, хөгжлийн түвшинд тохирсон эсэх зэрэг болно. | Any resource – including print and non-print materials and online/ open-access resources – which supports and enhances, directly or indirectly, learning and teaching. Typically the use of a learning resource in the classroom is subject to a process of evaluation and approval at the school, local or national level. Evaluation criteria may include relevance to the curriculum and expectations for learning, social considerations, and age or developmental appropriateness. (UNESCO, 2013) |
| *Сургалтын төлбөр*<br><br>*Tuition*<br><br>*Плата за обучение* | Sorgeldа iia DoiloBrl | Сургалтын үйл ажиллагаанд зориулан тухайн сургалтын байгууллагаас тогтоосон мөнгөн дүн. | The money an institution charges for instruction and training. (Glossary of terms in HE, 2016) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын төлбөрөөс чөлөөлөх*<br><br>*Tuition waiver*<br><br>*Освобождение от платы за обучение* | Sorgelda iia DoiloBrl fca CilokilеK | Сургалтын төлбөр төлөх үүргээс чөлөөлөх замаар суралцагчдад үзүүлж буй нэг төрлийн санхүүгийн дэмжлэг. | An exemption from the payment of the tuition usually awarded to students as part of an assistantship or fellowship. (Glossary of terms in HE, 2016) |
| *Сургалтын төлөвлөгөө*<br><br>*Study plan*<br><br>*Учебный план* | Sorgelda iia Doilobekit | Сургалт, судалгааны зорилгод (бакалавр, магистр, докторын хөтөлбөр г.м.) хүрэхийн тулд судалбал зохих хичээл (заавал судлах хичээл, сонгон судлах хичээл, чөлөөт сонгон судлах хичээл)-ийн багц. | A set of study courses (required courses, elective courses, and free elective courses) necessary for the achievement of education and research objectives (e.g. bachelor's, master's and doctoral programs). (NIAD-QE, 2016) |
| *Сургалтын уртасгасан цаг*<br><br>*Expanded learning time*<br><br>*Расширенное время обучения* | Sorgelda iia fordoseeeesea Ce( | Суралцагчийн сурлагын амжилтыг нэмэгдүүлэх, нэмэлт хичээл, үйл ажиллагаа явуулах зорилгоор сургалтыг нэг өдөр, долоо хоног эсвэл хичээлийн жилээр сунгах хугацаа. | Lengthening of the school day, school week or school year for all students to focus on core academic and enrichment activities to enhance learner success. (UNESCO, 2013) |
| *Суралцахуйн үр дүнгийн баталгаажуулалт*<br><br>*Validation of learning outcomes*<br><br>*Признание результатов обучения* | Sorolceeol iia foi*T doieit oa bidolegejigololda | Үнэлгээний янз бүрийн аргыг (бичгэн болон аман сорил, шалгалт, дадлагын ажил, төсөл, бүтээлийн сан) ашиглан хувь хүний суралцахуйн зорилтдоо хүрсэн амжилтыг үнэлэх үйл явц. Үнэлгээнд оролцогч нь боловсролын хөтөлбөрт заавал хамрагдсан байх шаардлагагүй байдаг. | Evaluation of an individual's achievement of learning objectives using a variety of assessment methods (written, oral and practical tests/ examinations, projects and portfolios) not presuming participation in an education programme. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөр*<br><br>*Curriculum*<br><br>*Образовательная программа* | Sorgelda iia KidolBrl | 1. Суралцагч юуг, хэзээ, ямар зорилгоор, яаж, хэр зэрэг судлахыг системтэй бөгөөд зорилготойгоор тодорхойлсон баримт бичиг.<br>2. Тодорхой нэг мэргэжлээр суралцан төгсөхөд шаардлагатай багц хичээлийн тогтолцоо. Ажил, мэргэжлийн салбарт хөл тавихад нь шаардлагатай мэргэшил эзэмшүүлэн гэрчилгээ олгохын тулд сургалтын байгууллагаас суралцагчдад санал болгож буй сургалтын агуулга болон хэрэглэгдэхүүнийг багтаасан ерөнхий төлөвлөгөө. | 1. Curriculum is a description of what, when, why, how and how well students should learn in a systematic and intentional way. (UNESCO, 2013)<br>2. Systematic group of courses or sequences of subjects required for a graduation or certification in a major field of study. It is a general overall plan of the content or specific materials of instruction that the school should offer the student by may of qualifying him for graduation or certification of entrance into a professional or vocational field. (VETP-1, 2018) |
| *Сургалтын хөтөлбөр судлал*<br><br>*Curriculum studies*<br><br>*Изучение образовательной программы* | Sorgelda iia KidolBrl Sodolol | Сургалтын хөтөлбөр гэж юу болох, ямар байх ёстой талаарх үзэл хандлага, баримт, хувилбаруудыг боловсролын онол, үзэл баримтлал, үйл ажиллагаатай уялдуулан судлах боловсрол судлалын салбар шинжлэх ухаан. | A field dealing with an array of sources that provide the following: (a) perspective on questions about what curriculum is or ought to be; (b) alternative or complementary paradigms of inquiry that enable explorations of such questions; and (c) diverse possibilities for proposing and enacting responses to the questions in educational theory and settings of educational practice. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн зорилго*<br><br>*Curriculum aims/goals*<br><br>*Цель образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Joril)T | Сургалтын хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүнг ерөнхийд нь гүйцэтгэлийн нарийн шалгуур үзүүлэлтгүйгээр өргөн хүрээнд авч үзсэн тодорхойлолт. Сургалтын хөтөлбөрийн зорилго нь боловсролын зорилго, философитой уялдаатай бөгөөд хувь хүний сургалтын амжилт гэхээс илүүтэйгээр бүлэг суралцагчийн хүрэх үр дүнг заадаг. | Broad descriptions of purposes or ends stated in general terms without criteria of achievement or mastery. Curriculum aims or goals relate to educational aims and philosophy. Typically, they refer to the accomplishment of groups rather than the achievement of individual learners. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт*<br><br>*Curriculum planning*<br><br>*Планирование образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Doilob;elda | Мөрдөгдөж буй сургалтын хөтөлбөрийн шаардлага болон байгаа нөөц бололцоонд тулгуурлан юуг, яагаад, хэрхэн сургах талаар сургалтын үйл ажиллагаа зохион байгуулахтай холбоотой шийдвэр гаргах үйл явц. Энэ нь сургуулийн түвшинд хичээл бүрээр сургалт болон үнэлгээний төлөвлөгөө боловсруулахад ашигладаг бол ангийн түвшинд нэгж хичээл, хичээлийн агуулга, дарааллыг нарийвчлан боловсруулахад ашигладаг. | The process concerned with making decisions about what to learn, why, and how to organize the teaching and learning process taking into account existing curriculum requirements and the resources available. At the school level, it involves developing course and assessment plans for different subjects. At the classroom level, it involves developing more detailed plans for learning units, individual lessons and lesson sequences. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн ач холбогдолтой байдал*<br><br>*Curriculum relevance*<br><br>*Актуальность образовательной программы* | HolBeeldel bIirdeI Sorgelda iia KidolBrl iia fecl | Суралцагч болон нийгмийн хэрэгцээ, хүсэл сонирхол, хүлээлтэд сургалтын хөтөлбөрийн нийцэж буй байдал. | Applicability and appropriateness of a curriculum to the needs, interests, aspirations and expectations of learners and society in general. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн бодлого*<br><br>*Curriculum policy*<br><br>*Политика образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Bdol)T | Сургалтын төлөвлөгөөний бүтэц, хэрэгжүүлэх арга зүйтэй холбоотой суурь бодлого. Бодлогыг боловсруулахдаа сургалтын хөтөлбөрийн системтэй байдал, багц цагийн үнэлэмж, сургалтын арга зүйг сайжруулах, үнэлгээний оновчтой байдал зэргийг харгалзан үздэг. Нөгөө талаас сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой засгийн газар, эрх бүхий боловсролын байгууллагын албан ёсны шийдвэр. Тэдгээр шийдвэр нь албан ёсны бодлогын баримт бичигт тусгагддаг. | Fundamental policies regarding the composition of the curriculum and the method of its implementation. When formulating this policy, attention must be paid to such matters as the systematization of the curriculum, ensuring credit validity, improvement of educational methods, and strict grading. (NIAD-QE, 2016). Formal decisions made by government or education authorities that have a direct or significant effect on the curriculum, its development and implementation. These decisions are normally recorded in a range of official documents. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт*<br><br>*Curriculum development*<br><br>*Совершенствование образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia BIbisoregololda | Сургалтын хөтөлбөрийг боловсруулах үйл явц. Чанартай сургалтын хөтөлбөр боловсруулахын тулд нарийн төлөвлөж, системтэй зохион байгуулах, оролцогч талуудын санал, зөвлөмжийг үнэлэн тусгаж, урт хугацаанд гарах үр нөлөөг харгалзан тогтвортой байдлыг хангахад анхаарах хэрэгтэй. | The process of designing the curriculum. In order to produce a quality curriculum, this process should be planned and systematic. It should value the input of stakeholders and also cater for sustainability and long-term impact. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн*<br><br>*Curriculum organizers*<br><br>*Организаторы образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia BirildoKa | Сургалтын үйл ажиллагааг сонгох, зохион байгуулах болон сургалтын хөтөлбөрийг бүрдүүлэх гол лавлах эсвэл үндэс суурь болох бүрэлдэхүүн. Эдгээр нь хичээл, сэдэв, сургалтын хугацаа, сургалтын үр дүн зэрэг байж болно. | Elements of the curriculum used as the main reference or basis for selecting and organizing learning experiences and defining the curriculum architecture. These can be subjects, themes, instructional time, learning outcomes, etc. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн бүтэц*<br><br>*Curriculum structure*<br><br>*Структура образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Bidoca | Сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зам, үргэлжлэх хугацаа зэргийг багтаасан сургалтын хөтөлбөрийн зохион байгуулалт. Сургалтын хөтөлбөр нь анги, түвшнээс хамаарч үндсэн ба сонгон суралцах хичээлүүдээс бүрдэж болно. | The way in which the curriculum is organized, including the subjects or learning areas, when they must be studied and the ‘pattern’ in which they must be studied. The curriculum may be composed, for example, of core and elective subjects studied with some variation between grades. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн загвар*<br><br>*Curriculum design*<br><br>*Дизайн образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia JeeeB* | Суралцагчдад юуг, ямар арга зүйгээр хэрхэн сургах, үнэлэх хийгээд шаардагдах нөөц материал зэрэг сургалтын хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг уялдуулан боловсруулах үйл явц. | The process of meaningfully constructing and interconnecting the components of a curriculum so as to address such fundamental questions as what needs to be learned and how and why, the resources required and how learning will be assessed. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн зорилт*<br><br>*Curriculum objectives*<br><br>*Основные задачи образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Jorilda | Сургалтын хүрэх үр дүнд заасны дагуу суралцагч юу мэддэг, чаддаг болсон байх (суралцагч юу сурч, мэдэхийг зорьсон), бүтээгдэхүүн эсвэл гүйцэтгэл (сургалтын үр дүнд суралцагч ямар бүтээгдэхүүн гаргах), үйл явцын (сургалтын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон) хэмжигдэхүйц хүлээлтүүдийг тусгасан ойрын ирээдүйд гүйцэтгэхээр шийдвэрлэсэн бодлого. Өөрөөр хэлбэл, суралцагч юу сурч мэдэх, юу хийж чаддаг болохыг заасан сургалтын хүрэх үр дүнг тодорхойлсон мэдээлэл. Мөн сургалтын хөтөлбөрийн зорилгыг дэлгэрүүлсэн хэлбэр гэж үзэж болно. | Specific statements setting measurable expectations for what learners should know and be able to do, described either in terms of learning outcomes (what the learners are expected to learn), products or performance (what learners will produce as a result of a learning activity) or processes (describing the focus of learning activities). They can be seen as refinements of curriculum aims/ goals that, for example, specify: performance standards or those skills and knowledge the learners are expected to be able to demonstrate; inferred or precise degree of mastery; and the conditions under which the performance will take place. In terms of effectiveness, curriculum |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | Сургалтын хөтөлбөрийн зорилтууд нь багш, суралцагч, эцэг эхчүүдэд ойлгомжтой, оновчтой, өмнөх мэдлэг, ур чадвартай уялдсан, хэрэгжүүлэх боломжтой, хэмжигдэхүйц байх ёстой. | objectives should: be concise and understandable to teachers, learners and parents; be feasible for the teachers and learners to accomplish; encompass previous learning and require the learner to integrate and then apply certain knowledge, skills, and attitudes in order to demonstrate achievement; and be measurable on a cumulative basis and at different stages of the learner's educational career. Related terms: "Curriculum aims/goals". (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн зураглал*<br><br>*Curriculum chart / curriculum map*<br><br>*Карта образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Jiroeel& | Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага болон хичээл хоорондын уялдаа холбоог тодорхойлсон суралцахуйн замыг илэрхийлэх ерөнхий ойлголт. | General terms for a chart/map showing the path of learning and the correspondence between courses and the knowledge, skills, and attitude students are expected to acquire. (NIAD-QE, 2016) |
| *Сургалтын хөтөлбөрийн интеграци*<br><br>*Curriculum integration*<br><br>*Интеграция образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia finDwkre]l | Нэгдмэл, цогц сургалтыг дэмжих үүднээс сургалтын агуулгыг нэгтгэж, уялдуулах үйл явц. | The process of combining/articulating learning content and subjects with a view to promoting holistic and comprehensive learning. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн нийцэл*<br><br>*Curriculum alignment*<br><br>*Выравнивание образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Neiice& | Нэгж хичээлийн заах арга зүй, үнэлгээний даалгавар, сургалтын үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрт заасан хүрэх үр дүнд нийцүүлэх, уялдуулах үйл явц. | A process aimed at ensuring coherence and consistency between the intended outcomes as specified in the formal curriculum and teaching methods, assessment tasks, and learning activities in the classroom. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн тохируулга*<br><br>*Curriculum adaptation*<br><br>*Адаптация образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Dokiregol)T | Сургалтын хөтөлбөрийг чадварын хувь ялгаатай түвшний суралцагчдын тусгай хэрэгцээнд нийцүүлэн тохируулах үйл явц. | A process of adjusting the existing curriculum to meet the diverse needs of learners of all abilities. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн нутагшуулалт*<br><br>*Localization of curriculum*<br><br>*Локализация образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Nodoesigololda | Орон нутгийн шинжтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулахын тулд иргэд, оролцогч тал, байгууллагуудын оролцоотойгоор сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг боловсруулах, сайжруулах үйл явц. | Process of defining parts or components of the curriculum at community/local or school level, normally with the involvement of local staff, stakeholders and institutions, so as to address issues that are locally relevant and allow for more meaningful learning experiences. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн удирдамж*<br><br>*Curriculum guidelines*<br><br>*Руководство / инструкции / рекомендации к образовательной программе* | Sorgelda iia KidolBrl iia fodoridomj l | Багшид зориулан сургалтын хөтөлбөрийг амжилттай төлөвлөн хэрэгжүүлэх арга зам, дэг журмыг тодорхойлон боловсруулсан баримт бичиг. Энэ нь сургалтын тодорхой чиглэл, хичээл (эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн удирдамж), боловсролын түвшин (сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн удирдамж), суралцагчдын бүлэг (тусгай хэрэгцээт суралцагчид, үндэсний цөөнх, цагаач иргэд), эсвэл сургалтын ерөнхий хөтөлбөр (сургалтын хөтөлбөр, заах арга зүй, үнэлгээний удирдамж)-ийн хүрээнд чиглэгдэж болно. | A document or set of documents usually providing guidance for teachers and instructors on approaches and procedures for a successful planning and implementation of the curriculum. Guidelines can focus on a specific learning area or subject (e.g. health education curriculum guidelines), a particular educational level (e.g. curriculum guidelines for preschool education), a specific group of learners (e.g. learners with special educational needs, minorities, immigrants) or more broadly on the curriculum (e.g. curriculum, instruction and assessment guidelines). (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн үндсэн үе шат*<br><br>*Key stages of the curriculum*<br><br>*Основные этапы образовательной программы* | foiIT ZedO Sorgelda iia KidolBrl iia foiedosoa | Хичээлийн жилийн туршид сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах үйл ажиллагааны шатлал, дараалал. Энэ нь сургалтын шат бүрд суралцагчийн нас, төлөвшлийн түвшинд тохирсон мэдлэг, ур чадвар, хандлага болон хүрэх зорилт, үр дүнг | curriculum into blocks of school years and normally covering the period of compulsory schooling. This typically implies defining the knowledge, skills, attitudes and the related attainment targets/learning A way of organizing the outcomes appropriate for the learner's age and maturity |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | тодорхойлдог. Хөтөлбөрийн гол үе шатууд нь албан боловсролын үе шатуудтай заавал давхцах албагүй. | level within each stage. Key stages of the curriculum may not necessarily overlap with formal educational stages. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ*<br><br>*Curriculum evaluation*<br><br>*Оценка образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia foinelekit | Албан ёсны сургалтын хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөөт хичээл, сургалтын үйл ажиллагаа нь зорьсон үр дүнд чиглэгдэн хүрч байгаа эсэхийг хэмжих, үнэлэх үйл явц. Үнэлгээг үр дүнтэй хэрэгжүүлснээр цаашид хөтөлбөрийг хөгжүүлэх, сайжруулах талаар шийдвэр гаргахад чухал нөлөөтэй. | The process of measuring and judging the extent to which the planned courses, programmes, learning activities and opportunities as expressed in the formal curriculum actually produce the expected results. If carried out effectively, this process can enable decisions to be made about improvements and future progress. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ*<br><br>*Curriculum framework*<br><br>*Рамка образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia HemoreeO KiriIT | Улс орны алсын хараа, эдийн засгийн хөгжил, боловсролын бодлогоос эхлээд боловсролын түвшин бүр дэх зорилго, зорилт, сургалтын чиглэл, үйл ажиллагаа, танхимын хичээлд ногдох цаг, үнэлгээ, түүнчлэн хөтөлбөр боловсруулагч, сургагч багш болон сурах бичиг зохиогчдод удирдамж, чиглэл болохуйц олон агуулгыг багтаасан суурь баримт бичиг юм. | An overarching document that: places national statements of vision, economic development and education policy in a curriculum context; sets out broad aims and objectives of the curriculum at the various stages of schooling; outlines the curriculum structure, its subjects or learning areas; allocates time to various subjects and/or learning areas in each grade or stage; provides guidelines |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | Сургалтын хөтөлбөрийн хүрээ гэсэн энэхүү нэр томьёог ерөнхий үр дүн (сургууль төгсөх үед), тусгай үр дүн (анги төгсөх үед) болон тодорхой нэг хичээл эсвэл хичээлийн сэдвийн хүрээний ахицын үзүүлэлтүүдийг (хүрэх үр дүнгийн цар хүрээ болон хүлээлт) тодорхойлох баримт бичиг гэж үзэж болно. | to subject curricula developers, teacher trainers and textbook writers. The term can also be used to refer to a document which specifies the general outcomes (to be attained throughout the grades), the specific outcomes (to be attained by the end of a given grade), and the achievement indicators (e.g. a representative list of the depth, breadth, and expectations of the outcome) for a particular subject or subject area. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн хэвтээ, босоо бүтэц*<br><br>*Vertical and horizontal articulation (of the curriculum)*<br><br>*Вертикальная и горизонтальная артикуляция образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia kibdekit, Bso)T Bidoca | Тодорхой хугацаанд мэдлэгийн нэг салбар эсвэл хичээлийн хүрээнд сургалтын агуулгыг дэс дараалалтай, залгамж холбоотой (логик дараалын уялдааг сайжруулах хэвтээ бүтэц) болон тодорхой түвшний (ангийн сургалтын хөтөлбөрт өөр түвшний мэдлэг) хичээлийг уялдуулах, нэгтгэх сургалтын агуулгын зохион байгуулалт (хичээл, сэдэв, мэдлэгийн хүрээ хоорондын уялдаа холбоог сайжруулах босоо бүтэц). | Organization of contents according to the sequence and continuity of learning within a given knowledge domain or subject over time (vertical articulation to improve coherence) and the scope and integration of curricular contents from different knowledge domains within a particular grade level (horizontal articulation or balance to develop integration between subjects, disciplines or knowledge domains). (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт*<br><br>*Curriculum implementation*<br><br>*Осуществление образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia kirekjilda | Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл явц. Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийг хөгжүүлэх, сургуулийн манлайлал, ёс зүйг дэмжих, багшийн мэргэжил дээшлүүлэх, шинэ сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, удирдамж боловсруулах зэрэг үйл ажиллагаанууд зайлшгүй чухал байдаг. | The process of putting the formal curriculum into practice. In the case of a new or revised curriculum this process ideally includes school development and improvement processes; fostered school leadership and ethos; in-service teacher training and the development of new textbooks, teaching and learning materials and resources, as well as guidelines. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн хяналт, шинжилгээ*<br><br>*Curriculum monitoring*<br><br>*Мониторинг в образовательной программе* | Sorgelda iia KidolBrl iia kimelda, Siejilekit | Сургалтын хөтөлбөрийн ач холбогдол, хэрэгжилт, зорилго, үр дүнд хүрсэн эсэхийг үнэлж, тогтоохын тулд мэдээлэл цуглуулах үйл явц. Энэ нь хөтөлбөрийн ач холбогдол, нийцэл, хэрэгжихүйц байдал, үр нөлөө, цар хүрээ, тогтвортой байдал болон суралцагч зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг тогтоох зорилготой. | A process of gathering information for evaluating the effectiveness of the curriculum and ensuring that the intended, implemented and attained curricula are aligned. This process typically focuses on such issues as relevance, consistency, practicality, effectiveness, scaling-up and sustainability, as well as whether learners are achieving the expected learning outcomes. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн чиг хандлага*<br><br>*Curriculum trends*<br><br>*Тенденция в образовательной программе* | Ciit Heedol) T Sorgelda iia KidolBrl iia | Өнөөгийн болон ирээдүйн боловсрол, нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн улмаас сургалтын хөтөлбөрт гардаг парадигмын үндсэн өөрчлөлт. | Increasingly important changes that are taking place in the field of curriculum to respond to current and anticipated developments in society and education. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл*<br><br>*Curriculum change*<br><br>*Изменение образовательной программы* | Sorgelda iia KidolBrl iia Sinecile& | Нөхцөл байдал, тэргүүлэх чиглэл өөрчлөгдсөнөөр түүнд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг засан сайжруулах, шинэчлэх үйл ажиллагаа. Нийгэмд бий болж буй өөрчлөлт, шинэчлэл, хөгжил, дэвшилтэй уялдуулан суралцагчийг амьдралд бэлтгэхэд ач холбогдолтой байхуйцаар сургалтын хөтөлбөрийг бүхлээр нь өөрчилж, шинээр боловсруулах эсвэл ерөнхий бүтцэд нь нөлөөлөхгүйгээр өөрчлөлт оруулах боломжтой. Мөн шинэ арга барил, хандлагыг бий болгодог инновац, одоо мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөрийг шинэчлэх өргөн хүрээний, бүхий л тогтолцоог өөрчлөн шинэчлэхийг хэлнэ. | Modifications introduced in the curriculum to improve or adapt it to new circumstances or priorities. This can be done through: minor adjustments that do not affect the curriculum structure; modernization to ensure that the curriculum remains current and relevant, reflects new developments in society and adequately prepares learners for life; innovation that brings new approaches and solutions; and large scale, system-wide reform that entirely reshapes the existing curriculum. (UNESCO, 2013) |

C

| | | | |
|---|---|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн элементүүд хоорондын уялдаа холбоо*<br><br>*Curriculum coherence*<br><br>*Последовательность / согласованность образовательной программы* | Hogoroed0 iia foyeldo)T HolB)T Sorgelda iia KidolBrl iia flwmnDA ooa | Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга төдийгүй сурах бичиг, сургалтын арга хэрэгсэл, үнэлгээ нь бүгд хоорондоо уялдах, нийцэх, нэг нэгнээ бататгах шинж байдал. | A characteristic of curriculum indicating the extent to which the curriculum aims and content, as well as textbooks, teaching methods, and assessment are all aligned and reinforce one another. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрийн ялгаатай байдал*<br><br>*Curriculum differentiation*<br><br>*Дифференцирование образовательной программы* | filgegedel bEiide& Sorgelda iia KidolBrl iia | Суралцагчдын мэдлэг, чадварын ялгаатай байдалд тохируулан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, өөрчлөх үйл явц. Энэ нь сургалтын агуулга, заах арга зүйн болон үнэлгээний аргуудыг суралцагчдын хэрэгцээ, онцлогт нийцүүлдэг. | The process of modifying or adapting the curriculum according to the different ability levels of the learners in the classroom. It is a strategy that teachers can use with a view to providing meaningful learning experiences for all learners. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх цикл*<br><br>*Curriculum review cycle*<br><br>*Цикл пересмотра образовательной программы* | Sorgelda iia KidolBrl dO foinelekit kuK }iV& | Сургалтын үйл ажиллагааг тогтмол сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх, алдаа, дутагдлыг олж илрүүлэх зорилгоор тодорхой давтамжтайгаар сургалтын хөтөлбөрийг үнэлэх, хянах, сайжруулах системтэй үйл явц. Энэ нь судалгаа ба сонголт, сайжруулалт ба хөгжил, хэрэгжилт, хяналт | A systematic approach to evaluating, reviewing and revising curricular areas and programmes within a specific timeframe which aims to identify gaps and weaknesses with a view to increasing curriculum effectiveness and continually improving student learning experiences. Normally it involves several phases including: research; and |

| | | | |
|---|---|---|---|
| | | үнэлгээ гэсэн хэд хэдэн үе шаттай. | selection; revision and development implementation; and evaluation and monitoring. (UNESCO, 2013) |
| *Сургалтын хэлбэр*<br><br>*Mode*<br><br>*Форма обучения* | Sorgelda iia kilbirI | Өдөр эсвэл оройн цагаар, ажлын байранд суурилсан, сургуулийн хотхонд эсвэл зайн сургалт зэргээр явагдаж буй сургалтын хэлбэрийг илэрхийлнэ. | Mode of study refers to whether the program is taken on a part-time or full-time basis, or through some form of work-linked learning and may include whether taken on-campus or through distance education. (INQAAHE, 2017) |
| *Сургалтын цөм хөтөлбөр*<br><br>*Core curriculum*<br><br>*Основная образовательная программа* | Sorgelda iia Coi^ KidolBrI | Тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичиг. Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөр дэх заавал судлах хичээлүүд. | The core curriculum refers to subjects that are provided by HEIs and which are considered essential for inclusion in the curriculum. (NIAD-QE, 2016) |
| *Сургуулийн зураглал*<br><br>*School mapping*<br><br>*Картирование школы* | SorgegolI iia JiroelE& | Хүн ам зүй болон орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвт суурилсан сургууль байгуулах, байршуулах, түүний бүтэц, хэв шинжийг тодорхойлох төлөвлөлт. | School mapping is an essential planning tool to overcome possibilities of regional inequities arising from the investment policies of the public authorities. School mapping incorporates spatial and demographic dimensions into the |

C

| | | | |
|---|---|---|---|
| | | | educational planning process. (Mongolia's Master Plan to develop Education in 2006-2015, 2006) |
| *Суурь судалгаа*<br><br>*Basic research*<br><br>*Фундаментальное исследование* | SegorI Sodol)T | Хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн туршилтын болон онолын үйл ажиллагаа. (Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 2006). Аливаа үзэгдэл, ажиглаж болохуйц баримт, нотолгоонд түшиглэн, шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн, тодорхой хэрэглээнд ашиглах зорилгогүй, туршилтын буюу онолын ажил. | Basic research is experimental or theoretical work undertaken primarily to acquire new knowledge of the underlying foundation of phenomena and observable facts, without any particular application or use in view. (The Law of Mongolia on Science and Technology, 2006). Basic research is experimental or theoretical work undertaken primarily to acquire new knowledge of the underlying foundations of phenomena and observable facts, without any particular application or use in view. (OECD, Frascati Manual: Guidelines for Collecting and Reporting Data on Research and Experimental Development, 2015) |
| *Суурь чадвар*<br><br>*Basic skills / generic skills*<br><br>*Основные навыки* | SegorI CideBrI | Суралцах, ажиллах, амьдрахад шаардлагатай мэдлэг, түүнийг хэрэглэх, ашиглах чадвар. Бичиг үсэг, тооны ухааныг сургалтын хөтөлбөрт суурь, эвсэл үндсэн чадвар гэж үздэг. | The fundamental knowledge as well as operational aspects of knowledge needed for learning, work and life. Within the curriculum, literacy and numeracy are normally considered as |

| | | | |
|---|---|---|---|
| | | Мөн суурь чадварыг хувь хүн өнөөгийн нийгэмд амжилттай аж төрөхөд шаардлагатай цогц чадвар гэж тодорхойлж болно. | foundational, essential or basic skills. The term can include a range of skills that individuals need to live successfully in contemporary society. (UNESCO, 2013) |
| *Сэдэвчилсэн үнэлгээ*<br><br>*Thematic evaluation*<br><br>*Тематическая оценка* | Sedobcileksea foinelekit | Сургалтын байгууллагын олон улсын харилцаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг эрх бүхий байгууллагаас үнэлэх үнэлгээ. | Evaluation in which institutions are assessed on their international exchanges, social contribution and so on in light of certain themes set by evaluation organizations. (NIAD-QE, 2016) |
| *Сэтгэл хөдлөлөө таних, удирдахуй*<br><br>*Emotional intelligence*<br><br>*Эмоциональный интеллект* | Seoekü& Kidelo& iiea DenieeO, fodorioeeol | Бодол, сэтгэхүйгээ сайжруулах үүднээс сэтгэл хөдлөлөө таньж, хянан удирдах чадвар. Үүнд: оюун ухаан, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үүднээс сэтгэл хөдлөлийг зөв танин мэдэх, ойлгох, зөв илэрхийлэх, удирдан залах зэрэг чадвар багтана. | The capacity to reason about emotions, and of emotions to enhance thinking. It includes the abilities to accurately perceive emotions, to access and generate emotions so as to assist thought, to understand emotions and emotional knowledge, and to reflectively regulate emotions so as to promote emotional and intellectual growth. (UNESCO, 2013) |

C

## Т

| | | | |
|---|---|---|---|
| *Танин мэдэхүйн хүрээний тархи судлал*<br><br>*Cognitive neuroscience*<br><br>*Когнитивная нейронаука* | Denia MedeKI iia Kiriyea O DerikA Sodolol& | Сэтгэл судлал, тооцоолон бодох ухаан, танин мэдэхүйн хүрээний тархи судлалын үндсийг судлах зорилго бүхий оюун ухаан, тархины хөгжлийг судалдаг салбар хоорондын шинжлэх ухаан. | Study and development of mind and brain research aimed at investigating the psychological, computational, and neuroscientific bases of cognition. (UNESCO, 2013) |
| *Танин мэдэхүйн чадамж*<br><br>*Cognitive competence*<br><br>*Когнитивная компетенция* | Denia MedeKI iia Cidemj I | Хувь хүний мэдлэгээ хөгжүүлэх, орчин нөхцөлдөө дасан зохицоход туслах хүчин зүйл болсон чадвар. Үүнд: учир шалтгааныг эргэцүүлэх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, системийн сэтгэлгээ ба загварчлах, онолчлох, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах, төлөвлөх, зорилгоо тодорхойлох зэрэг чадварууд хамаарна. | Skills that contribute to the objectives of individual knowledge development, also serving as individual protective factors contributing to successful adaptation. (UNESCO-CEPES, 2007). These may include competencies like: reasoning, information-gathering, information analysis, systems-thinking and pattern recognition, theory building, problem-solving, decision-making, planning and goal-setting. (ANQA, 2016) |
| *Танин мэдэхүйн шинжлэх ухаан*<br><br>*Cognitive science*<br><br>*Когнитивная наука* | Denia MedeKI iia Siejilek foeeegea | Сэтгэл судлал, гүн ухаан, компьютерын шинжлэх ухаан, хиймэл оюун ухаан, хэл шинжлэл зэрэг олон шинжлэх ухааны уулзварт орших салбар хоорондын шинжлэх ухаан. Танин мэдэхүйн шинжлэх ухаан | Study of the mind. An interdisciplinary science that draws upon many fields including neuroscience, psychology, philosophy, computer science, artificial intelligence, and linguistics. The purpose |

Т

| | | | |
|---|---|---|---|
| | | нь мэдрэхүй, сэтгэхүй, суралцахуй зэрэг хүний танин мэдэхүйн үйлийн загварыг боловсруулах зорилготой. | of cognitive science is to develop models that help explain human cognition – perception, thinking, and learning. (UNESCO, 2013) |
| *Тархи судлал*<br><br>*Neuroscience*<br><br>*Нейронаука* | DerikwA Sodolo& | Хүний зан төлөв, оюун ухаанд нөлөөлөх мэдрэлийн эсийн анатоми, физиологи, биохимийг судалдаг салбар хоорондын шинжлэх ухаан. | An interdisciplinary field of study concerned with the anatomy, physiology, and biochemistry of the nervous system and its effects on behaviour and mental experience. (UNESCO, 2013) |
| *Технологи*<br><br>*Technology*<br><br>*Технология* | DwknolokwA | Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаа бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц. | A suite of methods for implementing interrelated people, techniques, information, and organizational arrangements aimed at transforming intellectual creation into consumer goods. Source: Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 2006. |
| *Технологиор дэмжигдсэн сургалт*<br><br>*Technology-enhanced learning*<br><br>*Технологически усовершенствов-анное обучение* | DwknolokwA bf* Demjikdeksea Sorgelda | Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг ашиглах сургалтын үйл ажиллагаа. Үүнд: вебд, компьютерт суурилсан сургалт, виртуал сургалтын орчин, дижитал хамтын ажиллагаа зэрэг сургалтын өргөн хүрээний боломжууд | The use of information and communication technologies as mediating devices supporting student learning that can include elements of assessment, tutoring, and instruction. It involves a wide set of applications and processes, such as web-based learning, computer-based learning, virtual |

багтдаг. Төрөл бүрийн цахим мэдээллийн хэрэгсэл (интернэт, интранет /экстранет, аудио болон видео бичлэг, хиймэл дагуулын дамжуулалт, интерактив телевиз гэх мэт) ашиглан контент дамжуулах, шинэ санаа, мэдээлэл олж авах боломжтой. Веб блог, викис зэрэг медиа хэрэгсэл болон програм хангамжууд нь харилцах, мэдээлэл олж авах, контент бүтээх, цахимаар хамтран ажиллах боломжуудыг олгодог. Сургалтын хөтөлбөрт технологийг зохистой хэрэглэснээр шинэлэг заах арга барилыг хөгжүүлэх, суралцах үйл ажиллагааг баяжуулах, сонирхолтой болгоход дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн цахим сургалт, Е-сургалт, дижитал сургалт ч гэж нэрлэдэг.

classrooms and learning environments, and digital collaboration. It includes the delivery of content through a wide range of electronic media (e.g. internet, intranet/ extranet, audio- and videotape, satellite broadcast, interactive television, etc.) and access to resources that inform learners of new ideas, which they can then reflect upon and integrate into their existing knowledge. Social media and social software applications such as web logs (blogs) and wikis offer new opportunities for communicating, accessing knowledge, creating content and collaborating online. The appropriate use of technologies, when embedded into curriculum design, is expected to support the development of innovative teaching practices and to enhance and enrich learning experiences. Also referred to as ‘e-learning’ (or electronic learning) and ‘digital learning’. (UNESCO, 2013)

| | | | |
|---|---|---|---|
| *Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)*<br><br>*Education for sustainable development (ESD)*<br><br>*Образование для устойчивого развития (ОУР)* | DoeedeBrideI KiIhjiã oa BIbísoreã :Do, Ki, B'' | Дэлхийн өнөөгийн болон ирээдүйн тулгамдсан асуудлуудыг шийдэхэд сайн нөлөө үзүүлэхүйц бүтээлч байдлаар хандах, илүү тогтвортой, дасан зохицох чадамжтай нийгмийг бий болгоход чиглэсэн чадварыг суралцагчдад эзэмшүүлэх боловсролын нэг төрөл. | A type of education that aims to enable learners to constructively and creatively address present and future global challenges and create more sustainable and resilient societies. (UNESCO G. E., 2019) |
| *Тогтолцоо*<br><br>*System*<br><br>*Система* | DoeedeIce)T | Нэгдмэл бүхлийг бүрдүүлж байгаа, өөр хоорондоо харилцан үйлчилдэг хамааралтай хэсгүүдийн нэгдэл. Ихэнх тогтолцооны нийтлэг шинж чанар: Бүтэц хэсгүүд, тэдгээрийн бүрэлдэхүүнээр тодорхойлогдох; ажиллагаа - материал, энерги, мэдээллийн орцоос эхлээд тэдгээрийг боловсруулах эцсийн бүтээгдэхүүн болгох, хүртэл үе шатууд; харилцан холбоо – тогтолцоог бүрдүүлж байгаа хэсгүүд нь өөр хоорондоо чиг үүргийн болон бүтцийн холбоотой байдаг. | System is a set of interacting or interdependent entities forming an integrated whole. Most systems share common characteristics, including: Structure, defined by parts and their composition; Functioning, which involves inputs, processing and outputs of material, energy or information; Interconnectivity: the various parts of a system have functional as well as structural relationships between each other. (Davaadulam, 2010) |

Т

| | | | |
|---|---|---|---|
| *Төгс байдал*<br><br>*Excellence*<br><br>*Совершенство* | DeK_ biiide& | Тогтоосон стандартаас давж, онцгой сайн шинж, чанарыг илэрхийлсэн байдал. | Excellence means exhibiting characteristics that are unusually good and surpasses ordinary standards. (INQAAHE, 2017) |
| *Төгсөгч*<br><br>*Graduate*<br><br>*Выпускник* | DeKsokcI | Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг дүүргэсэн суралцагч (төгсөгч). | A student who has completed a course of study at HEI. (Glossary of terms in HE, 2016) |
| *Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)*<br><br>*Public –private partnerships (PPPs)*<br><br>*Государственно-частное партнёрство* | DoirO, HobA iia kibsi& oa Doieksile& :Doi,Ho,Ki,Doi" | ТХХТ нь засгийн газар болон хувийн хэвшлийн нэг буюу түүнээс дээш компанийн хооронд байгуулсан түншлэлийн үндсэн дээр санхүүжиж үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын үйлчилгээний байгууллага, хувийн бизнесийн хамтарсан байгууллага юм. Энэ хэлбэрийг олон улсад PPP, 3P, эсвэл P3 хэмээн товчлон нэрлэдэг. ТХХТ нь улсын хэвшлийн эрх бүхий байгууллага, хувийн хэвшлээс оролцогч талын хооронд байгуулсан гэрээн дээр үндэслэдэг бөгөөд гэрээнд оролцогч хувийн тал төрийн үйлчилгээг хүргэх, төсөл хэрэгжүүлэх талаар санхүү, техникийн ихээхэн хариуцлага ажиллагааны эрсдэлийг хүлээдэг. | Public-private partnership (PPP) describes a government service or private business venture which is funded and operated through a partnership of government and one or more private sector companies. These schemes are sometimes referred to as PPP, P3 or P3. PPP involves a contract between a public sector authority and a private party, in which the private party provides a public service or project and assumes substantial financial, technical and operational risk in the project. In some types of PPP, the cost of using the service is borne exclusively by the users of the service and not by the taxpayer. |

Зарим ТХХТ-д үйлчилгээний зардлыг татвар төлөгчид бус, харин тухайн үйлчилгээг хэрэглэгчид хариуцдаг. Зарим тохиолдолд хувийн салбар хөрөнгө оруулалт хийж засгийн газар үйлчилгээ хүргэх, бүрэн ба бүрэн бус санхүүжилт хийх үүргийг хүлээдэг. ТХХТ-д засгийн газраас оруулах хувь нэмэр нь биет хэлбэртэй (объектыг шилжүүлэн өгөх зэрэг) байж болно. Нийтийн бараа бий болгоход чиглэсэн төслүүд, тухайлбал дэд бүтцийн салбарын төслүүдэд хувийн хэвшлийг татах зорилгоор засгийн газар нэг удаагийн тэтгэлгийн хэлбэрээр хөрөнгө оруулалтын татаас олгож болдог. Бусад тохиолдолд засгийн газар тодорхой хугацаагаар татвараас чөлөөлөх, баталгаатай орлогын жилийн хэмжээг тогтоох зэргээр орлогын татаас олгох замаар төслийг дэмждэг.

In other types (notably the private finance initiative), capital investment is made by the private sector on the strength of a contract with government to provide agreed services and the cost of providing the service is borne wholly or in part by the government. Government contributions to a PPP may also be in kind (notably the transfer of existing assets). In projects that are aimed at creating public goods like in the infrastructure sector, the government may provide a capital subsidy in the form of a one-time grant, so as to make it more attractive to the private investors. In some other cases, the government may support the project by providing revenue subsidies, including tax breaks or by providing guaranteed annual revenues for a fixed period. (Davaadulam, 2010)

| | | | |
|---|---|---|---|
| *Төрийн албаны зөвлөл*<br><br>*Civil service commission*<br><br>*Комиссия по делам государственной службы* | DoirO iia felbia O Joib,æ | Төрийн албаны зөвлөлийн эрхлэх ажил нь өрсөлдөөнт шалгалт зохион байгуулах, ил тод, бодитой зарчмын дагуу хүмүүсийг сонгон шалгаруулах болно. Төрийн албаны төв комисс нь албан тушаал дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилох явцад мерит зарчмыг мөрдүүлэх; удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах, томилоход засгийн газарт туслах; сахилгын дүрэм журмын хэрэгжилтийг зохицуулах; ажиллагчдаас ирүүлсэн гомдлыг шийдвэрлэх; төрийн албан хаагчдын буруутай үйлдэлд томоохон шийтгэл ногдуулах шийдвэр гаргахын өмнө зөвлөх үүрэгтэй байдаг. | The mandate of a civil service commission includes administering competitive examinations and selecting the successful candidates according to transparent and objective criteria. The central PSC also enforces the merit principle in promotions and senior appointments; assists the government in recruiting and managing a senior executive service; regulates disciplinary procedure; hears appeals from employees; and is consulted before major penalties for misconduct are assessed. (Davaadulam, 2010) |
| *Төрийн бус өмчийн сургалтын байгууллага*<br><br>*Private institutions*<br><br>*Негосударственное образовательное учреждение /Частное* | Sorgelda iia biigolo) T DoirO iia BsO foimcl iia | Төрийн байгууллага үйл ажиллагаар нь хөтөлдөггүй ч хяналт, зохион байгуулалт, удирдлагаар хангадаг ашгийн эсвэл ашгийн бус сургалтын байгууллага. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, шашны байгууллага, тусгай сонирхлын бүлэг, сан эсвэл бизнесийн | Institutions that are not operated by public authorities but are controlled and managed, whether for profit or not, by private bodies such as education institutions, religious bodies, special interest groups, foundations or business enterprises. |

Т

| | | | |
|---|---|---|---|
| | | байгууллага гэх мэт хэлбэртэй байдаг. Энэ төрлийн байгууллага ихэвчлэн сургалтын төлбөр, хандив болон бусад эх үүсвэрээс санхүүждэг. | It is funded primarily through tuition, donations, and sources other than public funds. (UNESCO G. E., 2019). |
| *Төрийн өмчийн сургалтын байгууллагын санхүүжилт*<br><br>*Financing of state owned education institutions*<br><br>*Финансирование государственного образовательного учреждения* | bïigolol)T iia SeelKjilda DoirO iia foimcl iia Sorgelda iia | Их сургууль, дээд сургууль, коллеж, политехник коллежид олгогдож буй улсын төсөв, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлого. | The state budget, tuition fee, research project and operation income of universities, institutes, colleges, and polytechnic colleges. (The Law of Mongolia on Education, 2002) |
| *Төсөлд суурилсан сургалт*<br><br>*Project-based learning*<br><br>*Проектное обучение* | Doisol dO Segorileesea Sorgelda | Тодорхой төсөл, сэдэв, үзэл баримтлалд чиглэсэн бодит асуудлуудыг судлахад суралцагчдын оролцоог дэмжих үйл явц. Төсөлт ажлууд бодит асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг учраас “асуудалд суурилсан” гэж бас нэрлэдэг. Төслийн санааг багш санал болгох боломжтой ч үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх ажлыг суралцагчид ганцаараа болон багаар олон хоног, хэдэн долоо хоног, | A process that fosters learners’ engagement in studying authentic problems or issues centred on a particular project, theme, or idea. Often the term ‘project-based’ is used interchangeably with ‘problem-based’, especially when classroom projects focus on solving authentic problems. The nexus for the project may be suggested by a teacher, but the planning and execution of contingent activities are predominantly conducted by learners working |

| | | | |
|---|---|---|---|
| | | сараар ч хэрэгжүүлэх боломжтой. Энэ нь асуудалд суурилсан, үр дүнд чиглэсэн, бодит ертөнцийг танин мэдэх, асуудал шийдвэрлэх зорилго бүхий сургалтын хэлбэр юм. | individually and cooperatively over many days, weeks, or even months. This process is inquiry-based, outcome-oriented, and associated with conducting the curriculum in real-world contexts. (UNESCO, 2013) |
| *Тулгамдаж буй асуудал*<br><br>*Emerging issues*<br><br>*Возникающие проблемы / Актуальные проблемы* | Dolgemdej0 Bl fesegode& | Суралцагчийн танин мэдэхүйд чухал ач холбогдолтой, судлахаар тусгагдсан сургалтын агуулга. Тулгамдаж буй асуудлууд (жишээлбэл, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, дэлхийн энх тайвны боловсрол, тогтвортой хөгжил гэх зэрэг)-тай холбоотой мэдлэг, ур чадвар, хандлагыг сургалт, хичээлийн агуулгад тусгах, нэвтрүүлэх замаар “бодит амьдрал”-ын асуудлуудыг шийдвэрлэхэд суралцагчдыг татан оролцуулах боломжтой. | New or important learning content that is considered relevant for learners. As the curriculum needs to respond to emerging issues as they arise (for example, HIV and AIDS prevention, peace education, sustainable development, etc.), one approach that can be adopted is to integrate or mainstream knowledge, skills and attitudes into the existing learning areas or subjects, thereby engaging learners in the process of solving ‘real-life’ problems. (UNESCO, 2013) |
| *Туршилт, боловсруулалтын ажил*<br><br>*Experimental Development*<br><br>*Экспериментальная разработка* | Dorsilda, Blbsoregololda iia feji& | Шинэ бараа, материал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн шинэ үйл явц, тогтолцоо, үйлчилгээг нэвтрүүлэх, эдгээрийг сайжруулахад чиглэсэн системтэй судалгаа, туршилтын ажил. | It is systematic work, drawing on knowledge gained from research and practical experience, that is directed to producing new materials, products and devices; to installing new processes, systems and services; or to |

Т

| | | | |
|---|---|---|---|
| | | | improving substantially those already produced or installed. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |
| *Тусгай зөвшөөрөл*<br><br>*Licensing*<br><br>*Лицензия* | Doseeel Joibsiyere& | Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ бүхий ашигтай загварыг бусад этгээдэд ашиглуулах болзолтойгоор өгч байгаа зөвшөөрөл. (Патентын тухай хууль, 2006). Төрийн захиргааны байгууллагаас олгож буй албан ёсны зөвшөөрөл. Энэхүү зөвшөөрлийг дараах байдлаар олгоно. Үүнд: тусгай нэр ашиглах, эсвэл тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхийн тулд урьдчилан тогтоосон мэргэшлийн шалгуурыг хангасан хувь хүнд, магадлан итгэмжлэлийн статус авахаас өмнө, холбогдох төлөвлөгөөнд хийгдсэн үнэлгээнд үндэслэн сургалтын хөтөлбөрт, тухайлсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагад олгоно. | License is a permission granted by one party to another party with an agreement to use the patents, industrial designs or certified utility models. (The Law of Mongolia on Patent, 2006)The process by which a governmental agency grants official permission (I) to persons meeting pre-determined qualifications to engage in a given occupation and/or use of a particular title; (II) to programs, based on the evaluation of appropriate plans, to operate before obtaining accredited status, and (III) to institutions to perform specified functions. (UNESCO-CEPES, 2007) |

Т

| | | | |
|---|---|---|---|
| *Тусгай магадлан итгэмжлэл*<br><br>*Specialized accreditation*<br><br>*Специализированная аккредитация* | Doseeel Megeoelea fidekEmjiile& | Тусгай эсвэл хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллагаас сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулгад нарийвчилсан шалгуур үзүүлэлтийн дагуу хийж буй магадлан итгэмжлэл. | The accreditation of individual units or programs (e.g. professional education), by “specialized” or “program” accrediting bodies applying specific standards for curriculum and course content. (UNESCO-CEPES, 2007) |
| *Тусгай сургалтын хөтөлбөр*<br><br>*Functional curriculum*<br><br>*Функциональная программа* | KidolBrl<br>Doseeel Sorgelda iia | Оюуны бэрхшээлтэй, тусгай хэрэгцээтэй хүмүүст бие даан амьдрах, хөдөлмөрлөхөд зайлшгүй шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр. | A curriculum designed to teach skills deemed essential for living and working independently to learners with cognitive impairments. (UNESCO, 2013) |
| *Тусгай хэрэгцээт боловсрол*<br><br>*Special needs education*<br><br>*Специальное образование* | Doseeel kErekCekEdO BlbEsore& | Боловсролын хөтөлбөрт хамрагдан суралцахад нэмэлт дэмжлэг, туслалцаа, сурган хүмүүжүүлэх тусгай арга зүй шаардлагатай хүмүүст зориулсан боловсролын нэг төрөл. Тусгай хэрэгцээт боловсролын сургуульд ердийн сургуульд хэрэглэдэг сургалтын хөтөлбөрийг ашиглаж болох хэдий ч сургалтын нөөц, хэрэглэгдэхүүн (тусгайлан бэлтгэгдсэн боловсон хүчин, тоног төхөөрөмж, зай талбай)-ээр хангах болон | Education designed to facilitate learning by individuals who require additional support and adaptive pedagogical methods in order to participate and meet learning objectives in an education programme. Education programmes in special needs education may follow a similar curriculum as that offered in the parallel regular education system, but they take individual needs into account by providing specific resources (e.g. specially trained |

| | | | |
|---|---|---|---|
| | | шаардлагатай бол сургалтын зорилго, агуулгыг хувь хүний хэрэгцээ, онцлогт тохируулан өөрчилдөг. Энэхүү сургалтын хөтөлбөрийг ердийн сургууль дээрх тусгай ангид эсвэл тусгай сургуулиар судлах боломжтой. | personnel, equipment or space) and, if appropriate, modified educational content or learning objectives. These programmes can be offered to individual students within already-existing education programmes or as a separate class in the same or separate educational institutions. (UNESCO, 2013) |
| *Тусгай хэрэгцээт интеграци сургалт*<br><br>*Mainstreaming (in special needs education)*<br><br>*Мэйнстриминг (в специальном образовании)* | Doseeel kirekcekidO finDwkre]l Sorgelda | Тусгай хэрэгцээт суралцагчийг зохих сургалтын хөтөлбөрийн дагуу дэд бүтцийн зохицуулалт, болон тусгай бэлтгэгдсэн боловсон хүчнээр хангагдсан ерөнхий боловсролын сургуульд энгийн хүүхдүүдтэй хамт суралцуулах үйл ажиллагаа. | The integration of learners with special needs into general educational settings or regular schools, ideally facilitated by appropriate curriculum and infrastructure adjustments and by the provision of specially trained staff. (UNESCO, 2013) |
| *Туслах ажилтан*<br><br>*Academic assistant*<br><br>*Учебный ассистент* | DoseleeeO fejilldea | Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй ажилтан (сургалтын туслах ажилтан г.м.). | Workers staffed for assisting the implementation of academic programs (e.g. teaching assistants). (NIAD-QE, 2016) |

T

| | | | |
|---|---|---|---|
| *Туслах багшийн тогтолцоо*<br><br>*Teaching assistant system*<br><br>*Система ассистент-преподавателя* | Doseleee0 bɩeesl iia Doeedelce)T | Дээд боловсролын сургалтын байгууллага шилдэг төгсөгч, суралцагч нартаа заах арга зүйгээ сайжруулах боломжийг олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлэн түр хугацаагаар ажиллуулах тогтолцоо. Туслах багш нь бакалаврын оюутнуудад зөвлөхөөр ажиллаж, сургалт, туршилтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. | A system under which universities employ excellent graduate students on a temporary contract to provide them with opportunities to develop their teaching skills, and financial support. Teaching assistants serve as advisors to undergraduate students and assist experiments. (NIAD-QE, 2016) |
| *Түвшний тодорхойлогч*<br><br>*Level descriptor*<br><br>*Дескриптор уровня* | Doibsia 0 Dodoreeeiilleeec l | Түвшний тодорхойлогч нь суралцахуйн түвшний агуулга, онцлогийг заасан, хүрвэл зохих үр дүнгийн гүйцэтгэлтэй холбоотой суралцахуйн үзүүлэлтийг заасан мэдээлэл, тодорхойлолт. Энэ нь тухайлсан хичээлийн модулийг боловсруулах, сургалтын түвшин бүрд зохих багц цагийг тооцох зорилгоор тодорхойлсон суралцахуйн хүрэх үр дүн, үнэлгээний шалгуурыг боловсруулах, хянахад дэмжлэг болох зорилготой. | Level descriptors are statements that provide a broad indication of learning relevant to the achievement of a particular level, describing the characteristics and context of learning expected at that level. They are designed to support the review of specified learning outcomes and assessment criteria in order to develop particular modules and units and to assign credits at the appropriate level. (UNESCO-CEPES, 2007) |

| | | | |
|---|---|---|---|
| *Түүхэн судалгаа*<br><br>*Historical research*<br><br>*Историческое исследование* | Deok:a Sodol)T | Өнөөгийн үйл явдлыг тайлбарлах, ирээдүйн үйл явдлыг урьдчилан таамаглахад тус болох үйл явдлуудын шалтгаан, үр нөлөө, хандлагуудыг тодорхойлохын тулд өнгөрсөн хэрэг явдлуудтай холбоотой өгөгдлүүдийг системтэйгээр цуглуулж, үнэлгээ хийх. | The systematic collection and objective evaluation of data related to past occurrences to determine causes, effects, or trends of those events that may help explain present events and anticipate future events. (Noori, 2018) |
| *Тэгш байдал*<br><br>*Equality*<br><br>*Равенство* | DeksI bi:ide& | Тэгш ба тэгш бус байдал нь үндсэндээ улс төрийн үзэл баримтлал бөгөөд тэрээр улсын салбарт тодорхой утгаар хэрэглэгдэж ирэв. Сүүлийн жилүүдэд тэгш байдлыг орлого дахин хуваарилалтын утгаар нь ойлгохоос илүү ‘нийгмээс гадуурхахгүй байх’ гэсэн соёлын агуулгаар нь тайлбарлах, албан ёсны тодорхойлолтоос ‘нийгмийн ялгаатай байдлыг’ хүлээн зөвшөөрөх гэсэн санаагаар хэрэглэх нь илүү болсон байна. Тэгш байдлын тухай хууль, бодлого нь нийгмийн давхарга, жендер, арьс өнгө, хөгжлийн бэрхшээл, хүйсийн баримжааны улмаас бий болж тогтсон нийгмийн хуваагдал, | Concepts of equality and inequality are fundamentally political concepts that have become institutionalized in the public sector in particular ways. In recent years, the language has tended to shift away from redistributive meanings of equality and towards the more cultural interpretations implied in the idea of social exclusion; and from the formalised concept of equality to more fluid notions of social diversity. Equality legislation and equality policies are the product of struggles by particular groups to overcome patterns of structural inequality–around social divisions such as class, gender, race, |

| | | | |
|---|---|---|---|
| | | тэгш бус байдлыг арилгах гэсэн тодорхой бүлгүүдийн тэмцлийн үр дүнд бий болдог. Сүүлийн жилүүдэд нийгмийн төрөл бүрийн бүлгүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тэдний хэрэгцээнд чиглэсэн бодлого явуулах, нийгмийн шударга ёсыг тогтоох тухай үзэл баримтлалыг тууштай баримтлах хандлага нэмэгдэж байна. | disability and sexuality. In recent years, there has been an increasing emphasis on diversity – that is, a recognition of the need to respond to difference and to pursue a more active and dynamic concept of social justice. (Davaadulam, 2010) |
| *Тэгш боломж*<br><br>*Equal opportunity*<br><br>*Равенство прав / равные возможности* | Deksl Blomjl | Тэгш боломжийн гол зарчим нь үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлан гадуурхахыг хориглох, хүйсийн тэгш байдлыг эрхэмлэх гэсэн хоёр үндсэн элементийг агуулдаг. Энэ нь бүх салбарт, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёл болон гэр бүлийн амьдралын хүрээнд үйлчлэх ёстой. Тэгш боломж гэдэг нь оюутан, суралцагч бүрд боловсрол, сургалтад хамрагдах ижил боломж олгохыг хэлнэ. | The general principle of equal opportunities contains who key elements: one is the ban on discrimination on grounds of nationality or race, and the other is equality for men and women (gender equality). It is intended to apply to all fields, particularly economic, social, cultural and family life. Equal opportunities apply when every student or trainee with the necessary skills, experience and qualifications to undertake education or training is given an equal chance of doing so. (VETP-1, 2018) |

*Тэгш хамран сургах боловсрол (ялгаатай хэрэгцээнд суурилсан боловсрол)*

*Inclusive education*

*Инклюзивное образование*

Deksl Hemoroa Sorgeeo Blbisore& :filgegedel kirekcekia dO Segorileesea Blbisore&"

Хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хүүхэд бүрд ижил тэгш боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн боловсролын нэг төрөл. Тэгш хамруулах сургуулиуд нь суралцагч төвтэй заах арга зүйн хүрээнд эмзэг болон хөгжлийн бэрхшээлтэй гэх мэтээр ялгаварлан гадуурхалгүй хүүхэд бүрд чанартай боловсрол олгож найрсаг орчин, тэгш хүртээмжтэй нийгмийг цогцлоохыг зорьдог. ЮНЕСКО-гоос тэгш хүртээмжтэй боловсролыг тодорхойлохдоо хүн бүрд хүрэх боловсролын тогтолцооны чадавхыг бэхжүүлэх үйл явц гэж тодорхойлсон бөгөөд улмаар Бүх нийтийн боловсролыг хэрэгжүүлэх үндсэн стратеги гэж үзсэн.

A process of addressing and responding to the diversity of needs of all learners through increasing participation in learning, cultures and communities, and reducing exclusion from education and from within education. Inclusive schools are based upon a child-centred pedagogy capable of successfully educating all children, including those who have serious disadvantages and disabilities. The merit of such schools is not only that they are capable of providing quality education to all children; their establishment is a crucial step in helping to change discriminatory attitudes, in creating welcoming communities and in developing an inclusive society. UNESCO defines inclusive education as a process of strengthening the capacity of the education system to reach out to all learners and can thus be understood as a key strategy to achieve Education for All. (UNESCO, 2013)

Т

| | | | |
|---|---|---|---|
| *Тэгш хамран сургах сургалтын хөтөлбөр (ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр)*<br><br>*Inclusive curriculum*<br><br>*Инклюзивная программа* | :filgegedel kirekcekia dO Segorileeesea Sorgelda iia KidolBrl" DeksI Hemoroa SorgeeeO Sorgelda iia KidolBrl | Суралцагч бүрийн хувийн онцлог, хуримтлуулсан туршлага, хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд нийцүүлсэн сургалтын хөтөлбөр. Тус хөтөлбөрт оролцогч бүр сургалтын үйл ажиллагааны нэг хэсэг болохын зэрэгцээ өөр хоорондоо ялгарах байдлаас үл хамааран ижил тэгш боломж, үйлчилгээгээр хангагдана. | Curriculum which takes into consideration and caters for the diverse needs, previous experiences, interests and personal characteristics of all learners. It attempts to ensure that all students are part of the shared learning experiences of the classroom and that equal opportunities are provided regardless of learner differences. (UNESCO, 2013) |
| *Тэнхим*<br><br>*Department*<br><br>*Кафедра* | DeehKu^ | Сургалт, судалгааны чиг үүрэг бүхий бүтцийн үндсэн (бүрэлдэхүүн сургууль, факультетын доод шатны) нэгж. | A basic organizational unit for education and research, below the level of a faculty. (NIAD-QE, 2016) |
| *Тэргүүн туршлага*<br><br>*Best practice*<br><br>*Выдающийся опыт* | DeriKa Dorsil)T | “Шилдэг” болохыг нь ижил төстэй бусад байгууллага хүлээн зөвшөөрсөн дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа эсвэл хөтөлбөрийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн үр дүнд бий болсон, хэрэгжүүлж болохуйц бүтээлч үйл явц буюу туршлага. | A method or an innovative process involving a range of safe and reasonable practices resulting in the improved performance of a higher education institution or program, usually recognized as “best” by other peer organizations. (UNESCO-CEPES, 2007) |

T

| | | | |
|---|---|---|---|
| *Тэтгэлэг*<br>*Scholarship*<br>*Стипендия* | DeoeKIkit | Бакалаврын түвшний суралцагчдад сургалтын төлбөр болон бусад төлбөрөөс чөлөөлөх хэлбэрээр олгогддог санхүүгийн дэмжлэг, сургалтын тэтгэмж. | A study grant of financial assistance, usually given at the undergraduate level that may be supplied in the form of a waiver of tuition and/or fees. (Glossary of terms in HE, 2016) |
| | | **У** | |
| *Удирдлагын аудит*<br>*Management audit*<br>*Аудит управления* | feoidiDA fodoridol)T iia | Тухайн байгууллагын ерөнхий удирдлага, бодлого, шийдвэр гаргах үйл явцад хийх хяналт. | A management audit reviews the general management, policy, and policy-making of a given institution. (UNESCO-CEPES, 2007) |
| *Ур чадвар*<br>*Skills*<br>*Навыки, умения* | fo*T CideBrI | Эзэмшсэн мэдлэг, боловсрол, туршлагаа ашиглан даалгаврыг гүйцэтгэх, асуудлыг шийдвэрлэх чадвар, чадамж, авьяас. Илүү өргөн утгаар боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийгмийн харилцаанд оролцоход хувь хүнийг амжилтад хүргэх зан төлөв, хандлагыг илэрхийлнэ. Түүнчлэн хувь хүн болон нийгэмд аль алинд нь эдийн засгийн болон нийгмийн үр өгөөж үзүүлэхүйц төрмөл бус чадавх ч гэж тодорхойлдог. | The ability to perform tasks and solve problems. It is the ability, proficiency or dexterity to carry out tasks that come from education, training, practice or experience. It is applied more broadly to include behaviours, attitudes and personal attributes that make individuals more effective in particular contexts such as education and training, employment and social engagement. Non-innate capabilities that can be learned and transmitted, and have economic or social benefits to both individuals and their societies. (UNESCO, 2013, 2019) |

У

| | | | |
|---|---|---|---|
| *Ур чадварын хөрвөлт*<br><br>*Skills transfer*<br><br>*Передача навыков* | fo*T CideBrl iia Kirb:lda | Чадвар, дадал, чадамжуудыг нэг ажил мэргэшлээс нөгөөд шилжүүлэн ашиглах боломж. Хөрвөх ур чадварт асуудлыг шийдвэрлэх чадвар, шинэ санаа мэдээллийг үүр өгөөжтэй солилцох, бүтээлч, манлайлагч, шударга үнэнч байдал, аж ахуй эрхлэх чадварыг оруулна. Эдгээр ур чадварын тусламжтайгаар хувь хүн илүү үр дүнтэй ажил хөдөлмөр эрхлэх боломж, янз бүрийн ажлын орчинд дасан зохицох чадвараа дээшлүүлдэг. | The transfer of skills or competencies from one work context to another. Transferable skills include the ability to solve problems, communicate ideas and information effectively, be creative, show leadership and conscientiousness, and demonstrate entrepreneurial capabilities. People need these skills to be able to adapt to different work envirenments and so improve their chances of staying in gainful employment. (VETP-1, 2018) |
| *Ур чадварын шинжилгээ*<br><br>*Skills analysis*<br><br>*Анализ навыков* | fo*T CideBrl iia Siejilek:t | Аливаа ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах бүх төрлийн чадвар, дадал, чадамжийг тодорхойлох үйл явц. Тодорхой нэг ажлын үүрэг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшлийн түвшин, стандарт бус хөдөлмөрийн агуулга, хариуцлага, бие даасан байдал зэргийг мэргэшлийн түвшнээр ялган, ангилж байгаа хэмжүүр шалгуурыг судална. Мөн ур чадварын хэрэгцээ, шаардлага, | Process to identify different type of skills and practice. Study criteria that classifies the independency, responsibility, non-standard labour content, complexity level, skills, knowledge necessary to preform specific tasks by the qualifications level. Related to this it’s necessary to study the market needs, supplies and environment needed to improve skills, deficiency, trend, need and demand of skills. |

| | | | |
|---|---|---|---|
| | | ирээдүйн чиг хандлага, хомсдол, ур чадвар дээшлүүлэхэд дутагдаж буй орчин нөхцөл, хангамж, нөөц, зах зээлийн эрэлт хэрэгцээг үүнтэй холбоотойгоор судлах шаардлага гарна. | An identification of the skills or competencies needed for each job. (VETP-1, 2018) |
| *Урьдчилсан магадлан итгэмжлэл*<br><br>*Initial accreditation*<br><br>*Предварительная аккредитация* | fidekimjile& forioecileeesea Megeoelea | Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахын өмнө шинээр нээх сургалтын хөтөлбөрт урьдчилсан дүгнэлт гаргах. | Initial accreditation involves undertaking an evaluation of the conditions for the launch of a program or institution. |
| *Урьдчилсан үнэлгээ*<br><br>*Predictive assessment*<br><br>*Прогнозная оценка* | forioecileeesea foimelekit | Суралцагчийн сурлагын ахиц, амжилтыг нэмэгдүүлэх, суралцах үед гарч болох алдаа, дутагдлыг урьдчилан тогтоож, зохих арга хэмжээнүүдийг санал болгох зорилготой үнэлгээний хэлбэр. | Assessment aimed at identifying potential successes and failures in learners' development and suggesting appropriate action to stimulate progress and deal with anticipated shortcomings. (UNESCO, 2013) |
| *Утга учиртай суралцахуй*<br><br>*Meaningful learning*<br><br>*Значимое обучение* | fooe(T focirdel Sorolceeol | Янз бүрийн нөхцөл байдалд бүтээлчээр асуудлыг шийдэхэд хэрэглэгдэх үзэл санааг хөгжүүлэхэд чиглэдгээрээ зөнгөөрөө сурах сургалтаас ялгаатай. Суралцагчид хамаатай, бодит амьдралд чиглэсэн сургалтыг утга учиртай | Unlike rote learning, it is a process leading to the development of conceptual networks (i.e. concept mapping) that can be applied in different situations, supporting creativity and problem solving. According to constructivist views, it also refers to learning that |

У

| | | | |
|---|---|---|---|
| | | гэж үзнэ. “Ерөнхий санааны зураглал”-ыг үзнэ үү. | makes sense to students as it is connected to their personal experience and is practically oriented. Related term: “Concept map”. (UNESCO, 2013) |
| *Уян хатан сургалт*<br><br>*Flexible learning*<br><br>*Гибкий график учебной деятельности* | foyea Hedea Sorgelda | С у р а л ц а г ч и й н хэзээ, хаана, хэрхэн (хурд, орчин, арга зүй) суралцахтай х о л б о о т о й г о о р сургалтын төрөл бүрийн хэлбэр, аргуудыг суралцагчдад сонгох боломж олгодог сургалтын үйл ажиллагаа. Үүнд онлайнаар, ажлын байраа түшиглэсэн, зайны, ганцаарчилсан, хурдавчилсан зэрэг олон төрлийн сургалт хамаардаг. | Opportunities that provide more choices to the learners in terms of training types and means and when, where and how they learn. Flelxible learning may include use of online learning, work place-based learning, part-time learning, distance learning, and many forms of face-to-face and learning with options to fast track and defer cources. (VETP-1, 2018) |

| Y | | | |
|---|---|---|---|
| *Үе тэнгийнхний багшлах үйл ажиллагаа*<br><br>*Peer teaching / tutoring*<br><br>*Преподавание сверстников* | foiila fejille) T<br>foiiT Deeit oa kia O bieesileeeO | Сургуулийн орчинд суралцагчид багшийн үүргийг орлон гүйцэтгэж, үе тэнгийнхэнтэйгээ мэдлэгээ хуваалцаж, суралцахад нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа. | A practice in which students share their knowledge and support the learning of their peers through assuming a teaching role within a school setting. (UNESCO, 2013) |
| *Үе тэнгийнхний үнэлгээ*<br><br>*Peer assessment*<br><br>*Оценка сверстников* | foinelekit<br>foiiT Deeit oa kia O | Суралцагчийн сурах үйл явцыг бусад суралцагчдаар үнэлүүлэх арга барил. | Assessment of learners' work by other learners. (UNESCO, 2013) |
| *Үе тэнгийнхнээс суралцах*<br><br>*Peer learning*<br><br>*Обучение сверстников* | SorolceeO<br>foiiT Deeit oa kia fca | Суралцагчид хоорондоо мэдлэг, мэдээллээ солилцоход суурилсан сургалтын үйл ажиллагаа, арга барил. Суралцагчдын нэг нь ментор буюу дэмжин чиглүүлэгчийн үүрэгтэй байж болно. | A process based on exchange of knowledge and information between learners who may also act as mentors. (UNESCO, 2013) |
| *Үзүүлэлт*<br><br>*Indicators*<br><br>*Индикаторы* | foijeKlolda | Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн стандарт, шаардлагыг хангаан биелүүлж буй эсэхийг тодорхойлох боломж олгож буй нотолгоо, хөтөлбөрийн үйл ажиллагааны туршлага, | Operational variables referring to specific empirically measurable characteristics of higher education institutions or programs on which evidence can be collected that allows for a determination of |

нөхцөл байдлын хэмжигдэхүйц шинж чанаруудыг илэрхийлэх хувьсах хэмжигдэхүүн. Үзүүлэлт нь гүйцэтгэлийн чиг хандлага болон зохих арга хэмжээ авах шаардлагатай үйл ажиллагааны доголдолтой талыг тодорхойлж бодит гүйцэтгэлийг тавьсан зорилтуудтай харьцуулах боломжийг олгодог. Үзүүлэлтийг эдийн засгийн, бүтээмжийн, үр өгөөжийн хэмээн ангилж болно. Мөн үзүүлэлтийг дараах байдлаар ялгаж болно. Үүнд: (I) context indicator –орчны үзүүлэлт (дээд боловсролын байгууллагын, хөтөлбөрийн /нийгэм, эдийн засаг, улс төр, газарзүйн г.м./ тодорхой орчинд хамаарах); (II) input indicator – орцын үзүүлэлт (дээд боловсролын байгууллагад ашиглагдаж буй логистик, хүний нөөц болон санхүүгийн нөөцтэй хамааралтай); (III) process indicator – үйл явцын үзүүлэлт (дээд боловсролын байгууллагын нөөцийн ашиглалт, орцын

whether or not standards are being met. Indicators identify performance trends and signal areas in need of action and enable comparison of actual performance with established objectives. A distinction is made between the different types of indicators: indicators of economy; indicators of efficiency; and indicators of effectiveness. Another distinction is made between: (I) context indicators, that relate to the specific environment of a higher education institution or program (social, economic, political, geographical, etc.); (II) input indicators, that relate to the logistical, human, and financial resources used by a higher education institution; (III) process indicators, that refer to the use of resources by a higher education institution, to the management of the inputs, and to the functioning of the organization; and (IV) output indicators, that concern the actual achievements or products

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | удирдлага, байгууллагын үйл явцтай холбоотой үзүүлэлт); (IV) output indicators – гарцын үзүүлэлт (дээд боловсролын байгууллагын бодит амжилт, бүтээгдэхүүнийг илэрхийлсэн үзүүлэлт). Энэхүү ангиллыг CIPO–model (Context, Input, Process, Outputs) буюу (Орчин, Орц, Үйл явц, Гарц)-ын загвар гэж нэрлэдэг бөгөөд үнэлгээний судалгаанд өргөн хэрэглэгддэг. | of the higher education institution. This latter framework is also known as the CIPO-model (i.e. Context, Inputs, Process, Outputs), frequently used in evaluation studies. (UNESCO-CEPES, 2007) |
| *Үйлдвэрлэлийн дадлага*<br><br>*Internship*<br><br>*Производственная практика* | foiileoeBril& oa Dedol)T | Суралцаж буй мэргэжил эсвэл ирээдүйн ажил мэргэжлийн чиглэлийн хүрээнд нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах компанийн үйл ажиллагаанд оролцох эсвэл ажлын туршлага олж авах боломжоор оюутанд олгож буй тогтолцоо. Зарим дээд боловсролын сургалтын байгууллага хүлээн зөвшөөрөгдсөн дадлагын ажилд багц цаг тооцдог. | A system that enables students to undertake work experience or to participate in a company's contribution to social development in an area related to their major or future career. Some higher education institutions award credit for recognized internships. (NIAD-QE, 2016) |
| *Үйлчилгээний төлбөр*<br><br>*Fees*<br><br>*Денежный взнос* | DoiloBrI foiilecilekia O | Сургалтын төлбөрөөс гадна сургуулийн үйлчилгээний зардалд төлж буй мөнгөн дүн. | An amount charged by schools, in addition to tuition, to cover costs of institutional services. (Glossary of terms in HE, 2016) |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| *Ул алагчлах /шударга байх зарчим*<br><br>*Equity*<br><br>*Справедливость/ Равноправие* | foilO feleeecileeO < SidorgO bIiieeO Jerci^ | Бүх хүнд шударга, тэгш, алагчлалгүй хандах. | Just, fair and impartial treatment of all. (Davaadulam, 2010) |
| *Үндсэн (мэргэжлийн) хичээл*<br><br>*Major*<br><br>*Мажор / основная программа по специальности* | foiedosoa < MerkEjil& oa kUciyel& | Бакалаврын түвшинд суралцаж буй оюутны төвлөрөн суралцах хичээлүүд. Эдгээр нь суралцаж буй үндсэн мэргэжлийн салбарт хамаардаг. | The subject in which a student wishes to concentrate for an undergraduate degree. It may also refer to a student's principal field of study. (Glossary of terms in HE, 2016) |
| *Үндсэн /суурь хичээл*<br><br>*Core requirement*<br><br>*Основное требование* | foiedosoa < SegorI kUciyel& | Тухайн боловсролын зэргийг дүүргэхэд зайлшгүй судлах хичээл. | Compulsory courses required for completion of the degree. (Glossary of terms in HE, 2016) |
| *Үндсэн чадамж*<br><br>*Key competences/ competencies or skills*<br><br>*Ключевые компетенции* | foiedosoa Cidemj I | Орчин үеийн мэдлэгт суурилсан нийгэмд шаардагдах ур чадварын цогц. Европын парламент насан туршийн боловсрол (2006)-ын 8 үндсэн чадамжийг тодорхойлсон. Үүнд: төрөлх болон гадаад хэлээр харилцах; математик, байгалийн ухаан, технологийн | Key competences defined as the sum of skills (basic and new basic skills) needed to live in a contemporary knowledge society. The European Parliament set out eight key competences for lifelong learning (2006): communication in the mother tongue; communication in foreign |

Ү

чадамж; дижитал мэдлэг чадвар; сурахын тулд суралцах чадвар; хувь хүн хоорондын харилцаа, соёл хоорондын болоод нийгмийн харилцааны чадамж; аж ахуй эрхлэх чадамж, соёлын илэрхийлэл. Хэл, бичиг үсэг, тоо, мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) чадварууд нь суралцахуйн үндсэн суурь болдог бөгөөд сурахын төлөө суралцах чадамж нь сурч боловсрох бүх үйл ажиллагааны тулгуур болдог. Бүтээлч сэтгэлгээ, бүтээлч байдал, санаачилга, асуудал шийдэх, эрсдэлийг үнэлэх, шийдвэр гаргах, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдан залах нь нь бүх 8 чадамжид чухал үүрэг гүйцэтгэдэг. Сургалтын хөтөлбөр нь хувь хүний хөгжил, боловсрол, ажил эрхлэлт, мэдлэгт суурилсан нийгэмд байр суурь эзлэхэд чухал үүрэгтэй ур чадваруудыг эзэмшүүлэхэд чиглэгддэг. Эдгээр чадамжийг янз бүрийн нэр томьёогоор тодорхойлдог. Үүнд:

languages; competences in mathematics, science and technology; digital competence; learning to learn; interpersonal, intercultural and social competences, and civic competence; entrepreneurship; and cultural expression. Competence in the fundamental basic skills of language, literacy, numeracy and in information and communication technologies (ICT) is an essential foundation for learning, and learning to learn supports all learning activities. Critical thinking, creativity, initiative, problem solving, risk assessment, decision taking, and constructive management of feelings play a role in all eight key competences. Curriculum policies increasingly focus on competences that students are expected to develop during the whole process of learning across specific subjects or disciplines and that they need to succeed in education and for personal development, employment and inclusion

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | чадамжийг (гол, үндсэн, ерөнхий, хичээл хоорондын, хөрвөх чадамж), ур чадварыг (түлхүүр, суурь, үндсэн, нэн чухал, сэдэв хоорондын, хөтөлбөр хоорондын, 21-р зууны гэх мэт) ангилж үздэг. | in a knowledge society. A variety of terms are used to indicate these competences (key, core, general, generic, basic, cross-curricular or transversal competences) and skills (key, foundation, core, basic, essential, cross-thematic, cross-curricular or 21st century skills). (UNESCO, 2013) |
| *Үндэслэл*<br><br>*Rationale*<br><br>*Обоснование* | foiedosole& | Дээд боловсролын чанарын хүрээнд чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх зорилго, учир шалтгаан. | Rationale in the context of quality in higher education refers to the reasons or purposes for the establishment of quality assurance processes. (INQAAHE, 2017) |
| *Үнэлгээ*<br><br>*Assessment*<br><br>*Процесс оценки результатов обучения* | foinelekit | 1. Дээд боловсролын сургалтын байгууллагын (байгууллагын үнэлгээ), эсвэл сургалтын хөтөлбөрийн түвшинд (хөтөлбөрийн үнэлгээ) сургалтын үйл ажиллагааны үр өгөөж, агуулгынх нь нийцтэй байдлыг үнэлэн дүгнэх зорилгоор мэдээллийг системтэйгээр цуглуулан, дүн шинжилгээ хийж, хэрэглэх үйл явц. Энэ нь дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагаа (сургалтын үйл ажиллагаа | 1. The process of the systematic gathering, quantifying, and using of information in view of judging the instructional effectiveness and the curricular adequacy of a higher education institution as a whole (institutional assessment) or of its educational programs (program assessment). It implies the evaluation of the core activities of the higher education institution (quantitative and qualitative evidence of |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | болон судалгааны үр дүнгийн тоон болон чанарын баримт, нотолгоо)–ны үнэлгээ юм. 2. Суралцахуйн хүрэх үр дүн, суралцагчийн суралцах, хөгжих үйл ажиллагаа, түүнчлэн багшлахуйн үр өгөөжийг сайжруулахад чиглэсэн үнэлгээний үйл явц. | educational activities and research outcomes). 2. A technically designed process for evaluating student learning outcomes and for improving student learning and development as well as teaching effectiveness. (UNESCO-CEPES, 2007) |
| *Үнэлгээ*<br>*Evaluation*<br>*Оценивание* | foinelekit | Сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх, зөвлөмж өгөхөд чиглэсэн системтэй дүн шинжилгээ хийх ерөнхий үйл ажиллагаа. Үнэлгээ нь өөрийн болон хөндлөнгийн хэлбэрээр хийгдэнэ. | The general process of a systematic and critical analysis leading to judgments and recommendations regarding the quality of a higher education institution or a programme. An evaluation is carried out through internal or external procedures. In the United Kingdom, evaluation is also called review. (UNESCO-CEPES, 2007) |
| *Үнэлгээний бодлого*<br>*Assessment policy*<br>*Политика оценки* | foinelekia O Bdol)T | Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний зорилт, суралцагчийн хангах чанарын стандарт, үнэлгээний арга зүй зэрэг асуудлыг тодорхойлсон сургалтын байгууллагын бодлого. Сургуулийн бодлогод нийцүүлэн, хичээл бүрээр үр дүнгийн үнэлгээний бодлогыг | An institutional policy specifying such matters as the objectives of the assessment of students' learning outcomes, as well as the qualitative standards that students should achieve and the assessment methods used. Within individual courses, it is common for students to be made aware of the |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | суралцагчдад таниулж, мэдээлэхээс гадна дүгнэх арга зүй, шалгуур зэргийг оюутны гарын авлага, хичээлийн хөтөлбөрт тусгасан байна. | assessment policy by clearly informing them, in student handbooks and syllabi, about grading methods and criteria, based on institutional policy. (NIAD-QE, 2016) |
| *Үнэлгээний гарын авлага*<br><br>*Evaluation manual*<br><br>*Руководство оценивания* | foimelekia 0 Ge* oa feBI)T | Магадлан итгэмжлэлийн хөндлөнгийн үнэлгээний шинжээчдэд зориулсан удирдамж. Энэхүү удирдамжид баримт бичгийн шинжилгээ хийх, сургуульд очиж ажиллах, үнэлгээний тайлан бичих арга зүйг нарийн зааж өгнө. | Guidelines for external evaluators of accreditation. It covers detailed methodologies on document analyses, site visits and making evaluation reports. (NIAD-QE, 2016) |
| *Үнэлгээний рубрик*<br><br>*Rubrics (in assessment)*<br><br>*Рубрик (в оценке)* | foimelekia 0 Roibri! | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хэм хэмжээг оноогоор дүгнэх үнэлгээний хэрэглэгдэхүүн. Суралцагчид өөрсдийн ажлыг үнэлэх, улмаар засварлах, сайжруулахын тулд рубрик ашиглаж болно. Рубрик нь гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт ба түвшин гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд түүнийг ашиглан суралцагчийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг хэрхэн, ямар түвшинд хангаж буйг шалгуур бүрээр тодорхойлох боломжтой. | Scoring tools containing performance criteria and a performance scale to evaluate the quality of learner work, usually on a point scale. Learners may use rubrics to judge their own work, and to edit and improve it. A rubric is normally comprised of two components –criteria and levels of performance. For each criterion, the evaluator applying the rubric can determine to what degree the learner has met the criterion, i.e. the level of performance. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Үнэлгээний сорил*<br><br>*Assessment test*<br><br>*Тест оценивания* | foinelekia O Sori& | Суралцахуйн үр дүнг хэмжих, хянах арга хэрэгсэл. Бичгийн шалгалт, сорил гэх мэт шууд үнэлгээний аргаар оюутны мэдлэг, ур чадвар, хандлагыг хэмжих арга зүйн ерөнхий нэр томьёо. Сурлагын амжилтыг хэмжих бусад арга зүйтэй хослуулан хэрэглэснээр сургуулийн орчин дахь хүндрэл, бэрхшээл, боловсролын үр нөлөөг нягтлан тодорхойлох боломж бүрддэг. Түүнчлэн, үнэлгээний сорил нь суралцагчдын бие даан суралцах үйл ажиллагаанд удирдамж болдог. | A means of measuring and monitoring learning outcomes. It is a general term for methods of measuring students' knowledge, skills, and attitude through direct evaluations such as paper tests. Implemented in combination with other surveys that measure academic achievement, the results of assessment tests are used to check educational effects and challenges on campus. Assessment tests are also used in providing study guidance to students individually. (NIAD-QE, 2016) |
| *Үнэлгээний тайлан*<br><br>*Evaluation report/ assessment report*<br><br>*Отчёт об оценке* | foinelekia O Deiiloa | (I) Байгууллагын чанар, сургалтын стандарт, дэд бүтэц, багшлах бүрэлдэхүүнд үндэслэн их, дээд сургалтын байгууллагад ажиллаж гүйцэтгэсэн шинжээчийн багийн баримт бичиг. Байгууллагын талаарх энэхүү тайлан нь тухайн байгууллагын чанарын баталгаажуулалт, түүнтэй холбоотой зохицуулалт, хөтөлбөрийн чанарт үзүүлж буй үр нөлөөг илэрхийлнэ. Урьдач дүгнэлт дээр үндэслэсэн | (I) The document prepared following a quality assessment peer review team site visit that is generally focused on institutional quality, academic standards, learning infrastructure, and staffing. The report about an institution describes the quality assurance (QA) arrangements of the institution and the effects of these arrangements on the quality of its programs. The report is made available to the |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | төсөл хэлбэрээр, дараа нь албан ёсны хэлбэрээр тухайн байгууллагад нээлттэйгээр бичигдэнэ. Энэхүү тайлан аудитын аргазүйн тодорхойлолт, дүн шинжилгээ, аудиторуудын дүгнэлт, асуусан асуултуудын жагсаалтын хавсралтаас бүрдэнэ. Европын улсуудад ийм баримт бичгийг “Evaluation Report”, “Assessment Report” гэж голчлон нэрлэдэг. (II) Энэхүү тайлан нь магадлан итгэмжлэлийн байгууллагын хүрээнд тухайн байгууллагын чанарын баталгаажуулалтын зохицуулалт, мөн дээд боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт эдгээр зохицуулалт хэрхэн үр нөлөө үзүүлж байгааг тодорхойлоход чиглэгддэг. | institution, first in draft form for initial comments, and then in its final, official form. It contains, among other things, the description of the methodology of the audit, the findings, the conclusions of the auditors, and various appendices listing the questions asked. In Europe, the document is often called an “evaluation report” or an “assessment report”. (II) Such a report may also be prepared about an accreditation agency, describing its quality assurance arrangements and the effect of these arrangements on the quality of the programs in the institutions for which it is responsible. (UNESCO-CEPES, 2007) |
| *Үнэлгээний тогтолцоо*<br><br>*Grading system*<br><br>*Система оценивания* | foineIekia O DoeedeIce)T | Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдын сурлагын амжилтыг үнэлэхэд хэрэглэж буй үсгэн (A,B,C,D,F г.м.), үгэн (тэнцсэн/тэнцээгүй), тоон (хувь) үнэлгээ. | The type of scale – that is, letter grade, pass/fail, percentage – used by colleges and universities. (Glossary of terms in HE, 2016) |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| *Үнэлгээний хянан зохицуулалт*<br><br>*Moderation (in assessment)*<br><br>*Умеренность (в оценке)* | foinelekia O kinea Jokicegololda | Суралцагчийн шалгалтын үнэлгээний хариуг үнэн зөв, найдвартай болохыг баталгаажуулах зорилгоор стандарт тогтоох үйл явц. Багш нар суралцагчийн гүйцэтгэлтэй танилцаж, хүлээгдэж буй стандартыг хэр хангаж буй талаар ярилцаж, зөвшилцөх байдлаар зохион байгуулдаг. Хянан зохицуулалт нь өөр өөр орчин нөхцөлд үнэлгээний найдвартай байдлыг хангах, үнэлгээний дүнг хянах, харьцуулах боломжийг хангахад чиглэсэн цогц үйл ажиллагаа бөгөөд үнэлгээний дүнг эрх бүхий хөндлөнгийн байгууллага хянан шалгах боломжтой. | The process of establishing comparable standards for evaluating learners' responses to assessment tasks in order to ensure that the data are valid and reliable for the intended purposes. In schools, it involves groups of teachers looking at examples of student work, discussing the extent to which these meet the expected standard, and coming to an agreement on the level of attainment represented by each example. Moderation is a key strategy to increase the reliability of assessment and marking across different settings. It includes a set of approaches that aim to ensure the quality and comparability of assessment judgement. It may also involve a competent external organization systematically checking school-based marking. (UNESCO, 2013) |
| *Үнэлгээний шинжээч*<br><br>*Evaluator*<br><br>*Специалист по оценке / эксперт по оценке* | foinelekia O Siejikicl | Сургалтын байгууллагын өөрийн үнэлгээний тайлан болон сургууль дээр ажиллан хөндлөнгийн үнэлгээ хийж буй хүн. Үнэлгээ хийх шинжээчийг төрийн | People who carry out the actual evaluation process, e.g. analysis of self-assessment report and conduct of site visits. They are elected from academics in national and |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | болон хувийн их сургуулийн эрдэмтэн багш нараас эсвэл эдийн засагч, сэтгүүлч гэх зэрэг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсээс сонгоно. Үнэлгээг зохих хууль дүрмийн дагуу шударга явуулах талаар харилцан ойлголцлыг бий болгох үүднээс хөндлөнгийн үнэлгээ хийхийн өмнө чанарын баталгаажуулалтын байгууллага нь шинжээчдэд зориулан сургалт зохион байгуулна. | private universities or experts such as journalists and economists. A quality assurance agency provides training programs prior to the evaluation to ensure their mutual understanding and the fair, appropriate and smooth implementation of the process. (NIAD-QE, 2016) |
| *Үнэт зүйлс*<br>*Values*<br>*Ценности* | foinedO Joiile_ | Тодорхой соёлын хүрээнд хувь хүн, бүлэг хүмүүсийн бий болгосон үндсэн зарчим, итгэл үнэмшлийн цогц бөгөөд энэ нь хүмүүсийн хандлага, сонголт, зан үйл, нийгмийн амьдралыг удирдан чиглүүлэх чухал хүчин зүйл болдог. | Culturally defined principles and core beliefs shared by individuals and groups that guide and motivate attitudes, choices and behaviour, and serve as broad guidelines for social life. (UNESCO, 2013) |
| *Үр дүн*<br>*Outcomes*<br>*Результаты* | foi*T doieit | Дээд боловсролын сургалтын байгууллагын эсхүл хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд тавьсан зорилгодоо хүрэх эсхүл хүрсэн үр дүн бөгөөд энэ нь олон төрлийн шалгуур үзүүлэлт (оюутны мэдлэг, танин мэдэхүйн | Anticipated or achieved results of programs or the accomplishment of institutional objectives, as demonstrated by a wide range of indicators (such as student knowledge, cognitive skills, and attitudes). Outcomes are direct results of the |

| | | | |
|---|---|---|---|
| | | үр чадвар, хандлага)-ээр илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл, суралцагчийг бүх талаар хөгжүүлэхэд зориулан төлөвлөсөн сургалтын хөтөлбөрийн шууд үр дүн юм. Үр дүнг хүрэх үр дүн гэж тодорхойлж болох бөгөөд үүгээрээ зорилтоос ялгагдана. Түүнчлэн, үр дүнгийн тайлан нь тухайн салбар, хэлтсийн бүх багш, ажилчид, суралцагчдад ойлгогдохуйц, тодорхой н а р и й в ч и л с а н задаргаатай байх шаардлагатай. | instructional program, planned in terms of learner growth in all areas. An outcome must be distinguished from an objective, which is a desired result. Generally, each outcome statement should describe one effect of the instructional program, and not accumulate several into one statement. Also, the statements should be clearly detailed and easily understandable by all teaching staff and students in the given area or department. (UNESCO-CEPES, 2007) |
| *Үр дүнгийн үнэлгээ (хүрэх)*<br><br>*Outcomes assessment*<br><br>*Оценивание конечного результата обучения* | foi*T doieit oa foinelekit | Байгууллагын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд дээд боловсролын сургалтын байгууллагын тодорхой үр дүнг үнэлж, сайжруулах үйл явц. Үнэлгээ нь багшлах боловсон хүчний гүйцэтгэл, сургалт, дадлагын үр ашигтай байдал болон хөтөлбөр, хэлтсийн үүрэг (хөтөлбөрийн үнэлгээ, төсвийн тойм гэх мэт) –тэй холбоотой байж болно. Энэ нь өнөөгийн оюутнуудын хэрэгцээг ойлгох, хөгжүүлэх болон хөтөлбөрийн үнэлгээ, | The process of evaluation and improvement of specific results of a higher education institution in order to demonstrate its institutional effectiveness. Assessment may concern the performance of teaching staff, the effectiveness of institutional practices, and the functioning of departments or programs (e.g. program reviews, budget reviews, etc.). It is a formative procedure used for institutional self-study, financial retrenchment, program |

Ү

| | | | |
|---|---|---|---|
| | | санхүүгийн хэмнэлт, сургалтын бие даасан байдлын горимд хэрэглэгддэг. | evaluation, and improved understanding of the current needs of students. (UNESCO-CEPES, 2007) |
| *Үр дүнгийн үнэлгээ (хүрсэн)*<br><br>*Achievement evaluation*<br><br>*Оценка достижения* | foinelekit foi*T doieit oa | Тухайн дээд боловсролын сургалтын байгууллага нь тавьсан зорилго, зорилтоо хэр амжилттай хангаж биелүүлж байгааг тогтоох үнэлгээ. | Evaluation focused on how successfully the institution is achieving its goals and objectives. (ANQA, 2016) |
| *Үр дүнд суурилсан боловсрол*<br><br>*Outcomes-based education (OBE)*<br><br>*Образование, основанное на результатах* | foi*T doieit dO Segorileesea BIbisore& | Сургалтын хүрэх үр дүнг (зорилтот үр дүн) боловсролын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд гол хүчин зүйл болгон авч үздэг боловсролын нэг төрөл. Үр дүнд суурилсан боловсрол, сургалтын хөтөлбөрийг дэлхийн бусад улсуудад түгээмэл хэрэглэх болсон. Гэсэн хэдий ч сургалтын үр дүнг чадамжаар тодорхойлох үед боловсролын энэ төрөлд хандах хандлага нь улам бүр маргаантай болж байна. | An approach to schooling that makes outcomes (intended results) the key factor in planning and creating educational experiences. Outcomes-based education and curricula became popular in other parts of the world as well. However, this approach is increasingly controversial especially when outcomes such as competences/ competencies are used as curriculum organizers. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| **Ф** | | | |
| *Фраскатийн удирдамж*<br><br>*Frascatti Manual*<br><br>*Руководство Фраскати* | qres\EDA oa fodoridomj l | Судалгаа болон хөгжүүлэлттэй холбоотой статистик мэдээллийг цуглуулах, ашиглах талаарх арга зүйг боловсруулсан баримт бичиг. | A document stipulating the methodology for collecting and using statistics about research and development. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |
| **Х** | | | |
| *Хавсарга (хэрэглээний) судалгаа*<br><br>*Applied research*<br><br>*Прикладное исследование* | Hebsor)T :kirek,ekia 0" Sodol)T | Шинэ мэдлэгийг ашиглахад чиглэсэн судалгаа, туршилтын ажил. (Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 2006). Эхнээсээ тодорхой зорилгод чиглэсэн, шинэ мэдлэг бий болгох зорилготой судалгааны ажил байх бөгөөд суурь судалгааны ололт, үр дүнг тодорхой хэрэглээнд ашиглаж болох эсэхийг тодорхойлох, тодорхой зорилгод хүрэх арга замыг тогтоохоод чиглэсэн судалгаа. Хэрэглээний судалгааны үр дүн нь нэг буюу цөөн бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, арга зүй тогтолцоонд зориулагдсан байдаг. Хэрэглээний судалгааны үр дүн нь ихэвчлэн | Research and experimental research on the use of new knowledge. (The Law of Mongolia on Science and Technology, 2006). It is also original investigation undertaken in order to acquire new knowledge. It is, however, directed primarily towards a specific practical aim or objective. Applied research is undertaken either to determine possible uses for the findings of basic research or to determine new methods or ways of achieving specific and predetermined objectives. The results of applied research are intended primarily to be valid for a single or limited number of products, operations, methods or systems. The knowledge or information |

Ф

| | | | |
|---|---|---|---|
| | | патент, эсхүл бизнесийн, байгууллагын нууц хэлбэрээр гардаг. | derived from it is often patented but may be kept secret. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |
| *Хавсарга хичээл*<br><br>*Minor*<br><br>*Минор / второстепенная программа* | Hebsor)T kiciye& | Оюутан үндсэн мэргэжлээс гадна төвлөрөн суралцах хоёр дахь шатны хичээлүүд. | A subject in which the student takes the second greatest concentration of courses. (Glossary of terms in HE, 2016) |
| *Халамжлан зөвлөх үйл ажиллагаа / Менторын үйлчилгээ*<br><br>*Mentoring*<br><br>*Кураторство / Наставничество* | Helemjilea JoibeK foiila fejille)T < MmDo* oa foiilecilekit | Чиглүүлэгч, зааварлагч, сургагчийн үүрэг бүхий туршлагатай хүн залуучууд болон шинээр элсэгчдэд (сургалтад эсвэл байгууллагад шинээр орж буй хүн) удирдамж, чиглэл, дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэлбэр. Энэ харилцаа нь ганцаарчилсан эсвэл хэд хэдэн менторын сүлжээ байдлаар явагдаж болно. Энэ сүлжээнд үе тэнгийнхэн, өмнөх ангийнхан, эсвэл удирдлага багтаж болно. Нийгэм, сэтгэлзүйн ментор нь зөвлөх, найзын үүрэгтэй байдаг бол ажил мэргэжлийн холбоотой ментор нь дадлагажуулагч, спонсор зэрэг үүрэгтэй оролцдог. | A relationship between a less experienced individual and a more experienced individual known as a mentor through which the mentor facilitates and supports learning. It can involve a one-on-one relationship or a network of multiple mentors. The network can contain peers, 'step-ahead' peers, or supervisors. Psychosocial mentoring involves mentor roles such as counsellor or friend, and career-related mentoring involves mentor roles such as coach or sponsor. Each structure of mentoring may be better suited to support particular mentoring functions or desired outcomes. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Зөвлөх үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт нь тодорхой чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, эсвэл хүссэн үр дүнд хүрэхэд нь дэмжлэг болоход аль болох илүү нийцсэн байх хэрэгтэй. Жишээ нь, үе тэнгийнхний менторийн үйлчилгээ нь нийгэм-сэтгэлзүйн чиглэлийн үйл ажиллагааг илүү дэмждэг бол харин удирдлага, хяналтын ментор нь хувь хүний хөгжил, ажил мэргэжлийн чиглэлээр илүү дэмжлэг үзүүлэх боломжтой. | For example, the structure of peer mentoring may advance psychosocial functions, while supervisory mentoring may advance career functions. (UNESCO, 2013) |
| *Хамтарсан зэрэг*<br><br>*Joint degree*<br><br>*Двойная степень* | Hemdoreeesea Jerkit | Нэгээс дээш дээд боловсролын сургалтын байгууллага хамтран нэг дипломоор баталгаажуулсан зэрэг. | A joint degree is a single degree awarded by more than one higher education institution. (INQAAHE, 2017) |
| *Хамтарсан хөтөлбөр*<br><br>*Joint program*<br><br>*Совместная образовательная программа* | Hemdoreeesea KidolBrl | Нэгээс дээш дээд боловсролын сургалтын байгууллага хамтран хэрэгжүүлж буй нэг хөтөлбөр. | Хоёр ба түүнээс дээш дээд боловсролын сургалтын байгууллагууд хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөр. (INQAAHE, 2017) |

| | | | |
|---|---|---|---|
| *Хамтран суралцахуй*<br><br>*Collaborative learning*<br><br>*Коллективное обучение /Обучение в сотрудничестве* | Hemdorea SorolCeeol | Гүйцэтгэлийн хувьд ялгаатай түвшний суралцагчдад нэгэн зорилгын төлөө бүлгээр хамтран ажиллаж, нийгэмших үйл явц. Энэ нь бусадтай эерэг харилцах, хариуцлагатай байх, ур чадвараа хөгжүүлэх зорилготой суралцагчид хоорондын харилцаанд тулгуурладаг. | A process through which learners at various performance levels work together in small groups toward a common goal. Collaborative learning is a relationship among learners that fosters positive interdependence, individual accountability, and interpersonal skills. (UNESCO, 2013) |
| *Хандлага*<br><br>*Attitude*<br><br>*Установка / Отношение* | Heedol)T | Аливаа зүйлд хариу үйлдэл үзүүлэх тогтвортой, урт хугацааны, суралцаж олж авсан төлөв байдал бөгөөд энэ нь итгэл үнэмшил (танин мэдэхүй), мэдрэмж (нөлөөлөх байдал), санаа зорилго (когнитив) дээр суурилдаг . | Stable, long-lasting, learnt predisposition to respond to certain things in a certain way, attitudes are formed on the basis of beliefs, feelings and intentions. Source: (UNESCO, 2013) |
| *Харилцан хүлээн зөвшөөрөх*<br><br>*Mutual recognition*<br><br>*Взаимное признание образования* | HeriIcea KiIiyea JoibsiyereK | Хоёр болон түүнээс дээш байгууллага бие биеэ эсхүл, хөтөлбөр, боловсролын агуулгаа харилцан хүлээн зөвшөөрөх, түүнчлэн, чанарын баталгаажуулалтын болон магадлан итгэмжлэлийн хоёр ба түүнээс дээш байгууллага зохих арга зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгааг харилцан зөвшөөрөх явдал. | Agreement by two or more institutional bodies to validate each other's degrees, programs, or institutions and affirmation by two or more quality assurance or accrediting agencies that the methodology of the agencies are sound and that the procedures are functioning accordingly. (UNESCO-CEPES, 2007) |

| | | | |
|---|---|---|---|
| *Харилцах хугацаа*<br><br>*Contact period*<br><br>*Контактный период* | HerilceeO Hogoce)T | Танхимын болон хичээлээс гадуурх сургалтын идэвхтэй үйл ажиллагааны үед багш суралцагчдын харилцах, хамтран ажиллах үйлийн үргэлжлэх хугацаа. | The scheduled interaction time of teachers and learners engaged in active teaching and learning activities inside and outside the classroom. (UNESCO, 2013) |
| *Хиймэл оюун ухаан*<br><br>*Artificial Intelligence (AI)*<br><br>*Искусственный интеллект* | kiimel foyoa foeeegea | Харааны мэдрэх чадвар, харилцан ойлголцох, шийдвэр гаргах, хэл хоорондын орчуулах гэх зэрэг хүний оюун ухааны чадвар шаарддаг олон төрлийн үйл ажиллагааг компьютерын систем ашиглан орлуулах онол. | The theory and development of computer systems able to perform tasks normally requiring human intelligence, such as visual perception, speech recognition, decision-making, and translation between languages. (www.information-age.com) |
| *Хичээл*<br><br>*Course*<br><br>*Курс* | kiciyel | Улирлын туршид тогтмол хуваариар судлахаар төлөвлөсөн танхимын сургалт. Хичээлүүд нь оноосон нэр, кодоороо ялгагдана. | Regularly scheduled class sessions during the term. The courses offered by an institution are usually assigned a name and a number for identification purposes. (Glossary of terms in HE, 2016) |
| *Хичээл дундын хандлага*<br><br>*Multidisciplinary approach*<br><br>*Мультидисциплинар-ный подход* | kiciyel Domda iia Heedol)T | Хичээлийн сэдэв, асуудал, агуулгыг томьёолохын тулд хичээл хоорондын уялдаа холбоо, олон янзын үзэл баримтлалын үүднээс сургалтын хөтөлбөрийг уялдуулан | An approach to curriculum integration which focuses primarily on the different disciplines and the diverse perspectives they bring to illustrate a topic, theme or |

X

| | | | |
|---|---|---|---|
| | | нэгтгэх хандлага. Хичээл дундын сургалтын хөтөлбөрөөр нэгээс олон хичээлээр ижил сэдвийг судалдаг. | issue. A multidisciplinary curriculum is one in which the same topic is studied from the viewpoint of more than one discipline. (UNESCO, 2013) |
| *Хичээл хоорондын уялдааг хангах хандлага*<br><br>*Cross-curricular approach*<br><br>*Межпредметный подход* | iI HeekgeeO HeedoI)T kiciye& HogoroedO iia foyeldo)T | Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн хичээлээр олгох агуулга, эзэмшүүлэх ур чадвар, чадамжийн уялдаа холбоог хангах арга зүй, хандлага. | An approach to formulating curriculum that favours the dynamic use of learning topics and themes to be covered and skills/ competencies to be developed in a number of learning areas across the curriculum. (UNESCO, 2013) |
| *Хичээл хоорондын уялдааг хангах хандлага*<br><br>*Transdisciplinary approach*<br><br>*Трансдисциплинар-ный подход* | HeekgeeO HeedoI)T kiciye& HogoroedO iia foyeldo)T iI | Уламжлалт хичээл хоорондын зааг ялгааг арилгаж, бодит ертөнцийн талаар холбогдох мэдлэг, мэдээлэл олгохын тулд хичээл хоорондын нэгдэл, уялдуу холбоог харгалзан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг арга, хандлага. | An approach to curriculum integration which dissolves the boundaries between the conventional disciplines and organizes teaching and learning around the construction of meaning in the context of real-world problems or themes. (UNESCO, 2013) |
| *Хичээлийн жил*<br><br>*Academic year*<br><br>*Учебный год* | kiciye& oa Ji& | 1. Сургалтын хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа (12 сарын турш үргэлжлэхгүй, семестр эсвэл улиралд хуваагдаж болно). 2. Тухайн жилд дээд боловсролын сургалтын | 1. duration of a specific program of study (which may not last a complete 12 months and is divided into terms, semesters or quarters). 2. start and finish dates of the annual cycle of a university or |

X

| | | | |
|---|---|---|---|
| | | үйл ажиллагаа эхлэх, дуусах хугацаа. | national higher education system. (INQAAHE, 2017) |
| *Хичээлийн төлөвлөгөө*<br><br>*Lesson plan*<br><br>*План урока* | kiciye& Doilob;ekt | Жил, сар, долоо хоног, өдөр өдрөөр гэх мэт тодорхой хугацаагаар маягтын дагуу боловсруулан, заах агуулга сэдвийн тойм. Энэ нь сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтын зорилт, хичээлийн сэдэв, агуулга, шаардлагатай нөөц, авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зарцуулах хугацаа, анги зохион байгуулалт, үнэлгээний арга, өмнөх болон дараагийн хичээлийн залгамж холбоо зэргийг багтаадаг. | An outline of a topic to be addressed in a given period which can take a variety of forms and be prepared on a daily, weekly or monthly basis. It normally involves defining specific learning objectives aligned with the existing curriculum, selection of subject matter, required materials and resources, the activities that will take place as well as time and class management notes, assessment methods, and the links between previous and following lessons. (UNESCO, 2013) |
| *Хичээлийн түвшний жишиг харьцуулалт*<br><br>*Subject benchmark/ subject benchmark statement*<br><br>*Предметный эталон / заявление о предметном бенчмарке* | kiciye& oa Doibsia 0 Jiziit Hericegololda | Хичээлийн түвшний жишиг харьцуулалт нь сургалт, судалгааны ажлын хүрээнд тухайн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийн мөн чанар, мэргэшлийн зэрэг олгоход тавигдах стандарт, шаардлагыг тодорхойлох хэрэгсэл юм. Энэ нь сургалтын төлөвлөгөөний талаарх тогтсон тодорхойлолтоос илүүтэй магадлан | Subject benchmark statements provide means for the academic community to describe the nature and characteristics of programs in a specific subject and the general expectations about standards for the award of a qualification at a given level in a particular subject area. They are reference points in quality assurance framework more than |

X

| | | | |
|---|---|---|---|
| | | итгэмжлэлийн хүрээнд жишиг шалгуур болон ашиглагддаг. | prescriptive statements about curricula. (UNESCO-CEPES, 2007) |
| *Хичээлийн хуваарь*<br><br>*Schedule*<br><br>*Расписание учебных занятий* | kiciyel oa Hobiyerl | Багш, оюутны сургалт, судалгаа, хүмүүжлийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт. | Although this online schedule of classes is prepared on the basis of the best information available at the time, all information including class meeting times and locations, course offerings, and availability of enrollment is subject to change without notice or obligation. (Budikina, 2017) |
| *Хичээлээс гадуурх үйл ажиллагаа*<br><br>*Extra-curricular activities*<br><br>*Внеклассная работа* | kiciyel fca Gedegorkia foiila fejille)T | Суралцагчийг хүмүүнлэг иргэн болгон төлөвшүүлэх, өргөн хүрээний мэдлэг эзэмшүүлэхийн тулд сургалтын хөтөлбөрөөс гадуур, сургуулийн орчинд зохион байгуулах идэвхтэй үйл ажиллагаа. Үүнд, оюутны клуб, холбоо, судалгааны бүлгэм, дугуйлангийн үйл ажиллагаанууд хамаарна. | Student activities on campus, other than academic programs, which contribute to the nurture of rich humanity and widen knowledge. They include club activities, activities in student unions and students' research societies. (NIAD-QE, 2016) |
| *Холимог сургалт*<br><br>*Blended learning*<br><br>*Комбинированное обучение* | Holime( Sorgelda | Танхимын сургалтыг (ихэвчлэн интернэтэд суурилсан) зайн сургалттай хослуулсан уян хатан арга зүй. | Blended learning is a flexible approach that combines face-to-face teaching/learning with remote (usually internet-based) learning. (INQAAHE, 2017) |

*Хорин нэгдүгээр зууны чадвар*

*Twenty-first century skills*

*Умения / Навыки XXI века*

Horia Nikdoki* Jegoa 0 CideBrI

Иргэний мэдлэгт суурилсан нийгмийг бүтээх, хувь нэмрээ оруулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг илэрхийлж буй ерөнхий ойлголт. Энэ нь нийгмийн өөрчлөлт, ялангуяа технологийн хурдацтай хөгжил өнөөгийн хүмүүсийн амьдрах, ажиллах, суралцах арга замд нөлөө үзүүлж байгаатай холбоотойгоор урган гарсан ойлголт. Аж үйлдвэржилтийн нийгэмд боловсролын зорилго нь баримт, үйл явцад суурилсан мэдлэгийг хөгжүүлэхэд чиглэгдэж байсан бол өнөөгийн мэдээллийн технологид суурилсан мэдлэгийн нийгэмд үзэл санаа, мета-танин мэдэхүйн мэдлэгийг хөгжүүлэхийг чухалчилдаг. Түүнчлэн, олон улсын хамтын ажиллагаа, даяаршлын ур дүнд эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд гарсан өөрчлөлтүүд нь 21-р зууны ур чадварын хэрэгцээг чухалчлах хөдөлгөгч хүч болсон. Хамтын ажиллагаа, мэдээлэл, харилцаа,

An overarching concept for the knowledge, skills and attitudes citizens need to be able to fully participate in and contribute to the knowledge society. This need is mostly attributed to the changes in society, and more particularly, to the rapid development of technology and its impact on the way people live, work and learn. While in the industrial society the main focus of education was to contribute to the development of factual and procedural knowledge, in the information or knowledge society the development of conceptual and metacognitive knowledge is increasingly considered important. Furthermore, the changes in economy and the labour market caused by globalization and internationalization are an important driving force for the need of 21st century skills. Most frameworks seem to converge on a common set of 21st century skills or competences, namely: collaboration; communication; Information and Communication

X

| | | | |
|---|---|---|---|
| | | холбооны технологи (МХХТ)-ийн мэдлэг; нийгмийн болон соёлын чадамж (иргэншил); бүтээлч байдал, шүүн тунгаах сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар зэрэг нь 21-р зууны нийтлэг ур чадварт багтана. Эдгээрээс МХХТ нь 21-р зууны цөм ур чадвар болж байгаа нь технологийн боловсролын шинэ багц чадамжийг эзэмших шаардлага тулгарч байна. | Technology (ICT) literacy; and social and/or cultural competencies (including citizenship); creativity, critical thinking and problem solving. Across the various frameworks it is acknowledged that ICT is at the core of 21st century skills. The rapid development of ICT requires a whole new set of competences related to ICT and technological literacy. Source: UNESCO, IBE. Glossary of curriculum terminology, 2013 |
| *Хос хөтөлбөр*<br>*Dual program*<br>*Совместная образовательная программа* | Hoo_ KidolBrl | Хоёр ба түүнээс дээш сургалтын байгууллага хамтран хэрэгжүүлж буй сургалтын нэг хөтөлбөр. | A dual program is a program implemented by two or more higher education institutions for a single study program. (INQAAHE, 2017) |
| *Хос диплом*<br>*Double diploma*<br>*Двойной диплом* | Hoo_ dip,o^ | Нэгээс дээш дээд боловсролын сургалтын байгууллагууд хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийг амжилттай дүүргэн, боловсролын хос зэргэтэй төгссөнийг нотлох боловсролын баримт бичиг. | The document on receiving the higher education issued to the graduate by two (or more) partner higher education institutions after a successful completion of a course according to the joint educational program and fixing award of double (joint) academic degree to it. (Bologna Process, 2009) |

| | | | |
|---|---|---|---|
| *Хос зэрэг*<br><br>*Dual degree*<br><br>*Двойная степень* | Hoo_ Jerkit | Хоёр ба түүнээс дээш сургалтын байгууллага хамтран сургалтын нэг хөтөлбөрт олгож буй зэрэг (мэргэшил). | A dual degree is an award made by two or more higher education institutions for a single study program. (INQAAHE, 2017) |
| *Хос хэлний боловсрол*<br><br>*Bilingual education*<br><br>*Билингвальное образование / Двуязычное образование* | Hoo_ kilea O BIbisore& | Хоёр хэлээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн боловсролын нэг төрөл. Зорилгоос хамааран хос хэлний боловсролын хэд хэдэн загвар байдаг бөгөөд түгээмэл хэрэглэгддэг нь хос хэлээр тэнцвэртэй суралцах (additive) ба хоёрдогч хэлээр суралцах (subtractive) загварууд юм. Хос хэлээр тэнцвэртэй суралцах (additive) гэдэг нь хос хэлний боловсролын хөтөлбөрт хоёр хэл ижил түвшинд үнэ цэнтэй, хүлээн зөвшөөрөгдөж, суралцагчийн бичиг үсэг, харилцааны чадварыг хөгжүүлэх зорилготой байдаг. Хоёрдогч хэлээр суралцах (subtractive) гэдэгт нэг хэл нь (суралцагчийн эх хэл эсвэл цөөнхийн хэл) нөгөө хэлийг (хоёрдогч, гол төлөв албан ёсны эвсэл ноёрхогч хэл) давуу эзэмшихэд хэрэглэгддэг бөгөөд суралцагчийн | A language policy in education under which two languages are used as mediums of instruction. There are several models of bilingual education depending on the goal pursued, the most common being the additive and subtractive models. In additive bilingual education programmes both languages are given the same value and recognition and the goal for learners is the development of literacy and communication in two languages. In subtractive programmes, one language (e.g. the first language or learner's mother tongue, frequently a minority language) is used to favour the acquisition of the other language (e.g. the second or subsequent language, often the official or dominant language) and its teaching and learning is progressively reduced, |

X

| | | | |
|---|---|---|---|
| | | бичиг үсэг, харилцааны чадварыг хоёрдогч хэл дээр хөгжүүлэх зорилготой байдаг. | as the goal for learners is to develop literacy and communication in the second language. (UNESCO, 2013) |
| *Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч*<br><br>*Student with disabilities*<br><br>*Студент с ограниченными возможностями здоровья* | Kikjiǩ oa birkisiyeǩ Del Sorolceecl | Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн чадавх нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс суралцах боломж нь хязгаарлагдсан суралцагч. | A student whose learning opportunities are limited due to damages in physical limbs, loss of mental and feeling capacities because of accidents and /or natural and /or inherited phatogenic changes. (VETP-1, 2018) |
| *Хөгжүүлэх сургалтын хөтөлбөр*<br><br>*Developmental curriculum*<br><br>*Развивающийся образовательная программа* | KikjiKIK Sorgeǩda iia KidolBrl | Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулж, тэдний хөгжлийн үе шатуудыг харгалзан боловсруулсан сургалтын хөтөлбөр. Энэ нь суралцагчдын нас болон хөгжлийн онцлогт тохирсон байдаг. | A curriculum designed for learners with severe cognitive impairments reflecting their developmental stage. It should be age and developmentally appropriate. (UNESCO, 2013) |
| *Хөдөлгөөнт суралцахуй*<br><br>*Mobile learning*<br><br>*Мобильное обучение* | KideIKiKieǩO SorolCeeol | Сургалтын үйл ажиллагаа явагдаж буй орчин, нөхцөлд мэдлэг, мэдээлэл олж авах, танилцуулах зорилгоор дижитал хөдөлгөөнт төхөөрөмж, хэрэгслүүд (веб хөтөч, факс, таблет, гар утас гэх мэт)-ийг ашиглах сургалт. | The use of mobile devices such as personal digital assistants (e.g. a web browser, fax sender, tablet and cellular phone) in learning activities, bringing information and knowledge to situations and places where learning activities take place. (UNESCO, 2013) |

X

| | | | |
|---|---|---|---|
| *Хөдөлмөр эрхлэлт*<br><br>*Employment*<br><br>*Занятость* | KidelmorI frkUlelda | Хувь хүний ажил эсвэл аж ахуй эрхлэлт. | Person's work, occupation, job or business. (VETP-1, 2018) |
| *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан*<br><br>*Employment support fund*<br><br>*Фонд поддержки занятости /Фонд занятости* | KidelmorI frkUlelda iI DemjiK Seit | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилагдсан хөрөнгө ба бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх сан. | Employment support fund is established to support employment measures. This fund is compiled from different sources such as state budget, local budget and others. (VETP-1, 2018) |
| *Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр*<br><br>*Employment support program*<br><br>*Программа поддержки занятости* | KidelmorI frkUlelda iia DemjiK KidolBrI | Ажил эрхэлдэггүй хүмүүсийг ажил хөдөлмөртэй болгох зорилготой, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр. Ажил хөдөлмөр олгох хөтөлбөр нь гол төлөв мэргэжил дээшлүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа, дахин сургах буюу ажил хөдөлмөр эрэх, хайх, эзэмших чадвар дадал олгоход нь туслах замаар хэрэгжинэ. | Program aimed at providing opportunities to unemployed people to find jobs. Note: Employment support program mainly focuses on professional development, career guidance and re-training helping people acquire the skills to seek jobs and obtain qualification. (VETP-1, 2018) |
| *Хөдөлмөр эрхлэлтийн түвшин*<br><br>*Employment rate*<br><br>*Уровень занятости* | KidelmorI frkUlelda iia Doibsia | Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй буюу хөдөлмөрийн насны хүн ам (15 ба түүнээс дээш насны)-ын тоонд харьцуулсан харьцаа. | The number of persons in employment as a percentage of the population of working age (above 15 years of age). (VETP-1, 2018) |

| | | | |
|---|---|---|---|
| *Хөдөлмөр эрхлэх боломж*<br><br>*Employability*<br><br>*Способность к трудоустройству / трудоустраивае-мость* | Kidelmorl frkllek Blomjl | Хувь хүн мэргэжлээрээ амжилттай ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц. | Employability is the acquisition of attributes (knowledge, skills, and abilities) that make graduates more likely to be successful in their chosen occupations. (INQAAHE, 2017) |
| *Хөдөлмөрийн зах зээл*<br><br>*Labour market*<br><br>*Рынок труда* | Kidelmorl iia Je(T Jikil | Хөдөлмөр эрхлэхэд бэлэн байгаа хүмүүсийн нийлүүлэлт болон нээлттэй ажлын байрны хоорондын харьцааг тодорхойлсон тогтолцоо. Хөдөлмөрийн зах зээл нь хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт бүхий эдийн засгийн тогтолцоо юм. | The system of relationship between the supply of people available for employment and available jobs. A labour market in an economy functions with demand and supply of labour. (VETP-1, 2018) |
| *Хөндлөнгийн үнэлгээ*<br><br>*External assessment*<br><br>*Внешняя оценка* | Kiedelea O foinelekt | Үнэлгээний байгууллага, агентлагийн боловсруулж, хэрэгжүүлдэг үнэлгээний арга хэрэгсэл, үйл явц. Үнэлгээнд стандартчилагдсан сорил түгээмэл хэрэглэдэг ба шалгалт өгч байгаа суралцагсад ихэвчлэн боловсролын дараагийн түвшинд дэвшин суралцах, гэрчилгээ авах зорилготой байдаг. | A process and method of assessment developed and used by an examination body or agency other than the learner’s school. This process commonly involves standardized testing, and often serves to grade candidates for further educational opportunities and/or for certification purposes. (UNESCO, 2013) |

| | | | |
|---|---|---|---|
| *Хөрвөх чадвар*<br><br>*Transferable skills*<br><br>*Передаваемые умения / навыки* | KirbiK CideBrI | Эзэмшсэн мэдлэг чадвар нь олон төрлийн ажил үүргийг хийж гүйцэтгэхэд үр дүн үзүүлж байх чадвар. | Skills that are typically considered as not specifically related to a particular job, task, academic discipline or area of knowledge and that can be used in a wide variety of situations and work settings. (UNESCO, 2013) |
| *Хөтөч судлагдахуун*<br><br>*Carrier subject*<br><br>*Предмет-носитель* | KidocI SodoloedeeOa | Бие даасан хичээл биш хэдий ч, цар хүрээ, мөн чанарын хувьд суралцагчдын тодорхой мэдлэг, ур чадвар, хандлагыг хөгжүүлэхэд дэмжих судлагдахуун. Жишээ нь: байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудал, аюулгүй байдлын талаарх агуулгыг биологи, газарзүйн, хими, физик болон бусад хичээлийн хүрээнд олгож болдог. | A subject that by its scope and nature is more likely to help learners develop certain knowledge, skills and attitudes that are not the domain of a single subject. An example is environment and sustainability ‘carried by’ biology and geography. (UNESCO, 2013) |
| *Хувь хүнд тохирсон сургалт*<br><br>*Personalized learning*<br><br>*Персонализированное обучение* | HobiA Kimoa dO DokiireeeSea Sorgelda | Суралцагч амжилттай суралцах, зорилтот үр дүнд хүрэхэд нь туслахын тулд тэдний одоогийн нөхцөл байдал, онцлог, хэрэгцээнд боловсролыг нийцүүлэн олгох үйл явц. Хувь хүнд тохирсон сургалтаар боловсролын ялгаатай түвшинд сургалтын | A process of tailoring education to learners’ current situation, characteristics, and needs in order to help learners to achieve the best possible learning progress and outcomes. Personalized learning can appear on different levels of education, including |

| | | | |
|---|---|---|---|
| | | хөтөлбөр, хичээл, сургалтын материал, үйл ажиллагаа болон бусад дэмжлэгийг хувь хүнд нийцүүлэн хүргэх боломжтой. Түүнчлэн суралцагч бүрд өөрийн онцлог, хэрэгцээндээ тохирсон боловсрол эзэмшиж, суралцах боломжийг олгодог. | personalizing the curriculum, courses, learning materials and activities, and other learning support. Through personalized learning, each learner is provided with education that is tailored to his/her individual characteristics and needs and learns in a way that is most suitable for him/her, resulting in different learning experiences for each learner. (UNESCO, 2013) |
| *Хувь хүний мэргэшлийн үнэлгээ*<br><br>*Assessment of individual qualifications*<br><br>*Оценивание индивидуальной классификации \ профессионализма* | HobuA Kimoa O Merkisi& oa foinelekit | Хувь хүний цаашдын боловсролын болон мэргэжлийн хөгжилд зориулан эрх бүхий байгууллагаас олгосон тухайн хүний боловсролын албан ёсны үнэлгээ эсвэл бичгээр үйлдэгдсэн тодорхойлолт. | The formal written appraisal or evaluation of qualifications of an individual by a competent authority in order to grant him or her recognition for future academic and/or professional development. (UNESCO-CEPES, 2007) |
| *Хураангуй*<br><br>*Abstract*<br><br>*Резюме / Краткий обзор* | Horiyeekgol | Судалгааны төсөл болон төслийн үр дүнгийн талаарх товч хураангуй. Судалгааны чухал талуудыг гол үр дүн болон дүгнэлтүүдийн хамт оруулсан мэдээллийн хэсэг. | A brief summary of a research project and its findings. A summary of a study that describes its most important aspects, including major results and conclusions. (Noori, 2018) |

| | | | |
|---|---|---|---|
| *Хуурмаг боловсролын зэрэг олгогч*<br><br>*Degree mill*<br><br>*Ложная учёная степень* | Hegorme( Blbisoreg oa Jerkit folgoecl | Тухайн мэргэжлийн зэргийг эзэмшихэд зайлшгүй шаардлагатай шалгуурыг хангаагүй суралцагчдад мөнгөөр боловсролын зэрэг олгодог байгууллага. | A degree mill is an organization or institution that issues degree certification for an appropriate payment, with little or no requirements for the individual to demonstrate full competence at the relevant degree level in the discipline area. (INQAAHE, 2017) |
| *Хуурмаг магадлан итгэмжлэл олгогч*<br><br>*Accreditation mill*<br><br>*Ложная аккредитация* | Hegorme( Megeoelea fidekimjileg folgoecl | Сургалтын байгууллагаас чанарын зохих шалгуур, стандартыг хангахыг шаардахгүйгээр, үйл ажиллагаанд нь бодитой, үечилсэн үнэлгээ хийхгүйгээр мөнгөний төлөө магадлан итгэмжилдэг байгууллага. | An organisation that awards accreditation to institutions or agencies for money without requiring the institution or agency to meet appropriate quality standards, lacking any review of activity and without any requirement for subsequent periodic review. (INQAAHE, 2017) |
| *Хүлээн зөвшөөрөх үйл явц*<br><br>*Recognition*<br><br>*Признание* | Kiliyea Joibsiyerek foiila YeBca | (I) Хувь хүний боловсролын болон мэргэшлийн зэрэг; (II) Дээд боловсролын байгууллагын хөтөлбөр; (III) Чанарын баталгаажуулалтын байгууллагыг тодорхой стандарт, үнэт зүйлд үндэслэн эрх бүхий байгууллагаас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдал. | Formal acknowledgement of (I) individual academic or professional qualifications; (II) programs of a higher education institution; and/or (III) quality assurance agencies, by a competent recognition authority that acknowledges certain standards and values |

X

Хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь байгууллага хоорондын болон олон улсын түвшний шинжтэй байж болно. Хувь хүний суралцсан туршлага, мэргэшлийн зэргийг (боловсролын зэрэг, диплом, суралцсан хугацаа зэрэг) хүлээн зөвшөөрөх нь тухайн хүний цаашдын боловсрол эзэмших болон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг дэмжин хүчин төгөлдөр болгож байгаа байдал. Энд академик түвшинд болон мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн байх асуудлыг тусад нь авч үзнэ. Хөтөлбөр албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байна гэдэг нь аливаа дээд боловсролын байгууллагын тодорхой хөтөлбөрийг нөгөө байгууллага нь хүлээн зөвшөөрөх явдал юм. Үүнд: хоёр сургалтын байгууллага харилцан бие биеэ хүлээн зөвшөөрч, суралцагчдад дараагийн шатны байгууллагад үргэлжлүүлэн суралцах боломж бий болгох, бусад сургалтын байгууллагын тодорхой хичээлийн агуулга, материал

with respect to special purposes that indicate the consequences of recognition. Recognition is usually of a cross-institutional or cross-border nature. As regards recognition of individual qualifications, learning experiences (e.g. degrees, diplomas, or periods of study) are validated with a view to facilitating the access of holders to educational and/or employment activities. Here, at least two kinds of recognition, those for academic and those for professional purposes, should be distinguished (see below). Program recognition generally refers to the recognition of a specific program of study of one higher education institution by another. It functions on the basis of a peer acknowledgement procedure and is meant to allow a student to engage in continued study at the latter institution or to exempt him or her from studying again subjects and materials which are not significantly different in

| | | | |
|---|---|---|---|
| | | суралцагчийн урьд нь судалсан хичээлээс төдийлөн зөрүү байхгүй тохиолдолд тухайн хичээлийг дахин судлуулахгүйгээр чөлөөлөгдөх нөхцөлийг бий болгох зэрэг хамаарна. Байгууллага албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байна гэдэг нь, чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллагаар олон улсын түвшинд танигдсан, чанарын баталгаажуулалтын байгууллагаас (ихэнхдээ гадаадын) гаргасан албан ёсоор зөвшөөрөл өгөх тусгай стандартын дагуу үнэлэгдсэн, чанарын хувьд итгэлтэй, үр дүнтэй, хариуцлагатай байгууллага хэмээн тооцогдох явдал юм. | different higher education institutions. With regard to institutions, recognition refers to the acknowledgement of quality assurance agencies or accrediting organizations, deemed to be trustful, efficient, and accountable institutions of quality assurance, following particular recognition standards set by the competent (usually foreign) recognition authorities. (UNESCO-CEPES, 2007) |
| *Хүний нөөцийн хөгжил*<br><br>*Staff development / human resource development*<br><br>*Повышение квалификации человеческих ресурсов* | Kimoa O Noik:ca iia Kikji& | Тухайн сургалтын байгууллага зорилго, зорилтдоо хүрэх, удирдлагын бүтцийн үйл ажиллагаар үр өгөөжтэй болгохын тулд байгууллагын удирдлага, сургалт судалгаар хөгжүүлэхэд оролцдог захиргааны ажилтан болон мэргэжилтнүүдийг | A general term used for systematic approaches to enhance the performance of administrative and technical staff involved in management or in the support of education and research, and of the organization itself, so that the institution's management structure |

X

| | | | |
|---|---|---|---|
| | | хөгжүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн цогц арга, хандлагыг илэрхийлэх ерөнхий нэр томьёо. | functions more effectively in pursuit of the accomplishment of its goals and objectives. (INQAAHE, 2016) |
| *Хүрэх зорилт*<br><br>*Attainment targets*<br><br>*Цели достижения* | KirK Jorilda | Хөтөлбөр болон боловсролын тодорхой түвшнийг дүүргэснээр суралцагчийн эзэмшсэн, тодорхой шалгуурын дагуу үнэлүүлсэн байх шаардлагатай мэдлэг, ойлголт, ур чадвар. | Targets which specify the knowledge, understanding and skills related to specific subjects or disciplines that learners are expected to have acquired by the end of a programme or educational level and to be assessed against a predetermined set of criteria. (UNESCO, 2013) |
| *Хүчинтэй байдлын баталгаажуулалт*<br><br>*Validation*<br><br>*Валидация* | Kicoedel bẽiidel& oa bẽdolegejigololda | Сургалтын хөтөлбөр нь боловсролын зэрэг олгох шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэхэд холбогдох эрх бүхий байгууллага (сургалтын байгууллагын өөрөө эсхүл хөндлөнгийн үнэлгээний байгууллага)-аас дүгнэлт гаргаж буй үйл явц. Өөрөөр хэлбэл, эзэмшсэн мэдлэг, чадварыг хүлээн зөвшөөрөх, баримтжуулах. | The process by which a program is judged to have met the requirements for an award by a relevant institution with degree-awarding powers (institutional self-evaluation) or by a relevant examining board (validation by an outside examining body). Process involving structured assessment, evaluation, documentation and recognition of a person's knowledge and competences, independently of how it is acquired. (UNESCO-CEPES, 2007) |

*Хэмжигдэхүйц үр дүн*

*Measurable outcomes*

*Измеряемые результаты / итоги*

kEmjikdeKiica foi*T doieit

Тоон үзүүлэлтээр илэрхийлж болохуйц үр дүн, суралцагчийн хүрэх үр дүнгийн бүх хэмжээс. Энэ нь суралцагчийн өөрийгөө удирдах, нөөц бололцоогоо ашиглах ур чадварууд, хандлага, үнэт зүйлсийн төлөвшил зэргийг багтаадаг. Хэмжигдэхүйц үр дүнгийн жишээнд ажилд орсон хүний тоо, сонгууль өгөхөөр бүртгэгдсэн хүний тоо, ахисан түвшний боловсролын зэрэг авсан төгсөгчдийн тоо зэрэг багтаж болно. Суралцахуйн амжилтуудад ярих, сонсох, унших, бичих, тооцоолон бодох чадварууд багтана. Өөрийгөө удирдах, нөөц бололцоогоо ашиглах чадварт асуудлыг шийдвэрлэх, шүүн тунгаах сэтгэлгээ, танин мэдэхүйн дээд түвшний чадварууд багтана. Суралцагчийн хандлага, үнэт зүйлсийн төлөвшлийн хэмжигдэхүүнд өөрийгөө хүндлэх, өөртөө итгэлтэй байх, хүмүүстэй харилцах ур чадварыг хамааруулдаг.

Results that can be quantified; all measures of student outcomes (except certain subjective learning achievements), including executive function skills, and affective-related measures. Examples of measurable outcomes include: numbers of persons who gain employment, numbers of people who register to vote, and numbers of people who achieve a graduate education degree. Learning achievements concern speaking, listening, reading, writing, and numeracy. Executive function skills include problem-solving, critical thinking, and meta-cognition. Affective-related measures include self-esteem, self-confidence, and interpersonal communication. (UNESCO-CEPES, 2007)

Х

| | | | |
|---|---|---|---|
| *Хэрэгжсэн сургалтын хөтөлбөр*<br><br>*Implemented curriculum*<br><br>*Реализованная образовательная программа* | KidolBrl kirekjiksea Sorgelda iia | Сургууль дээрх суралцагч, багш болон бусад суралцагчдын хоорондын сургалтын бодит үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл, сургалтын хөтөлбөрийг практикт хэрэгжүүлэх байдал. | The actual teaching and learning activities taking place in schools through interaction between learners and teachers as well as among learners, e.g. how the intended curriculum is translated into practice and actually delivered. (UNESCO, 2013) |
| *Хяналт шинжилгээ*<br><br>*Monitoring*<br><br>*Мониторинг* | kuneldа Siejilekt | Хяналт-шинжилгээ нь дараах хоёр утгыг илэрхийлнэ. 1. Тойм үнэлгээ хийх замаар үйл ажиллагааны чанарыг хангах үйл явц. 2. Аудит, үр дүнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл, хөндлөнгийн шалгалт зэрэг дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын бүх хэлбэр, мөн сайжруулах үйл явцыг ерөнхийд нь илэрхийлэх нэршил. | Monitoring has two meanings: 1. the specific process of keeping quality activities under review; 2. a generic term covering all forms of internal and external quality assurance and improvement processes including audit, assessment, accred bitation and external examination. (INQAAHE, 2017) |

## Ц

| | | | |
|---|---|---|---|
| *Цахим сургалт*<br><br>*E-learning*<br><br>*Е-обучение* | Cekl^ Sorgelda | Мэдээлэл, холбоо, харилцааны технологид суурилан мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн бүх хэлбэрийн сургалтын үйл ажиллагаа. Энэ нь танхимын болон бусад хэлбэртэй байж болох бөгөөд зайны болон виртуал сургалтын орчинд хамааруулж болно. | All forms of electronically supported teaching and learning, especially the web-based and computer-based acquisition of, and engagement with, knowledge and skills. It may take place in or out of the classroom. It is often an essential component of distant education and may involve virtual learning environments. (UNESCO, 2013) |
| *Цахим үнэлгээ буюу мэдээллийн технологид суурилсан үнэлгээ*<br><br>*E-assessment /ICT-based assessment*<br><br>*Е-оценка / Оценка, основанная на ИКТ* | Cekl^ foinelekit ByO Medekilea& oa Dwknolokl^A dO Segorileeesea foinelekit | Мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглан сургалтын үр дүнг үнэлэх үнэлгээ. Уламжлалт үнэлгээний загварыг илүү үр дүнтэй, үр нөлөөтэй байдлаар ашиглах, чадамжийг үнэлэх арга хэлбэрийг өөрчлөх, уламжлалт үнэлгээний хэлбэрээр үнэлэхэд хүндрэлтэй байсан чадвар, чадамжийг үнэлэхэд ашигладаг. МХХТ-д суурилсан үнэлгээ нь симуляци, интерактив, хариуг сонгох зэрэг олон хэлбэртэй байж болно. | Assessment involving the use of information and communication technologies (ICT). ICT can be used (a) to deliver traditional assessment formats more effectively and efficiently, and (b) to change the way competences are assessed and develop formats that facilitate the assessment of competences that have been difficult to capture with traditional assessment formats. ICT-based assessments may also incorporate simulation, interactivity and constructed response formats. (UNESCO, 2013) |

Ш

| | | | |
|---|---|---|---|
| *Цэвэр суурь судалгаа*<br><br>*Pure basic research*<br><br>*Чистое фундаментальное исследование* | Ceb:* Segorl Sodol)T | Эдийн засаг, нийгмийн шууд ашиг хараагүй, үр дүнг хэрэглээнд шууд ашиглах, дамжуулах зорилгогүй, зөвхөн шинэ мэдлэгийг бий болгоход чиглэсэн судалгаа. | Pure basic research is carried out for the advancement of knowledge, without seeking long-term economic or social benefits or making any effort to apply the results to practical problems or to transfer the results to sectors responsible for their application. (Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020, 2007) |

**Ч**

| | | | |
|---|---|---|---|
| *Чадамж*<br><br>*Competence*<br><br>*Компетенция* | Cidemj l | Хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавих мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд суралцагчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшил. (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009). Европын холбооны улс орнуудад чадамж гэдгийг тухайн нөхцөл байдалд нийцэхүйц мэдлэг, ур чадвар, хандлагын цогц гэж тодорхойлдог. Чадамж нь тодорхой нөхцөлд (боловсрол эзэмших, | Within the European Union area a competence is defined as a combination of knowledge, skills and attitudes appropriate to the context. Competence indicates the ability to apply learning outcomes adequately in a defined context (education, work, personal or professional development). Competence is not limited to cognitive elements (involving the use of theory, concepts or tacit knowledge); it also encompasses functional aspects (involving technical skills) |

ажил эрхлэлт, хувь хүний хөгжил эсвэл мэргэжил дээшлүүлэлт) сурсан зүйлээ зохистой ашиглах ур чадварыг илэрхийлдэг. Чадамж нь танин мэдэхүйн элементээр хязгаарлагдахгүй (онол, үзэл баримтлал, өөрийн мэдлэгээ ашиглах чадвар гэх мэт), бөгөөд ажил үүргээ гүйцэтгэх чадварууд (техникийн ур чадвараа ашиглах) түүнчлэн хүмүүс хоорондын харилцаа (нийгэм эсвэл байгууллагатай харилцах ур чадвар гэх мэт) ёс зүйн үнэ цэнэ зэргийг багтаадаг. Чадамж нь тодорхой хичээл, мэргэжлийн хүрээний мэдлэг, ур чадвар, хандлагад хамааралтай тодорхой нэг чиглэлд давамгайлсан байж болно, эсвэл бүх хичээл/ мэргэжлүүдэд хамааралтай ерөнхий/ огтлолцсон байх боломжтой. Зарим тохиолдолд "ур чадвар" гэсэн нэр томьёо нь (өргөн хүрээнд) "чадамж"-тай ижил түвшинд хэрэглэгддэг.

as well as interpersonal attributes (e.g. social or organizational skills) and ethical values. Competences can be domain-specific, e.g. relating to knowledge, skills and attitudes within one specific subject or discipline, or general / transversal because they have relevance to all domains/subjects. In some contexts the term 'skills' (in a broader sense) is sometimes used as an equivalent of 'competences'. (UNESCO, 2013)

| | | | |
|---|---|---|---|
| *Чадамжид суурилсан боловсрол, сургалт*<br><br>*Competency-based Education and Training*<br><br>*Компетентностное образование и обучение* | Blbisore&, Sorgelda Cidemjl dO Segorileeesea | Мэргэшлийн үндэсний хүрээнд чадамжийн стандартыг хангахын тулд зайлшгүй эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлага олгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын арга зүй. | An approach to vocational education and training in which skills, knowledge and attitudes are specified in order to define, steer and help to achieve competence standards, mostly within a kind of national qualifications framework. (UNESCO, 2013) |
| *Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр*<br><br>*Competency-based curriculum*<br><br>*Образовательная программа, основанная на компетентностном подходе* | Cidemjl dO Segorileeesea Sorgelda iia KidolBrl | Суралцагчийн эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлсон хичээл, сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл бөгөөд сургалтын агуулга хүрэх үр дүн, заах арга зүй, орчин, үнэлгээний, аргуудыг багтаасан байдаг. Сургалтын хүрэх үр дүн нь ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн ажилтан бэлтгэхэд чиглэгддэг. | The specifications for a course and subject which describe all the learning experiences a student or learners undergoes. The CBC generally includes learning outcomes,, contents, conditions methodologies and assessment methods. It specifies outcomes which are consistent with the requirements of the workplace as agreed through industry or community consultations. (VETP, 2018) |
| *Чанар (зорилгод тэмүүлсэн хандлага)*<br><br>*Quality as fitness for purpose*<br><br>*Качество как цель* | Heedol)T" Cine* :Joril)T dO Demeoloksea | Дээд боловсролын сургалтын байгууллагын эрхэм зорилго, зорилтыг хангаан биелүүлэхэд тухайн сургалтын байгууллага, хөтөлбөрийн үйл ажиллагааны үр өгөөжтэй байдлыг чухалчлан магадлан итгэмжлэл, чанарын | A concept that stresses the need to meet generally accepted standards such as those defined by an accreditation or quality assurance body, the focus being on the effectiveness of the processes at work in the institution or program in fulfilling its |

Ч

| | | | |
|---|---|---|---|
| | | баталгаажуулалтын байгууллагаас тодорхойлсон стандартад нийцүүлэх шаардлагатай хэмээн нийтээр хүлээн зөвшөөрсөн ойлголт. | objectives and mission. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанар (сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн хандлага)*<br><br>*Quality as enhancement or improvement*<br><br>*Улучшение качества* | Heedol) T" Cine* :Joril) T dO Demeolksea | Дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан хараат бус байдал, академик эрх чөлөөгөө эдлэх, үүргээ ухамсарлан, тогтмол сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн тасралтгүй эрэл хайгуул дээр төвлөрсөн үзэл санаа. | Focusing on the continuous search for permanent improvement, stressing the responsibility of the higher education institution to make the best use of its institutional autonomy and freedom. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанар (сургалтын)*<br><br>*Quality (academic)*<br><br>*Качество (академическое)* | Cine* :Sorgelda iia" | Олон хэмжээст, олон түвшнийг хамарсан, хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт. Энэ нь тухайн боловсролын тогтолцоо, сургалтын байгууллага, хөтөлбөр эсхүл мэргэжлийн салбарын хүрээнд боловсролыг загварчлах орчин нөхцөл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрхэм зорилго, зорилтууд болон тодорхой стандарт зэрэгт хамааралтай. Чанарын тухай ойлголтууд харилцан адилгүй байх бөгөөд зарим тохиолдолд дараах хүчин зүйлээс хамааран зөрчилдөх | Quality in higher education is a multi-dimensional, multilevel, and dynamic concept that relates to the contextual settings of an educational model, to the institutional mission and objectives, as well as to specific standards within a given system, institution, program, or discipline. Quality may thus take different, sometimes conflicting, meanings depending on (I) the understanding of various interests of different constituencies or stakeholders in higher education (e.g. students; |

Ч

| | | | |
|---|---|---|---|
| | | нь ч бий. Үүнд: дээд боловсролын оролцогч талуудын харилцан адилгүй ашиг сонирхол, түүнээс үүдэлтэй ойлголтууд (жишээлбэл, оюутан, их сургууль, мэргэжлийн чиглэл, хөдөлмөрийн зах зээл, нийгэм, засгийн газар г.м.); нөлөөлөх хүчин зүйлс (орц, үйл явц, гарц, эрхэм зорилго, зорилт г.м.); үнэлгээ хийгдэхүйц академик орчны онцлог шинэ чанар эсвэл хандлага; дээд боловсролын хөгжлийн түүхэн үе шат. | universities; disciplines; the labour market; society; a government); (II) its references: inputs, processes, outputs, missions, objectives etc.; (III) the attributes or characteristics of the academic world worth, evaluating; and (IV) the historical period in the development of higher education. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанар (төгөлдөр байх хандлага)*<br><br>*Quality as excellence*<br><br>*Качество как превосходство / совершенство* | Cine* :DeKIde* bÉiieeO HeedoI)T" | Чанарын дээд түвшнийг хамгийн сайн стандарт гэж ойлгодог уламжлалт, элит давхаргын академик үзэл санаа. (Сургалтын хөтөлбөр нь нарийн төвөгтэй байх тусам өндөр түвшний боловсрол гэсэн ойлголтоос үүдэлтэй). | A traditional, elitist academic view, according to which only the best standards of excellence (usually meaning a high level of difficulty and of complexity of a program, the seriousness of the student testing procedures, etc.) are understood as revealing true academic quality. (UNESCO-CEPES, 2007) |

*Чанарын баталгаажуулалт*

*Quality assurance*

*Обеспечение качества*

Cine* oa bidolegej igololda

Дээд боловсролын тогтолцоо, сургалтын байгууллага, мөн хөтөлбөрийн чанарыг үнэлж буй (үнэлэх, хянах, баталгаажуулах, сайжруулах) тасралтгүй үргэлжлэх үйл явц. Зохицуулах механизмын хувьд чанарын баталгаажуулалт нь харилцан хүлээн зөвшөөрсөн уялдаа холбоо бүхий үйл явц, тогтсон шалгуураар дамжуулан мэдээлэл болон дүгнэлт гаргаж, хариуцлагыг дээшлүүлэх, чанарыг сайжруулахад төвлөрдөг. Ихэнх тогтолцоо чанарын дотоод баталгаажуулалт (дээд боловсролын чанарыг хянах сайжруулах байгууллагын дотоод үйл ажиллагаа) болон чанарын хөндлөнгийн баталгаажуулалт (дээд боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн чанарыг баталгаажуулах байгууллага хоорондын эсвэл байгууллагын гаднах тогтолцоо)–ыг хоорондоо ялгаатай гэж үздэг. Чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа нь тогтсон чанарын соёлын хүрээнд төлөвшин бий

An all-embracing term referring to an ongoing, continuous process of evaluating (assessing, monitoring, guaranteeing, maintaining, and improving) the quality of a higher education system, institutions, or programs. As a regulatory mechanism, quality assurance focuses on both accountability and improvement, providing information and judgments (not ranking) through an agreed upon and consistent process and well-established criteria. Many systems make a distinction between internal quality assurance (i.e. intra-institutional practices in view of monitoring and improving the quality of higher education) and external quality assurance (i.e. inter- or supra-institutional schemes assuring the quality of higher education institutions and programs). Quality assurance activities depend on the existence of the necessary institutional mechanisms preferably sustained by a solid

Ч

болдог байгууллагын зохих тогтолцооноос хамааралтай байдаг. Чанарын удирдлага,, сайжруулалт, хяналт, үнэлгээ зэрэг нь чанарын баталгаажуулалтыг бий болгодог арга хэрэгслүүд юм. Чанарын баталгаажуулалтын цар хүрээ тухайн дээд боловсролын тогтолцооны хэлбэр, хамрах хүрээнээс хамаарах бөгөөд урьдач нөхцөлийг бүрдүүлдгээрээ магадлан итгэмжлэлээс ялгаатай. Энэ хоёр ойлголтын харилцан хамаарал нь улс орнуудын практикт янз бүр байдаг. Эдгээр ойлголт нь үйл ажиллагаа явуулах, боловсролын үйлчилгээ үзүүлэх, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын зэрэг олгох чадавх, төрөөс санхүүжилт авах эрх зэрэг олон хүчин зүйлүүдийн суурь болдог. Чанарын баталгаажуулалт болон чанарын удирдлага нь зарим тохиолдолд ижил утгаар хэрэглэгддэг хэдий ч чанарын баталгаажуулалтыг дээд боловсролын чанарын удирдлагын нэг бүрэлдэхүүн гэж үздэг.

quality culture. Quality management, quality enhancement, quality control, and quality assessment are means through which quality assurance is ensured. The scope of quality assurance is determined by the shape and size of the higher education system. Quality assurance varies from accreditation, in the sense that the former is only a prerequisite for the latter. In practice, the relationship between the two varies a great deal from one country to another. Both imply various consequences such as the capacity to operate and to provide educational services, the capacity to award officially recognized degrees, and the right to be funded by the state. Quality assurance is often considered as a part of the quality management of higher education, while sometimes the two terms are used synonymously. (UNESCO-CEPES, 2007)

*Чанарын дотоод баталгаажуулалт (ЧДБ)*

*Internal quality assurance (IQA)*

*Обеспечение внутреннего качества (ОВК)*

Cine* oa DodogedO bidolegejigololda - Ci, Do, bi

Дээд боловсролын сургалтын байгууллага төрөл бүрийн үйл ажиллагаагаа хянаж, үнэлэх хариуцлагаа хэрэгжүүлэх үйл явц. Байгууллагын хүрсэн үр дүнг үйл ажиллагаагаа сайжруулах, шинэчлэхэд ашигладаг. Багшлахуйн ЧДБ гэдэг нь багшийн сургалт, судалгааны үйл ажиллагааны чанар, түүнчлэн суралцагчийн суралцахуйн үр дүнгийн түвшнийг тасралтгүй баталгаажуулахыг хэлнэ. Сургалтын хөтөлбөрийг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэгтэй бүтцийн нэгжүүд нь тухайн хөтөлбөрт гарч буй сургалт, судалгааны санаачилгууд, мөн суралцагчийн эзэмшвэл зохих чадвар, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд дүн шинжилгээ, нэгдсэн үнэлгээ хийх үүрэгтэй бөгөөд үр дүнг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг. Сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрт хяналт-шинжилгээ хийх, шинэчлэх, сайжруулах механизмыг бүрдүүлэх ба уг механизм нь сургалтын болон судалгааны чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулдаг байх ёстой.

Internal quality assurance (IQA) is a process by which higher education institutions themselves take responsibility for checking and evaluating the quality of their various activities. The results are used to reform and improve the institutions, as well as to ensure quality. IQA of teaching refers to an institution continuously assuring the quality of its teaching and research activities as well as the level of students' learning outcomes. Organizational units responsible for orchestrating and implementing academic programs analyze and evaluate educational and research initiatives in those programs, as well as the abilities students should acquire and the programs' learning outcomes. They use the results to make improvements. Institutions are responsible for monitoring such efforts in each academic program and for ensuring that reform and improvement mechanisms are working in the aggregate, thereby resulting in the maintenance of educational and research quality. (NIAD-QE, 2016)

Ч

| | | | |
|---|---|---|---|
| *Чанарын ерөнхий удирдлага*<br><br>*Total quality management (TQM)*<br><br>*Тотальное / полное управление качеством* | Cine* oa Yeroehkil fodoridol)T | Дараах хүчин зүйлүүдийг чухалчилсан онцгой үр нөлөө бүхий, чанарын удирдлагын талаарх цогц хандлага.Үүнд: Тасралтгүй сайжруулалт, хэрэглэгч рүү чиглэсэн стратегийн удирдлага, дээд боловсролын чанарыг баталгаажуулах ил тод, нээлттэй тогтолцоог бий болгох шаардлага, ажилчдадаа эрх мэдэл, эрх чөлөө олгосон удирдлага, хяналтын тогтолцоо зэрэг хамаарна. Энэхүү хандлагын хүрээнд үнэлгээ хийхдээ хөндлөнгөөс тогтоосон стандарт, хэрэглэгчийн сэтгэл ханамж, шинжээчийн болон мэргэжлийн дүгнэлт, ижил түвшний байгууллага зэргийг чухалчилдаг. | A particularly influential comprehensive approach to quality management that places emphasis on factors such as continuous improvement, customer focus, strategic management, need for explicit systems to assure quality of higher education, and a view of leadership and supervision that stresses employee empowerment and delegation. Such an approach to quality management emphasizes assessment that is undertaken of: (I) defined objectives or standards (set internally or by external funding bodies); (II) measures of customer satisfaction; (III) expert and professional judgment; and (IV) comparator organizations. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанарын соёл*<br><br>*Quality culture*<br><br>*Культура качества* | Cine* oa Soyo& | Байгууллагын соёл, удирдлагын тогтолцоонд чанарын тухай ойлголтыг нийтээр хүлээн зөвшөөрч, баримталдаг хэв маяг. Дээд боловсролын чанарын талаар ойлголттой байж чанарыг эрхэмлэж, | It refers to a set of shared, accepted, and integrated patterns of quality (often called principles of quality) to be found in the organizational cultures and the management systems of institutions Awareness of and commitment to the. |

Ч

| | | | |
|---|---|---|---|
| | | нотолгоонд суурилсан соёлыг төлөвшүүлэн, түүнийг үр өгөөжтэй удирдах нь (чанарын баталгаажуулалтын үйл явцаар) чанарын соёлын бүрэлдэхүүн хэсгүүд болно. Цаг үргэлж чанарын элемент хувьсан өөрчлөгдөж байдаг тул чанарыг дэмжих хандлага, зохицуулалт (чанарын соёл)-ын нэгдсэн тогтолцоо нь дээд боловсролын чанарын талаарх шинэ үзэл баримтлалыг дэмжиж байх нь чухал. | quality of higher education, in conjunction with a solid culture of evidence and with the efficient management of this quality (through quality assurance procedures) are the ingredients of a quality culture. As quality elements change and evolve over time, so must the integrated system of quality supportive attitudes and arrangements (quality culture) change to support new quality paradigms in higher education. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанарын төлөвлөлт*<br><br>*Quality planning*<br><br>*Планирование качества* | Cine* oa Doilob;elda | Дээд боловсролын чанар, чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх зорилт, нөхцөлийг тодорхойлж буй цогц үйл ажиллагаа. Чанарын төлөвлөлт нь бүтээгдэхүүний төлөвлөлт (чанартай гэгдэх шинж чанаруудын ач холбогдол болон чанарын хүрээн дэх зорилт, нөхцөл байдал, саад бэрхшээлийг олж илрүүлэх, ангилах, тодорхойлох), удирдлагын болон үйл ажиллагааны | It consists of the set of actions that establishes the objectives and the conditions referring to the quality of higher education and to the application of the mechanism of the quality system. Quality planning includes product planning (identification, classification, and determination of the importance of the features referring to quality as well as to the establishment of the objectives, the conditions referring to quality, and its restraints), |

Ч

| | | | |
|---|---|---|---|
| | | төлөвлөлт, чанарын төлөвлөгөө боловсруулалт, чанарыг сайжруулах арга зам зэргээс бүрдэнэ. | managerial and operational planning (including its organization and programming), an elaboration of quality plans, and the provision of quality improvement measures. Related terms: Accreditation, Audit, Culture of Evidence, Evaluation. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанарын удирдлага*<br><br>*Quality management*<br><br>*Управление качеством* | Cine* oa fodoridol)T | Чанарыг бүхэлд нь сайжруулах зорилгоор системийн болон байгууллагын түвшинд чанарыг баталгаажуулахад чиглэн хийгддэг үйл ажиллагааны цогц байдал. Энэ нь чанарын бодлого, зорилт, хариуцлагын хэрэгжилтийг хангах бүхий л үйл ажиллагаар хамран, чанарын төлөвлөлт, хяналт, баталгаажуулалт, болон сайжруулалтын механизмаар дамжин хэрэгждэг. | An aggregate of measures taken regularly at system or institutional level in order to assure the quality of higher education with an emphasis on improving quality as a whole. As a generic term, it covers all activities that ensure fulfillment of the quality policy and the quality objectives and responsibilities and implements them through quality planning, quality control, quality assurance, and quality improvement mechanisms. (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанарын үнэлгээ*<br><br>*Quality assessment/ quality review*<br><br>*Оценка качества* | Cine* oa foinelekit | Дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарыг хөндлөнгөөс үнэлж буй (үнэлэх, хэмжих, дүгнэлт гаргах) | The actual process of external evaluation (reviewing, measuring, judging) of the quality of higher education institutions and programs. |

Ч

| | | |
|---|---|---|
| | бодит үйл ажиллагаа. Энэхүү үйл явц нь хөндлөнгийн байгууллагаас дээд боловсролын зохион байгуулалт, практик үйл ажиллагаа, хөтөлбөр, үйлчилгээний чанарыг үнэлэх зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, механизм, арга зүй зэргээс бүрдэнэ. Чанарын үнэлгээний үзэл санааг тодорхойлж, хэрэгжүүлэхэд хэд хэдэн зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд: онцлог (үндэсний, сургалтын байгууллагын); аргазүй (өөрийн үнэлгээ, шинжээчийн үнэлгээ, шинжээч ажиллах); түвшин (тогтолцооны, сургуулийн, тэнхимийн, хувь хүний); механизм (шагнал урамшуулал, бодлого, бүтэц, соёл); чанарын үнэт зүйлсэд академик үнэт зүйлс (тодорхой мэргэжлийн чиглэл дээр төвлөрсөн уламжлалт үнэт зүйлс); зохион байгуулалтын үнэт зүйлс (практик үйл ажиллагаанд суурилсан үнэт зүйлс); сурган хүмүүжүүлэх үнэт зүйлс (багш, багшийн ур чадвар болон тэнхимийн | It consists of those techniques, mechanisms, and activities that are carried out by an external body in order to evaluate the quality of the higher education processes, practices, programs, and services. Some aspects are important when defining and working with the concept of quality assessment: (I) the context (national, institutional); (II) the methodology (self assessment, assessment by peer review, site visits); (III) the levels (system, institution, department, individual); (IV) the mechanisms (rewards, policies, structures, cultures); (V) certain quality values attached to quality assessment such as academic values, traditional values (focusing upon the subject field), managerial values (focusing on procedures and practices); pedagogical values (focusing on staff and their teaching skills and classroom practice); employment values (emphasizing graduate output characteristics |

Ч

| | | | |
|---|---|---|---|
| | | хичээлийн практик үйл ажиллагаа); хөдөлмөр эрхлэлтийн үнэт зүйлс (төгсөгчийн төлөвшил, суралцахуйн үр дүн) зэрэг орно. | and learning outcomes). (UNESCO-CEPES, 2007) |
| *Чанарын хяналт*<br><br>*Quality control*<br><br>*Контроль качества* | Cine* oa kineIda | Дотоод чанарын баталгаажуулалтын хүрээнд сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарыг үнэлэх үйл явц. Энэ нь чанарын шаардлагыг хангахад зориулан хэрэглэгддэг байгууллагын цогц үйл ажиллагаа болон арга хэрэгслүүд (хяналтын үйл ажиллагаа болон байгууллага дотооддоо зохион байгуулалттай төлөвлөн хэрэгжүүлж буй бодлого)-ийг илэрхийлнэ. Чанарын удирдлага, чанарын баталгаажуулалттай ижил утгаар хэрэглэгддэг энэхүү ойлголт нь хүрэх шаардлагатай зохих чанарын босго шалгуурт нийцүүлэн дээд боловсролын үйлчилгээ, бүтээгдэхүүн эсвэл үйл явцын чанарыг баталгаажуулах зорилгоор тогтмол хийгдэж буй үйл ажиллагаа, хэрэгжүүлэх | The process of quality evaluation that focuses on the internal measurement of the quality of an institution or a program. It refers to a set of operational activities and techniques (monitoring activities and a structured internally planned and implemented policy) elaborated and used to fulfill requirements of quality. Often used interchangeably with quality management and quality assurance, it refers to an aggregate of actions and measures taken regularly to assure the quality of higher education products, services, or processes, with an emphasis on the assurance that a prescribed threshold of quality is met. It aims both at monitoring the process and at eliminating certain causes generating an unsatisfactory |

Ч

арга хэмжээний нэгдэл юм. Мөн үйл явцыг үнэлэн, үйл ажиллагааг доголдуулж буй шалтгааныг илрүүлэн арилгахад чиглэнэ. Зарим тохиолдолд босго/ минимум чанарын хяналт (ямар нэг чанарын гэрчилгээ олгох хэлбэрээр) нь тухайн дээд боловсролын сургалтын байгууллага хүлээн зөвшөөрсөн чанарын босго шалгуурыг хангаж буй эсэх, чанарын зохих хяналтын үйл ажиллагааг төлөвшүүлэх тогтолцоо байгаа эсэхийг баталгаажуулахад чиглэсэн шүүлтүүр механизм болдог.

functioning. Sometimes a minimal quality control (mostly in the shape of some kind of certification) exists serving as a filtering mechanism in confirming that a higher education institution is fulfilling minimal agreed upon quality requirements and has appropriate quality monitoring procedures in place. (UNESCO-CEPES, 2007)

Ш

## Ш

| | | | |
|---|---|---|---|
| *Шалгалт*<br><br>*Examination*<br><br>*Экспертиза* | SilgeIda | Сургалтын байгууллагын сургалт, судалгааны нөхцөлийг баримт бичгийн шинжилгээ болон сургууль дээр ажиллах замаар үнэлж дүгнэж буй үйл явц. | The detailed inspection of conditions for education and research of subject institutions through document analyses and site visits. (ANQA, 2016) |
| *Шалгуур*<br><br>*Criteria*<br><br>*Критерия* | Silgego* | Тодорхой зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин. | Checkpoints or benchmarks determining the attainment of certain objectives and/or standards. (UNESCO-CEPES, 2007) |
| *Шилжилт*<br><br>*Mobility*<br><br>*Мобильность / подвижность* | SiljiIda | Оюутан, багш, ажилтнууд өөрийн орны болон гадаад орны дээд боловсролын сургалтын өөр байгууллагад шилжих хөдөлгөөн. | Mobility is shorthand for students and academics studying and working in other institutions, whether in the same country or abroad. (INQAAHE, 2017) |
| *Шилжин суралцах*<br><br>*Transfer*<br><br>*Перенос* | Siljia SorolceeO | Тодорхой түвшний боловсролын зэргийн хөтөлбөрийг дүүргэх зорилгоор нэг сургуулиас нөгөө сургуульд шилжин суралцах үйл явц. | The process of moving from one university to another to complete a degree. (Glossary of terms in HE, 2016) |

| | | | |
|---|---|---|---|
| *Шинжлэх ухаан, технологийн төсөл*<br><br>*Science and technology project*<br><br>*Научно-технологический проект* | Siejilek foeeegea, Dwknolokia iia Doisoß | Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг онол, арга зүйн өндөр түвшинд явуулж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичиг. | A document designed to provide research and experimental development at a high level of theoretical and methodological basis and to produce results that meet customer needs and requirements and to introduce and use them in production and service. (The Law of Mongolia on Science and Technology, 2006) |
| *Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа*<br><br>*Science and technology activities*<br><br>*Научно-технологическая деятельность / научно-техническая деятельность* | Siejilek foeeegea, Dwknolokia iia<br>foiila fejille)T | Эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа. | Scientific and technological activities (STA) are defined as systematic activities which are closely concerned with the generation, advancement, dissemination, and application of scientific and technical knowledge in all fields of science and technology. (The Law of Mongolia on Science and Technology, 2006) |
| *Шинжлэх ухааны парк*<br><br>*Science park*<br><br>*Научный парк* | Siejilek foeeegea O pir ! | Өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор холбогдох хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэх тусгайлсан газар нутагтай, үйлдвэрлэл, үйлчилгээ, | A complex with the purpose of developing the production of high technology and innovation products with a special area to implement functions set forth by a respective Law and production, service and social infrastructure. |

Ш

| | | | |
|---|---|---|---|
| | | нийгмийн дэд бүтэц бүхий цогцолбор. | (The Law of Mongolia on Innovation, 2012) |
| *Шинжээч ажиллах*<br><br>*Site visit*<br><br>*Посещение эксперта* | SiejikɛcI fejilleeO | Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны бүрэлдэхүүн болох хөндлөнгийн үнэлгээний нэг хэсэг. Шинжээч ажиллуулахыг сургалтын байгууллага өөрөө санаачилж болно. Сургалтын байгууллагын боловсруулсан өөрийн үнэлгээний тайланг хянан дүгнэх зорилгоор хөндлөнгийн шинжээчид сургууль дээр очиж ажиллах, улмаар тус сургалтын байгууллагын чанар, үр өгөөжийг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгнө. | A component of external evaluation that is normally part of an accreditation process. It may be initiated by the institution itself. It consists of external experts visiting a higher education institution to examine the self-study produced by the institution and to interview faculty members, students, and other staff in order to assess quality and effectiveness (and to put forward recommendations for improvement). Related terms: Accreditation, Evaluation, Peer Review. (UNESCO-CEPES, 2007) |
| *Шинжээчийн удирдамж*<br><br>*Guidelines for site visit*<br><br>*Руководство для визитов* | SiejikɛcI iia fodoridomj I | Дээд боловсролын байгууллагад очиж ажиллах шинжээчдийн багийн бэлтгэл хангах, ажиллах үедээ гүйцэтгэх даалгаврыг зааварчилсан баримт бичиг. | A document of instructions for the site-visiting team, which covers specifics from preparation to the tasks to be undertaken during their visit. (NIAD-QE, 2016) |

Ш

*Шинжээчийн үнэлгээ/ хөндлөнгийн үнэлгээ*

*Peer review/external review*

*Экспертная оценка / Внешняя оценка*

Siejikcl iia foinelekt < Kiedelea O foinelekt

Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн чанар, үр өгөөж, боловсон хүчин, бүтэц зохион байгуулалтын талаар хөндлөнгийн шинжээчийн хийж буй үнэлгээ. Шинжээч нь ихэвчлэн дээд боловсролын байгууллагын тухайн салбарт ажилладаг багш, эрдэмтэд байх шаардлагатай боловч амьдрал дээр өөр салбарын төлөөллүүдийг ч оруулах нь бий. Гэсэн хэдий ч тэдгээр нь дээд боловсролын талаар ерөнхий мэдлэгтэй, үнэлгээ хийж буй мэргэжлийн салбарын талаар арвин туршлагатай байх шаардлагатай. Үнэлгээ нь дараах хүчин зүйлүүдийн хувьд харилцан адилгүй байж болно. Үүнд: шинжээчийг томилох эрх мэдэл бүхий этгээд, шинжээчийн төрөл, тэдгээрийн сонгон шалгаруулалт ба сургалт, үнэлгээ хийх сургалтын байгууллага, тавигдах стандарт зэрэг хамаарна. Хөндлөнгийн үнэлгээ нь тухайн дээд боловсролын сургалтын байгууллагаас

Assessment procedure regarding the quality and effectiveness of the academic programs of an institution, its staffing, and/or its structure, carried out by external experts (peers). (Strictly speaking, peers are academics of the same discipline, but in practice, different types of external evaluators exist, even though all are meant to be specialists in the field reviewed and knowledgeable about higher education in general.) For a review, the source of authority of peers, types of peers, their selection and training, their site visits, and the standards to be met may vary. A review is usually based on a self-evaluation report provided by the institution and can be used as a basis for indicators or as a method of judgment for (external) evaluation in higher education. Related terms: Accreditation, Evaluation, Quality Assessment, Site Visit, Standards. (UNESCO-CEPES, 2007)

Ш

| | | | |
|---|---|---|---|
| | | бэлтгэсэн өөрийн үнэлгээний тайлан дээр үндэслэн, хөндлөнгийн үнэлгээний аргазүй, шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдэнэ. | |
| *Шинэ бүтээл/Нээлт*<br><br>*Invention*<br><br>*Изобретение* | Si%T Bidoki& < Nekikilda | Байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдэл. | An invention is a new solution, which motivated and invented based on the natural law and related to production procedures or products containing a degree of inventions. (The Law of Mongolia on Patent, 2006) |
| *Шинэ мэдлэг*<br><br>*New knowledge*<br><br>*Новое знание* | Si%T Medelkit | Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ашиглаж болохуйц, эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны бүтээл. | The intellectual masterpiece, which can be used and protected for the purpose of solving economic and social issues arising from scientific and technological activities. (The Law of Mongolia on Innovation, 2012) |
| *Шударга байдал (үнэлгээнд)*<br><br>*Fairness (in assessment)*<br><br>*Справедливость (в оценке)* | Sidorg0 biiide& :foinelekia dO'' | Суралцагчийн хэрэгцээ шаардлага, онцлогт нийцүүлж, үнэлгээний арга, аргачлалд тохирох өөрчлөлт хийх шинж байдал. Суралцагч тухайн үнэлгээний талаар мэдээлэл, ойлголттой байж, үнэлгээний арга хэлбэр нь хэр тохиромжтой болохыг | Refers to the consideration of learner's needs and characteristics, and any reasonable adjustments that need to be applied to take account of them. It is important to ensure that the learner is informed about, understands and is able to participate in the |

Ш

| | | | |
|---|---|---|---|
| | | хүлээн зөвшөөрч баталгаажуулах нь чухал. Түүнчлэн үнэлгээний дүнгийн талаар санал, гомдол гаргах, шаардлагатай бол дахин үнэлүүлэх боломжтой байдлыг илэрхийлсэн ухагдахуун юм. | assessment process, and agrees that the process is appropriate. It also includes an opportunity for the person being assessed to challenge the result of the assessment and to be reassessed if necessary. (UNESCO, 2013) |
| *Шүүмжлэлт сэтгэлгээ*<br><br>*Critical thinking*<br><br>*Критическое мышление* | SiKmjiIleIdO SeoeKuIlKt | Оновчтой асуулт тавих, холбогдох мэдээлэл цуглуулан бүтээлчээр ангилах, шинэ мэдээллийг мэдлэгт тулгуурлан хүлээн авах, итгэл үнэмшил, таамаглалаа эргэцүүлэн тунгаах, логик сэтгэлгээгээр учир шалтгааныг олох, бодитой дүгнэлт гаргах үйл явц. Дүн шинжилгээ хийх, таньж ойлгох, таамаглал гаргах, тайлбарлах, үнэлэх, өөрийн бодол санаагаа хянан залруулах зэрэг ур чадварууд нь шүүмжлэлт сэтгэхүйн цөм болдог. | A process that involves asking appropriate questions, gathering and creatively sorting through relevant information, relating new information to existing knowledge, re-examining beliefs and assumptions, reasoning logically, and drawing reliable and trustworthy conclusions. The cognitive skills of analysis, interpretation, inference, explanation, evaluation, and of monitoring and correcting one's own reasoning are at the heart of critical thinking. (UNESCO, 2013) |

Ш

| Э | | | |
|---|---|---|---|
| *Эгэх хариуцлага*<br><br>*Accountability*<br><br>*Подотчетность \Отчетность \ Ответсвенность* | fkiK Herigocel)T | Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийг оролцогч талуудад тайлбарлах, үндэслэлтэйгээр нотлох үйл явц, үүнтэй холбоотой үүрэг хариуцлагыг тодорхойлдог ерөнхий ойлголт. | A general term used to describe the responsibility or the process by which corporations (HEIs) explain or justify their performance to their stakeholders and the public. (NIAD-QE, 2016) |
| *Эдийн засгийн идэвхтэй хүн ам*<br><br>*Economically active population*<br><br>*Экономически активное население* | fdA oa Jese( oa fidebkidel Kimoa fema | Хөдөлмөрийн насны, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээгүй болон хөдөлмөрийн наснаас дээш насны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүн амын тооны нийлбэрээр тооцно. | Economically active population is those who participate in economic activities (employed), those who are ready to participate (seeking employment) and those who are 15 and older to participate in economic activities. (VETP-1, 2018) |
| *Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг магадлан итгэмжлэх*<br><br>*Accreditation of prior learning*<br><br>*Аккредитация предшествующего обучения* | Megeoelea fidekimjilek<br>fjensiksea MedelKit , fo*T CideBrl il | Эзэмшсэн мэдлэг, ур чадвар, туршлагад нь тулгуурлан тодорхой мэргэшлийг эзэмшихэд шаардагдах багц цагийг тооцох үйл явц. Суралцагч суралцахуйн хүрэх үр дүнгээр тодорхойлогдсон мэдлэг, ур чадварыг эзэмшсэн нь нотлогдсоноор багц цагийг тооцно. | The process by which individuals are awarded credit toward qualifications based on their prior learning and (sometimes) experience (also called experiential learning). The credit is awarded upon clear evidence that the respective learning has resulted in the student having achieved the |

Э

| | | | |
|---|---|---|---|
| | | | appropriate learning outcomes. (UNESCO-CEPES, 2007) |
| *Эзэмшсэн сургалтын хөтөлбөр*<br><br>*Attained curriculum*<br><br>*Достигнутая образовательная программа* | KidolBrl fjemsiksea Sorgelda iia | Сургалтын үр дүнд суралцагч зохих мэдлэг, ойлголт, ур чадвар, хандлагыг эзэмшсэн болохыг тодорхойлсон хөтөлбөр бөгөөд үнэлгээний янз бүрийн аргаар үнэлэгдэн, практикт батлагдсан байна. | Curriculum which indicates the knowledge, understanding, skills and attitudes that learners actually acquire as a result of teaching and learning, assessed through different means and/or demonstrated in practice. (UNESCO, 2013) |
| *Экспертийн үнэлгээ*<br><br>*Peer review / expert review*<br><br>*Экспертная оценка* | f\sp`rDA oa foinelekit | Эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээлийн чанар, үр дүнг сайжруулах зорилго бүхий үнэлгээ. | In academic publishing, the goal of peer review is to assess the quality of articles submitted for publication in a scholarly journal. (Budikina, 2017) |
| *Элсэлт*<br><br>*Enrolment/ Entry*<br><br>*Зачисление в образовательное учреждение / поступление* | flselda | Хувь хүн боловсролын тусгай хөтөлбөр, сургалтын үе шат эсвэл модульд нас үл харгалзан албан ёсоор бүртгүүлэх. Өөрөөр хэлбэл, сургалтын байгууллагаас (сургууль, коллеж гэх мэт) элсэгчдийг бүртгэн тэдний хичээлийн ирц болон оролцооны хэлбэрийг нь хянах үйл явц. Өмнөх мэдлэг, ур чадварыг нь хүлээн зөвшөөрсний үндсэн дээр сургалтыг эхлүүлэх үйл явц. | Individuals officially registered in a given educational programme, or stage or module thereof, regardless of age. In other words, it's Training providers' (school, colleges) processes for registering learners on courses and monitoring attendance or other forms of participation. It is a process to start the training on the basis of recognition of previous learning. (VETP-1, 2018) |

Э

| | | | |
|---|---|---|---|
| *Элсэлтийн бодлого*<br><br>*Admission policy*<br><br>*Политика приема/ зачисления/ вступления* | flselda iia Bdol)T | Сургалтын байгууллагын эрхэм зорилго, онцлогт нийцүүлэн сургалтын үйл ажиллагаа, элсэгчдэд тавигдах шаардлага, сонгон шалгаруулах арга зүйг тодорхойлсон цогц удирдамж. | A set of guidelines that each institution/faculty sets out regarding the features of the educational activities, the type of students it wishes to enroll, and the admission selection methods on the basis of its own missions and features. (NIAD-QE, 2016) |
| *Эндаумент*<br><br>*Endowment*<br><br>*Эндаумент* | fnde-oimmDA | Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, профессор багш, суралцагчдад боломж олгож, санхүүгийн олон талт эх үүсвэр бүрдүүлж, эрдмийн эрх чөлөөг хангаж өгдөг ач холбогдол бүхий санхүүжилтийн загвар. | The design of a financing model that ensures financial stability of tertiary education institutions, provides opportunities for professors and students, creating a diversified financial source, and providing academic freedom. (www.num.edu.mn, www.harvard.edu) |
| *Энтрепренер*<br><br>*Entrepreneur*<br><br>*Антрепренёр* | fnDrwprwnw* | Өөрийн хүсэл эрмэлзлийн дагуу сайн дураар аз туршиж, бүтээлчээр сэтгэж, шинэ зүйл санаачлан, эрсдэл хүлээхэд бэлэн, бие даан хувийн бизнес эрхлэгч. | An entrepreneur is an individual who runs a business voluntarily innovating and experimenting new ideas creatively assuming all the risks. (VETP, 2018) |

| | | | |
|---|---|---|---|
| *Эрдмийн зөвлөл*<br><br>*Academic Council / Academic board*<br><br>*Учёный совет* | frde^ oa Joib;e& | Эрдмийн зөвлөл нь тухайн салбарын мэргэжлийн удирдлагын дээд байгууллага. Эрдмийн зөвлөл нь салбарын сургалт, эрдэм шинжилгээ, уран бүтээл, нийгэмд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажлын үндсэн чиглэлийг тогтооход үйл ажиллагаагаа чиглүүлнэ. Эрдмийн зөвлөл нь дарга, орлогч дарга эрдэмтэн нарийн бичгийн дарга, төрөлжсөн хороодтой байна. | An academic council is the highest governing body of a sector. Academic Council's activities are focused to define the key directions of activities aimed to provide training, research, creative work and social services. The Academic Council consists of a chair and a deputy chair, and categorized committees. (Compilation of rules and regulations of higher education institutions, 2007) |
| *Эрсдэлийн менежмент*<br><br>*Risk management*<br><br>*Управление рисками* | frosde& oa MmmjmmDA | Болзошгүй эрсдэлийг тогтоох, дүн шинжилгээ хийх, хянах, үнэлэх, урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах үйл явц. | The identification, analysis, assessment, control and avoidance, minimization, or elimination of unacceptable risks. (VETP-1, 2018) |
| *Эрхэм зорилго*<br><br>*Mission*<br><br>*Миссия* | frk^ Joril)T | Дээд боловсролын байгууллагын сургалт, судалгааны үйл ажиллагаагаар дамжуулан хүний нөөцийн хөгжил болон нийгмийн хариуцлагаа хангах биелүүлэхийн тулд тавьж буй хэтийн зорилго. Эрхэм зорилгодоо үндэслэн алсын хараагаа тодорхойлж, | The ultimate purpose that all higher education institutions are expected to achieve according to the act, such as human resource development and contributions to society through education and research. Each educational institution articulates a vision based on the mission establishes verifiable, |

Э

| | | | |
|---|---|---|---|
| | | хэрэгжихүйц зорилт, төлөвлөгөөг боловсруулж, эдгээртэй уялдуулан сургалт, судалгааны болон бусад үйл ажиллагаар хэрэгжүүлдэг. Эрхэм зорилго, зорилго, зорилтоо тодорхойлох нь боловсролын б а й г у у л л а г ы н чанарыг тасралтгүй сайжруулахтай салшгүй холбоотой. Сургалтын байгууллага нь өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр дамжуулан сул болон давуу талдаа дүн шинжилгээ хийн чанараа сайжруулж байх шаардлагатай. | objectives and plans, and carries out its educational, research, and other activities accordingly. This articulation of mission, goals, and objectives is a given for the continual enhancement of quality in. educational institutions Institutions need to improve quality by analyzing their strengths and weaknesses through self-assessments and third-party evaluations. (NIAD-QE, 2016) |
| *Эшлэл*<br><br>*Citation*<br><br>*Цитата* | fsill& | Аливаа судалгаа, тайлан эсвэл төсөлт ажлыг бэлтгэхэд ашигласан эх сурвалжийг баримтжуулах, хүлээн зөвшөөрөх үйлдэл. Мөн баримтжуулалт гэж нэрлэдэг. Бүтэн эшлэл нь зохиогч, гарчиг, хэвлэгдсэн он болон бусад холбогдох мэдээллийг үнэн зөв жагсаан бичдэг. Мөн тухайн ажлын академик түвшнийг илтгэх бөгөөд уншигчид эх сурвалжтай гүнзгийрүүлэн танилцах боломж олгох мэдээллийн хэсэг юм. Эшлэлийн хэд хэдэн загвар, стандарт байдаг. | The act of acknowledging or documenting a reference source used in preparing a research, report or project. It is also described as documentation. A full citation lists accurate information about author, title, publication date and related facts. There are a number of different citation styles. (Noori, 2018) |

## Ю

| | | | |
|---|---|---|---|
| *Ю-мультиранк*<br><br>*U-multirank*<br><br>*Ю-Мультиранк* | Yoi - MoiliDiren! | Дээд боловсролын сургалтын байгууллагын чанар, чансааг олон хэмжээст үзүүлэлтээр хэрэглэгчдийн саналд тулгуурлан дүгнэдэг олон улсын эрэмбийн систем юм. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарыг үндсэн 5 үзүүлэлтээр харьцуулан эрэмбийг тогтоодог. Үүнд: 1) Сургалт, заах арга зүйн чанар 2) Судалгааны үр дүн, гүйцэтгэл 3) Мэдлэгийн шилжүүлэлт 4) Олон улсын харилцаа 5) Бүс нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр зэрэг багтана. Европын Холбооны улс орнууд ихэвчлэн хэрэглэдэг. | U-Multirank is a multidimensional, user-driven approach to international ranking of higher education institutions. It compares the performances of higher education institutions – in short: universities – in the five dimensions of university activity: (1) teaching and learning, (2) research, (3) knowledge transfer, (4) international orientation and (5) regional engagement. (www.umultirank.org) |

| Я | | | |
|---|---|---|---|
| *Явцын үнэлгээ*<br><br>*Formative assessment*<br><br>*Оценка (прогресса) приобретенных знаний и умений* | YeBCa iia foimelekit | Суралцагчийн сурлагын амжилтыг дээшлүүлэх үүднээс сургалтын явцад хийгддэг үнэлгээ бөгөөд одоогийн сурлагын амжилт болон хүрэхийг зорьсон түвшин хоорондын зөрүүг арилгахын тулд сурах үйл явцыг дүгнэх, санал зөвлөмж өгөх, тэдний үнэлгээ болон сургалтын үйл ажиллагаанд татан оролцуулахыг хэлнэ. | Assessment conducted throughout the educational process with a view to enhancing student learning. It implies: eliciting evidence about learning to close the gap between current and desired performance (so that action can be taken to close the gap); providing feedback to students; and involving students in the assessment and learning process. (UNESCO, 2013) |
| *Явцын шалгалт*<br><br>*Midterm exam*<br><br>*Промежуточный экзамен* | YeBCa iia SilgeIda | Сургалтын агуулгын хагасыг судалсны дараа тухайн хугацаанаас өмнө судалсан агуулгаар авдаг шалгалт. | An exam administered after half the academic term has passed, which cover all course material up until that point. (Glossary of terms in HE, 2016) |

## НОМ ЗҮЙ / BIBIOGRAPHY


Anthony J. Nitko, Susan M. Brookhart. (2007). *Educational Assessment of Students.* Virginia: Pearson Merrill Prentice Hall.

ANQA. (2016). *Glossary of Quality Assurance*. http://www.anqa.am: http://www.anqa.am/en/publications/glossary-of-quality-assurance/.

*AQF Glossary of Terminology.* (2013, January). www.aqf.edu.au: https://www.aqf.edu.au/sites/aqf/files/aqf_glossary_jan2013.pdf.

*Bologna Process.* (2009). Moskow: Исследовательский центр проблем качества подготовки специалистов.

Budikina. (2017). *American-focused dictionary of higher education.* Moskow: Flinta.

Davaadulam. (2010). *Glossary of concepts and terms in governance.* Ulaanbaatar.

EURODYCE. (2007). *European Glossary on Education: Decision-making, Advisory, Operational and Regulatory Bodies in Higher Education.* http://www.indire.it: http://www.indire.it/lucabas/lkmw_file/eurydice/Volume_5_EN.pdf.

INQAAHE. (2017). *Analytic Quality Glossary*. https://www.inqaahe.org: https://www.inqaahe.org/quality-glossary.

MECSS. (2006). *Их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрэм.* www.mecss.gov.mn: https://mecss.gov.mn/law/61/.

MECSS. (2007). *Compilation of rules and regulations of higher education institutions*. www.mecss.gov.mn: https://mecss.gov.mn/law/81/.

*Mongolia's Master Plan to develop Education in 2006-2015.* (2006). www.legalinfo.mn: https://www.legalinfo.mn/law/details/1988.

*Mongolia's Master plan to develop Science and Technology in 2007-2020.* (2007). www.legalinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/5604.

NIAD-QE. (2016). *Glossary of Quality Assurance in Japanese Higher Education.* Tokyo: http://www.niad.ac.jp.

Noori, A. (2018). *Glossary of research terms*. www.researchgate.net: https://www.researchgate.net/publication/324775202_Glossary_of_Research_Terms.

OECD. (2014). *The State of Higher Education .* Paris: OECD.

OECD. (2015). *Frascati Manual: Guidelines for Collecting and Reporting Data on Research and Experimental Development.* Paris: OECD Publishing.

Oxford. (2015). *International trends in Higher Education.* https://www.ox.ac.uk:

https://www.ox.ac.uk/sites/files/oxford/International%20Trends%20in%20Higher%20Education%202015.pdf.

Parliament, E. (2015). *Higher Education in the EU: Approaches, issues and trends.* http://www.europarl.europa.eu: http://www.europarl.europa.eu/EPRS/EPRS-IDA-554169-Higher-education-in-the-EU-FINAL.pdf.

Tayyeb Ali Khan, Nasira Jabeen. (2011). Tenure track system in higher education institutions of Pakistan: Prospects and challenges . *Educational Research and Reviews*, 605-621.

TESDA. (2017). *TVET glossary of terms.* Manila.

*The Law of Mongolia on Copyright and related rights.* (2006). www.legalinfo.mn: https://www.legalinfo.mn/law/details/283?lawid=283*The Law of Mongolia on Education.* (2002). www.legalinfo.mn: https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020

*The Law of Mongolia on Higher Education.* (2002). www.legalinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/251?lawid=251

*The Law of Mongolia on Innovation.* (2012). www.legalinfo.mn: https://www.legalinfo.mn/law/details/8668?lawid=8668

*The Law of Mongolia on Patent.* (2006). www.legalinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/440?lawid=440

*The Law of Mongolia on Science and Technology.* (2006). www.leaglinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/94?lawid=94

*The Law of Mongolia on Technology Transfer.* (1998). www.legalinfo.mn: https://www.legalinfo.mn/law/details/477?lawid=477

*The Law of Mongolia on Vocational Education and Training.* (2009). www.legalinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/376?lawid=376

UNESCO. (2009). *Trends in Global Higher Education: Tracking an Academic Revolution.* Paris: UNESCO.

UNESCO. (2010). *World Conference on Higher Education: final report.* https://unesdoc.unesco.org: https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000189242?posInSet=1&queryId=N-EXPLORE-92cbbd80-43d9-49fc-9a2f-4e11a204b8ae

UNESCO, G. E. (2017). *Accountability in Education: Meeting our commitments. .* Paris: UNESCO Publishing.

UNESCO, G. E. (2019). *Migration, displacement and education: building bridges, not walls.* Paris: UNESCO Publishing.

UNESCO, I. (2013). *Glossary of Curriculum Terminology.* Geneva: (UNESCO-IBE) .

UNESCO, IBE, IIEP, PEIC. (2015). *Safety, resilience, and Social Cohesion. Glossary of terms.* www.iiep.unesco.org: file:///C:/Users/user/Downloads/234806eng.pdf

UNESCO, ILO. (2016). *ILO/UNESCO Recommendation concerning the Status of Teachers (1966) and the UNESCO Recommendation concerning the Status of Higher Education Teaching Personnel (1997).* www.ilo.org : https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_dialogue/---sector/documents/normativeinstrument/wcms_493315.pdf

UNESCO-CEPES. (2007). *Quality Assurance and Accreditation: A Glossary of Basic Terms and Definitions.* Bucharest, Romanian.

UNESCO-UIS, OECD, EUROSTAT. (2018). *UOE data collection on formal education: Manual on concepts, definitions and classifications .* Montreal, Paris, Luxembourg.

VETP-1. (2018). *Mongolian-English Glossary of Terminologies Technical, Vocational Education and Training.* Ulaanbaatar.

Watt, C. M. (1999). *Academic keywords: A Devil's Dictionary for Higher Education.* New York: Routledge.

Wiki. (2019). *Wikipedia*. www.wikipedia.org: https://en.wikipedia.org/wiki/Bologna_Process.

Worldbank. (2012). *Skills, Not Just Diplomas: Managing Education for Results in Eastern Europe and Central Asia.* www.worldbank.org: http://documents.worldbank.org/curated/en/281131468337867775/pdf/652050REPLACEM061562B09780821380963.pdf.

АМБЧБУТ. (2016). *Чанарын баталгаажуулалтын нэр томьёоны тайлбар толь.* www.anqa.am: http://www.anqa.am/en/publications/glossary-of-quality-assurance/

*Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль.* (2018). www.legalinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/13532?lawid=13532

Батсайхан, Б., Дэлгэржав, М. (2019). *Боловсрол судлалын тайлбар толь.* Улаанбаатар: "Соёмбо принтинг" ХХК.

*Боловсролын тухай хууль.* (2002). www.legalinfo.mn : https://www.legalinfo.mn/law/details/9020?lawid=9020

БСШУСЯ. (2006 оны 12 29). *Их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрэм.* www.mecss.gov.mn : https://mecss.gov.mn/law/61/

БСШУСЯ. (2015). *Дээд боловсролын салбарт хэрэглэгдэх хууль, тогтоол, тушаал, шийдвэрийн эмхэтгэл.* Улаанбаатар: МУИС-ийн Хэвлэх үйлдвэр.

Ванчигсүрэн, Д., Энхтүвшин, Б. (1994). *Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь.* Улаанбаатар .

Европын сургалтын сан, БСШУСЯ, Боловсролын хүрээлэн. (2002). *Хөдөлмөрийн зах зээл, сургалтын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн холбогдолтой нэр томьёоны толь.* Улаанбаатар: Албан бус боловсролын төвийн хэвлэх үйлдвэр.

Лханям, Л., Цээпил, С., Баатар,С. (2011). *Мэргэшлийн түвшний тогтолцоо, мэргэжлийн боловсрол сургалтын нэр томъёоны тайлбар толь.* Улаанбаатар.

Мөнххуяг, Ц. (2017). *Мэргэжил, Боловсрол, Сургалт, UNESCO-UNEVOC товч тайлбар толь.* Улаанбаатар.

Ууганбаяр, Н. (2018). *Боловсрол судлалын чиглэлээр олон улсын сэтгүүлд судалгааны ажил хэвлүүлэх, хэвлүүлсэн ажлыг үнэлэх.* Улаанбаатар.

ХСИС. (2015). *Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандарт.* www.leu.gov.mn: http://resource3.sodonvision.com/lawuniversity/file/2018/4/f26x62gabyxonggz2rj0j5urf/baiguullagin%20standard.pdf.

ЮНЕСКО. (2012). *Парижская декларация.* www.unesdoc.unesco.org: https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000246687_rus.

www.elsevier.com

www.springer.com

www.taylorandfrancis.com

## ХАВСРАЛТ. ДЭЭД БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ДЭЛХИЙН НЭР ХҮНДТЭЙ СЭТГҮҮЛИЙН МЭДЭЭЛЭЛ / LIST OF JOURNALS IN HIGHER EDUCATION STUDIES

| Сэтгүүлийн нэр | ISSN (print) | Хэвлэгдэж эхэлсэн он | Хэвлэгч |
|---|---|---|---|
| Accreditation and Quality Assurance | 0949-1775 | 1996 | Springer, New York LLC |
| Active Learning in Higher Education | 1469-7874 | 2000 | SAGE Publications, USA |
| Art, Design & Communication in Higher Education | 1474-273X | 2002 | Intellect Ltd. |
| Arts and Humanities in Higher Education | 1474-0222 | 2002 | SAGE Publications Inc. |
| Assessment & Evaluation in Higher Education | 0260-2938 | 1975 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., USA |
| Christian Higher Education | 1536-3759 | 2002 | Taylor & Francis |
| Comparative Education | 0305-0068 | 1964 | Carfax Publishing Ltd. |
| Diversity in Higher Education | 1479-3644 | 2008 | Emerald Group Publishing Ltd. |
| Educational Philosophy and Theory | 0013-1857 | 1969 | Taylor & Francis |
| Educational Psychology in Practice | 0266-7363 | 2000 | Routledge |
| Educational Research for Policy and Practice | 1570-2081 | 2007 | Kluwer Academic Publishers |
| Educational Research Review | 1747-938X | 2006 | Elsevier BV |
| Educational Researcher | 0013-189X | 1972 | SAGE Publications Inc. |
| Educational Technology Research and Development | 10421629 | 1953 | Springer, New York LLC |
| Educational Theory | 1741-5446 (online) | 1951 | Wiley-Blackwell |
| European Journal of Education | 0141-8211 | 2015 | Blackwell Publishing Inc. |
| Higher Education in Europe | 0379-7724 | 1976 | Taylor & Francis |
| Higher Education Pedagogies | 2375 2696 | 2001 | Taylor and Francis Ltd. |

| | | | |
|---|---|---|---|
| Higher Education Policy | 0952-8733 | 1988 | Palgrave Macmillan Ltd. England |
| Higher Education Quarterly | 0951-5224 | 1947 | Basil Blackwell |
| Higher Education Research and Development | 0729-4360 | 1982 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., Australia |
| Higher Education, Skills and Work-based Learning | 2042-3896 | 2010 | Emerald Group Publishing Ltd |
| Higher education: The International Journal of Higher Education and Educational Planning | 0018-1560 | 1972 | Springer, Netherlands |
| Industry and Higher Education | 0950-4222 | 1987 | IP Publishing Ltd, UK |
| Innovations in Education and Teaching International | 1470-3297 | 1964 | Routledge |
| Innovative Higher Education | 0742-5627 | 1976 | Springer, Netherlands |
| International Journal of African Higher Education | 2313-5069 | 2014 | International Network for Higher Education in Africa (INHEA) |
| International Journal of Educational Development | 0738-0593 | 1981 | Elsevier BV |
| International Journal of Educational Management | 0951-354X | 1987 | Emerald Group Publishing Ltd. |
| International Journal of Educational Research | 0883-0355 | 1986 | Elsevier Ltd. |
| International Journal of Educational Technology in Higher Education | 2365-9440 (online) | 2010 | Springer, Netherlands |
| International Journal of Learning in Higher Education | 2327-7955 | 2004 | Common Ground Research Networks |
| International Journal of Lifelong Education | 0260-1370 | 1982 | Taylor & Francis |
| International Journal of Sustainability in Higher Education | 1467-6370 | 2000 | Emerald Group Publishing Ltd., |

| | | | |
|---|---|---|---|
| Journal of Applied Research in Higher Education | 1758-1184 | 2009 | Emerald Group Publishing Ltd., |
| Journal of College Student Development | 0897-5264 | 1959 | The Johns Hopkins University Press, USA |
| Journal of Computing in Higher Education | 1042-1726 | 1989 | Springer, USA |
| Journal of Continuing Higher Education | 0737-7363 | 1978 | Routledge |
| Journal of Diversity in Higher Education | 1938-8926 | 2005 | American Psychological Association, USA |
| Journal of Further and Higher Education | 0309-877X | 1977 | Routledge |
| Journal of Geography in Higher Education | 0309-8265 | 1999 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., Eng. |
| Journal of Higher Education | 0022-1546 | 1930 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., USA |
| Journal of higher education in Africa/Revue de l'enseignement superieur en Afrique | 0851-7762 | 2010 | Codesria, Senegal |
| Journal of Higher Education Outreach and Engagement | 1534-6102 | 1996 | University of Georgia |
| Journal of Higher Education Policy and Management | 1360-080X | 1979 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., England |
| Journal of Hispanic Higher Education | 1538-1927 | 2002 | SAGE Publications |
| Journal of Marketing for Higher Education | 0884-1241 | 1988 | Haworth Press Inc. |
| Journal of the European Higher Education Area | 2192-0109 | 2011 | Raabe Fachverlag fur Wissenschaftsinformation, Germany |
| NASPA Journal About Women in Higher Education | 1940-7882 | 2008 | Taylor & Francis |
| Perspectives: Policy and Practice in Higher Education | 1360-3108 | 1997 | Routledge |
| Policy Futures in Education | 1478-2103 | 2003 | Symposium Journals Ltd., |

| | | | |
|---|---|---|---|
| Quality Assurance in Education | 0968-4883 | 1993 | Emerald Group Publishing Ltd. |
| Quality in Higher Education | 1353-8322 | 1995 | Carfax Publishing Ltd. |
| Research in Comparative and International Education | 1745-4999 | 2006 | Symposium Journals Ltd., |
| Research in Higher Education | 0361-0365 | 1973 | Springer, Netherlands |
| Research Papers in Education | 0267-1522 | 1986 | Taylor & Francis |
| Review of Higher Education | 0162-5748 | 1977 | The Johns Hopkins University Press, USA |
| Review of Research in Education | 0091-732X | 1973 | SAGE Publications |
| Scandinavian Journal of Educational Research | 0031-3831 | 1957 | Carfax Publishing Ltd. |
| Studies in Educational Ethnography | 1529-210X | 1999 | Emerald Group Publishing Ltd. |
| Studies in Educational Evaluation | 0191-491X | 1975 | Elsevier Ltd. |
| Studies in Higher Education | 0307-5079 | 1976 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., England |
| Teaching Education | 1047-6210 | 1975 | Routledge |
| Teaching in Higher Education | 1356-2517 | 1996 | Routledge Journals, Taylors&Francis Ltd., USA |
| Tertiary Education and Management | 1358-3883 | 1995 | Taylor & Francis |
| The ABNF journal : official journal of the Association of Black Nursing Faculty in Higher Education, Inc | 1046-7041 | 1990 | Tucker Publications Inc. |
| The Tnternet and Higher Education | 1096-7516 | 1998 | Elsevier Science inc, USA |
| Theory and Research in Education | 1477-8785 | 2003 | SAGE Publications |

## АГУУЛГА/ CONTENTS

Өмнөх үг / Foreword ....4

Товчилсон үг / Acronyms ....6

Дээд боловсролын нэр томьёоны товч тайлбар / Higher education terms

А ....11
Б ....22
В ....48
Г ....49
Д ....53
Е ....67
Ж ....71
З ....73
И ....76
К ....79
Л ....80
М ....81
Н ....100
О ....106
Ө ....113
П ....116
С ....117
Т ....165
У ....182
Ү ....186
Ф ....200
Х ....201
Ц ....222
Ч ....223
Ш ....237
Э ....243
Ю ....248
Я ....249

Ном зүй / Bibliography ....250

Хавсралт / Appendix ....256

Нэр томьёоны лавлагаа / References of terms....259

# МОНГОЛ НЭР ТОМЬЁОНЫ ЛАВЛАГАА


**А**

| | |
|---|---|
| *Авьяас* | *11* |
| *Авьяастай суралцагч* | *11* |
| *Агуулгын стандарт* | *11* |
| *Ажил хайгч* | *12* |
| *Ажил, мэргэжлийн дэмжлэг* | *12* |
| *Ажил, мэргэжлийн чадвар* | *12* |
| *Ажил, мэргэжлийн чиг баримжаа ба зөвлөгөө өгөх үйлчилгээ* | *13* |
| *Ажилгүй иргэн* | *14* |
| *Ажилгүйдлийн ангилал* | *14* |
| *Академик эрх чөлөө* | *14* |
| *Албан боловсрол* | *14* |
| *Албан бус боловсрол* | *14* |
| *Албан сургалтын хөтөлбөр* | *15* |
| *Амжилтгүй төгсөлт* | *15* |
| *Амьдрах орчин, туршлагаас суралцахуй /Албан бус боловсрол* | *15* |
| *Амьдрах чадвар, ухаан* | *16* |
| *Анги, танхимд хийгдэх үнэлгээ* | *17* |
| *Ангийн багшийн тогтолцоо* | *17* |
| *Ангилал* | *18* |
| *АНУ-ын анагаахын сургуулийн элсэлтийн шалгалт* | *18* |
| *Асуудал шийдвэрлэх үйл явц* | *18* |
| *Асуудалд суурилсан сургалт* | *19* |
| *Аудит* | *20* |
| *Ахисан түвшний сургууль* | *20* |
| *Ахисан түвшний хөтөлбөр* | *20* |
| *Ачаалал* | *20* |
| *Ашигтай загвар* | *21* |
| *Ашигтай загварын гэрчилгээ* | *21* |

**Б**

| | |
|---|---|
| *Багаар ажиллах* | *22* |
| *Багаар багшлах үйл ажиллагаа* | *22* |
| *Багц цаг* | *22* |
| *Багш бэлтгэх тогтолцоо* | *23* |
| *Багш нарын зөвлөл* | *23* |
| *Багшийг үнэлэх оюутны үнэлгээ* | *24* |
| *Багшийн ажлын гүйцэтгэл* | *25* |
| *Багшийн ёс зүйн зөрчил* | *25* |
| *Багшийн мэргэжлийн ёс зүй* | *25* |
| *Багшийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ* | *25* |
| *Багшийн хөгжил* | *26* |
| *Багшийн хөгжлийн төв* | *26* |
| *Багшлах бүрэлдэхүүн* | *26* |
| *Багшлахуй* | *27* |
| *Байгууллага хоорондын жишиг үнэлгээ* | *27* |
| *Байгууллагын аудит, хяналт* | *28* |
| *Байгууллагын магадлан итгэмжлэл* | *28* |
| *Байгууллагын судалгаа* | *28* |
| *Байгууллагын үнэлгээ* | *29* |
| *Бакалаврын зэрэг* | *29* |
| *Бакалаврын хөтөлбөр* | *29* |
| *Баримт бичгийн шинжилгээ* | *30* |
| *Баримт нотолгоо хэрэглэх соёл* | *30* |
| *Баталгаажилт* | *31* |
| *Баталгаажуулалт* | *31* |
| *Блумын таксономи* | *31* |
| *Бодит суралцахуй* | *33* |
| *Бодит үнэлгээ (дүгнэлт)* | *33* |
| *Бодлогын шинжилгээ* | *34* |
| *Боловсрол* | *34* |
| *Боловсролын үр ашиг* | *35* |
| *Боловсролын агуулга* | *35* |
| *Боловсролын зэрэг* | *36* |
| *Боловсролын зэрэг, агуулгыг хүлээн зөвшөөрөх* | *36* |
| *Боловсролын нээлттэй эх материал* | *36* |
| *Боловсролын олон улсын стандарт ангилал (БОУСА)* | *37* |
| *Боловсролын салбарын мэдээллийн систем* | *38* |
| *Боловсролын стандарт* | *38* |
| *Боловсролын түвшин* | *39* |
| *Боловсролын үр өгөөж* | *40* |
| *Болоны тунхаглал* | *40* |
| *Болоны үйл явц* | *41* |
| *Босго* | *41* |
| *Брейнсторминг* | *41* |
| *Буцалтгүй тусламж* | *42* |
| *Бүрэлдэхүүн сургуулийн захирал* | *42* |
| *Бүрэлдэхүүн сургууль* | *43* |
| *Бүс нутгийн магадлан итгэмжлэл* | *43* |
| *Бүтцийн сургууль* | *43* |
| *Бүтээгдэхүүний загвар* | *44* |

| | |
|---|---|
| Бүтээлийн сангийн үнэлгээ | 44 |
| Бүтээлийн хуулбарлалт | 44 |
| Бүтээлийн чөлөө | 45 |
| Бүтээлч байдал, бүтээлч сэтгэлгээ | 45 |
| Бүх нийтийн боловсрол (БНБ) | 47 |
| **В** | |
| Виртуал их сургууль | 48 |
| **Г** | |
| Гарааны бизнес | 49 |
| Гарааны компани | 49 |
| Гарц / үр дүн | 49 |
| Голч дүн | 50 |
| Гуравдагч талын үнэлгээ | 51 |
| Гүйцэтгэлийн стандарт | 51 |
| Гүйцэтгэлийн үзүүлэлт | 51 |
| Гүйцэтгэлийн үнэлгээ | 52 |
| Гүйцэтгэлийн шалгуур | 52 |
| Гэрчилгээжүүлэлт | 52 |
| **Д** | |
| Давтан суралцагч | 53 |
| Дагалдан сургалт | 53 |
| Дадлагажих сургалт | 54 |
| Даяаршил | 54 |
| Дидактик | 54 |
| Диплом | 55 |
| Дипломын хавсралт | 56 |
| Диссертац | 56 |
| Докторант | 56 |
| Докторын дараах судлаач | 56 |
| Докторын сургалтын хөтөлбөр | 56 |
| Дүгнэх үнэлгээ | 57 |
| Дүнгийн тодорхойлолт | 57 |
| Дэлхийн иргэний боловсрол | 57 |
| Дэлхийн ур чадварын тэмцээн | 58 |
| Дээд боловсрол | 58 |
| Дээд боловсролын интернациональчлал | 60 |
| Дээд боловсролын салбар | 61 |
| Дээд боловсролын стратеги | 62 |
| Дээд боловсролын сургалтын байгууллага | 62 |
| Дээд боловсролын сургалтын байгууллагын засаглал | 63 |
| Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансаа | 64 |
| Дээд эрэмбийн сэтгэлгээ | 67 |
| **Е** | |
| Европын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллагуудын бүртгэл | 67 |
| Европын мэргэшлийн хүрээ (шаталсан бүтэц) | 69 |
| Европын холбооны кредит шилжүүлэх, тооцох тогтолцоо | 69 |
| Ерөнхий боловсрол | 70 |
| Ерөнхий санааны зураглал | 70 |
| **Ж** | |
| Жендерийн тэгш байдал | 71 |
| Жишиг өгөгдөл | 71 |
| Жишиг үзүүлэлт (магадлан итгэмжлэл) | 72 |
| Жишиг харьцуулалт | 72 |
| **З** | |
| Зайны сургалт | 73 |
| Зайны сургалтын хөтөлбөр | 73 |
| Залгамж хичээл | 73 |
| Засан сайжруулах үйл ажиллагаа | 73 |
| Захиргааны зөвлөл | 74 |
| Зорилго | 74 |
| Зохиогч | 74 |
| Зочин профессор | 74 |
| Зөвлөгөө (хөтөлбөрт) | 74 |
| Зөвлөх багш | 75 |
| Зөөлөн чадвар | 75 |
| Зэрэг олгох журам | 76 |
| **И** | |
| Идэвхтэй суралцахуй | 76 |
| Импакт фактор | 77 |
| Инновац | 77 |
| Инновацын тогтолцоо | 78 |
| Их сургууль | 78 |
| **К** | |
| Компьютерын загварчлал | 79 |
| **Л** | |
| Лаборатори | 80 |
| Лабораторийн ажил | 80 |
| Лайкертын шкал | 80 |
| Лекц | 80 |
| Либерал арт боловсрол | 81 |
| **М** | |
| Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр | 81 |
| Магадлан итгэмжлэл | 81 |

| | |
|---|---|
| Магадлан итгэмжлэлийн мэдээллийн сан | 83 |
| Магадлан итгэмжлэлийн статус | 83 |
| Магадлан итгэмжлэлийн судалгаа | 84 |
| Магадлан итгэмжлэлийн хүчинтэй хугацаа | 84 |
| Магадлан итгэмжлэх байгууллага | 85 |
| Магистрант | 86 |
| Магистрын сургалтын  хөтөлбөр | 86 |
| Ментор | 86 |
| Мета – үнэлгээ | 87 |
| Модулийн тодорхойлолт | 87 |
| Модуль | 87 |
| Мэдлэг | 87 |
| Мэдлэгт суурилсан  нийгэм | 88 |
| Мэдлэгт суурилсан эдийн засаг | 88 |
| Мэдээллийн сан | 89 |
| Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ) | 90 |
| Мэдээлэл, харилцаа, холбооны технологийн чадвар | 90 |
| Мэргэжлийн багшлах бүрэлдэхүүн | 91 |
| Мэргэжлийн боловсрол | 91 |
| Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС) | 92 |
| Мэргэжлийн ёс зүйн код (чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлд) | 92 |
| Мэргэжлийн зэрэг олгох хөтөлбөр | 93 |
| Мэргэжлийн сургалтын коллеж | 93 |
| Мэргэжлийн суурь чадвар | 93 |
| Мэргэжлийн түвшнийг хүлээн зөвшөөрөх | 93 |
| Мэргэжлийн үндсэн ур чадвар | 94 |
| Мэргэжлийн хандлага | 94 |
| Мэргэжлийн хөтөлбөр | 94 |
| Мэргэжлийн чадамж | 96 |
| Мэргэшил | 96 |
| Мэргэшил олгох байгууллага | 97 |
| Мэргэшлийн түвшний тодорхойлогч | 97 |
| Мэргэшлийн үндэсний хүрээ (шаталсан бүтэц) | 98 |
| Мэргэлийн багш | 99 |
| **Н** | |
| Насан туршийн боловсрол | 100 |
| Насанд хүрэгчдийн боловсрол | 100 |
| Нийгэм-сэтгэл хөдлөлийн суралцахуй | 101 |
| Нийтийг хамарсан нээлттэй цахим хичээл | 102 |
| Нийцэл | 102 |
| Ногоон ур чадвар | 102 |
| Ном зүй | 103 |
| Нормд харьцуулсан үнэлгээ | 103 |
| Ноу-хау | 103 |
| Нэг сэдэвт бүтээл | 103 |
| Нээлттэй боловсрол | 104 |
| Нээлттэй их сургууль | 105 |
| Нээлттэй хичээл | 105 |
| **О** | |
| Олон улсын жишиг үнэлгээ | 106 |
| Олон улсын их сургууль | 107 |
| Олон хэлний боловсрол | 108 |
| Оношлох үнэлгээ | 108 |
| Оролцогч тал | 109 |
| ОУСҮХ (Олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр) | 109 |
| Оюуны шилжих хөдөлгөөн | 110 |
| Оюутан | 110 |
| Оюутан солилцооны хөтөлбөр | 110 |
| Оюутанд чиглэсэн дэмжлэг | 111 |
| Оюутны судалгаа | 111 |
| Оюутны суралцахуйн үр дүнгийн үнэлгээ | 112 |
| Оюутны үнэлгээ | 112 |
| **Ө** | |
| Өгөгдлийн шинжилгээ | 113 |
| Өгөгдөл | 113 |
| Өгөгдөл цуглуулга | 114 |
| Өмнөх мэдлэгийг хүлээн зөвшөөрөх | 114 |
| Өөрийн үнэлгээ | 114 |
| Өөрийн үнэлгээний баг | 114 |
| Өөрийн үнэлгээний тайлан | 115 |
| Өөрийн үнэлгээний удирдамж | 115 |
| Өргөжин тэлэх сургалтын хөтөлбөр | 115 |
| **П** | |
| Парадигм | 116 |
| Патент | 116 |
| Патент, гэрчилгээ эзэмшигч | 117 |
| **С** | |
| Сайжруулалт | 117 |
| Сайн засаглал | 117 |
| Сайн сайхан байдал (сургалтын байгууллагын) | 118 |

| | |
|---|---|
| *Салбар нэгж* | *119* |
| *Салбар хоорондын хамтын ажиллагаа* | *119* |
| *Салбар хоорондын арга хандлага* | *119* |
| *Санал, зөвлөмж* | *120* |
| *Санхүүгийн дэмжлэг* | *120* |
| *Сахилгын журам* | *120* |
| *СВОТ шинжилгээ* | *121* |
| *Семестр* | *122* |
| *Семинар* | *122* |
| *Силлабус* | *122* |
| *Соёл хоорондын харилцан ойлголцол* | *123* |
| *Соёлын мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр* | *123* |
| *Соёлын мэдрэмжтэй сурган хүмүүжүүлэх зүй* | *124* |
| *Соёлын хэм хэмжээ* | *124* |
| *Сонгон судлах сургалтын хөтөлбөр* | *124* |
| *Сонгон судлах хичээл* | *125* |
| *Сорил* | *125* |
| *Сорилын даалгаврын сан* | *125* |
| *Стандарт* | *125* |
| *Судалгаа шинжилгээний ажлын үр дүн* | *128* |
| *Судалгаа, хөгжүүлэлт* | *128* |
| *Судалгаанд суурилсан сургалт* | *129* |
| *Судалгааны ажил* | *130* |
| *Судалгааны ажлын зөвлөх* | *130* |
| *Судалгааны ажлын удирдагч* | *131* |
| *Судалгааны их сургууль* | *131* |
| *Судалгааны тайлан* | *131* |
| *Судалгааны төсөл* | *131* |
| *Судалгааны туслах ажилтан ажиллуулах тогтолцоо* | *132* |
| *Судалгааны тэтгэлэг* | *132* |
| *Судлаач* | *132* |
| *Суралцагчийн тэтгэлэг* | *132* |
| *Суралцагчийн ялгаатай байдалд тулгуурласан заах аргазүй* | *133* |
| *Суралцах боломж* | *133* |
| *Суралцахуй* | *133* |
| *Суралцахуйг удирдан чиглүүлэх загвар* | *134* |
| *Суралцахуйд зарцуулах хугацаа* | *135* |
| *Суралцахуйн арга туршлага* | *136* |
| *Суралцахуйн ахиц* | *136* |
| *Суралцахуйн дамжуулалт* | *137* |
| *Суралцахуйн дөрвөн тулгуурт суурилсан сургалтын хөтөлбөр* | *138* |
| *Суралцахуйн дэмжлэг* | *139* |
| *Суралцахуйн интерактив арга* | *139* |
| *Суралцахуйн орчин* | *139* |
| *Суралцахуйн удирдлага* | *140* |
| *Суралцахуйн үндсэн хэрэгцээ* | *140* |
| *Суралцахуйн үнэлгээ* | *141* |
| *Суралцахуйн үр дүн* | *141* |
| *Суралцахуйн хэв маяг* | *142* |
| *Сурах бичиг* | *143* |
| *Сурахын тулд суралцах* | *144* |
| *Сургагч* | *145* |
| *Сургалтын агуулга* | *145* |
| *Сургалтын багц цагийн бүрдэл* | *146* |
| *Сургалтын далд хөтөлбөр* | *146* |
| *Сургалтын зээл* | *146* |
| *Сургалтын нөөц* | *147* |
| *Сургалтын төлбөр* | *147* |
| *Сургалтын төлбөрөөс чөлөөлөх* | *148* |
| *Сургалтын төлөвлөгөө* | *148* |
| *Сургалтын уртасгасан цаг* | *148* |
| *Сургалтын үр дүнгийн баталгаажуулалт* | *148* |
| *Сургалтын хөтөлбөр* | *149* |
| *Сургалтын хөтөлбөр судлал* | *149* |
| *Сургалтын хөтөлбөрийн зорилго* | *150* |
| *Сургалтын хөтөлбөрийн төлөвлөлт* | *150* |
| *Сургалтын хөтөлбөрийн ач холбогдолтой байдал* | *151* |
| *Сургалтын хөтөлбөрийн бодлого* | *151* |
| *Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт* | *152* |
| *Сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн* | *152* |
| *Сургалтын хөтөлбөрийн бүтэц* | *152* |
| *Сургалтын хөтөлбөрийн загвар* | *153* |
| *Сургалтын хөтөлбөрийн зорилт* | *153* |
| *Сургалтын хөтөлбөрийн зураглал* | *154* |
| *Сургалтын хөтөлбөрийн интеграци* | *154* |
| *Сургалтын хөтөлбөрийн нийцэл* | *155* |
| *Сургалтын хөтөлбөрийн тохируулга* | *155* |
| *Сургалтын хөтөлбөрийн нутагшуулалт* | *155* |
| *Сургалтын хөтөлбөрийн удирдамж* | *156* |
| *Сургалтын хөтөлбөрийн үндсэн үе шат* | *156* |

| | |
|---|---|
| *Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ* | *157* |
| *Сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ* | *157* |
| *Сургалтын хөтөлбөрийн хэвтээ, босоо бүтэц* | *158* |
| *Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт* | *159* |
| *Сургалтын хөтөлбөрийн хяналт, шинжилгээ* | *159* |
| *Сургалтын хөтөлбөрийн чиг хандлага* | *160* |
| *Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл* | *160* |
| *Сургалтын хөтөлбөрийн элементүүд хоорондын уялдаа холбоо* | *161* |
| *Сургалтын хөтөлбөрийн ялгаатай байдал* | *161* |
| *Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх цикл* | *161* |
| *Сургалтын хэлбэр* | *162* |
| *Сургалтын цөм хөтөлбөр* | *162* |
| *Сургуулийн зураглал* | *162* |
| *Суурь судалгаа* | *163* |
| *Суурь чадвар* | *163* |
| *Сэдэвчилсэн үнэлгээ* | *164* |
| *Сэтгэл хөдлөлөө таних, удирдах* | *164* |
| **Т** | |
| *Танин мэдэхүйн хүрээний тархи судлал* | *165* |
| *Танин мэдэхүйн чадамж* | *165* |
| *Танин мэдэхүйн шинжлэх ухаан* | *165* |
| *Тархи судлал* | *166* |
| *Технологи* | *166* |
| *Технологиор дэмжигдсэн сургалт* | *166* |
| *Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)* | *168* |
| *Тогтолцоо* | *168* |
| *Төгс байдал* | *169* |
| *Төгсөгч* | *169* |
| *Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)* | *169* |
| *Төрийн албаны зөвлөл* | *171* |
| *Төрийн бус өмчийн сургалтын байгууллага* | *171* |
| *Төрийн өмчийн сургалтын байгууллагын санхүүжилт* | *172* |
| *Төсөлд суурилсан сургалт* | *172* |
| *Тулгамдаж буй асуудал* | *173* |
| *Туршилт, боловсруулалтын ажил* | *173* |
| *Тусгай зөвшөөрөл* | *174* |
| *Тусгай магадлан итгэмжлэл* | *175* |
| *Тусгай сургалтын хөтөлбөр* | *175* |
| *Тусгай хэрэгцээт боловсрол* | *175* |
| *Тусгай хэрэгцээт интеграци сургалт* | *176* |
| *Туслах ажилтан* | *176* |
| *Туслах багшийн тогтолцоо* | *177* |
| *Түвшний тодорхойлогч* | *177* |
| *Түүхэн судалгаа* | *178* |
| *Тэгш байдал* | *178* |
| *Тэгш боломж* | *179* |
| *Тэгш хамран сургах боловсрол (ялгаатай хэрэгцээнд суурилсан боловсрол)* | *180* |
| *Тэгш хамран сургах сургалтын хөтөлбөр (ялгаатай хэрэгцээнд суурилсан сургалтын хөтөлбөр)* | *181* |
| *Тэнхим* | *181* |
| *Тэргүүн туршлага* | *181* |
| *Тэтгэлэг* | *182* |
| **У** | |
| *Удирдлагын аудит* | *182* |
| *Ур чадвар* | *182* |
| *Ур чадварын хөрвөлт* | *183* |
| *Ур чадварын шинжилгээ* | *183* |
| *Урьдчилсан магадлан итгэмжлэл* | *184* |
| *Урьдчилсан үнэлгээ* | *184* |
| *Утга учиртай суралцахуй* | *184* |
| *Уян хатан сургалт* | *185* |
| **Ү** | |
| *Үе тэнгийнхний багшлах үйл ажиллагаа* | *186* |
| *Үе тэнгийнхний үнэлгээ* | *186* |
| *Үе тэнгийнхнээс суралцах* | *186* |
| *Үзүүлэлт* | *186* |
| *Үйлдвэрлэлийн дадлага* | *188* |
| *Үйлчилгээний төлбөр* | *188* |
| *Үл алагчлах /шударга байх зарчим* | *189* |
| *Үндсэн (мэргэжлийн) хичээл* | *189* |
| *Үндсэн /суурь хичээл* | *189* |
| *Үндсэн чадамж* | *189* |
| *Үндэслэл* | *191* |
| *Үнэлгээ* | *191* |
| *Үнэлгээ* | *192* |
| *Үнэлгээний бодлого* | *192* |
| *Үнэлгээний гарын авлага* | *193* |
| *Үнэлгээний рубрик* | *193* |
| *Үнэлгээний сорил* | *194* |

| | |
|---|---|
| Үнэлгээний тайлан | 194 |
| Үнэлгээний тогтолцоо | 195 |
| Үнэлгээний хянан зохицуулалт | 196 |
| Үнэлгээний шинжээч | 196 |
| Үнэт зүйлс | 197 |
| Үр дүн | 197 |
| Үр дүнгийн үнэлгээ(хүрэх) | 198 |
| Үр дүнгийн үнэлгээ(хүрсэн) | 199 |
| Үр дүнд суурилсан боловсрол | 199 |
| **Ф** | |
| Фраскатийн удирдамж | 200 |
| **Х** | |
| Хавсарга (хэрэглээний) судалгаа | 200 |
| Хавсарга хичээл | 201 |
| Халамжлан зөвлөх үйл ажиллагаа / Менторын үйлчилгээ | 201 |
| Хамтарсан зэрэг | 202 |
| Хамтарсан хөтөлбөр | 202 |
| Хамтран суралцахуй | 203 |
| Хандлага | 203 |
| Харилцан хүлээн зөвшөөрөх | 203 |
| Харилцах хугацаа | 204 |
| Хиймэл оюун ухаан | 204 |
| Хичээл | 204 |
| Хичээл дундын хандлага | 204 |
| Хичээл хоорондын уялдааг хангах хандлага | 205 |
| Хичээл хоорондын уялдааг хангах хандлага | 205 |
| Хичээлийн жил | 205 |
| Хичээлийн төлөвлөгөө | 206 |
| Хичээлийн түвшний жишиг харьцуулалт | 206 |
| Хичээлийн хуваарь | 207 |
| Хичээлээс гадуурх үйл ажиллагаа | 207 |
| Холимог сургалт | 207 |
| Хорин нэгдүгээр зууны чадвар | 208 |
| Хос хөтөлбөр | 209 |
| Хос диплом | 209 |
| Хос зэрэг | 210 |
| Хос хэлний боловсрол | 210 |
| Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч | 211 |
| Хөгжүүлэх сургалтын хөтөлбөр | 211 |
| Хөдөлгөөнт суралцахуй | 211 |
| Хөдөлмөр эрхлэлт | 212 |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 212 |
| Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр | 212 |
| Хөдөлмөр эрхлэлтийн түвшин | 212 |
| Хөдөлмөр эрхлэх боломж | 213 |
| Хөдөлмөрийн зах зээл | 213 |
| Хөндлөнгийн үнэлгээ | 213 |
| Хөрвөх чадвар | 214 |
| Хөтөч судлагдахуун | 214 |
| Хувь хүнд тохирсон сургалт | 214 |
| Хувь хүний мэргэшлийн үнэлгээ | 215 |
| Хураангуй | 215 |
| Хуурмаг боловсролын зэрэг олгогч | 216 |
| Хуурмаг магадлан итгэмжлэл олгогч | 216 |
| Хүлээн зөвшөөрөх үйл явц | 216 |
| Хүний нөөцийн хөгжил | 218 |
| Хүрэх зорилт | 219 |
| Хүчинтэй байдлын баталгаажуулалт | 219 |
| Хэмжигдэхүйц үр дүн | 220 |
| Хэрэгжсэн сургалтын хөтөлбөр | 221 |
| Хяналт шинжилгээ | 221 |
| **Ц** | |
| Цахим сургалт | 222 |
| Цахим үнэлгээ буюу мэдээллийн технологид суурилсан үнэлгээ | 222 |
| Цэвэр суурь судалгаа | 223 |
| **Ч** | |
| Чадамж | 223 |
| Чадамжид суурилсан боловсрол, сургалт | 225 |
| Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр | 225 |
| Чанар (зорилгод тэмүүлсэн хандлага) | 225 |
| Чанар (сайжруулах, хөгжүүлэхэд чиглэсэн хандлага) | 226 |
| Чанар (сургалтын) | 226 |
| Чанар (төгөлдөр байх хандлага) | 227 |
| Чанарын баталгаажуулалт | 228 |
| Чанарын дотоод баталгаажуулалт (ЧДБ) | 230 |
| Чанарын ерөнхий удирдлага | 231 |
| Чанарын соёл | 231 |
| Чанарын төлөвлөлт | 232 |
| Чанарын удирдлага | 233 |
| Чанарын үнэлгээ | 233 |
| Чанарын хяналт | 235 |

**Ш**

| | |
|---|---|
| *Шалгалт (магадлан итгэмжлэлд)* | *237* |
| *Шалгуур* | *237* |
| *Шилжилт* | *237* |
| *Шилжин суралцах* | *237* |
| *Шинжлэх ухаан, технологийн төсөл* | *238* |
| *Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа* | *238* |
| *Шинжлэх ухааны парк* | *238* |
| *Шинжээч ажиллах* | *239* |
| *Шинжээчийн удирдамж* | *239* |
| *Шинжээчийн үнэлгээ/ хөндлөнгийн үнэлгээ* | *240* |
| *Шинэ бүтээл/Нээлт* | *241* |
| *Шинэ мэдлэг* | *241* |
| *Шударга байдал (үнэлгээнд)* | *241* |
| *Шүүмжлэлт сэтгэхүй* | *242* |

**Э**

| | |
|---|---|
| *Эгэх хариуцлага* | *243* |
| *Эдийн засгийн идэвхтэй хүн ам* | *243* |
| *Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг магадлан итгэмжлэх* | *243* |
| *Эзэмшсэн сургалтын хөтөлбөр* | *244* |
| *Экспертийн үнэлгээ* | *244* |
| *Элсэлт* | *244* |
| *Элсэлтийн бодлого* | *245* |
| *Эндаумент* | *245* |
| *Энтрепренер* | *245* |
| *Эрдмийн зөвлөл* | *246* |
| *Эрсдэлийн менежмент* | *246* |
| *Эрхэм зорилго* | *246* |
| *Эшлэл* | *247* |

**Ю**

| | |
|---|---|
| *Ю-мультиранк* | *248* |

**Я**

| | |
|---|---|
| *Явцын үнэлгээ* | *249* |
| *Явцын шалгалт* | *249* |

## АНГЛИ НЭР ТОМЬЁОНЫ ЛАВЛАГАА


**A**

| | |
|---|---|
| *Ability* | *11* |
| *Abstract* | *215* |
| *Academic advisor / Thesis advisor* | *75* |
| *Academic assistant* | *176* |
| *Academic Council / Academic board* | *246* |
| *Academic degree* | *36* |
| *Academic freedom* | *14* |
| *Academic recognition* | *36* |
| *Academic staff* | *26* |
| *Academic year* | *205* |
| *Accountability* | *243* |
| *Accreditation* | *81* |
| *Accreditation body* | *85* |
| *Accreditation mill* | *216* |
| *Accreditation of prior learning* | *243* |
| *Accreditation status* | *83* |
| *Accreditation survey* | *84* |
| *Accredited / validated program* | *81* |
| *Accumulation of study credits* | *146* |
| *Achievement evaluation* | *199* |
| *Active learning* | *76* |
| *Administrative council* | *74* |
| *Admission policy* | *245* |
| *Adult education* | *100* |
| *Aim* | *74* |
| *Applied research* | *200* |
| *Apprenticeship* | *53* |
| *Artificial Intelligence (AI)* | *204* |
| *Assessment* | *192* |
| *Assessment of individual qualifications* | *215* |
| *Assessment policy* | *192* |
| *Assessment test* | *194* |
| *Assurance* | *31* |
| *Attained curriculum* | *244* |
| *Attainment targets* | *219* |
| *Attitude* | *203* |
| *Audit* | *20* |
| *Authentic assessment* | *33* |
| *Authentic learning* | *33* |
| *Author* | *74* |
| *Awarding body* | *97* |

**B**

| | |
|---|---|
| *Bachelor degree* | *29* |
| *Basic learning needs* | *140* |
| *Basic research* | *163* |
| *Basic skills* | *163* |
| *Benchmark (in accreditation)* | *72* |
| *Benchmarking* | *72* |
| *Best practice* | *181* |
| *Bibliography* | *103* |
| *Bilingual education* | *210* |
| *Blended learning* | *207* |
| *Bloom's taxonomy* | *31* |
| *Bologna declaration* | *40* |
| *Bologna process* | *41* |
| *Brain drain* | *110* |
| *Brainstorming* | *41* |
| *Branch unit* | *119* |

**C**

| | |
|---|---|
| *Career guidance and counseling* | *13* |
| *Career support* | *12* |
| *Carrier subject* | *214* |
| *Certification* | *52* |
| *Citation* | *247* |
| *Civil service commission* | *171* |
| *Classification* | *18* |
| *Classroom-based assessment (CBA)* | *17* |
| *Code of ethics (in quality assurance and accreditation)* | *92* |
| *Code of practice* | *120* |
| *Cognitive competence* | *165* |
| *Cognitive neuroscience* | *165* |
| *Cognitive science* | *165* |
| *Collaborative learning* | *203* |
| *Competence* | *223* |
| *Competency-based curriculum* | *225* |
| *Competency-based Education and Training* | *225* |
| *Computer-simulation* | *79* |
| *Concept map* | *70* |
| *Consistency* | *102* |
| *Consultation (in curriculum)* | *74* |
| *Contact period* | *204* |
| *Content standard* | *11* |

| | |
|---|---|
| *Core curriculum* | *162* |
| *Core requirement* | *189* |
| *Corrective action* | *73* |
| *Course* | *204* |
| *Course evaluation (by students)* | *112* |
| *Creativity, creative thinking* | *45* |
| *Credits* | *22* |
| *Criteria* | *237* |
| *Critical thinking* | *242* |
| *Cross-curricular approach* | *205* |
| *Cultural norms* | *124* |
| *Culturally responsive curriculum* | *123* |
| *Culturally responsive pedagogy* | *124* |
| *Culture of evidence* | *30* |
| *Curriculum* | *149* |
| *Curriculum adaptation* | *155* |
| *Curriculum aims/goals* | *150* |
| *Curriculum alignment* | *155* |
| *Curriculum change* | *160* |
| *Curriculum chart / curriculum map* | *154* |
| *Curriculum coherence* | *161* |
| *Curriculum design* | *153* |
| *Curriculum development* | *152* |
| *Curriculum differentiation* | *161* |
| *Curriculum evaluation* | *157* |
| *Curriculum framework* | *157* |
| *Curriculum guidelines* | *156* |
| *Curriculum implementation* | *159* |
| *Curriculum integration* | *154* |
| *Curriculum monitoring* | *159* |
| *Curriculum objectives* | *153* |
| *Curriculum organizers* | *152* |
| *Curriculum planning* | *150* |
| *Curriculum policy* | *151* |
| *Curriculum relevance* | *151* |
| *Curriculum review cycle* | *161* |
| *Curriculum structure* | *152* |
| *Curriculum studies* | *149* |
| *Curriculum trends* | *160* |
| **D** | |
| *Data* | *113* |
| *Data analysis* | *113* |
| *Data collection* | *114* |
| *Dean* | *42* |
| *Degree mill* | *216* |
| *Department* | *181* |
| *Developmental curriculum* | *211* |
| *Diagnostic assessment* | *108* |
| *Didactics* | *54* |
| *Differentiated instruction* | *133* |
| *Diploma* | *55* |
| *Diploma supplement* | *56* |
| *Dissertation* | *56* |
| *Distance learning* | *73* |
| *Distance learning program* | *73* |
| *Doctoral program* | *56* |
| *Doctoral student* | *56* |
| *Document analysis* | *30* |
| *Double diploma* | *209* |
| *Dual degree* | *210* |
| *Dual program* | *209* |
| *Duration of accreditation* | *84* |
| **E** | |
| *E-assessment /ICT-based assessment* | *222* |
| *Economically active population* | *243* |
| *Education* | *34* |
| *Education for All (EFA)* | *47* |
| *Education for sustainable development (ESD)* | *168* |
| *Education information system* | *38* |
| *Educational content* | *35* |
| *Educational effectiveness* | *40* |
| *Educational efficiency* | *35* |
| *Educational standards* | *38* |
| *E-learning* | *222* |
| *Elective course* | *125* |
| *Elective curriculum* | *124* |
| *Emerging issues* | *173* |
| *Emotional intelligence* | *164* |
| *Employability* | *213* |
| *Employment* | *212* |
| *Employment rate* | *212* |
| *Employment support fund* | *212* |
| *Employment support program* | *212* |
| *Endowment* | *245* |
| *Enrolment/ Entry* | *244* |
| *Entrepreneur* | *245* |
| *Equal opportunity* | *179* |
| *Equality* | *178* |
| *Equity* | *189* |
| *European Credit Transfer and Accumulation System (ECTS)* | *69* |
| *European qualifications framework* | *69* |

| | |
|---|---|
| *Evaluation* | *191* |
| *Evaluation (in teaching and learning)* | *141* |
| Evaluation manual | *193* |
| *Evaluation report/assessment report* | *194* |
| *Evaluator* | *196* |
| *Examination (in accreditation)* | *237* |
| *Excellence* | *169* |
| *Expanded learning time* | *148* |
| *Experimental Development* | *173* |
| *External assessment* | *213* |
| *External evaluation* | *57* |
| *Extra-curricular activities* | *207* |
| **F** | |
| *Faculty* | *43* |
| *Faculty council* | *23* |
| *Faculty development* | *26* |
| *Fairness (in assessment)* | *241* |
| *Feedback* | *120* |
| *Fees* | *188* |
| *Fellowship /research grant* | *132* |
| *Field study* | *54* |
| *Financial support* | *120* |
| *Financing of state owned education institutions* | *172* |
| *Flexible learning* | *185* |
| *Formal curriculum* | *15* |
| *Formal education* | *14* |
| *Formative assessment* | *249* |
| *Four pillars-oriented curriculum* | *138* |
| *Frascatti Manual* | *200* |
| *Functional curriculum* | *175* |
| **G** | |
| *Gender equality* | *71* |
| *General education* | *70* |
| *Gifted learners* | *11* |
| *Global citizenship education (GCED* | *57* |
| *Globalization* | *54* |
| *Good governance* | *117* |
| *Governance (of a higher education institution)* | *63* |
| *Grade point average (GPA)* | *50* |
| *Grading system* | *195* |
| *Graduate* | *169* |
| *Graduate program* | *20* |
| *Graduate school* | *20* |
| *Graduate student* | *86* |
| *Graduate university* | *131* |

| | |
|---|---|
| *Grant* | *42* |
| *Green skills* | *102* |
| *Guidelines for self-assessment* | *115* |
| *Guidelines for site visit* | *239* |
| **H** | |
| *Hard skills* | *12* |
| *Hidden curriculum* | *146* |
| *Higher education institution* | *62* |
| *Higher education sector* | *61* |
| *Higher-order thinking* | *67* |
| *Historical research* | *178* |
| **I** | |
| *Impact Factor* | *77* |
| *Implemented curriculum* | *221* |
| *Improvement* | *117* |
| *Inclusive curriculum* | *181* |
| *Inclusive education* | *180* |
| *Indicators* | *186* |
| *Informal learning* | *15* |
| *Information and Communication Technology (ICT)* | *90* |
| *Information and communications technology (ICT) skills* | *90* |
| *Initial accreditation* | *184* |
| *Innovation* | *77* |
| *Innovation system* | *78* |
| *Inquiry-based learning* | *129* |
| *Institutional accreditation* | *28* |
| *Institutional audit /institutional review* | *28* |
| *Institutional evaluation* | *29* |
| *Instructional design (ID)* | *134* |
| *Interactive teaching and learning* | *139* |
| *Intercultural understanding* | *123* |
| *Interdisciplinary activity* | *119* |
| *Interdisciplinary approach* | *119* |
| *Internal quality assurance (IQA)* | *230* |
| *International benchmarking* | *106* |
| *International Standard Classification of Education (ISCED)* | *37* |
| *International university* | *107* |
| *Internationalisation of higher education* | *60* |
| *Internship* | *188* |
| *Invention* | *241* |
| *IR (institutional research) institutional research* | *28* |

| | |
|---|---|
| **J** | |
| Job seeker | 12 |
| Joint degree | 202 |
| Joint program | 202 |
| **K** | |
| Key competences/ competencies or skills | 189 |
| Key stages of the curriculum | 156 |
| Know-how | 103 |
| Knowledge | 87 |
| Knowledge society | 88 |
| Knowledge-based economy | 88 |
| **L** | |
| Laboratory / Lab | 80 |
| Laboratory work | 80 |
| Labour market | 213 |
| Learning | 133 |
| Learning content | 145 |
| Learning environment | 139 |
| Learning experiences | 136 |
| Learning outcomes | 141 |
| Learning progression | 136 |
| Learning resources | 147 |
| Learning styles | 142 |
| Learning support | 139 |
| Learning time | 135 |
| Learning to learn | 144 |
| Lecture | 80 |
| Lesson plan | 206 |
| Level descriptors | 177 |
| Levels of education | 39 |
| Liberal arts education | 81 |
| Licensing | 174 |
| Life skills | 16 |
| Lifelong learning | 100 |
| Likert scale | 80 |
| Localization of curriculum | 155 |
| **M** | |
| Mainstreaming (in special needs education) | 176 |
| Major | 189 |
| Management audit | 182 |
| Management of teaching and learning | 140 |
| Master's program /Graduate program | 86 |
| Meaningful learning | 184 |
| Measurable outcomes | 220 |
| Medical college admission test | 18 |
| Mentor | 86 |
| Mentoring / Mentorship | 201 |
| Meta-evalution | 87 |
| Midterm exam | 249 |
| Minor | 201 |
| Mission | 246 |
| Mobile learning | 211 |
| Mobility | 237 |
| Mode | 162 |
| Moderation (in assessment) | 196 |
| Module | 87 |
| Module specification | 87 |
| Monitoring | 221 |
| Monograph | 103 |
| MOOC (Massive Open Online Course) | 102 |
| Multidisciplinary approach | 204 |
| Multilingual education | 108 |
| Mutual recognition | 203 |
| **N** | |
| National qualifications framework | 98 |
| Neuroscience | 166 |
| New knowledge | 241 |
| Non-formal education | 14 |
| Norm-referenced assessment | 103 |
| **O** | |
| Open class | 105 |
| Open education | 104 |
| Open Educational Resources (OERs) | 36 |
| Open university | 105 |
| Opportunity to learn | 133 |
| Outcomes | 197 |
| Outcomes assessment | 198 |
| Outcomes-based education (OBE) | 199 |
| Outputs | 49 |
| **P** | |
| Paradigm | 116 |
| Patent | 116 |
| Patent and certificate holder | 117 |
| Peer assessment | 186 |
| Peer learning | 186 |
| Peer review | 244 |
| Peer review/external review | 240 |
| Peer teaching /tutoring | 186 |
| Performance assessment | 52 |
| Performance criteria | 52 |
| Performance indicators | 51 |

| | |
|---|---|
| Performance standards | 51 |
| Personalized learning | 214 |
| PISA (Programme for International Student Assessment) | 109 |
| Plagiarism | 44 |
| Policy analysis | 34 |
| Portfolio | 89 |
| Portfolio assessment | 44 |
| Portfolio for Accreditation | 83 |
| Postdoctoral researcher | 56 |
| Predictive assessment | 184 |
| Pre-requisite | 73 |
| Private institutions | 171 |
| Problem solving | 18 |
| Problem-based learning | 19 |
| Product design | 44 |
| Professional competencies | 96 |
| Professional degree program | 93 |
| Professional ethics standards of a teacher | 25 |
| Professional faculty | 91 |
| Professional recognition | 93 |
| Professional training college | 93 |
| Professionalism | 94 |
| Project-based learning | 172 |
| Public –private partnerships (PPPs) | 169 |
| Pure basic research | 223 |
| **Q** | |
| Qualification | 96 |
| Qualification descriptors | 97 |
| Qualified teacher | 99 |
| Quality (academic) | 226 |
| Quality as enhancement or improvement | 226 |
| Quality as excellence | 227 |
| Quality as fitness for purpose | 225 |
| Quality assessment/quality review | 233 |
| Quality assurance | 228 |
| Quality control | 235 |
| Quality culture | 231 |
| Quality management | 233 |
| Quality planning | 232 |
| **R** | |
| Ranking of higher education institutions | 64 |
| Rationale | 191 |
| Recognition | 216 |
| Recognition of prior learning | 114 |
| Regional Accreditation | 43 |
| Register of European Higher Education Quality Assurance Agencies (REHEQA) | 67 |
| Repeater | 53 |
| Research | 130 |
| Research and Development (R&D) | 128 |
| Research assistant system | 132 |
| Research outcome | 128 |
| Research proposal | 131 |
| Research report | 131 |
| Research supervisor | 131 |
| Researcher | 132 |
| Risk management | 246 |
| Room teacher system | 17 |
| Rubrics (in assessment) | 193 |
| Rules for degrees | 76 |
| **S** | |
| Sabbatical | 45 |
| Schedule | 207 |
| Scholarship | 182 |
| School mapping | 162 |
| Science and technology activities | 238 |
| Science and technology project | 238 |
| Science park | 238 |
| Self-assessment | 114 |
| Self-assessment personnel | 114 |
| Self-assessment report | 115 |
| Semester | 122 |
| Seminar | 122 |
| Site visit | 239 |
| Skills | 182 |
| Skills analysis | 183 |
| Skills transfer | 183 |
| Social and emotional learning (SEL) | 101 |
| Soft skills | 75 |
| Special needs education | 175 |
| Specialized accreditation | 175 |
| Spiral curriculum | 115 |
| Staff development | 218 |
| Stakeholders | 109 |
| Standards | 125 |
| Start up Business | 49 |
| Start up company | 49 |
| Strategy of higher education | 62 |
| Structural school/ branch school | 43 |
| Student | 110 |
| Student evaluation of teachers | 24 |

| | |
|---|---|
| *Student exchange program* | *110* |
| *Student loan* | *146* |
| *Student outcome assessment* | *112* |
| *Student scholarship* | *132* |
| *Student support* | *111* |
| *Student survey* | *111* |
| *Student with disabilities* | *211* |
| *Study plan* | *148* |
| *Study program* | *94* |
| *Subject benchmark/subject benchmark statement* | *206* |
| *SWOT analysis* | *121* |
| *Syllabus* | *122* |
| *System* | *168* |
| **T** | |
| *Teacher development center* | *26* |
| *Teacher ethic's violations* | *25* |
| *Teacher performance* | *25* |
| *Teacher's professional ethics* | *25* |
| *Teaching* | *27* |
| *Teaching assistant system* | *177* |
| *Team teaching* | *22* |
| *Team work* | *22* |
| *Technology* | *166* |
| *Technology-enhanced learning* | *166* |
| *Tenure track system* | *23* |
| *Tertiary education* | *58* |
| *Test* | *125* |
| *Test item bank* | *125* |
| *Textbook* | *143* |
| *Thematic evaluation* | *164* |
| *Thesis advisor* | *130* |
| *Third-party evaluation* | *51* |
| *Threshold* | *41* |
| *Total quality management (TQM)* | *231* |
| *Transcript* | *57* |
| *Transdisciplinary approach* | *205* |
| *Transfer* | *237* |
| *Transfer of learning* | *137* |
| *Transferable skills* | *214* |
| *Trans-institutional benchmarking* | *27* |
| *Tuition* | *147* |
| *Tuition waiver* | *148* |
| *Tutoring* | *145* |
| *Twenty-first century skills* | *208* |
| **U** | |
| *U-multirank* | *248* |
| *Undergraduate program* | *29* |
| *Unemployed Citizen* | *14* |
| *Unemployment classification* | *14* |
| *University* | *78* |
| *Unsuccessful graduation* | *15* |
| *Utility model* | *21* |
| *Utility model certificate* | *21* |
| **V** | |
| *Validation* | *219* |
| *Validation of learning outcomes* | *148* |
| *Values* | *197* |
| *Verification* | *31* |
| *Vertical and horizontal articulation (of the curriculum)* | *158* |
| *Viewpoints* | *71* |
| *Virtual university* | *48* |
| *Visiting professor* | *74* |
| *Vocational basic skills* | *93* |
| *Vocational education* | *91* |
| *Vocational education and training (VET)* | *92* |
| *Vocational key skills* | *94* |
| **W** | |
| *Wellbeing (in institution)* | *118* |
| *Workload* | *20* |
| *World Skills Competition* | *58* |

# ОРОС НЭР ТОМЬЁОНЫ ЛАВЛАГАА


| | |
|---|---|
| **А** | |
| *Автор* | *74* |
| *Адаптация образовательной программы* | *155* |
| *Административный совет* | *74* |
| *Академическая свобода* | *14* |
| *Академическая степень/учёная степень* | *36* |
| *Академическое признание* | *36* |
| *Аккредитационный орган* | *85* |
| *Аккредитация* | *81* |
| *Аккредитация образовательного заведения /организации* | *28* |
| *Аккредитация предшествующего обучения* | *243* |
| *Аккредитованная/ утвержденная программа* | *81* |
| *Активное обучение* | *76* |
| *Актуальность образовательной программы* | *151* |
| *Анализ данных* | *113* |
| *Анализ документов* | *30* |
| *Анализ навыков* | *183* |
| *Анализ политики* | *34* |
| *Антрепренёр* | *245* |
| *Аудит* | *20* |
| *Аудит / Инспекция образовательного учреждения / организации* | *28* |
| *Аудит управления* | *182* |
| *Аутентичное обучение* | *33* |
| *Аутентичное оценивание* | *33* |
| **Б** | |
| *Безработный гражданин* | *14* |
| *Бенчмарк (аккредитация)* | *72* |
| *Бенчмаркинг* | *72* |
| *Библиография* | *103* |
| *Билингвальное образование / Двуязычное образование* | *210* |
| *Благое / хорошее управление* | *117* |
| *Благополучие (в учебном заведении)* | *118* |
| *Болонская декларация* | *40* |
| *Болонский процесс* | *41* |
| *Брейнсторминг, мозговой штурм* | *41* |
| **В** | |
| *Валидация* | *219* |
| *Верификация* | *31* |
| *Вертикальная и горизонтальная артикуляция образовательной программы* | *158* |
| *Взаимное признание образования* | *203* |
| *Виртуальный университет* | *48* |
| *Внеклассная работа* | *207* |
| *Внешнее оценивание* | *57* |
| *Внешняя оценка* | *213* |
| *Возможность в обучении* | *133* |
| *Возникающие проблемы / Актуальные проблемы* | *173* |
| *Ворлдскиллс* | *58* |
| *Вступительный экзамен в медицинский колледж в США* | *18* |
| *Выдающийся опыт* | *181* |
| *Выпускник* | *169* |
| *Выравнивание образовательной программы* | *155* |
| *Высшее образование* | *58* |
| *Высшее учебное заведение* | *62* |
| **Г** | |
| *Гибкий график учебной деятельности* | *185* |
| *Глобализация* | *54* |
| *Государственно-частное партнёрство* | *169* |
| *Грант* | *42* |
| *Групповое обучение* | *22* |
| **Д** | |
| *Данные* | *113* |
| *Двойная степень* | *202* |
| *Двойная степень* | *210* |
| *Двойной диплом* | *209* |
| *Декан / директор* | *42* |
| *Денежный взнос* | *188* |
| *Дескрипторы квалификации / Описание уровней квалификаций* | *97* |
| *Дескрипторы уровня* | *177* |
| *Диагностическая оценка* | *108* |
| *Дидактика* | *54* |
| *Дизайн образовательной программы* | *153* |
| *Диплом* | *55* |
| *Диссертация* | *56* |
| *Дистанционное обучение* | *73* |

| | |
|---|---|
| *Дифференцирование образовательной программы* | *161* |
| *Дифференцированная инструкция* | *133* |
| *Докторант /Аспирант* | *56* |
| *Достигнутая образовательная программа* | *244* |
| **Е** | |
| *Европейская квалификационная рамка* | *69* |
| *Европейская система переноса и накопления кредитов* | *69* |
| *Европейский реестр агенств по обеспечению качества высшего образования* | *67* |
| *Е-обучение* | *222* |
| *Е-оценка / Оценка, основанная на ИКТ* | *222* |
| **Ж** | |
| *Жизненно необходимые навыки* | *16* |
| **З** | |
| *Заинтересованные стороны / Стейкхолдер* | *109* |
| *Занятость* | *212* |
| *Зачетная книжка, Справка об успеваемости студента* | *57* |
| *Зачисление в образовательное учреждение / поступление* | *244* |
| *Зеленые навыки* | *102* |
| *Знание* | *87* |
| *Значимое обучение* | *184* |
| **И** | |
| *Изменение образовательной программы* | *160* |
| *Измеряемые результаты / итоги* | *220* |
| *Изобретение* | *241* |
| *Изучение образовательной программы* | *149* |
| *Импакт-фактор* | *77* |
| Индикаторы | *186* |
| *Индикаторы выполнения* | *51* |
| *Инклюзивная программа* | *181* |
| *Инклюзивное образование* | *180* |
| *Инновационная система* | *78* |
| *Инновация* | *77* |
| *Интеграция образовательной программы* | *154* |
| *Интерактивное обучение* | *139* |
| *Интернационализация высшего образования* | *60* |
| *Информационная система в образовании* | *38* |
| *Информационно-коммуникационная технология* | *90* |
| *Информация /отзыв/Обратная связь* | *120* |
| *Искусственный интеллект* | *204* |
| *Исследование* | *130* |
| *Исследование и Разработка* | *128* |
| *Исследования организационного уровня* | *28* |
| *Исследователь* | *132* |
| *Исследовательский университет* | *131* |
| *Историческое исследование* | *178* |
| *Ищущий работу* | *12* |
| **К** | |
| *Карта образовательной программы* | *154* |
| *Картирование школы* | *162* |
| *Карьерная поддержка* | *12* |
| *Кафедра* | *181* |
| *Качество (академическое)* | *226* |
| *Качество как превосходство / совершенство* | *227* |
| *Качество как цель* | *225* |
| *Квалификация* | *96* |
| *Квалифицированный преподаватель* | *99* |
| *Классификация* | *18* |
| *Классификация занятости* | *14* |
| *Ключевые компетенции* | *189* |
| *Когнитивная компетенция* | *165* |
| *Когнитивная наука* | *165* |
| *Когнитивная нейронаука* | *165* |
| *Кодекс практики* | *120* |
| *Колледж профессиональной подготовки* | *93* |
| *Коллективное обучение /Обучение в сотрудничестве* | *203* |
| *Командная работа* | *22* |
| *Комбинированное обучение* | *207* |
| *Комиссия по делам государственной службы* | *171* |
| *Компетентностное образование и обучение* | *225* |
| *Компетенция* | *223* |
| *Компьютерное моделирование / симулирование* | *79* |
| *Консультант по учебным вопросам* | *75* |
| *Консультация (в образовательной программе)* | *74* |

| | |
|---|---|
| *Контактный период* | *204* |
| *Контроль качества* | *235* |
| *Концептуальная карта* | *70* |
| *Корректирующее действие* | *73* |
| *Креативность, креативное мышление* | *45* |
| *Кредит / зачетная единица* | *22* |
| *Кредит на образование* | *146* |
| *Критерии выполнения* | *52* |
| *Критерия* | *237* |
| *Критическое мышление* | *242* |
| *Культура доказывания* | *30* |
| *Культура качества* | *231* |
| *Культурная норма* | *124* |
| *Культурно-адаптивная образовательная программа* | *123* |
| *Кураторство / Наставничество* | *201* |
| *Курс* | *204* |
| **Л** | |
| *Лаборатория* | *80* |
| *Лабораторная работа* | *80* |
| *Лекция* | *80* |
| *Либеральное образование* | *81* |
| *Лицензия* | *174* |
| *Ложная аккредитация* | *216* |
| *Ложная учёная степень* | *216* |
| *Локализация образовательной программы* | *155* |
| **М** | |
| *Магистрант* | *86* |
| *Мажор / основная программа по специальности* | *189* |
| *Массовый открытый онлайн-курс* | *102* |
| *Междисциплинарная деятельность* | *119* |
| *Междисциплинарный подход* | *119* |
| *Международная программа по оценке образовательных достижений учащихся* | *109* |
| *Международная стандартная классификация образования (МСКО)* | *37* |
| *Международный бенчмаркинг* | *106* |
| *Международный университет* | *107* |
| *Межкультурное взаимопонимание* | *123* |
| *Межпредметный подход* | *205* |
| *Ментор* | *86* |
| *Мета-оценка* | *87* |
| *Минор / второстепенная программа* | *201* |
| *Миссия* | *246* |
| *Мобильное обучение* | *211* |
| *Мобильность / подвижность* | *237* |
| *Модуль* | *87* |
| *Мониторинг* | *221* |
| *Мониторинг в образовательной программе* | *159* |
| *Монография* | *103* |
| *Моральный кодекс (в аккредитации, обеспечении качества)* | *92* |
| *Мультидисциплинарный подход* | *204* |
| *Мультилингвальное образование* | *108* |
| *Мышление высшего порядка* | *67* |
| *Мэйнстриминг (в специальном образовании)* | *176* |
| *Мягкие навыки* | *75* |
| **Н** | |
| *Навыки, умения* | *182* |
| *Нагрузка / Трудозатраты* | *20* |
| *Накопление зачетных единиц* | *146* |
| *Нарушение педагогической этики* | *25* |
| *Научиться учиться* | *144* |
| *Научно-технологическая деятельность / научно-техническая деятельность* | *238* |
| *Научно-технологический проект* | *238* |
| *Научный отчет* | *131* |
| *Научный парк* | *238* |
| *Научный проект* | *131* |
| *Научный руководитель* | *130* |
| *Научный руководитель* | *131* |
| *Национальная рамка квалификаций* | *98* |
| *Негосударственное образовательное учреждение /Частное* | *171* |
| *Нейронаука* | *166* |
| *Неудачный выпуск* | *15* |
| *Неформальное образование* | *14* |
| *Неформальное обучение / Информальное обучение* | *15* |
| *Новое знание* | *241* |
| *Нормативно-ориентированная оценка* | *103* |
| *Ноу-хау* | *103* |
| **О** | |
| *Обеспечение* | *31* |
| *Обеспечение внутреннего качества (ОВК)* | *230* |
| *Обеспечение качества* | *228* |

| | |
|---|---|
| Обзор/Отчет/Обследование аккредитации | 84 |
| Обоснование | 191 |
| Образование | 34 |
| Образование в духе глобальной гражданственности | 57 |
| Образование в течение всей жизни | 100 |
| Образование для всех (ОДВ) | 47 |
| Образование для устойчивого развития (ОУР) | 168 |
| Образование, основанное на результатах | 199 |
| Образовательная программа | 149 |
| Образовательная программа бакалавриата | 29 |
| Образовательная программа, основанная на компетентностном подходе | 225 |
| Образовательная программа, основанная на четырёх столпах образования | 138 |
| Образовательная скрытая программа | 146 |
| Образовательный стандарт | 38 |
| Обучение взрослых | 100 |
| Обучение сверстников | 186 |
| Обучение, основанное на исследованиях | 129 |
| Общее образование | 70 |
| Общество знания | 88 |
| Одаренный студент | 11 |
| Опрос студентов | 111 |
| Опыт учебной деятельности | 136 |
| Орган по присуждению квалификации | 97 |
| Организаторы образовательной программы | 152 |
| Ориентиры | 71 |
| Освобождение от платы за обучение | 148 |
| Основная образовательная программа | 162 |
| Основное требование | 189 |
| Основные задачи образовательной программы | 153 |
| Основные навыки | 163 |
| Основные потребности в обучении | 140 |
| Основные этапы реализации образовательной программы | 156 |
| Осуществление образовательной программы | 159 |
| Отделение университета | 119 |
| Открытое образование | 104 |
| Открытые образовательные ресурсы | 36 |
| Открытый университет | 105 |
| Открытый урок | 105 |
| Отчёт об оценке | 194 |
| Отчет самооценки | 115 |
| Оценивание | 191 |
| Оценивание (в учебной деятельности) | 141 |
| Оценивание индивидуальной классификации \ профессионализма | 215 |
| Оценивание конечного результата обучения | 198 |
| Оценивание на основе предоставленного портфолио | 44 |
| Оценка (прогресса)приобретенных знаний и умений | 249 |
| Оценка в классе | 17 |
| Оценка в курсе | 112 |
| Оценка выполнения | 52 |
| Оценка достижения | 199 |
| Оценка качества | 233 |
| Оценка образовательного заведения / организации | 29 |
| Оценка образовательной программы | 157 |
| Оценка преподавателей студентами | 24 |
| Оценка результатов учебной деятельности студентов | 112 |
| Оценка сверстников | 186 |
| Оценка третьей стороной | 51 |
| **П** | |
| Парадигма | 116 |
| Патент | 116 |
| Патентообладатель | 117 |
| Педагогика, учитывающая особенности культуры | 124 |
| Педагогический дизайн/ Педагогическое проектирование | 134 |
| Передаваемые умения / навыки | 214 |
| Передача навыков | 183 |
| Перенос | 237 |
| Перенос учебной деятельности | 137 |
| Персонал по самооценке | 114 |
| Персонализированное обучение | 214 |
| Плагиат | 44 |
| План урока | 206 |
| Планирование качества | 232 |

| | |
|---|---|
| Планирование образовательной программы | 150 |
| Плата за обучение | 147 |
| Повторитель /Студент повторного обучения | 53 |
| Повышение квалификации человеческих ресурсов | 218 |
| Поддержка студенческой жизни | 111 |
| Подотчетность \Отчетность \ Ответсвенность | 243 |
| Показатели труда преподавателя | 25 |
| Полезная модель | 21 |
| Политика образовательной программы | 151 |
| Политика оценки | 192 |
| Политика приема/ зачисления/ вступления | 245 |
| Порог | 41 |
| Портфолио | 89 |
| Портфолио для аккредитации | 83 |
| Посещение эксперта | 239 |
| Последовательность / согласованность образовательной программы | 161 |
| Постдокторант / Постдокторский научный сотрудник | 56 |
| Правила присуждения учёных степеней | 76 |
| Практический опыт | 54 |
| Предварительная аккредитация | 184 |
| Предварительные необходимые предметы | 73 |
| Предмет-носитель | 214 |
| Предметный эталон / заявление о предметном бенчмарке | 206 |
| Преподавание сверстников | 186 |
| Преподавание | 27 |
| Признание | 216 |
| Признание предварительного обучения | 114 |
| Признание результатов обучения | 148 |
| Прикладное исследование | 200 |
| Приложение к диплому | 56 |
| Проблемное обучение | 19 |
| Прогнозная оценка | 184 |
| Программа | 94 |
| Программа аспирантуры \ Докторская программа | 56 |
| Программа дистанционного обучения | 73 |
| Программа для магистратуры | 86 |
| Программа для магистратуры и аспирантуры | 20 |
| Программа для профессиональной подготовки | 93 |
| Программа поддержки занятости | 212 |
| Программа студенческого обмена | 110 |
| Прогресс в учебной деятельности | 136 |
| Продуктивность образования | 35 |
| Продуктовый дизайн | 44 |
| Проектное обучение | 172 |
| Производственная практика | 188 |
| Промежуточный результат | 49 |
| Промежуточный экзамен | 249 |
| Профессионализм | 94 |
| Профессиональная компетенция | 96 |
| Профессиональная ориентация и консультирование | 13 |
| Профессиональная этика преподавателя | 25 |
| Профессиональное образование | 91 |
| Профессиональное образование и обучение | 92 |
| Профессиональное признание | 93 |
| Профессиональное развитие преподавателя | 26 |
| Профессиональные навыки | 93 |
| Профессиональные основные навыки | 94 |
| Профессиональный преподавательский состав | 91 |
| Профессор, приглашенный для чтения лекций в учебное заведение | 74 |
| Профессорско-преподавательский состав | 26 |
| Процесс оценки результатов обучения | 192 |

**Р**

| | |
|---|---|
| Равенство | 178 |
| Равенство прав / равные возможности | 179 |
| Равноправие мужчин и женщин / Гендерное равноправие | 71 |
| Развивающийся образовательная программа | 211 |
| Рамка образовательной программы | 157 |
| Расписание учебных занятий | 207 |
| Расширенное время обучения | 148 |
| Реализованная образовательная программа | 221 |
| Региональная аккредитация | 43 |

| | |
|---|---|
| *Результат исследования* | *128* |
| *Результаты* | *197* |
| *Результаты учебной деятельности* | *141* |
| *Резюме / Краткий обзор* | *215* |
| *Рейтинг высших учебных заведений* | *64* |
| *Репетиторство* | *145* |
| *Решение проблемы* | *18* |
| *Рубрик (в оценке)* | *193* |
| *Руководство / инструкции / рекомендации к образовательной программе* | *156* |
| *Руководство для визитов* | *239* |
| *Руководство оценивания* | *193* |
| *Руководство Фраскати* | *200* |
| *Руководство для самооценки* | *115* |
| *Рынок труда* | *213* |
| **С** | |
| *Самооценка* | *114* |
| *Сбор данных* | *114* |
| *Свидетельство на полезную модель* | *21* |
| *СВОТ анализ* | *121* |
| *Сектор высшего образования* | *61* |
| *Семестр* | *122* |
| *Семинар* | *122* |
| *Сертификация/Свидетельство* | *52* |
| *Силлабус /Учебно-методическая программа* | *122* |
| *Система* | *168* |
| *Система ассистент-преподавателя* | *177* |
| *Система классных руководителей* | *17* |
| *Система научных сотрудников* | *132* |
| *Система оценивания* | *195* |
| *Система тенюра* | *23* |
| *Совершенство* | *169* |
| *Совершенствование образовательной программы* | *152* |
| *Совет профессорско-преподавательского состава* | *23* |
| *Совместная образовательная программа* | *202* |
| *Совместная образовательная программа* | *209* |
| *Согласованность/ Связность* | *102* |
| *Содержание образования / Образовательный контент* | *35* |
| *Содержание обучения* | *145* |
| *Социально-эмоциональная учебная деятельность* | *101* |
| *Специализированная аккредитация* | *175* |
| *Специалист по оценке / эксперт по оценке* | *196* |
| *Специальное образование* | *175* |
| *Спецификация модуля* | *87* |
| *Спиральная образовательная программа* | *115* |
| *Способность* | *11* |
| *Способность к трудоустройству/ Трудоустраиваемость* | *213* |
| *Справедливость (в оценке)* | *241* |
| *Справедливость/ Равноправие* | *189* |
| *Средний академический балл* | *50* |
| *Срок действия аккредитации* | *84* |
| *Срок обучения* | *135* |
| *Стандарт профессиональной этики преподавателя* | *25* |
| *Стандарт содержания* | *11* |
| *Стандарты* | *125* |
| *Стандарты выполнения* | *51* |
| *Стартап бизнес* | *49* |
| *Стартап компания* | *49* |
| *Статус аккредитации* | *83* |
| *Степень бакалавра* | *29* |
| *Стиль учебной деятельности учащегося* | *142* |
| *Стипендия* | *182* |
| *Стипендия / научный грант* | *132* |
| *Стратегия высшего образования* | *62* |
| *Структура образовательной программы* | *152* |
| *Структурное подразделение для магистратуры и аспирантуры* | *20* |
| *Структурное подразделение/Филиал* | *43* |
| *Студент* | *110* |
| *Студент с ограниченными возможностями здоровья* | *211* |
| *Студенческая стипендия* | *132* |
| **Т** | |
| *Таксономия Блума* | *31* |
| *Твердые навыки /Профессиональные навыки* | *12* |
| *Творческий отпуск* | *45* |
| *Тематическая оценка* | *164* |
| *Тенденция в образовательной программе* | *160* |
| *Тест* | *125* |
| *Тест оценивания* | *194* |

| | |
|---|---|
| *Технологически усовершенствованное обучение* | *166* |
| *Технология* | *166* |
| *Тотальное /полное управление качеством* | *231* |
| *Трансдисциплинарный подход* | *205* |
| *Транс-институциональный бенчмаркинг* | *27* |
| **У** | |
| *Улучшение* | *117* |
| *Улучшение качества* | *226* |
| *Умения / Навыки XXI века* | *208* |
| *Умения /Навыки в области информационно-коммуникационных технологий (ИКТ)* | *90* |
| *Умеренность (в оценке)* | *196* |
| *Университет* | *78* |
| *Управление высшим учебным заведением* | *63* |
| *Управление качеством* | *233* |
| *Управление преподавания и обучения* | *140* |
| *Управление рисками* | *246* |
| *Уровень занятости* | *212* |
| *Уровень образования* | *39* |
| *Условия, в которых протекает учебная деятельность* | *139* |
| *Установка / Отношение* | *203* |
| *Утечка мозгов* | *110* |
| *Учебная поддержка* | *139* |
| *Учебник* | *143* |
| *Учебные ресурсы/учебные материалы* | *147* |
| *Учебный ассистент* | *176* |
| *Учебный год* | *205* |
| *Учебный план* | *148* |
| *Учение / Учебная деятельность* | *133* |
| *Ученичество* | *53* |
| *Учёный совет* | *246* |
| **Ф** | |
| *Факультативная программа* | *124* |
| *Факультативные курсы \ Курсы по выбору* | *125* |
| *Факультет* | *43* |
| *Финансирование государственного образовательного учреждения* | *172* |
| *Финансовая поддержка* | *120* |
| *Фонд поддержки занятости /Фонд занятости* | *212* |
| *Фонд тестовых заданий* | *125* |
| *Форма обучения* | *162* |
| *Формальная образовательная программа* | *15* |
| *Формальное образование* | *14* |
| *Фундаментальное исследование* | *163* |
| *Функциональная программа* | *175* |
| **Ц** | |
| *Цели достижения* | *219* |
| *Цель* | *74* |
| *Цель образовательной программы* | *150* |
| *Ценности* | *197* |
| *Центр профессионального развития преподавателя* | *26* |
| *Цикл пересмотра образовательной программы* | *161* |
| *Цитата* | *247* |
| **Ч** | |
| *Чистое фундаментальное исследование* | *223* |
| **Ш** | |
| *Шкала Лайкерта* | *80* |
| **Э** | |
| *Экономика, основанная на знаниях* | *88* |
| *Экономически активное население* | *243* |
| *Экспериментальная разработка* | *173* |
| *Экспертиза (в аккредитации)* | *237* |
| *Экспертная оценка* | *244* |
| *Экспертная оценка / Внешняя оценка* | *240* |
| *Эмоциональный интеллект* | *164* |
| *Эндаумент* | *245* |
| *Эффективность образования* | *40* |
| **Ю** | |
| *Ю-Мультиранк* | *248* |

Хэвлэлийн үйлдвэрлэл, худалдаа
СОДПРЕСС ХХК
Утас: 311427, 330999

ISBN 99978-61-95-7
9 789997 861955

Хаяг:
МОНГОЛ УЛС
Улаанбаатар хот – 14191
БСШУСЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн
Утас: 976-70125286
Цахим шуудан: info@mier.mn